НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙГ
ТАНИЛЦУУЛАХ ВЕБИНАРЫН ХӨТӨЛБӨР

Хэзээ: 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг
Хаана: Зуум платформ
Зохион байгуулагч: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба
Оролцогчид: Нээлттэй засгийн түншлэлийн Ажлын хэсгийн гишүүд, олон нийт

Хугацаа	Танилцуулах асуудал	Хариуцах албан тушаалтан
09.15-09.30	Бүртгэл	
09.30-10.00	Нээлт	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Болорсайхан
10.00-10.30	Нээлттэй засгийн түншлэлийн Үйл ажиллагааны үндэсний 5-р төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлууд	Нээлттэй засгийн түншлэлийн Судалгааны мэргэжилтэн Сара Жэйкобс
10.30-10.45	Асуулт, хариулт	
10.45-11.15	Нээлттэй засгийн түншлэлийн 2023-2028 оны стратеги	Нээлттэй засгийн түншлэлийн Ази Номхон далайн бүсийн удирдагчийн үүрэг гүйцэтгэгч Айвигейл Онг
11.15-11.30	Асуулт, хариулт	
11.30-11.50	Санал, хүсэлт	Ажлын хэсгийн гишүүд
11.50-12.00	Хаалт	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Болорсайхан

---oOo---

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ ВЕБИНАРЫН ТЭМДЭГЛЭЛ

Нээлттэй засгийн түншлэл (НЗТ) болон Монгол Улсын Нээлттэй Засгийн Түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөөний төслийг хамтран боловсруулах тухай танилцуулгыг НЗТ-ийн Ази Номхон далайн бүсийн удирдагчийн үүрэг гүйцэтгэгч Айвигейл Онг болон Хараат бус тайлагнах механизмын (ХБТМ) судалгааны мэргэжилтэн Сара Жэйкобс нар төсөл боловсруулах явцад анхаарах зүйлс, шинээр баталсан стратегийн агуулга, ХБТМ-ын талаар мэдээлэл өгч 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 09.30-10.30 цагт зуум платформ дээр вебинар зохион байгуулав.

Оролцсон:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа
2. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Д.Цэнд-Аюуш
3. Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга О.Энхзул
4. “Оюуны-Инноваци” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Төрболд
5. “Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэн”-ийн Хөтөлбөрийн ажилтан Э.Баасансүрэн
6. “Залуус эрүүл мэнд төв” ТББ-ын хөтөлбөрийн менежер Г.Нямпүрэв
7. “Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо”-ны Удирдах зөвлөлийн гишүүн Х.Оюунцэцэг
8. “Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төв” НҮТББ-ын гүйцэтгэх захирал Б.Дуламхорлын төлөөлөл н.Билгүүн
9. “Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож
10. Азийн сангийн Хотын засаглалтыг сайжруулах төслийн менежер Г.Халиунгоо
11. Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Сайн байцгаана уу? Өнөөдөр цаг зав гарган энэхүү вебинарт оролцож байгаа танд баярлалаа.

Хүний эрхийг хангах Үндэсний хороо (ХЭХҮХ) нь НЗТ Дэмжих нэгжээр ажилладаг бөгөөд өнөөдрийн арга хэмжээг Болорсайхан дарга нээх байсан боловч хүүхэд хамгааллын сонсгол давхацсан тул миний бие өнөөдрийн вебинарыг удирдан мөн синхрон орчуулга хийж та бүхэнд хүргэх болно.

Монгол Улсын НЗТ-ийн Үндэсний үйл ажиллагааны 4-р төлөвлөгөөг бид 2 хоногийн өмнө Англи, Монгол хэлээр албан ёсоор хүргүүлсэн. Одоо бид Монгол Улсын НЗТ-ийн 2024-2027 оны Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөөг боловсруулах ёстой.

Өнөөдрийн вебинарыг НЗТ-ийн Ази Номхон далайн бүсийн удирдагчийн үүрэг гүйцэтгэгч Айвигейл Онг болон ХБТМ-ын судалгааны мэргэжилтэн Сара Жэйкобс нар төсөл боловсруулах явцад анхаарах зүйлс, шинээр баталсан стратегийн агуулга, ХБТМ-ын талаар мэдээлэл өгөхөөр бэлэн боллоо.

Та бүхэнд асууж тодруулах зүйл байвал чат хэсэгт тэмдэглэн үлдээж болно мөн танилцуулга дууссаны дараа асуулт, хариултын цаг гаргасан байгаа. Ингээд Сара Жэйкобс болон Айвигейл Онг нарын танилцуулгыг хүргэе.

Хамтран бүтээх нь Монгол Улс

2023 оны 10 дугаар сар

Ivy Ong: ivy.ong@opengovpartnership.org

Sarah Jacobs: sarah.jacobs@opengovpartnership.org

Open Government Partnership

Онцгой загвар

Олон талын оролцоотой шинэ арга барил

+ ЗГ болон ИНБ эрх тэгш түншлэл
+ Өөрийгөө үнэлэх/Бие даасан тайлан гаргах
+ Бусдаас суралцах, туршлага солилцох

Үйлдэлд чиглэх

+ ЗГ болон ИНБ хамтран УУАТ боловсруулах
+ Тодорхой амлалтуудыг баталгаажуулах
+ ЗГ бүхлээрээ оролцох арга барил

Уян хатан боловч амбицтай байх

+ Улс орон бүрийн эхлэх цэг өөр өөр байдаг
+ Гүйцэтгэгчээс гадна бусад олон төрлийн бүлэгтэй ажиллах
+ Уулын оргил руу уралдах

НЗТ-ийн тоо баримт

75
Улс орон

3000+
ИНБ

104
Орон нутгийн засаг захиргаа

380+
ХБТМ тайлан

401
YYAT

24%
ЗГ-ыг нээлттэй болгосон амлалтын хуьь

5200+
Амлалт

Монгол Улсын гол үр дүн

2014-2016

+ Гэмт хэргийн гаралтын цахим зураглал
+ Байгаль орчны талаарх олон нийтийн мэдээллийн жагсаалт
+ Шилэн дансны портал

2016-2018

+ ЗГ-ын олборлох гэрээний ил тод байдал
+ НӨАТ-ын баримтын онлайн бүртгэл
+ Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээн дахь иргэний оролцоо

ХБТМ гэж юу вэ?

Хараат бус тайлагнах механизм нь НЗТ-ийн гишүүдэд хариуцлага тооцож, нээлттэй засгийн хүчин чармайлтыг дэмждэг

Яагаад хамтран бүтээх хэрэгтэй вэ?

+ **Түгээн дэлгэрүүлэх ба эвслийг бүрдүүлэх:** Нээлттэй засгийн төлөөх иргэний нийгмийн хүчтэй эвслийг бий болгох, НЗТ-ийн платформоор дамжуулан үндэсний ашиг сонирхлын асуудлыг нэн тэргүүнд анхаарах
+ **Харилцаа холбоо:** Нээлттэй засаг болон НЗТ-ийн талаарх олон нийтийн мэдлэгжүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад оролцох, амлалт (жишээ нь, шинэ эрх, шинэ үйлчилгээ гэх мэт) эсвэл өөрчлөгдсөн бодлого, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл солилцох.
+ **Шинжээчийн мэдлэг олгох:** Бодлого боловсруулах эсвэл хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгөх
+ **Үйлчилгээг үзүүлэх/хамтдаа бүтээх:** Засгийн газартай хамтран шинэчлэлийг хэрэгжүүлэх
+ **Үр шим хүртэгчийн оруулсан хувь нэмэр, түүнийг ашиглах, сайжруулах санал өгөх:** Төлөвлөгөөг ашиглах хүмүүс болон амлалтаас үр шим хүртэгч нарыг дэмжиснээр шинэ бодлого, хөтөлбөр, үйлчилгээний загварт тэдний саналыг тусгах, хэрэгжүүлэх явцад санал хүсэлтийг хэрэгжүүлэгч агентлагт дамжуулах
+ **Хамтрагчийн үүрэг маш чухал!**



ХБТМ амлалтын загварыг хэрхэн үнэлдэг вэ?

- **Баталгаажуулах**
  - Бичсэн төлөвлөгөөн дахь үйл ажиллагааг дуусахад баталгаажуулж болохоор тодорхой байна уу? Санал болгож буй зорилт, арга хэмжээ хангалттай тодорхой байна уу? Хэрэгжилтийг үнэлэхэд бодитойгоор шалгах боломжтой үйл ажиллагаанууд багтсан байна уу?
- **Нээлттэй засгийн дурангаар харах**
  - Бодлогын салбар, институт, шийдвэр гаргах үйл явцыг олон нийтэд ил тод, оролцоотой, эгэх хариуцлагатай болгох амлалт тусгасан уу?
- **Үр дүнд хүрэх боломжтой эсэх**
  - Тодорхойгүй, Хязгаарлагдмал, Бодитой

Зөв шийдлийг олох

- Амлалт нь ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна вэ?
- Асуудлын шалтгаан юу вэ?
- Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?
- Та ямар шийдэл санал болгож байна вэ?
- Энэхүү амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг хүсч байна вэ?
- Энэхүү амлалт нь ил тод байдлыг хэрхэн дэмжих, эгэх хариуцлагыг хэрхэн нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог хэрхэн сайжруулах вэ?

Улс төрийн нам, сонгуулийн сурталчилгааны ил тод байдал, санхүүжилтийг сайжруулах

- Сонгууль, нийтийн санал асуулгын сурталчилгааны ил тод санхүүжилтийн эрх зүйн болон зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох
- Улс төрийн үйл ажиллагаа, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн талаарх мэдээллийг сайжруулах
- Сонгуулийн Ерөнхий Хорооны цахим хуудсыг програмаар унших боломжтой хэлбэрт оруулах, засварлах
- Улс төрийн нам, бие даан нэр дэвшигч, салбар нэгж, орон нутгийн болон бүс нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөллийн гишүүдэд улс төрийн үйл ажиллагааг ил тод санхүүжүүлэх талаар мэдлэг олгох

Улс төрийн үйл ажиллагаа, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн талаарх мэдээллийг сайжруулах

Манлайлагч	Сонгуулийн Ерөнхий Хороо
Хамтран манлайлагч	Төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний Аудитын Газар, Цахим Хөгжил Харилцаа Холбооны Яам
Үзүүлэлт	- Улс төрийн үйл ажиллагаа, сонгуулийн кампанит ажлыг санхүүжүүлэхэд тогтмол хяналт тавьдаг субьектүүдээс мэдээлэл оруулах, цуглуулах боломжийг олгох шийдлийг санал болгох. -Улс төрийн нам, бие даагч гишүүн, нэр дэвшигчдийн жагсаалтаар сонгогдсон орон нутаг, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гишүүдийн жилийн санхүүгийн тайлан бэлэн байх, хайх боломжтой мэдээллийн санд байршуулах, хуульд заасны дагуу санхүүгийн тайлан гаргах. Улс төрийн нам, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн тухай мэдээллийг улс төрийн намууд, бие даан нэр дэвшигчид, сонгогдсон нэр дэвшигчид Сонгуулийн Ерөнхий Хороо, Үндэсний Аудитын Газарт ирүүлсэн байх ёстой бөгөөд мэдээллийг янз бүрийн үндэслэлээр хялбар хайх, нээлттэй хэлбэрээр тогтмол нийтлэх боломжтой байх ёстой. Ийм мэдээлэл Сонгуулийн Ерөнхий Хорооны цахим хуудсанд тавигдсан байна.
Эх сурвалж	450,000 төгрөг. Улсын төсөв, Сонгуулийн Ерөнхий Хороо, Захиргаа, удирдлагын үйл ажиллагаа A 896002

Стратегийн амлалт гэж юу вэ?

НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн тодорхой, стратегийн бодлогыг хэрэгжүүлэх боломж гэж үзнэ.

+ Хамтран бүтээх үйл явцын туршид боловсруулж буй амлалтууд **биелэгдэх** болон **амбицтай** эсэхийг анхаарч үзээрэй.
+ Амлалтуудыг эрэмбэлэхдээ:
  – Тоглоомын дүрэм (эсвэл шинээр бий болгох), бодлого, төрийн салбар, иргэд төр хоорондын харилцааг зохицуулдаг практик, бодлого эсвэл институтийг **өөрчлөх тоглоом** юм.
  – Засгийн газрын хэмжээнд **заавал дагаж мөрдөх, зохион байгуулалттай өөрчлөлтүүд**ийг бий болгох

Монгол Улсын хувьд боломжтой салбарууд

- Иргэний орон зай
- Олборлолтын ил тод байдал
- Төрийн худалдан авалт
- Зөвлөлдөх ардчилал

Илүү үр дүнд хүрэх ХБТМ-ын зөвлөмжүүд

Та маш тодорхой, үр дүнд чиглэсэн амлалтуудыг боловсруулсан эсэхээ шалгана уу:

Энэ амлалт дараах зүйлсийг тодорхой тусгасан уу:	
✔	Тодорхой асуудал?
✔	Эхлэх цэгийн талаарх мэдээлэл - амлалтын үр дүнг та юутай харьцуулах вэ?
✔	Хүлээгдэж буй үр дүн?
✔	Хэрэгжүүлсэн тохиолдолд хүлээгдэж буй үр дүнд хүрэх үйл ажиллагаа эсвэл хүрэх үе шатууд юу байх вэ?

Асуулт асуух цаг

OGP's 2023-2028 Strategy

Open Government Partnership

Стратеги боловсруулсан үйл явц

2022.05-08 сар

Олон нийтийн хэлэлцүүлэг

- НЗТ-ийн ирээдүйн талаарх олон нийтийн яриа хэлэлцүүлэг
- НЗТ-ийн цахим хуудсанд нээлттэй хэлэлцүүлэг
- Оролцогч талуудын судалгаа

2022.08-11 сар

Стратегийг боловсруулах

- Олон нийтийн ярианы хураангуй
- НЗТ-ийн загвар, стратегийн талаар зорилтот олон нийтийн яриа
- НЗТ-ийн цахим хуудсанд нээлттэй хэлэлцүүлэг

2022.11–2023.03

Эцэслэх болон Хэрэгжүүлэх

- НЗТ-ийн стратегийн төслийн талаарх санал хүсэлт
- Батлсан эцсийн стратеги
- НЗТ Удирдах хороо

Алсын хараа

БИДНИЙ АЛСЫН ХАРАА БОЛ НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ГАЗРУУД ИРГЭНИЙ НИЙГЭМ, АРД ТҮМЭНТЭЙГЭЭ ХАМТРАН АЖИЛЛАСНААР АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЖ, НИЙГМИЙН САЙН ҮР ДҮНГ АВЧИРАХ ЮМ.

Зорилго

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО БОЛ ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ШИНЭТГЭГЧ, ТЭМЦЭГЧ НАРЫГ ЗОРИГЖУУЛАХ, ХОЛБОХ, ОЛОН НИЙТИЙГ ӨСӨН НЭМЭХ БОЛОМЖООР ХАНГАХАД ОРШИНО.

Стратегийн зорилтууд

https://www.opengovpartnership.org/strategy/

Зорилт 1:
Нээлттэй засгийн шинэтгэгч, активист, тэмцэгч нарыг багтаасан өсөн нэмэгдэх, тууштай, харилцан уялдаатай олон нийтийг бий болгох

- Нээлттэй засгийн төлөө илүү хүчирхэг, улс төрийн шинжтэй дэлхийн нийтийн эвслийг байгуулах
- Шинэтгэгч нарын манлайллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийх
- Нээлттэй засгийн зарчмыг бататгахын тулд стратегийн холбоо, түншлэлийг өргөжүүлэх

Зорилт 2:
Төрийн бүх түвшинд, салбарууд тэргүүлэх ажлыг хэрхэн хэрэгжүүлэх дээр нээлттэй засгийг төвлөрүүлэх

- Олон төрлийн орчин, хэрэгцээнд тохирсон уян хатан үйл ажиллагааны хүрээгээр хангах
- Нээлттэй засгийн үйл ажиллагааг бүх түвшинд, төрийн ажлын салбаруудад голлон дэмжих
- Улс төрийн боломжит “цонх” гарахад хариу үйлдэл сайн байх

Зорилт 3:
Иргэний нийгмийн орон зайг хамгаалах, тэлэх

- Иргэний нийгмийн орон зайн үйл ажиллагааг дэмжиж, тэмцэгч нарыг хөгжүүлэх
- Иргэний нийгмийн орон зайн талаарх Нээлттэй засгийн түншлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтмол хянах

Зорилт 4:
Нээлттэй засгийн шинэчлэлийн хамтын үйл ажиллагаа эрчимжүүлэх

- Ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо, хүртээмжийн шаардлагыг нэмэгдүүлэх
- Хамтын тэргүүлэх үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах уриалгыг эхлүүлэх

Зорилт 5:
Нээлттэй засгийн шинэчлэл, нотолгоо түүхийг өгүүлэн зоригжуулах нутаг орон болох

- Өндөр чанартай контентыг хөгжүүлэх, хадгалах хуваалцах
- Хүмүүст түүхээ хуваалцах холбогдох орон зайг бий болгох

THE OPEN GOV CHALLENGE

Нээлттэй засгийн сорилт

+Түншлэлийн бүх гишүүдийг багадаа нэг стратегийн сэдэвчилсэн чиглэл авч, таван жилийн стратегийн хугацаанд бодит ахиц дэвшлийг харуулахыг уриалах санаачилга.

+Бэрхшээлтэй асуудлууд нь стратегийн зөвлөлдөх уулзалтын үр дүнд олон нийтээс шууд гарч ирсэн тэргүүлэх сэдвүүдийг тусгасан байдаг.

+Дотоод бодлогын амбицад анхаарлаа хандуулж, ҮЗ болон иргэний нийгэмтэй хамтран өөрсдийн сорилтыг бий болгохыг дэмжинэ.

+Гишүүд нэгээс илүү сорилтыг хүлээн авч болох ба Сорилтууд дотроо дэд сорилттой байж болно.

Сорилт ямар зорилготой вэ

+ Зорилго нь стратегийн бодлогын хүрээнд амлалтуудын амбицыг нэмэгдүүлэх, нээлттэй засгийн хөндлөнгийн үнэ цэнийг харуулах явдал юм.
+ НЗТ-ийн гишүүдийг өөрсдийн нөхцөл байдалд тохирсон сонголтуудтай цэсээр хангадаг.
+ Стратегийн хариу: олон нийтийн үйл ажиллагаа, шинэчлэлийн хамтын эрч хүчийг харуулах.

Сорилтууд

1. **Авлигатай тэмцэх:** Авлигатай тэмцэх төрийн стратеги буюу зураглалыг боловсруулах, бэхжүүлэх.
2. **Байгаль орчин, уур амьсгал:** Уур амьсгал, байгаль орчны асуудлаар стратеги эсвэл хэлэлцээрийн хэрэгжилтийг бэхжүүлэхийн тулд нээлттэй засгийг ашиглах.
3. **Олон нийтийн оролцоо:** Засгийн газрын гол салбар, үйл явц, институтад зорилгод нийцсэн, өндөр чанартай, хүртээмжтэй олон нийтийн оролцооны туршлагыг нэвтрүүлэх.
4. **Иргэний орон зай:** Иргэний нийгмийн байгууллага, иргэний үйл ажиллагаанд таатай орчин, орон зайг бэхжүүлэх.
5. **Төсвийн нээлттэй байдал:** Төсөв болон зарцуулалтын мөчлөгийн хүрээнд олон нийтийн хяналт, оролцооны шинэчлэлийг ахиулах.

https://www.opengovpartnership.org/the-open-gov-challenge/

Сорилтууд

6. **Жендэр ба хүртээмж:** Эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, эдийн засгийн оролцоог бүрэн хангах зорилгоор нээлттэй засгийн шинэчлэлийг батлах.
7. **Мэдээллийн хүртээмж:** Мэдээлэл олж авах эрх зүйн орчны үр нөлөөг сайжруулах.
8. **Шударга ёс:** Хүн төвтэй шударга ёсны шинэчлэлийг ахиулах.
9. **Хэвлэл мэдээллийн эрх чөлөө:** Сэтгүүлчид болон хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг хөгжүүлэх, бэхжүүлэх.
10. **Дижитал засаглал:** AI болон өгөгдөл хамгаалах тогтолцооны ил тод байдал, олон нийтийн хяналтыг бэхжүүлэх.

https://www.opengovpartnership.org/the-open-gov-challenge/

НЗТ-ийн хүрээн дэх сорилт

Сорилтыг хэрэгжүүлэхэд **зэрэгцээ үйл явц шаардлагагүй** болно.

Гишүүд:

+ Одоо хэрэгжиж байгаа НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө ашиглах
+ Үйл ажиллагааны хүрээний уян хатан байдлыг судлах
+ НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээнээс давж гарах уян хатан байдлыг судалж, ҮҮАТ-өөс гадуур, ҮЗ-тэй зөвшилцөн саналаа ирүүлэх.

Сорилтын ахиц дэвшлийг ХБТМ улс орны түвшин, сэдэв тус бүрийг үнэлнэ.

+ Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгамдсан сорилт байгаа тохиолдолд үүнийг ХБТМ-ын үнэлгээний тогтмол мөчлөгийн хүрээнд үнэлнэ.
+ Хэрэв сорилтыг үйл ажиллагааны хүрээнээс давсан бол ХБТМ нь сорилтын үеийн дунд болон төгсгөлд дүн шинжилгээ хийнэ.

Гишүүд сорилтыг хэрхэн хүлээж авах вэ?

Алхам 1: НЗТ-ийн гишүүн засгийн газрууд (иргэний нийгмийн байгууллага/ҮЗ-тэй зөвшилцсөний үндсэн дээр) маягтыг бөглөж, Сорилт батлах амлалтаа Дэмжих нэгжид мэдэгдэнэ.

Алхам 2: Гишүүд иргэний нийгмийн байгууллагатай хамтран “Сорилт”-ын үйл явцыг эхлүүлнэ.

Алхам 3: Гишүүд өөрсдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд Сорилтын холбогдох амлалтыг нэмдэг (эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнээс гадуур уян хатан байдлыг ашиглана).

Алхам 4: Хэрэв YYAT-д байгаа бол сорилтыг ХБТМ тогтмол мөчлөгийн нэг хэсэг болгон үнэлнэ; хэрэв YYAT-ний хүрээнээс давсан бол хувь хүний үнэлгээ байхгүй. ХБТМ нь сорилтын үеийн дунд ба төгсгөлд дүн шинжилгээ хийнэ.

Баярлалаа!

Нэмэлт материал

- **НЗТ-ийн гарын авлага 4.1:** Оролцогчдод зориулсан дүрэм, заавар (2022 оны 2-р сард шинэчлэгдсэн). Энэхүү баримт бичиг НЗТ-ийн хуанли, тайлан хойшлуулах тухай дүрэм, сонгууль/шилжилтийн үйл явцыг хэрхэн зохицуулах тухай зөвлөгөө, Үйл ажиллагааны төлөвлөгөө болон өөрийн үнэлгээний тайланг хэрхэн боловсруулах зааварчилгааг өгөх болно.
- **НЗТ-ийн оролцоо ба хамтын бүтээлийн стандартууд.** Оролцоо ба хамтын бүтээлийн стандартууд нь гишүүдийг НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний мөчлөгийн бүх үе шатанд амбицтай хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих зааварчилгааг өгдөг бөгөөд үүний зэрэгцээ хамгийн бага шаардлагыг хангаж, давсан байх ёстой гэж шаарддаг.
- **НЗТ-ийн дэлхийн тайлан.** Дэлхийн тайлан нь нээлттэй засгийн төлөв байдлын цогц үнэлгээ юм. Энэхүү тайлан нь НЗТ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааны эхний найман жилд гаргасан ахиц дэвшлийг нарийвчлан, үнэн зөвөөр дүгнэсэн болно.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

За ингээд асуулт, хариултыг хүлээн авахад бэлэн боллоо. Миний зүгээс нэг асуулт байна. Ажлын хэсэг 5-р төлөвлөгөө боловсруулахаас гадна Монгол Улс ямар сорилтод нэгдэх тухай зэрэгцэн төлөвлөх ёстой юу?

Нээлттэй засгийн түншлэлийн Ази Номхон далайн бүсийн удирдагчийн үүрэг гүйцэтгэгч Айвигейл Онг:

Яг одоо байх албагүй ээ. Төлөвлөгөө боловсруулах явцад сорилтыг оруулан танилцуулж болно эсвэл төлөвлөгөө боловсруулсны дараа ямар сорилтод нэгдэх тухай ярилцахаар тусгайлан “форум” зохион байгуулж хэлэлцээд тогтож болно.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Чатаар асуулт ирсэн байна. Үндэсний үйл ажиллагааны 5-р төлөвлөгөө боловсруулах хугацаа, үе шатны талаар мэдээлэл өгнө үү.

Төлөвлөгөө боловсруулах Ажлын хуваарийг та бүхэнд хүргүүлнэ. Бид 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор НЗТ-д төлөвлөгөөг батлаад хүргүүлэх ёстой.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Чат хэсэг: Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, амжилттай хэрэгжсэн жишээ, үүрэг амлалт байвал та хуваалцана уу.

Хараат бус тайлагнах механизмын судалгааны мэргэжилтэн Сара Жэйкобс:

Би өөрийн РРТ танилцуулга дээр жишээ дурдсан нь Хорват Улсын жишээ байсан. Дэлгэрэнгүй мэдээллийг линкээр чат хэсэгт орууллаа. Хорват Улсын хувьд ил тод байдлыг сайжруулах, ялангуяа улс төрийн болон намын санхүүжилтийн асуудал дээр дэвшил гаргасан. Мөн Кени Улс, Норвеги Улс, Коста Рика зэрэг олон сайн жишээ байна. Бидний зүгээс өгдөг гол зөвлөмж бол хүн бүрт мэдээлэл хүрэх ёстой, олон нийтэд мэдээлэл өгөх сувагтай байх ёстой мөн бүгд мэдээлэл мэдлэгтэй байх нь маш чухал. Улс төрийн намтай очиж уулзах, олон нийтэд нээлттэй байхыг сурталчилах нь мөн үр дүнтэй байдаг.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Чат хэсэг: Олон улсын байгууллагуудыг (ОУБ) НЗТ-д татан оролцуулах нь чухал байна. Учир нь эдгээр байгууллага их хэмжээтэй худалдан авалтыг зохион байгуулдаг. Тэр явц олон нийтэд нээлттэй, эгэх хариуцлагатай байх ёстой.

Нээлттэй засгийн түншлэлийн Ази Номхон далайн бүсийн удирдагчийн үүрэг гүйцэтгэгч Айвигейл Онг:

Миний бодлоор энэ сэдвийг Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дотор ярилцахад сонирхолтой байх болов уу. ОУБ-ыг татан оролцуулвал хэнийг оролцуулах, хэрхэн оролцуулах, хамтран бүтээх явцад оролцуулах эсэх гээд олон асуудлууд байна. Зарим улсад Дэлхийн банк, ОУБ-ын төлөөлөл орж орон нутгийн ТББ-ыг дэмжих санхүүжилт олгох, хамтран бүтээх явцад оролцон мэдээлэлтэй байх нь зөв байдаг. Азийн сан, Бүгд найрамдахчуудын хүрээлэн зэрэг байгууллагууд Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг гэж ойлгож байна. Зөвхөн томоохон гэрээ, худалдан авалтаас гадна ИНБ, шинжээч нарыг оролцуулах, ил тод байдлыг сайжруулах зэрэг

асуудлыг хөндөж амлалт өгч болно.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Чат хэсэг: Хүртээмжтэй байдал ба түүний зарчмыг орон нутгийн байгууллагад боломж олгохыг хэлж байна гэж ойлгодог. Гэтэл худалдан авалтын өндөр шаардлагыг дагаад гүйцэтгэх ажлыг зөвхөн том компаниуд эсвэл гадаад компаниуд авдаг. Орон нутгийн компанид боломж хомс, хүнд нөхцөлд бага үнэлэмжээр гэрээт гүйцэтгэгчээр ажиллах л сонголт үлддэг.

Нээлттэй засгийн түншлэлийн Ази Номхон далайн бүсийн удирдагчийн үүрэг гүйцэтгэгч Айвигейл Онг:

Энэ асуудлыг Ажлын хэсэг төлөвлөгөө боловсруулах явцад анхаарах нь зөв байх аа.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Коммент үргэлжилж байна. Техникийн дэмжлэг авах үүднээс ОУБ-ыг оролцуулах нь зөв.

Нэмэлт асуулт ирээгүй тул өнөөдрийн вебинарыг дуусгахад бэлэн боллоо. Цаг зав гарган оролцсон та бүхэнд баярлалаа. Өнөөдөр Айвигейл Онгын танилцуулсан НЗТ-ийн 2023-2028 оны стратегийг ХЭХҮХ-ны Ажлын алба Монгол хэлруу хөрвүүлэн бэлдсэн файл, Ажлын хэсгийн ажлын хуваарь зэрэг холбоогдох мэдээллийг цахимаар хүргэх болно.

Вебинар 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 10.35 цагт өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
2024-2027 ОНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.НОМИНЧИМЭГ

Вебинарын зураг



OGP's
2023-2028
Strategy
Open
Government
Partnership

Nyampurev Galsa...
Urantsooj Gombo...
Bilguun (Nest)
Khaliungoo Ganbat
Tsend-Ayush Dorj...

www.irgen-tur.mn вебсайт дээр нийтэлсэн мэдээлэл

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТ БОЛОВ

25 Oct 2023 share

Монгол Улс Нээлттэй засгийн түншлэлд 2013 онд нэгдсэнээс хойш Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг дөрвөн удаа хэрэгжүүлжээ. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөөний төсөл боловсруулж танилцуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлсан. Ажлын хэсгийн гишүүдэд Нээлттэй засгийн түншлэлийн тухай танилцуулах вебинарыг цахимаар 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Нээлттэй засгийн түншлэлийн Ази Номхон далайн бүсийн удирдагчийн үүрэг гүйцэтгэгч Айвигейл Онг, Хараат бус тайлагнах механизмын судалгааны мэргэжилтэн Сара Жэйкобс нар төлөвлөгөөг боловсруулах явцад анхаарах зүйлс, шинээр батлсан стратегийн агуулга, хараат бус тайлагнах механизмын талаар мэдээлэл хүргэлээ. Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сарын 11-нд эцэслэн танилцуулах хуваарьтай ажиллаж байна.

Татаж авах файлууд:
МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 2024-2027 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН
МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 2024-2027 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХУВААРЬ

OPEN GOVERNMENT PARTNERSHIP INTRODUCTORY WEBINAR

25 Oct 2023 share

Since Mongolia joined the Open Government Partnership (OGP) in 2013, the National Action Plan (NAP) has been implemented four times. By order of the Minister of Mongolia and the Chief Cabinet Secretary, the composition of the Working Group to draft and present the OGP 2024-2027 NAP V draft of Mongolia was approved. An online webinar to introduce the OGP to members of the Working group was held on October 25, 2023. At the event, Ivygale Ong - Acting Regional Lead of Asia Pacific and Sara Jacobs -Independent Reporting Mechanism (IRM) Research Officer provided information on the issues to consider during the development of the plan, the content of the newly adopted strategy, and the IRM. The OGP 2024-2027 NAP V draft of Mongolia is scheduled to be presented on December 11, 2023.

Download files:
COMPOSITION OF THE WORKING GROUP TO DRAFT AND PRESENT THE OPEN GOVERNMENT PARTNERSHIP 2024-2027 NATIONAL ACTION PLAN V OF MONGOLIA
WORK SCHEDULE FOR WORKING GROUP

Вебинарыг онлайнаар үзэх линк: https://youtu.be/fFzopbmtqc0?si=xhsdd7k6kv3Clsvn



Нээлттэй засгийн түншлэл - Цахим вебинар 2023.10.25

Хүний эрхийг хангах Үндэсний хороо
11 subscribers
Subscribe
0 Share Download Clip Save

7 views Nov 8, 2023
НЗТ-ийн Аэи Номхон далайн бүсийн удирдагчийн үүрэг гүйцэтгэгч Айви Онг, НЗТ-ийн Судалгааны мэргэжилтэн Сара Жэйкобс нарын Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулах цахим вебинарыг Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулав.

Хүний эрхийг хангах Үндэсний хороо
11 subscribers

Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны Үндэсний V төлөвлөгөөний төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

№	Төлөөлөл	Гишүүн	Холбоо барих цахим хаяг
1	Төрийн байгууллагын төлөөлөл	Б.Баасандорж (Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга)	baasandorj@ags.gov.mn
2	Төрийн байгууллагын төлөөлөл	Б.Болорсайхан (Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга)	Bolorsaikhan@cabinet.gov.mn
3	Төрийн байгууллагын төлөөлөл	Ч.Болортуяа (Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх)	Bolortuya@pmo.gov.mn
4	Төрийн байгууллагын төлөөлөл	Ч.Ундрахбаяр (Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх)	Undrakhbayar@pmo.gov.mn
5	Төрийн байгууллагын төлөөлөл	Ч.Ариунхур (Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх)	Ariunkhur@ags.gov.mn
6	Төрийн байгууллагын төлөөлөл	Д.Ган-Эрдэнэ (Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч)	Gan-erdene@ags.gov.mn
7	Төрийн байгууллагын төлөөлөл	Б.Анар (Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач)	Bayarsaikhan.anar@gmail.com
8	Төрийн байгууллагын төлөөлөл	Л.Балчинлувсан (Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга)	Balchinluvsan.l@mrpam.gov.mn
9	Төрийн байгууллагын төлөөлөл	М.Санжаадорж (Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга)	Sanjaadorj_m@mof.gov.mn
10	Төрийн байгууллагын төлөөлөл	Э.Энхтуяа (Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга)	Enkhtuya@mojha.gov.mn

11	Төрийн байгууллагын төлөөлөл	Б.Золбоо (Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын Хүний эрхийн хэлтсийн дарга)	Dep09-03@mfa.gov.mn
12	Төрийн байгууллагын төлөөлөл	П.Оюунаа (Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга)	Oyunaa@mecs.gov.mn
13	Төрийн байгууллагын төлөөлөл	Ц.Болорчулуун (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга)	Bolorchuluun@mofa.gov.mn
14	Төрийн байгууллагын төлөөлөл	М.Мэндбаяр (Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга)	Mendbayar@mmhi.gov.mn
15	Төрийн байгууллагын төлөөлөл	Б.Буяннэмэх (Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга)	Bnnmkh@gmail.com
16	Төрийн байгууллагын төлөөлөл	Б.Билэгдэмбэрэл (Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга)	Bilegdemberel@mddc.gov.mn
17	Төрийн байгууллагын төлөөлөл	О.Номинчимэг (Нийслэлийн Засаг даргын Нийгмийн бодлого, байгаль орчин, агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч)	Nominchimeg.odsuren@outlook.com
18	Төрийн байгууллагын төлөөлөл	Л.Баярмандал (Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)	Bayarmandal.l@mrpam.gov.mn
19	Төрийн байгууллагын төлөөлөл	Ш.Энхтуяа (Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)	Enkhtuya@mmra.gov.mn
20	Төрийн байгууллагын төлөөлөл	Х.Эрдэм-Ундрах (Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн захирал)	Erdemundrakh@legalinstitute.mn

21	Төрийн байгууллагын төлөөлөл	Ц.Батзул (Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга)	Batzul@spa.gov.mn
22	Төрийн байгууллагын төлөөлөл	Н.Дабааням (Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн дарга)	Davaanyam@11-11.mn
23	Төрийн байгууллагын төлөөлөл	Д.Цэнд-Аюуш (Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар)	Tsend-ayush@iaac.mn
24	Төрийн байгууллагын төлөөлөл	О.Энхзул (Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга)	Enkhzul@cabinet.gov.mn
25	Төрийн байгууллагын төлөөлөл	Х.Энхбат (Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга)	Enkhbat.kh@gmail.com
26	Төрийн байгууллагын төлөөлөл	Б.Дөлгөөн (“Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв” УТҮГ-ын захирал)	Dulguun@nrpa.gov.mn
27	Төрийн байгууллагын төлөөлөл	Д.Номинчимэг (Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн)	Nchr@cabinet.gov.mn
28	Төрийн байгууллагын төлөөлөл	С.Баясгалан (Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга)	Bayasgalan.saranjav@gmail.com
29	Нээлттэй засгийн түншлэл	Л.Төр-Од (“Нээлттэй засаглалын түншлэл”-ийн олон улсын элч төлөөлөгч)	Turod2030@gmail.com
30	Шинжээч	О.Хатанболд (Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, доктор)	Khatanboldo@gmail.com
31	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Д.Бумдарь (Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор, доктор, “Стратеги академи” ТББ-ын захирал)	Bumdari.dagvaochir@gmail.com
32	Олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөл	Э.Мөнхжаргал (“Транспэрэнси Интернешнл Монгол”	Munkhjargal@transparency.mn

		ТББ-ын гүйцэтгэх захирал)	
33	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Б.Төрболд (“Оюуны-Инноваци” ТББ-ын гүйцэтгэх захирал)	Turbold.tr@gmail.com
34	Олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөл	Г.Халиунгоо (Азийн сангийн Хотын засаглалтыг сайжруулах төслийн менежер)	Khaliungoo.ganbat@asiafoundation.org
35	Олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөл	Э.Баасансүрэн (Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Хөтөлбөрийн ажилтан)	Baasansuren@iri.org
36	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Н.Наранцэцэг (“Байгаль эхийн аврал сан” ТББ-ын тэргүүн)	Naraa_green@yahoo.com
37	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Б.Амарзаяа (“Бодлогод залуусын хяналт” ТББ-ын гүйцэтгэх захирал)	Amarzaya.tumurbaatar@gmail.com
38	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Ч.Энхбаяр (“Глоб Интернэшнл төв” ТББ-ын гүйцэтгэх захирал)	Enkhbayar@globeinter.org
39	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Д.Жаргалсайхан (“Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын тэргүүн)	Tserendulam@gund.mn
40	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Г.Нямпүрэв (“Залуус эрүүл мэнд төв” ТББ-ын хөтөлбөрийн менежер)	G.nyampurev@gmail.com
41	Төрийн бус байгууллагын төлөөлөл	О.Нурболат (Монголын Казахуудын хэл, соёлыг дэмжих холбооны захирал)	Nurbolat.bu@gmail.com
42	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Х.Оюунцэцэг (Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн)	Khurts.oyuntsetseg@gmail.com
43	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Ш.Ариунаа (“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн)	Ariunaa.shag@gmail.com
44	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Д.Оюунбадам (“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер)	Oyunbadam@forum.mn
45	Төрийн бус байгууллагын төлөөлөл	С.Оюунтуяа (“Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын гүйцэтгэх захирал)	Oyunasu5@gmail.com
46	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Б.Дуламхорлоо (“Сэтгүүл зүйн	Duuya@nestmongolia.org

		инновац хөгжлийн үүр төв” НҮТББ-ын гүйцэтгэх захирал)	
47	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Э.Тунгалаг (“Тунгаахуй өгөгдлийн урлан” ТББ-ын гүйцэтгэх захирал)	Tungalag@tungaahui.mn
48	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Ч.Отгонбаатар (“Хил хязгааргүй хуульчид” ТББ-ын захирал)	Otgonbaatar@mongolianlawyers.com
49	Төрийн бус байгууллагын төлөөлөл	С.Амармэнд (“Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ-ын Судалгааны хорооны дарга)	Sainbayaramarmend@gmail.com
50	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Г.Уранцоож (“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн)	Gurantsooj@rocketmail.com
51	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Ц.Тамир (“Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” ТББ-ын гүйцэтгэх захирал)	Tamiraa.ts@gmail.com

___oOo___

МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 2024-2027 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХУВААРЬ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн	Хугацаа
1	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Нээлттэй засгийн түншлэлийг танилцуулах вебинар зохион байгуулах	Ажлын алба	2023.10.25
2	Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны Үндэсний V төлөвлөгөө боловсруулахад хэрэгцээтэй мэдээллийг ажлын хэсгийн гишүүдэд хүргэх	Ажлын алба	2023.10.25
3	Ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг зохион байгуулах	Ажлын алба	2023.11.09
4	Анхдугаар хуралдаанаас гарсан шийдвэр, өөрчлөлт, сайжруулалтыг төлөвлөгөөний төсөлд тусган Ажлын хэсгийн гишүүдэд илгээх	Ажлын алба	2023.11.10
5	Ажлын хэсгийн хоёрдугаар хуралдааныг зохион байгуулах	Ажлын алба	2023.11.16
6	Хоёрдугаар хуралдаанаас гарсан шийдвэр, өөрчлөлт, сайжруулалтыг төлөвлөгөөний төсөлд тусган Ажлын хэсгийн гишүүдэд илгээх	Ажлын алба	2023.11.17
7	Ажлын хэсгийн гуравдугаар хуралдааныг зохион байгуулах, Хэлэлцүүлэг зохион байгуулах	Ажлын алба	2023.11.23
8	Гуравдугаар хуралдаанаас гарсан шийдвэр, өөрчлөлт, сайжруулалтыг төлөвлөгөөний төсөлд тусган эцэслэн боловсруулах	Ажлын алба	2023.11.24
9	Төлөвлөгөөний төслийг Нээлттэй засгийн Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах	Ажлын алба	2023.11.30

___oOo___

Албан бус орчуулга

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 2023-2028 ОНЫ СТРАТЕГИ

Open Government Partnership

БИДНИЙ АЛСЫН ХАРАА БОЛ НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ГАЗРУУД ИРГЭНИЙ НИЙГЭМ, АРД ИРГЭДТЭЙГЭЭ ХАМТРАН АЖИЛЛАСНААР АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЖ, НИЙГМИЙН САЙН ҮР ДҮНГ АВЧРАХ ЮМ.

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО БОЛ ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ШИНЭТГЭГЧ, ТЭМЦЭГЧ НАРЫГ ЗОРИГЖУУЛАХ, ХОЛБОХ, ОЛОН НИЙТИЙГ ӨСӨН НЭМЭХ БОЛОМЖООР ХАНГАХАД ОРШИНО.

Стратегийн зорилт 1

Нээлттэй засгийн шинэтгэгч, активист, тэмцэгч нарыг багтаасан өсөн нэмэгдэх, тууштай, харилцан уялдаатай олон нийтийг бий болгох

- Нээлттэй засгийн төлөө илүү хүчирхэг, улс төрийн шинжтэй дэлхийн нийтийн эвслийг байгуулах
- Шинэтгэгч нарын манлайллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийх
- Нээлттэй засгийн зарчмыг бататгахын тулд стратегийн холбоо, түншлэлийг өргөжүүлэх

Стратегийн зорилт 2

Төрийн бүх түвшинд, салбарууд тэргүүлэх ажлыг хэрхэн хэрэгжүүлэх дээр нээлттэй засгийг төвлөрүүлэх

- Олон төрлийн орчин, хэрэгцээнд тохирсон уян хатан үйл ажиллагааны хүрээгээр хангах
- Нээлттэй засгийн үйл ажиллагааг бүх түвшинд, төрийн ажлын салбаруудад голлон дэмжих
- Улс төрийн боломжит “цонх” гарахад хариу үйлдэл сайн байх

Стратегийн зорилт 3

Иргэний нийгмийн орон зайг хамгаалах, тэлэх

- Иргэний нийгмийн орон зайн үйл ажиллагааг дэмжиж, тэмцэгч нарыг хөгжүүлэх
- Иргэний нийгмийн орон зайн талаарх Нээлттэй засгийн түншлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтмол хянах

Стратегийн зорилт 4

Нээлттэй засгийн шинэчлэлийн хамтын үйл явцыг эрчимжүүлэх

- Ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо, хүртээмжийн шаардлагыг нэмэгдүүлэх
- Хамтын тэргүүлэх үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах уриалгыг эхлүүлэх



Стратегийн зорилт 5

Нээлттэй засгийн шинэчлэл, нотолгоо, түүхийг өгүүлэн зоригжуулах нутаг орон болох

- Өндөр чанартай контентыг хөгжүүлэх, хадгалах, хуваалцах
- Хүмүүст түүхээ хуваалцах, холбогдох орон зайг бий болгох

Хуудас 4
Оршил ба Орчин нөхцөл →

Хуудас 6
Алсын хараа ба Эрхэм зорилго →

Хуудас 8
Стратегийг боловсруулах үйл явц →

Хуудас 10
Стратеги: Зорилго ба Өөрчлөлтийн онол →

Стратегийн зорилт 1
Хөдөлгөөн байгуулах

Стратегийн зорилт 2
Нээлттэй засгийн нөлөө

Стратегийн зорилт 3
Иргэний орон зайг хамгаалах, тэлэх

Стратегийн зорилт 4
Хамтын хөгжил

Стратегийн зорилт 5
Урам зориг, шинэлэг санаа

Хуудас 31
Засаглал ба Манлайлал
Хуудас 33
Баялгийг ашиглах арга барил
Хуудас 35
Хэрэгжүүлэх арга барил
Хуудас 36
Суралцах арга барил

ОРШИЛ БА ОРЧИН НӨХЦӨЛ

Нээлттэй засгийн түншлэл (НЗТ)-г 2011 онд Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд хамтран хүнд хэцүү сорилтуудад анхаарлаа хандуулан ажиллах шинэ арга замыг эрэлхийлж байгуулсан юм. Анх үүсгэн байгуулсан гол санаа нь Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага, ард иргэд хоорондоо нягт хамтран ажиллах, инновацыг дэлхий дахинд хуваалцах, нээлттэй засгийн тодорхой болон хэмжигдэхүйц үйл ажиллагааг хэрэгжүүлж уралдах, зөвхөн эрх мэдэлтэй нь биш, харин бүх хүний төлөө ажиллахад нь Засгийн газарт туслах явдал байлаа.

НЗТ нь эхний арван жилд 200 орчим үндэсний болон орон нутгийн Засгийн газар, 1000 орчим иргэний нийгмийн байгууллагуудыг элсүүлж өргөжсөн. Сүүлийн арван жилийн хугацаанд үндсэн загвар үр дүнгээ өгдөг болохыг харуулсан.

НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг зохиох, хэрэгжүүлэх явцад иргэний нийгмийн байгууллага оролцсоноор амлалтууд илүү амбицтай, сайн хэрэгждэг, төрийн хэрэгт өөрчлөлтийг бий болгож, ард иргэдийн хувьд илүү сайн үр дүнг авчирдгийг харуулсан. НЗТ-ийн Бие даасан тайлагнах механизм (БДТМ) нь 500 орчим НЗТ-ийн амлалт Засгийн газруудыг нээж өгсөн болохыг тогтоожээ.

НЗТ-ийн олон нийт өсөн нэмэгдэж, чухал үр дүнд хүрэхийн хэрээр уур амьсгалын өөрчлөлт, зөрчилдөөн, тэгш бус байдал, дэлхий дахиныг нөмөрсөн цар тахал зэрэг тогтолцооны сорилтуудыг даван туулахын зэрэгцээ ардчиллаас ухарсан урт хугацааг бид мөн туулжээ. Захиргаадалтыг дэмжигч, популист удирдагчид иргэний нийгмийн орон зайг хязгаарлах, онлайнаар ташаа мэдээлэл түгээх, хүний эрх рүү дайрахыг оролдсон. Авлига нь ардчилсан эрх чөлөөг сулруулах гэсэн эдгээр хүчин

чармайлтын үндэс болж, нийгэмд тулгарч буй сорилт бэрхшээлүүдийг улам дордуулдаг. НЗТ-ийн хамт олон засгийн газруудыг илүү нээлттэй, хариу үйлдэл хурдан, эгэх хариуцлагатай болгохын тулд шинэ санаа дэвшүүлж, хамтдаа суралцаж байгаа ч эрх мэдлийг бэхжүүлж, засгийн газруудыг хаалттай байлгах хүчин чармайлт давхар гарсаар байна.

НЗТ найдвар тээсэн хувилбарыг төлөөлдөг. НЗТ-ийн олон нийт нь өөрчлөлт хийхийг хичээж буй мянга мянган няцашгүй, бүтээлч, зоримог анхдагчид, шинийг санаачлагчид, бие сэтгэлээ зориулсан шинэтгэгч нараас бүрддэг. Улс орнууд ашиг хүртэгчийн өмчлөх эрхийг ил тод болгох, нээлттэй гэрээ байгуулах зэрэг авлигын эсрэг өргөн цар хүрээтэй арга хэмжээг нааштай хүлээн авч байна. Олон нийтийн оролцооны шинэлэг арга барил нь дэлхий даяар бодлого боловсруулах хүрээнд илүү түгээмэл болж, тэр ч байтугай үл итгэгчид хүртэл хүлээн зөвшөөрч байна.

Түүнчлэн сүүлийн үед түүхэндээ тохиож байгаагүй ардчиллыг хамгаалах хөдөлгөөн өрнөж байна. Популистууд болон захиргаадалтыг дэмжигч нар бусад бүлэглэлээс илүү эрх мэдлээ хадгалан барьж чадахаа больж сонгууль түүхэнд хэзээ ч ийм өрсөлдөөнтэй явагдаж байсангүй. Украин зэрэг улсууд гадаад, дотоод туйлын аюул заналхийлэлтэй тулгарсан ч ардчилал нугаршгүй байж болохыг нотолж байна.

Энэхүү Стратегийн олгож буй боломж нь НЗТ эерэг энергийг удаан хугацааны бодлогын өөрчлөлтөд шингээж, одоогийн болон ирээдүйн сорилт бэрхшээлүүдийг даван туулахад ашиглах явдал юм. Стратегийг дэлхийн өнцөг бүрийн олон мянган хүмүүсийг хамарсан НЗТ-ийн түүхэн дэх хамгийн цогц нийгмийн оролцооны үйл явцаар боловсруулсан. Үүний үр дүнд НЗТ нь иргэдийн хүлээлтэд нийцсэн илүү нээлттэй, ардчилсан засгийн газарт зориулсан тодорхой үйл ажиллагаа, шинэчлэл, санаануудад үндэслэн илүү улс төрийн, үнэт зүйлс дээр тулгуурласан түншлэл бий болгох шинэчилсэн алсын хараатай болж байна.

АЛСЫН ХАРАА БА ЭРХЭМ ЗОРИЛГО

Нээлттэй засгийн арга барилын хувьд:

- Хүн бүр өөрийн амьдралд нөлөөлөх Засгийн газрын үйл явц, шийдвэрийн талаар холбогдох, ашиглах боломжтой, цаг үеэ олсон мэдээлэл авах.
- Хүн бүр өөрийн амьдралд нөлөөлөх төрийн бодлого, шийдвэрийг төлөвшүүлэхэд чөлөөтэй, тэгш боломжоор оролцох.
- Хууль дээдлэх ёсыг дэмжихгүй, эрхийг нь хүндэтгэхгүй, эсвэл хэрэгцээ нь хангагдахгүй үед хүн бүр эрсдэл эсвэл хор хөнөөл учруулахгүйгээр засаж залруулахыг эрэлхийлэх эрх чөлөө, хууль ёсны эрх мэдэлтэй. Төрийн албан хаагчид шийдвэр, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээдэг.
- Төрийн нөөцийг ил тодоор, шударгаар, үнэнээр зарцуулах.
- Засгийн газрууд иргэний нийгэм, академи, хувийн хэвшлийн болон бусад хүмүүстэй хамтран нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шинэлэг, тогтвортой шийдлийг олж хэрэгжүүлэх.
- Ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо, хүртээмжийг бүх шатны төрийн байгууллагын соёл, практикт шингээх.

Эхний арван жилийн хугацаанд НЗТ-ийн алсын хараг хэрэгжүүлэх үндсэн зам нь үндэсний болон орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд шинэчлэлийн амлалтуудыг хамтран бий болгох явдал байлаа. НЗТ-ийн арга барил нь улс төрийн өндөр түвшний удирдлага болон амлалтыг хадгалах, шинэтгэгч нарын дунд солилцоог өрнүүлэх, тэднийг техникийн мэдлэг ба нотолгоогоор дэмжих, гишүүдийг ХБТМ-аар дамжуулан эгэх хариуцлага хүлээхэд гол анхаарлаа хандуулсан. НЗТ-ийн олон нийт энэ аргачлалаар дамжуулан агуу амжилтад хүрч чадсан ч хамтдаа илүү ихийг хийх боломж байна.

Энэхүү Стратеги нь дээрх ололт амжилт дээр суурилан өсөн нэмэгдэж байгаа шинэтгэгч нар буюу өдөр тутмын ажилдаа нээлттэй засгийг өөрчлөн нэвтрүүлж байдаг улс төрийн удирдагчид, иргэний нийгмийн байгууллагууд, нийгмийн хөдөлгөөнүүд, бизнесийн манлайлагчид, сэтгүүлчид, төрийн албан хаагчдаас урт хугацааны өөрчлөлт гарах ёстой гэж үздэг. Ингэж арга барилыг өөрчлөхийг шаардсанаар НЗТ-ийн олон нийт эдгээр шинэтгэгч болон манлайлагч нараас илүү хүчтэй хөдөлгөөнийг дэлгэрүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх юм. Тэд өөрчлөлтийг өдөөж НЗТ-ээр дамжуулах буюу түүнээс ч илүү үйлдэл хийгээд зогсохгүй хүмүүсийг засгийн газрынхаа гол цөм болгох хүчин чармайлтыг нь дэмждэг байна.

БИДНИЙ АЛСЫН ХАРАА БОЛ НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ГАЗРУУД ИРГЭНИЙ НИЙГЭМ, АРД ИРГЭДТЭЙГЭЭ ХАМТРАН АЖИЛЛАСНААР АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЖ, НИЙГМИЙН САЙН ҮР ДҮНГ АВЧРАХ ЮМ.

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО БОЛ ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ШИНЭТГЭГЧ, ТЭМЦЭГЧ НАРЫГ ЗОРИГЖУУЛАХ, ХОЛБОХ, ОЛОН НИЙТИЙГ ӨСӨН НЭМЭХ БОЛОМЖООР ХАНГАХАД ОРШИНО.

НЗТ-ИЙН ИРЭЭДҮЙГ ХАМТДАА БҮТЭЭХ НЬ

2022 оны 5-8 дугаар сар

Олон нийтийн дунд өрнөсөн яриа

- НЗТ-ийн ирээдүйн тухай олон нийтийн дунд өрнөсөн яриа
- НЗТ-ийн вэбсайт дээрх нээлттэй хэлэлцүүлэг
- Оролцогч талуудын судалгаа

2022 оны 8-11 дүгээр сар

Стратеги боловсруулах

- Олон нийтийн ярианы хураангуй
- НЗТ-ийн загвар, стратегийн талаар олон нийтийн зорилтот яриа
- НЗТ-ийн вэбсайт дээрх нээлттэй хэлэлцүүлэг

2022 оны 11 дүгээр сар-2023 оны 3 дугаар сар

Үйл ажиллагааг эцэслэх ба Эхлүүлэх

- НЗТ-ийн стратегийн төсөл дээр санал авах
- НЗТ-ийн Удирдах хорооноос батлагдсан эцсийн стратеги

СТРАТЕГИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Стратеги нь жилийн турш өрнөсөн зөвлөлдөх үйл явцын үр дүн бөгөөд түүнийг тодорхойлоход гурван үе шатыг хамарсан

а) НЗТ-ийн гүйцэтгэж болох ач холбогдол, хувь нэмэр, хамгийн их нөлөө бүхий үүрэг;

б) илүү их нөлөө үзүүлэхийн тулд тодорхой загвар, стратеги, тэргүүлэх зүйлс;

в) Стратегийг хэрэгжүүлэх арга замууд.

1 ЖИЛИЙН
ЗӨВЛӨЛДӨХ ҮЙЛ ЯВЦ

1000
ГАРУЙ ХУВЬ НЭМЭР

Хувь хүн, байгууллага, эвсэл, НЗТ-ийн гишүүд болон олон талт оролцогч нараас төрөл бүрийн суваг буюу онлайн зөвлөлдөх платформ, зайн болон биечлэн уулзалт, НЗТ-ийн бүсийн үйл ажиллагаагаар дамжуулан 1000 гаруй хувь нэмэр оруулах мэдээлэл хүлээн авсан нь үйл явцын туршид төсөл дээр бүх тал санал бодлоо илэрхийлэх хэлбэр байлаа. НЗТ-ийн Удирдах хороо, Дэмжих нэгжийн зорилго нь уг үйл явцыг НЗТ-ийн оролцоо, хамтын бүтээлийн стандартад нийцүүлэхэд чиглэсэн байв.

Зөвлөлдөх санал асуулгын эхний шатнаас гарсан ололтууд нь ач холбогдол, хувь нэмэр, үр нөлөө дээр төвлөрсөн байсан нь шинээр гарч ирж буй стратегийн зарим чиглэлүүдийг хөгжүүлэхэд хүргэсэн юм. Эдгээр чиглэлийг батлахын тулд хоёр дахь шатанд цаашид зөвлөлдөж, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой санаа авахаар болсон байна. Эдгээр хувь нэмэр нь хоёр сарын хугацаанд олон нийтийн санал бодлоо илэрхийлэх зорилгоор нэгдсэн Стратегийн төслийг цогцлоосон юм. Дээрх үе шатуудаар хүлээн авсан санал хүсэлт нь энэхүү эцсийн стратегид тусгагдсан.

Үйл явцын загвар, цар хүрээний талаар, ирүүлсэн санал бодлыг эцсийн Стратегийг хэрхэн боловсруулсан талаар, мөн энэ үйл явцын сургамжийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг үе шат бүрийн төгсгөлийн тайлан мэдээллээс уншиж болно.

СТРАТЕГИ: ЗОРИЛГО БА ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛ

2011 оноос хойш НЗТ нь Засгийн газрыг илүү ил тод, эгэх хариуцлагатай, оролцоотой, хүртээмжтэй болгохын тулд суурь үнэт зүйлс болон зарчмуудаа ахиулахад анхаарч ирсэн. 2023-2028 оны стратегидаа эдгээр үнэт зүйлс болон зарчмууд дээр тулгуурлан харилцан бэхжүүлсэн таван зорилтыг хэрэгжүүлэх болно. Үүнд:

1. Нээлттэй засгийн шинэтгэгч, активист, тэмцэгч нарыг багтаасан өсөн нэмэгдэх, тууштай, харилцан уялдаатай олон нийтийг бий болгох.

2. Төрийн бүх түвшинд, салбарууд тэргүүлэх ажлыг хэрхэн хэрэгжүүлэх дээр нээлттэй засгийг төвлөрүүлэх.

3. Иргэний нийгмийн орон зайг хамгаалах, тэлэх.

4. Нээлттэй засгийн шинэчлэлийн хамтын үйл явцыг эрчимжүүлэх.

5. Нээлттэй засгийн шинэчлэл, нотолгоо, түүхийг өгүүлэн зоригжуулах нутаг орон болох.

Эдгээр зорилтуудыг цогц байхаар бүтээсэн бөгөөд НЗТ-ийн олон нийт дахь хүн бүр өөрийн гүйцэтгэх үүрэгтэй мөн орчинд нь тохирсон хэрэгжүүлэх стратегитай байхаар зохиосон юм. Тухайлбал, улс төр болон төрөөс нээлттэй засгийг дэмждэг орчинд эсвэл шинэчлэл хийх боломжийг олгох үед засгийн газар болон иргэний нийгэм дэх шинэтгэгч нарын чадамж, чадварыг дээшлүүлэх арга барилыг ашигласнаар тэд улс төрийн үүрэг, амлалтыг үйл ажиллагаанд хөрвүүлж, засгийн газрын нээлттэй арга барилыг урт хугацаанд шигтгэж чадах юм. Удаашрах, улс төрийн хүсэл зорилго буурах эсвэл иргэний нийгмийн орон зай хумигдах нөхцөлд энэ арга нь шинэтгэгч нарын чадамж, чадварыг дээшлүүлэхээс гадна үнэ цэнтэй үнэмшил төрүүлэхүйц төлөвлөгөөг гаргах, цаашид ахиц дэвшил гаргаж чадахаар өөр нэвтрэх цэгийг олох, харилцан яриа өрнүүлэх орон зайг хамгаалах, мөн шинэчлэлийн эргэлтээс сэргийлэх болно.

НЗТ-ийг зохиосон суурь зарчмууд нь стратегийн зорилтууд дээр цаашид тулгуурлахаас гадна эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх талаар хувьсал үүсэж болно.

Засгийн газрын шинэтгэгч нар иргэний нийгмийн байгууллагатай хамтран илүү амбицтай, үр нөлөөтэй шинэчлэлийг заагварчилдаг. НЗТ-ийн гэрэл зураг

Үйл ажиллагаанд чиглэсэн: НЗТ нь үйл ажиллагааны платформ юм. Тэнд бүх гишүүд тодорхой, Нээлттэй засгийн амлалтуудыг бүтээж, хэрэгжүүлдэг. Дараа нь БДТМ болон бусад байгууллагууд хяналт тавьдаг.

НЗТ-ийг Загварчилсан Зарчмууд

Үйл ажиллагаанд чиглэсэн: НЗТ нь үйл ажиллагааны платформ юм. Тэнд бүх гишүүд тодорхой, Нээлттэй засгийн амлалтуудыг бүтээж, хэрэгжүүлдэг. Дараа нь БДТМ болон бусад байгууллагууд хяналт тавьдаг.

Уян хатан боловч амбицтай: Гишүүд өөр өөр эхлэх цэгтэй ч бүгд одоогийн практикаас илүүг хийж, тасралтгүй сайжрахыг хичээх болно.

Бодит түншлэл: НЗТ нь илүү сайн үр дүнд хүрэхийн тулд төр, иргэний нийгмийн байгууллага хамт ажилладаг мөн хамтран манлайлдаг хүчин чармайлт юм. Ингэснээр иргэний нийгмийн байгууллага, ард иргэд шинэчлэлийг бүрэлдүүлж, хэрэгжүүлэхэд тусалж, Засгийн газрыг дэвшил гаргах, эгэх хариуцлагатай байхыг шаардах юм.

Улс орны эзэмшил: НЗТ нь дэлхий нийтийн санаачилгын хувьд иргэдэд хандах төр засгийн хариуцлагыг мушгин гуйвуулах биш, харин бэхжүүлэх зорилготой.

Инновац ба солилцоо: Нээлттэй засгийн хамгийн сайн практикт ямар ч улс орон эсвэл бүс нутагт монопол гэж байдаггүй. Хүн бүрд хуваалцах, сурах зүйл байдаг.

Хүртээмж: Дэлхийн, үндэсний, орон нутгийн түвшинд НЗТ бүтэц болон засаглалд хүйс, арьс өнгө, үндэс угсаа, газар зүйн байршил эсвэл нийгэм эдийн засгийн байдлаас шалтгаалан өмнө нь дутуу төлөөлөгддөг байсан хүмүүсийг оруулахыг дэмжих зорилготой. НЗТ нь бүх гишүүдэд тодорхой амлалт өгч НЗТ-ийн үйл явц болон амлалтыг урагшлуулах, хүртээмжийг гол зүг чигээ болгохыг уриалдаг.

Энэ стратегийг үндэс болгодог өөрчлөлтийн онол нь хүмүүст хүрдэг нээлттэй засагт тогтвортой өөрчлөлт хийх хэд хэдэн чухал нөхцөлийг хүлээн зөвшөөрдөг. Эдгээр нь НЗТ-ийн өөрийн өгөгдөл, үнэлгээ болон нээлттэй засгийн талбарт өөрчлөлт хэрхэн гардаг тухай илүү өргөн цар хүрээтэй нотолгоо дээр тулгуурладаг. Стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга зам нь эдгээр нөхцөл байдалд нөлөөлөх зорилготой юм.

- **Олон нийтийн дэмжлэг:** Сонгууль, олон нийтийн кампанит ажил, нийгмийн хөдөлгөөнөөр илэрхийлэх мөн олон нийт шинэчлэлийг хүчтэй дэмжих нь улс төрийн удирдлага, төрийн үйл ажиллагаанд орчин болон эрэлтийг бий болгож, ингэснээр хувиран өөрчлөгддөг шинэчлэлийг боломжтой бөгөөд тогтвортой болгодог.
- **Иргэний орон зай**: Ард иргэд болон олон нийтийн мэтгэлцээнд утга учиртай оролцох чадварыг дэмжиж, хамгаалах хууль, практик, соёл оршин тогтнох нь ард иргэд, иргэний нийгмийн байгууллага, бусад бүлгүүдийн хувьд амбицтай, нээлттэй засгийн шинэчлэлийг үр дүнтэй дэмжих, хэрэгжүүлэхэд туслах ач холбогдолтой урьдчилсан нөхцөл юм.
- **Улс төрийн болон олон түвшний удирдлага:** Нээлттэй засгийн шинэчлэлийн ирээдүйг улс төрийн өндөр удирдлага бүрэлдүүлдэг. Нийгмийн хөдөлгөөн, иргэний нийгмийн байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагаатай уялдуулан улс төрийн удирдагчид өөр өөр боловч харилцан хамааралтай үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь хөтөлбөрийг өөрчлөх, улс төрийн боломжийг бий болгох, өөрчлөлтийг хэрэгжүүлэх, хадгалахыг хэлнэ. Нээлттэй засгийг хариуцсан нийгмийн бүх хэсгийн манлайлагч нар өөрсдийн амлалтыг хадгалж, цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөлтийг бий болгох чадвараа хөгжүүлэх ёстой.
- **Олон талт хамтын ажиллагаа:** Хамтын бүтээл нь нээлттэй засгийн гол зүрх бөгөөд илүү амбицтай, үр дүнтэй шинэчлэлийг бий болгодог. Сулавтар эвслийг оролцуулаад хамт ажиллаж буй бүх хүмүүс цаг хугацаа өнгөрөхийн хэрээр Засгийн газрын бодлого, практик, соёлд чухал мөн тогтвортой өөрчлөлт гаргаж чаддаг. Утга учиртай оролцоотой, нөлөө бүхий хүмүүсийг ихэсгэх нь нээлттэй засгийн өөрчлөлтийн гол хөшүүрэг болдог
- **Олон улсын дэмжлэг ба солилцоо:** Гадны оролцогчид үндэсний болон орон нутгийн өөрчлөлтийг удирддаггүй ч гэсэн дотоодын хүчин чармайлтыг дэмжиж нээлттэй засгийг илүү сэтгэл татам мөн магадлалтай болгодог өргөн цар хүрээтэй нөхцөл байдалд хувь нэмрээ оруулдаг. Олон улсын тавцан, стандарт, арга хэмжээний нэг хэсэг байх нь нээлттэй засгийн амлалтыг бий болгож, дэмжлэг үзүүлэхэд тусалдаг. Бусад орчны удирдагчид болон шинэтгэгч нартай холбогдох, одоогийн нөхцөлөөс суралцах, бусдаас урам зориг авах нь энэ ажилд үндэсний болон орон нутгийн удирдагчдыг дэмжин тусалж чадна.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1:

Нээлттэй засгийн шинэтгэгч, активист, тэмцэгч нарыг багтаасан өсөн нэмэгдэх, тууштай, харилцан уялдаатай олон нийтийг бий болгох

НЗТ-ийн хамгийн том хүч чадал бол нээлттэй засгийн шинэтгэгч, активист, тэмцэгч нарыг бүрдүүлдэг олон нийт юм. 2011 онд Засгийн газар, иргэний нийгмийн удирдагчдын жижиг бүлэг байгуулагдсанаас хойш НЗТ-ийн олон нийт илүү том, олон талын төлөөлөлтэй болсон.

Тэгээд нэг гадны санал болгосон юмыг дуурайж явж байгаа юм шиг ийм сэтгэгдэл төрчих вий. Үндсэн хуулийн зорилготой нийцүүлэх ажиллагаа нь өөрөө жоохон төвөгтэй, тэгэхдээ энэ системийн арга гэдэг юмыг хэрэглэх юм бол боломжтой. Бид Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг нэг системийн загварт оруулсан. Тэр загварыгаа та нар сонирхвол бид товчхон танилцуулгыг дараа хийж өгч болох байх. Гол нь манай Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийг тойрсон, 2 дугаар бүлгээр тодорхойлсон гол үзэл баримтлал зарчмууд байгаа. Тэрэн дотор 14 дүгээр зүйл 15,16,17,18,19 энэ дотор ерөөсөө хамгийн гол чухал нь болбол 16 дугаар зүйл байгаа юм. 16 дугаар зүйл нь Монгол Улсын иргэн болгонд баталгаатай эдлүүлэх 18 багц эрх байгаа. Тэр эрх дотор төр захиргааны, засгийн, төрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл авах, санаа бодлоо илэрхийлэх гээд энэ түншлэлийн хүрээнд шийдэх гээд байгаа олон асуудлууд үндсэн хуулийн 10, 16 дугаар зүйлээр тодорхойлсон эрхүүдтэй шууд уялдаж байдаг. Тэгэхээр зорилгоо үндсэн хуулийн 16 дугаар зүйлтэй холбоод тодорхойлчихвол хэн хэндээ амар юм биш үү гэдгийг хэлмээр байна.

За нөгөө талаасаа Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлээр бол төрийн үйл ажиллагааны үндсэн гол зорилгыг 19.1-ээр тодорхойлсон байдаг юм. Тэгэхээр энэ түншлэлийнхээ хүрээнд 19 дүгээр зүйл дээр хийж байгаа төрийн гүйцэтгэх ёстой үүргийг 16 дугаар зүйлтэйгээ холбоод энэ 2-ын хоорондын уялдааг энэ түншлэл гэдэг юмаараа үүсгээд хийчих юм болбол Үндсэн хуулиа хэрэгжүүлдэг нэг хүчтэй механизмын тогтолцоог үүсгэчих юм биш байгаа гэсэн горьдлого байна.

За саяхан манайхан ХЭҮК-ын захиалгаар Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийг тодорхойлох, тэрэн дотор орсон үг болгоныг тодорхойлох ажил хийж байна, нийтдээ бараг мянгаад үг байгаа. Давхцалыг нь хасах юм болбол 1400 үг байгаа. Тэр 1400 үгийг тодорхойлох дээр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд байгаа 18 багц эрхийг нэгж эрхүүд рүү задлаад, жишээлбэл хүн амьд, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэж байгаа болбол хүн эрүүл орчинд амьдрах эрхтэй, хүн аюулгүй орчинд амьдрах эрхтэй гээд нэгж эрхүүд рүү задлаад тэрнийг тодорхойлох ажлыг манай сан дээр хийгдэж байгаа.

Бидний тодорхойлолт та нөхдийн энэ ажил, энэ төлөвлөгөөг боловсруулах ажилд нэлээн суурь болж болохоор байна. Тэгээд тэрнээс бас хуваалцахад бид бэлэн байна.

За тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд энэ түншлэлтэй холбоотой, энэ зорилготой холбоотой хэрэгжүүлэхэд бидний ашигладаг бүх дүрэм журам хуулиудыг бүгдээрэнг нь нийлүүлж байгаад цогцоор нь системийн шинжилгээ гэдэг юмыг хийхгүйгээр, бид ноднин тийм юм хийсэн, тэр маань тэдэн хувьтай байна гэдэг үндэслэлээр дараагийн жилийнхээ хийх ажлыг тодорхойлоход жоохон учир дутагдалтай болчих болов уу. Тэгэхээр би цаг хугацаа болдог болбол тийм системийн шинжилгээгээ хийлгээрэй гэдгийг хүсэж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

За баярлалаа, Жаргалсайхан гуай санал хэллээ.

Хэдүүлээ дэгийн дагуу 1-3 минутад багтаагаад саналаа хэлчихвэл болж байна уу, гишүүд ээ? 3,3-аар санал, асуултаа багцлаад явья.

Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор, доктор, "Стратеги академи" ТББ-ын захирал Д.Бумдарь:

Би бас өнөөдөр хүрэлцэж ирэхээ мэдээд явуулсан имэйлийг нь харсан. Тэгээд миний хувьд бол яг ижилхэн, зорилго юунд оршиж байгаа юм, энийг бид нар хийснээр Монгол Улсад ямар үр шим ирэх юм бэ гэдгийг тодорхойлох ёстой. Дээрээс нь яагаад яг Зөвлөлдөх ардчилал гэдгийг сонгосон юм бол? Мөн баялгийн сангийн асуудал яригдаж байна. Баялгийн санг ярихын тулд бид нар энэ баялгийн санг бүрдүүлж байгаа уул уурхайгаас олж байгаа мөнгө маань өөрөө дахиад зөвхөн Амнат гэдэг ч юм уу тэндээс орж ирж байгаа зүйл байгаа гэтэл тэрийгээ энд байгаа хүмүүс хэр сайн мэддэг юм, дотооддоо хэрхэн хураагдаж орж ирдэг юм гээд маш олон асуудлууд байгаа. Тэгэхээр энэ нөгөө зорилго юу юм, тэгээд яагаад энэ 4 хүрээг гаргаж ирсэн юм, энэнийхээ цаад талын хүрээг нь бүгдээрээ мэдэж байгаа юм уу гэдэг дээр би бас тодруулмаар байна.

"Бодлогод залуусын хяналт" ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Амарзаяа:

За бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Миний хувьд эхлээд хэдүүлээ НЗТ-ийн 2023-2028 оны стратегийг харах зөв байх, орчуулаад файлаар явуулчихсан байсан. Тэгэхээр 2023-2028 оны стратегийн зорилтуудыг нь харах хэрэгтэй байх гэж бодож байна. Тэгээд тэр хүрээндээ тааруулаад төлөвлөгөөгөө ярихгүй бол бид нарт ирсэн төлөвлөгөөний драфт маань өмнө нь хэрэгжүүлж амжаагүй эсвэл өнгөрсөн хугацаанд төлөвлөчхөөд хэрэгжүүлж амжаагүй ажлуудаа дараагийн жилийнхээ төлөвлөгөөнд оруулаад хийгээд явах ёстой байдаг бол энэ дээр нэмээд ярих ёстой байх. Үгүй болбол 2023-2028 оны стратегийн зорилттой нь илүү нийцүүлсэн байдлаар төлөвлөгөөгөө яривал яасан юм бэ гэж бодож байна.

НЗТ-д Монгол Улс 2013 оноос хойш нэгдээд явж байгаа, төр иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх зорилготой. Яаж иргэн, иргэний нийгмийн байгууллага, төр хамтарч ажиллах вэ гэдэг арга зүйн зөвлөгөө, заавар бүх юмыг нь өгөөд явдаг ийм түншлэлийн нэг хэсэг байгаа. Тэгэхээр Монгол Улсад иргэний нийгэм төр хоёр хамтарч ажиллах арга барил дутмаг, хоёр тийшээ харчихсан байдалтай, нэг нэгнийгээ байнга шүүмжилдэг шүү дээ. Хамтарч ажиллах, түншилж ажиллах тал дээр болбол нэлээн асуудалтай. Тэгэхээр энэ түншлэлд эвлэлдэж нэгдээд гишүүн байгаагийнхаа хувиар энэ аргачлалыг нь сайн ашиглаад, хурлаа сайн хийгээд, төлөвлөгөөгөө сайн хэрэгжүүлээд явах юм болбол уг нь ардчилалд иргэний нийгмийн орон зайг тэлэхэд нэлээн ахиц дэвшил авчрахаар, дээрээс нь төрийн ажилладаг арга барилд ч гэсэндээ нэлээн өөрчлөлтийг бий болгохоор ийм түншлэл санагдаж байгаа. Өмнөх гишүүдийг нь харахад дандаа төрийн байгууллагаас олонх нь байсан харагдаж байсан. Энэ удаад иргэний нийгмийн байгууллага, судлаачдыг олноор нь нэмж оруулсанд бол талархалтай байна. Тэгэхээр энэ стратегийн зорилтуудаа хараад төлөвлөгөөн дээрээ ярилцаад явах саналтай байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

3 хүн санал хэллээ бас асуултд тодруулаа. Стратегийг та бүхний имэйл рүү Ажлын албанаас Англи, Монгол хэл дээр явуулсан байгаа шүү.

Бид Ажлын хэсэг өөрөө хэрхэн яаж ажиллах юм бэ гэдэг хуваарь баталж

гаргасан юм. Та бүхэн рүү явуулсан тэгээд Ажлын хэсгийг байгуулсны дараагаар бид нар яг хуваарийнхаа дагуу 10 дугаар сарын 25-ны өдөр гаднын 2 экспертийг уриад цахим сургалт хийсэн. Харамсалтай нь маш цөөхөн хүмүүс оролцсон.

Бид нар зорилго, зорилтоо яривал дор хаяж ахиад 2 цаг хэрэгтэй. Яг тэн дээр 2 эксперт НЗТ-ийн төлөвлөгөөний төслийн зорилго, зорилтыг ярьсан. Хэрвээ манай ажлын хэсгийн гишүүд бүгд санал нэг байгаа болбол бид ахиад энэ 2 эксперттэй ярьж байгаад цахимаар энийг бүүр нэлээн дэлгэрэнгүй ярихад бэлэн.

Ажлын хэсэг маань өөрөө оновчтой төлөвлөгөөтэй ажиллах ёстой, зөв зохион байгуулалттай ажиллах ёстой гэж сая Жаргалсайхан хэлсэн, тэр үүднээсээ бид сургалтаа хийсэн.

За тэгээд НЗТ-ийн V төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай мэдээллийг гишүүддээ хүргэж эхний хурал болохоос өмнө та бүхэндээ хүргэсэн. Анхны хурал өнөөдөр болж байна. 09, 16, 23-ны өдөр гээд төлөвлөчихсөн байгаа юм. Та бүхэн бас саналаа хэлэхдээ Ажлын хэсэг яаж ажиллах талаар яг саяын 3 гишүүн шиг саналуудаа хэлээрэй.

Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор, доктор, "Стратеги академи" ТББ-ын захирал Д.Бумдарь:

Бичлэгийг дахин явуулж болох уу?

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Бичлэгийн дахин явуулая. Болортуяа зөвлөх саналаа хэлнэ үү.

Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа:

Бүгдээрэнд нь өдрийн мэнд дэвшүүлье.

Тэгэхээр 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг миний бие өөрөө ахалж боловсруулж байсан. За тэгээд тайлагналын үйл ажиллагаа дуусаад сая Эстонид НЗТ-ийн олон улсын глобал форум болсон. Манайхаас ЦХХХ-ны сайд Учрал төлөөлж очоод бас сайшаагдан шагнал авсан.

Өмнөх ажлын хэсгийн туршлагаас товчхон та бүхэнд дурдахад 10 дугаар сарын 25-ны өдөр төв байгууллагын маань Азийг хариуцсан бүсийн мэргэжилтнүүд анх энэ Ажлын хэсэгт орж байгаа хүмүүст зориулаад сургалт явуулсан. Ажлын хэсгээс онлайнаар имэйлээр хүргэгдсэн юм байна. Тэрийг заавал үзэх хэрэгтэй. Энэ ажлын хэсэгт орж байгаа гишүүдийн хувьд, сая Амарзаяа хэлж байна, ер нь НЗТ-ийн гол зорилго бол төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааны чухал механизмын нэг байдаг. Монголд энэ төдийлөн сайн бэхжээгүй үед бол НЗТ маш чухал үүрэг гүйцэтгэж байгаа.

Түншлэл 2011 онд байгуулагдаад Монгол Улс 2013 онд элсэж байсан санагдаж байна. Тэгээд одоо 5 дахь төлөвлөгөөгөө боловсруулах гээд явж байна. Гол зорилго бид нар аль болох ЗГ-ын үйл ажиллагааг нээлттэй ил тод болгоход оршиж байгаа. За ингэхдээ бид нар олон улсад тодорхой үүрэг амлалтуудыг өгдөг. Дэлхийн 80 орчим улс энэ түншлэлийн гишүүн бөгөөд үүрэг амлалтыг 2 жилийн хугацаатай тухайн байгууллага маань дүгнэдэг бас ХБТМ-аар тайлангууд хянагддаг. Тийм ч учраас Монгол Улсын ЗГ энэ дээр маш хариуцлагатай хандаж байсан он жилүүд ч байна, алдаа оноо гаргаж байсан он жилүүд ч байсан юм байна лээ.

Би Баасандорж даргад горимын санал гаргах гээд байгаа юм. Миний хувьд өнгөрсөн удаад шинээр ахалж байсан учраас алдаж оноож байсан зүйл байгаа байх. Одоо бид нарт маш богино хугацаа байгаа учраас 10 зорилттой шинэ драфт гаргачихсан байна шүү дээ. Бид нар цаг хожихын тулд шинээр байгуулагдсан Ажлын хэсгийн 52 гишүүдээ 4-5 баг болоод хуваачих нь оновчтой. Жишээ нь эрдэс

баялгийн салбарын ил тод байдал гэхэд энэ дээр орох шаардлагагүй хүмүүс байгаа. Яг асуудлаа мэддэг хүн, яг асуудлаа мэддэг яам нь юм уу, иргэний нийгэм нь хамтраад л энэ төлөвлөгөө, заалтууд дээр ажиллачихвал цаг хугацааны хувьд аягүй их хэмнэлттэй. Тэгэхгүй бол жишээ нь эрдэс баялгийн салбарын талаар ойлголтгүй хүн энэ дээр орж цаг алдаад санал өгөх гээд ямар ч шаардлагагүй юм байна лээ.

Нэгдүгээр зорилтыг бид V төлөвлөгөөндөө оруулъя аа гэж үзэх юм болбол иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллага маань бусад оролцогч талуудаасаа саналаа авч өгөх энэ үүргээ хүлээчихдэг байхгүй юу. Өөрөөр хэлбэл бид нар одоо эрдэс баялгийн нэгдүгээр зорилт дээр энэ ажлын хэсгийн гишүүдээсээ 1-5 хүнийг томилчихлоо гэхэд тэр 5 хүн дотор орсон 3 нь иргэний нийгэм байлаа гэхэд тэр 3 иргэний нийгмийн байгууллага маань бусад яг энэ салбартай холбогдолтой иргэний нийгмийн байгууллагуудынхаа саналыг нь аваад протоколжуулаад баримтжуулаад явдаг. Тэгж байж бид нарын Ажлын хэсэг хүлээн зөвшөөрөгдөлт сайн болно.

Тэгээд тухайн салбарынхаа хурлуудыг нь тусад нь хийж байж төр, иргэний нийгмийн, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны саналууд гүйцэд авагддаг. Миний санаж байгаагаар өнгөрсөн төлөвлөгөө бараг 200 орчим саналаас шигшигдэж байж ингэж гарч ирж байсан. Төр-Од захирал бас байж байна. Төр-Од захирал энэ дээр бас нэлээн туршлагатай учраас саналаа хэлнэ байх гэж бодож байна.

Бичил ажлын хэсгүүд нь төрийн байгууллагуудаасаа, хувийн хэвшлээсээ, иргэний нийгмээсээ ингээд саналаа авчхаж болно. Хувийн хэвшил гэхэд бид нарт товчлох маш том боломж байгаа. Яагаад гэвэл танхим өөрөө Ажлын хэсгийн гишүүнээр ороод ирж байгаа учраас танхим өөрийнхөө сүлжээгээр дамжуулаад л хувийн хэвшлийнхээ саналыг авчихна. Жишээ нь УУХҮЯ энэ дээр орлоо гээд бусад яамдуудын саналыг аваад, иргэний нийгэм маань энэ салбарынхаа иргэний нийгмийн саналыг аваад ингээд явбал хэдүүлээ бас нөгөө хүлээн зөвшөөрөгдөлт ихтэй болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

За баярлалаа Болортуяа зөвлөхөд. За тэгвэл саяын Болортуяа зөвлөх буюу Ажлын хэсгийн гишүүний гаргасан горимын саналын дагуу манай нарийн бичгийн даргаас товч танилцуулгыг хийгээд өгөх үү?

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Дэлгэц дээр ворд файл харагдаж байгаа. Та бүхэнд линкээр бас хүргүүлсэн байгаа. Нийт 10 зорилт буюу миний өмнө хэлсэнчлэн IV төлөвлөгөөнөөс хэрэгжиж дуусаагүй үүрэг амлалтуудыг оруулсан.

Зорилт 1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сайжруулах:

- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьж, хэлэлцүүлэх
- Эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх
- Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн холбогдох байгууллага, төрийн өмчит компаниудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх; Монголын Олборлох Ил Тод Санаачилгын тайлангаар дамжуулан нийтэд ил тод болгодог мэдээллүүдийг төрийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар

дамжуулан шууд мэдээлдэг болох
- Ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөвт суулган шийдвэрлэх

Зорилт 2. Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах:
- Төрийн болон албаны нууцын жагсаалтыг мэдээллийн ил тод байдлын зорилгод нийцүүлэн өөрчлөх
- Төрийн болон албаны нууцын тухай хуулийг өөрчилж Засгийн газрын тогтоол, төрийн байгууллагын шийдвэрээр бус зөвхөн хуулиар төрийн нууцын жагсаалтыг батлах
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг эцэслэн боловсруулж өргөн барих. Лобби үйл ажиллагаа зохион байгуулах
- Сэтгүүлч эх сурвалжаа нууцлах баталгааг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд тусгах

Зорилт 3. Төрийн худалдан авах ажиллагаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгах, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах:
- Цахим каталогийн системийн өгөгдлийг цуглуулж ашиглалтад оруулах
- Худалдан авах ажиллагааны хариуцлагын тогтолцоог төгөлдөржүүлж, RED FLAG INDICATOR бий болгох, олон нийтэд ил тод түгээх

Зорилт 4. Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бусаар бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох:
- Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийн төрөөс хараат бус ажиллах орон зайг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх
- Иргэний нийгмийн суурь зарчим, үнэт зүйлсийг багтаасан Төр, иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод, иргэн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоотой явуулах

Зорилт 5. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн оролцоог хангах, хяналтыг сайжруулах:
- Хяналт үнэлгээний дүнг олон нийтэд болон шийдвэр гаргагч нарт танилцуулж, сайжруулах арга хэмжээний төсөл боловсруулах

Зорилт 6. Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх:
- Монгол Улсын төсөв, хөрөнгө оруулалт, тусгай сангууд, зээл тусламж, төсөл хөтөлбөрийн төлөвлөлтөөс эхлээд хэрэгжүүлж дуусах бүхий л үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтыг төсвийн хууль тогтоомжид оруулах, үүний тулд одоо байгаа зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тэдгээрийг хэрхэн боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий зөвлөлдөх механизмыг талуудын оролцоотойгоор ажиллуулж үр дүнд хүрэх
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журамд батлагдсан төсвийн тоон мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар ил болгох зохицуулалт оруулах
- Shilendans.gov.mn сайтыг шинэчлэхдээ төсвийн хэрэгжилт, ил тод байдлыг хангахад ашиглагдаж буй систем хоорондын уялдааг хангах, талуудын оролцоог тэгш хангаж санал солилцох, судалгаан дээр

тулгуурлан хөгжүүлэх
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд жилийн турш саналаа өгч болох цахим талбар бий болгох
- Төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn сайт дахь хайлтын системд төслийг “эхлэх огноо”-оор нь хайлт хийх сонголт оруулах

Зорилт 7. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, чанар, аюулгүй байдал, ханган нийлүүлэлтийн ил тод байдал, хяналтыг сайжруулах:
- Эмийн үнийн эрх зүйн орчны үнэлгээг хийж, хууль эрх зүйн баримт бичигт үнийн зохицуулалтын талаар өөрчлөлт оруулах
- Эмийн сурталчилгааны төгсгөлд эмийн зохистой хэрэглээний тухай дурдах журмыг батлах

Зорилт 8. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх:
- “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)”-ний үйл ажиллагаа

Зорилт 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах:
- Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг УИХ-аар батлуулах

Зорилт 10. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлж, цаазаар авах ялын хор хөнөөлийг олон нийтэд таниулах соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах:
- Цаазаар авах ялын хор хөнөөлийг таниулсан сургалт хийх
- Медиа контент хийх

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

За баярлалаа Номинчимэгт.

Саяын танилцуулсан бидний төлөвлөгөөнүүд НЗТ-ийн 2023-2028 оны стратегиар батлагдсан байгаа. Суурилах ёстой 5 зорилт бүхий стратеги байгаа:

Стратегийн зорилт 1 - Нээлттэй засгийн шинэтгэгч, активист, тэмцэгч нарыг багтаасан өсөн нэмэгдэх, тууштай, харилцан уялдаатай олон нийтийг бий болгох
- Нээлттэй засгийн төлөө илүү хүчирхэг, улс төрийн шинжтэй дэлхийн нийтийн эвслийг байгуулах
- Шинэтгэгч нарын манлайллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийх
- Нээлттэй засгийн зарчмыг бататгахын тулд стратегийн холбоо, түншлэлийг өргөжүүлэх

Стратегийн зорилт 2 - Төрийн бүх түвшинд, салбарууд тэргүүлэх ажлыг хэрхэн хэрэгжүүлэх дээр нээлттэй засгийг төвлөрүүлэх
- Олон төрлийн орчин, хэрэгцээнд тохирсон уян хатан үйл ажиллагааны хүрээгээр хангах
- Нээлттэй засгийн үйл ажиллагааг бүх түвшинд, төрийн ажлын салбаруудад голлон дэмжих
- Улс төрийн боломжит “цонх” гарахад хариу үйлдэл сайн байх

Стратегийн зорилт 3 - Иргэний нийгмийн орон зайг хамгаалах, тэлэх
- Иргэний нийгмийн орон зайн үйл ажиллагааг дэмжиж, тэмцэгч нарыг хөгжүүлэх
- Иргэний нийгмийн орон зайн талаарх Нээлттэй засгийн түншлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтмол хянах

Стратегийн зорилт 4 - Нээлттэй засгийн шинэчлэлийн хамтын үйл явцыг эрчимжүүлэх

- Ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо, хүртээмжийн шаардлагыг нэмэгдүүлэх
- Хамтын тэргүүлэх үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах уриалгыг эхлүүлэх

Стратегийн зорилт 5 - Нээлттэй засгийн шинэчлэл, нотолгоо, түүхийг өгүүлэн зоригжуулах нутаг орон болох

- Өндөр чанартай контентыг хөгжүүлэх, хадгалах, хуваалцах
- Хүмүүст түүхээ хуваалцах, холбогдох орон зайг бий болгох

Стратегийг та бүхэн рүү мэйл хаягаар тань явуулсан байгаа шүү. Англи, Монгол аль аль хувилбараар нь явуулсан байгаа. За саяын танилцуулга товч хийсэн юм чинь та бүхэнд санал асуулт байна уу?

Би Болортуяа зөвлөхийн горимын саналыг Ажлын хэсгийн гишүүний хувьд дэмжиж байна. Бүлэг бүлгүүдээрээ мэргэшсэн чиглэлээр жижиг ажлын хэсэгт хуваах нь зөв байх аа. Тэрийг хэдүүлээ саналаа сонсчхоод хуваарилалтаа хийе.

Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Х.Оюунцэцэг:

За сайн байна уу?

Түрүүн Жаргалсайхан гуай асуугаад байсан, ер нь юуны төлөө яагаад энэ 52 хүн цугларч байгаа юм бэ гээд. Энэ асуудлыг хариуцаад ажиллаж байсан хүний хувьд 2012-2015 онд ХШҮДАГ-ын даргаар ажиллаж байхдаа бид нар НЗТ-ийн эхний төлөвлөгөөг боловсруулаад ер нь бол амилуулж байсан. Тэгэхээр хуучин бол сайн засаглал гэж НҮБ төрийн, засгийн газруудын үндсэн философийг сайн засаглалыг тогтооё гэдэг байсан. Төр засаг өөрөө бүртгэлээ сайжруулах, хүний эрхээ хангах гээд НҮБ-ын зарчмууд байсан шүү дээ. За ингээд ерөнхийдөө сайн засаг, төрийн байгууллага, систем сайжирчхаж байгаа юм чинь одоо иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа яах вэ, тийм ээ? Одоо хөгжүүлье ээ гэдгээр НҮБ өөрөө дэргэдээ энэ НЗТ-ийн санаачилгад засгийн газруудыг оролцуулаад явж байдаг. Тэгээд Монголын ЗГ нэг жилдээ 25 мянган ам.долларын гишүүнчлэлийн төлбөр төлдөг, тийм ээ? Тэгээд бусад улс орнуудын ЗГ хэрхэн иргэний нийгэмтэйгээ төр засаг яаж ард түмний хүсэн хүлээж байгаа үр дүнд хүрэхийн төлөө ажиллах вэ гэдэг дээр энэ механизмыг бүрдүүлээд явж байгаа учраас тэр утгаараа бол би маш зөв гэж бодож байна. Тэр тусмаа ЗГХЭГ дээр энэ ажлыг нэгтгээд явж байгаад нь их талархаж байгаа.

За ингээд саналаа өгье. Ажлын хэсэгт орж ажиллана. Нэг асуулт байна. Саяын тэр цаазын ялыг халах асуудал хаанаас яагаад ороод ирэв? Хамгийн сүүлийн 10 зорилтын нэг зорилт дээр нь тэр гараад ирэх юм. Зүгээр санал юм байна гэж ойлголоо.

Нийгмийг 2 хуваасан зорилт тавьчхаад энэ чинь шал хачин юм байна гэдэг асуудал гарах вий гэдгээс би болгоомжилж байна. Тийм учраас тэрнийг бол нэг их дэмжмээргүй байна. Яаж, хэрхэн ЗГ иргэний нийгэмтэйгээ хамтарч ажиллаж болох вэ гэдэг дээр, жишээлбэл ХАҮТ, Ажил олгогчдын нийгэмлэг, хэрхэн бизнесийн салбарт хүний эрхийг хангах вэ ч гэдэг юм уу энэ асуудал дээрээ илүү акцент авах нь дээр юм уу гэж бодож байна.

“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож:

НЗТ гэдэг чинь их чухал л даа. Тийм болохоор нэг их асуугаад байх шаардлага байхгүй. Би юу гэж бодож байна вэ гэхээр энэ чинь 5 дахь удаагийн төлөвлөгөө шүү дээ. Тийм болохоор бид нар нэлээн нухацтай тэгээд бүүр нэг тийм чанарын өөрчлөлт гарахаар ч гэдэг юм уу тэгж ажиллах ёстой юм болов уу гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт энэ бол төрийг нээлттэй болгох, төрийг нээлттэй байлгах арга

юм. Нэг удаа нээлттэй гэж хэлчхээд тэгээд дуусчих биш тэр нь дандаа байж байдаг. Би яагаад энийг ингэж хэлж байгаа юм бэ гэхээр манай төрийн үйл ажиллагааны тайлагнал нь ерөөсөө байдаггүй. Уг нь юм хийгээд байдаг гэхдээ тэр тайлан нь ерөөсөө байдаггүй, тайлан нь байдаггүй учраас юм хийхгүй байна гэж боддог. Тийм учраас энэ бүх зөрчил үл ойлголцол эхэлж байгаа шүү дээ. Тийм болохоор энэ тайлагналыг сайн болгох тэгээд яг энэ нээлттэй болгох нээлттэй байлгахын төлөө түншлэл юм. Тэрнээс биш янз бүрийн юмыг хамтарч хийх биш. Жишээлбэл цаазын ялыг авах ч гэдэг юм уу эсвэл бас өөр юу ч байна даа ингээд хэрэгжүүлэх гээд яваад байна шүү дээ. Бизнес ба хүний эрх тэртээ тэргүй Бизнес ба хүний эрхийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө гарчихсан байгаа. Тийм болохоор тэрийг энэ лүү нэгтгээд байх хэрэггүй. Гэхдээ нээлттэй байлгахын тулд яах ёстой юм бэ гэдэг дээр маш сайн анхаарах ёстой. Мэдээж хэрэг салбар салбараар нь анхаарах ёстой байх гэж бодож байна. Тэгээд Болортуяагийн хэлж байгаа ч гэсэн зөв, сэдэв сэдвээрээ ажилладаг салбар салбараараа баг болоод ажиллах нь зөв юм болов уу гэж бодож байна.

Уул уурхайтай холбоотой эрдэс баялгийн салбар дахь ил тод байдлыг хангахтай холбоотой тэр хуулийг бий болгох, тэр эрдэс баялгийн сангийн мэдээллийг ил тод нээлттэй болгох гээд энэ бол зайлшгүй чухал асуудал. Өмнө нь хэрэгжүүлэх гэж аваад хэрэгжүүлж чадаагүй байгаа тэр 9 зорилтууд байна шүү дээ. Тэрнийгээ бол дахиж сайн хараад тэгээд авах ёстой байх.

Тэгээд ялангуяа эрдэс баялгийн салбар дахь ил тод байдлыг бий болгох тэр хуультай болгох гэсэн үүрэг амлалтыг бол бид нар ямар ч байсан хийх хэрэгтэй байх. Тэрэнд бол мэдээж хэрэг хамтарч ажиллах байгууллагууд нь болохоор УУХҮЯ, ТББ-аас ТАН эвсэл байгаа шүү дээ. “Төлсөн авснаа нийтэл” эвсэл бол анхнаас нь эхлээд л энэ хуулийн төслийг боловсруулаад ил тод болгох гээд л өчнөөн янзаар дахин дахин өөрчлөөд л одоо тэгээд бүүр нөгөө Байгалийн нөөцийн ил тод байдлын тухай хууль болчхоод ингээд явж байгаа. Тэгэхээр энийг бол маш түргэн хугацаанд бий болгох хэрэгтэй байна.

Гуравдугаар асуудал бол нэгэнт өнгөрсөн тэр биелээгүй байгаа зорилтуудаа хэрэгжүүлье, тийм ээ? Тэрнийгээ тэгэхдээ бол дахиж харъя. Тийм янз бүрийн юман дээр орсны шаардлагагүй байх. Бүх гишүүдээсээ саналаа аваад тэгээд саналын дагуу шийдчихэж болно.

Дөрөвдүгээрт болохоор энэ төлөвлөгөөнүүд дээрээ ямар ямар байгууллага яг юун дээр ажиллах вэ гэдэг саналыг нь авчих хэрэгтэй байх. Би тэгээд энэнтэй уялдуулаад яах вэ? Хүний эрх хөгжилтэй бол бид нар бол Тан эвслийн гишүүн болохоор эрдэс баялгийн салбар дахь ил тод байдлыг бий болгох тэр хуультай холбоотой, ер нь тэр салбарт бол манай байгууллага орж ажиллахад бэлэн байна. Саналаа өгчихье.

Тавдугаарт иргэний нийгмийн орон зай, иргэний нийгмийн байгууллагыг ч гэсэн ил тод болгох шаардлага байгаа. Тэгэхээр ил тод болно гэдэг нь өөрөөр хэлбэл олон нийтэд тайлагнана гэсэн үг шүү дээ. Тэгэхээр яг өнөөдөр Монголын иргэний нийгмийн байгууллагуудад өөрийнхөө үйл ажиллагааг нийтэд хүргэе гээд ил тод байлгаад байх тийм хэмжээний санхүүжилт, үйл ажиллагаа явуулах таатай орчин бол байхгүй.

Хүний эрх, хөгжил төв бол ингээд мэддэг чаддаг юмаа хэлээд хамтарч ажиллахад бэлэн байна. За тэгээд сүүлд нь бол санал маягийн юм хэлмээр байна. Олон улсын янз бүрийн, нээлттэй засаглалын түншлэл гэдэг дээр ингээд ороод ажиллаад явдаг тэгээд тэрэнд юу харагддаг вэ гэхээр ЗГ болохоор иргэний нийгмийн байгууллагуудынхаа хийж байгаа юмнуудыг түүж аваад тайлагнадаг байхгүй юу. Тэгэхээр тэгж болохгүй, тэгмээргүй байна. Засаг өөрөө иргэний нийгмийн байгууллагаар юм хийлгэхийн тулд тодорхой санхүүжилтийг өгдөг байх хэрэгтэй байна шүү дээ. Одоо тийм үүрэг хүлээж сурах хэрэгтэй байхгүй юу.

Монголын ЗГ тэгэхээр V үйл ажиллагааны төлөвлөгөөн дотор төсвийн санхүүжилтийг иргэний нийгмийн байгууллагад оруулах хэрэгтэй. Тэгээд тэр нь юунд зарцуулагдах ёстой вэ гээд янз бүрийн сектор дахь төрийн байгууллагын ил тод байдлыг хянах, үнэлэх тийм үйл ажиллагаанд нь бол иргэний нийгмийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ ээ гэсэн тийм төсөвтэй болгож байж V үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайн болгох ийм боломж бүрдэнэ ээ гэж бодож байна. Баярлалаа.

Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Хөтөлбөрийн ажилтан Э.Баасансүрэн:

Болорсайхан даргатай 08 дугаар сард уулзаж байхад дэд ажлын хэсэг үүсгэе гэж ярьж байсан. Тэгэхээр тэрнийхээ дагуу дэд ажлын хэсгийг үүсгээд явъя.

Нэг тодруулж асуух юм нь манай амлалт маань хэрхэн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдах вэ? Ямарваа нэг амлалт заавал нэг санхүүжилттэй, нөөц боломжтой байж хэрэгжинэ шүү дээ. Мэдээж бид нар хэдэн мянган амлалтыг өгмөөр байна гэхдээ яг тэр маань хэрхэн манай үндэсний хөтөлбөрүүд, ЗГ-ын төлөвлөгөөтэй уялдаж байгаа вэ? Яаж тэрийг, нөөц боломжийг нь хангах вэ гэдгийг тодруулж асуумаар байна.

Хоёрдугаарт Номинчимэг нарийн бичгийн даргын илтгэл дээр яригдаж байсан нөгөө шалгуур үзүүлэлт. Сүүлд бид төлөвлөгөөгөө эргээд хянаж байсан чинь шалгуур үзүүлэлт дээр асуудал үүссэн шүү дээ. Энийг нь одоо биелсэн гэж үзэх юм уу биелээгүй гэж үзэх юм уу гэнгүүт өөрсдийнхөө мэдлэг, туршлага дээрээ үнэлээд биелсэн гэж үзье, биелээгүй гэж үзье гээд өөр өөр байр сууринаас дүгнээд байсан. Тэгэхээр одоо дараа дараагийн Ажлын хэсгийн хурлууд дээрээ эхлээд амлалтаа тодорхойлж байгаад шалгуур үзүүлэлтээ тодорхойлох эсвэл эхлээд амлалтаа эцэслэчхээд дараа нь шалгуур үзүүлэлтийг тодорхойлох гэж байна уу гэдгийг тодруулж асуумаар байна.

Тэгээд өөр нэг айхтар ач холбогдолтой биш ч гэсэн бүсийн хэмжээний хурал болох тийм төлөвлөгөө гарсан болов уу. Эдгээрийг тодруулъя аа. За баярлалаа.

“Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа:

За, сайн байцгаана уу? Өнгөрсөн төлөвлөгөөний хэрэгжилт дээр хамтарч ажилласан, хэрэгжилт гаргах үйл явцад оролцож тайлан мэдээллээ өгсөн ТББ-ын нэг байна. Төлөвлөгөө гаргах үйл явцыг бол би Болортуяагийн саналыг дэмжиж байна. Үнэхээр өнгөрсөн удаад маш олуулаа бараг зуугаад хүн байсан санагдаж байна. Аягүй том зааланд хэчнээн бүлгүүд хамтарч ажиллаж гаргаж байсан тэр бол хамгийн үр дүнтэй байсан.

Төлөвлөгөө гарсны дараах тайлангийн явц дээр шалгуур үзүүлэлт маш тодорхойгүй байгаа юм уу гэж харсан. Үнэхээр тайлангуудаа ХЗДХЯ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлыг бол маш ахиц дэвшилтэй хийчихсэн байгаа гэдэг тайлан өгөхөд иргэний нийгмийн байгууллагын зүгээс хангалтгүй байгаа гэж дүгнэсэн. Ийм асуудлууд бол нэлээн гарч байх шиг байсан учраас бид тэр шалгуур дээр анхаарах хэрэгтэй байх.

Дээр нь авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртэй хэрхэн яаж уялдах юм бэ? Энэ уялдаж явах уу? Тэрэн дээр бас тодорхой хэвлэл мэдээллийн салбартай хамааралтай зорилтууд явж байгаа. Энд давхардсан санаанууд байна. Тэгэхээр энэ уялдаа холбоо хэрхэн яаж явах юм?

НЗТ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр дээр иргэний нийгмийн байгууллагууд бол үүрэг хүлээдэг ээ. Нэр орсон учраас тайлан хийсэн ажлаа өгдөг. Тэгээд тэр хийсэн ажлыг нь аваад л нэг цаасан дээр буулгаад л өнхрөөд байдаг: Харилцан уялдаа холбоо байдаг уу? Энийг хийхэд ямар бэрхшээл тулгараад байгаа юм? Та нар эндээс ямар үр өгөөж, шинэчлэл харав? Цаашдаа

юу хиймээр байдаг юм? Ямар ч тийм дуу хоолой авахгүй мөртөө бид нарын жилийн тайландаа оруулдаг ингээд л тайлангаа өг гээд шаардаад аваад байдаг. Энэ чинь бид нар нөгөө бэлгэдлийн шинжтэй төлөвлөгөө гаргаад л эцсийн дүнд нь нэг жилийн дараа ч юм уу тайланд иргэний нийгмийн байгууллагуудынхаа хийсэн ажлуудыг нэгтгээд л яамдуудаас өгсөн төлөвлөгөөтэй нэг харьцуулж үздэг ийм нэг юм руу явчих вий. Тэрийг бид нар засах ёстой гэж харж байна. Тэгээд саяын иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүдийг хэлж байгаа үнэхээр яг энэ ажил төлөвлөж хамтарч хийж байгаа болбол тэр дэмжлэг оролцоо болгоныг бас харж явах ёстой байх аа гэдэг саналыг хэлье ээ. За баярлалаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

За баярлалаа. Зарим хүмүүс маань асуулт асууж байгаа учраас би хариулая.

Оюунцэцэг хуульч бол цаазын ялыг халах ёстой гэдэг асуудлыг яах вэ гэж байна. Ганцхан нээлттэй засаг дээр ч биш Монгол Улс олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүрэгтэй. Гэхдээ бид нар зөвхөн Эрүүгийн хуулиасаа л авчихсан. Үндсэн хууль дээр сайн унших юм болбол утга санаа нь байгаа ч юм шиг зарим хуульчид байхгүй ээ ч гэж тайлбарладаг.

Уранцоож төрийн үйл ажиллагааны тайлагнал нээлттэй биш ээ гэдэг дээр би санал нэг байна. Төрийн үйл ажиллагааны төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээгээр яг юу хийсэн юм, тухайн төрийн байгууллага юу хийсэн юм нээлттэй биш. Өнөөдөр Монгол Улсын ЗГ-ын хурлаар 16 яамд 21 аймаг маань хагас жилээр хөгжлийн бодлого төлөвлөлт, ажлуудаа хэрхэн хийсэн юм тайлагнасан. Энэ дээр Ерөнхий сайд онцгойлон хэлсэн. Төрийн байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан, хагас жилийн тайлан болдог болбол И-Монголиа дээр нэг цонх үүсгээд нээлттэй тавиач ээ гэдэг. Ерөнхий сайд өнөөдөр засаг дээр ярьсан зүйл. Тэгэхээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдчихсан, Хүний хувийн мэдээллийн тухай хууль батлагдчихсан, ямар мэдээлэл нь хязгаартай нээлттэй байх юм гэдэг бүх зүйлүүд тодорхой болчихсон. Тэгэхээр НЗТ-ийн хүрээнд ер нь ЗГ-аас энэ хууль тогтоомжийнхоо хүрээнд төрийн байгууллагуудынхаа үйл ажиллагаа, ялангуяа тайлангуудыг нь нээлттэй тайлагнах системийг бий болгохоор өнөөдөр яг яригдсан байгаа шүү. Тэрнээс одоо бол үнэхээр хаалттай шүү дээ. Төрийн байгууллага юм хийгээд байдаг нээлттэй биш болохоор иргэд, иргэний нийгмийн байгууллагууд маань бухимдаад байдаг тэгээд үл ойлголцол үүсээд байдаг. Тэгэхээр энэ болбол маш ажил хэрэгч санал байлаа.

За биелээгүй 14 зорилт байгаа. Эндээс аль алийг нь авахаа Ажлын хэсэг дээрээ ярья аа гэсэн, ялангуяа та эрдэс баялаг дээр оръё гэдэг саналыг хэлж байна. Тэгэхээр хэдүүлээ тэр 14 дотроо энийгээ ярья.

За мөн маш чухал нэг саналыг хэлсэн. Иргэний нийгмийн байгууллагын ил тод байдлыг бий болгох чухал асуудал, учир нь иргэний нийгмийн байгууллага төрийн байгууллага 2 чинь өөрөө харилцан хяналт тэнцлийн баланс шүү дээ. Аль аль нь нээлттэй, аль аль нь харилцан ойлголцдог байх хэрэгтэй. Хурал эхлэхэд хэлсэн шүү дээ манай байгууллагын нэг чиг үүрэг бол яг иргэний нийгмийн байгууллагуудтайгаа хамтраад төрийн байгууллагуудынхаа үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгдөг үнэлгээ мониторинг хийдэг тогтолцоо болохоор үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа.

За төсөв санхүүтэй холбоотой асуудлыг би ойлголоо. Баасансүрэн амлалт маань хэрхэн уялдах вэ гэж асуусан. Засгаас, төрөөс гаргаж байгаа бодлого шийдвэртэй яаж уялдах вэ? Бүрэлдэхүүнийг та бүхэн харах юм бол дийлэнх нь иргэний нийгмийн төлөөлөл байгаа. Гэхдээ яагаад ЭЗХЯ, СаЯ, ЗГХЭГ, БОАЖЯ-ыг оруулсан юм гэдэг маань энэ бодлого хөтөлбөр гаргадаг ЗГ-ын үйл ажиллагааны

хөтөлбөр ирэх жил шинэчлэгдэж батлагдана. За тэгээд улсын жилийн төлөвлөгөө гээд яг эд нартай уях үүднээс гол яамдуудын төлөөллүүдийг оруулсан байгаа юм. Тэгээд үйл ажиллагаандаа оруулчхаад хэрхэн яаж хяналт тавина гэдэг дээр нь манай байгууллагын үнэлгээ мониторинг явцын болон урт богино дунд хугаатай хяналт хийдэг чиг үүрэгтэй байгууллага мониторинг хийнэ. Тэгэхээр энэ үүднээсээ манай байгууллага түлхүү орж байгаа юм. Аль аль талаасаа хэрэгжилт, төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал дээр нь анхаарсны үүднээс Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг харах юм болбол яг тийм зорилготойгоор бүрэлдэхүүн бүрдчихсэн байгаа шүү гэдгийг хэлье ээ.

За НЗТ-ийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа смарт зарчимд тулгуурлая. Одоо та бүхний бүгд мэдэж байгаа тодорхой байх, хэмжигдэхүйц байх, хүрэх боломжтой байх, чухал хамааралтай байх, цаг хугацаандаа байх. Тэгэхээр бид нар төлөвлөгөөг яг энэ зарчмын дагуу л боловсруулах ёстой.

“Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ-ын Судалгааны хорооны дарга С.Амармэнд:

Би Болортуяа зөвлөхөөс асуух нэг товчхон асуух асуулт байна. Та түрүүн яриандаа манайх өнгөрсөн удаагийн тайлангаа тавихдаа сайн үнэлгээ авсан гэж байсан. Ямар зүйл дээрээ бид нар сайн гэдэг үнэлгээ авав?

Бас одоо шинэ байгуулагдаж байгаа Ажлын хэсэг энэ үнэлгээ дээр тулгуурлаж ажлаа явуулбал зүгээр юм болов уу гэдэг санал байна.

“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам:

Өнгөрсөн төлөвлөгөөн дээр төсвийн хэсгийг боловсруулахад Сангийн яамтай хамтарч ажилласан. За тэгээд энэ удаагийн төлөвлөгөөг харахаар ерөнхийдөө төсвийн асуудлаар бас нэлээн асуудлууд нэмж тусгах шаардлагатай харагдаж байна. Тэгэхээр ерөнхийдөө Сангийн яамыг оруулахаасаа гадна Үндэсний аудитын газрын төлөөллийг манай төсвийн хэсэг дээр оруулж өгвөл их зүгээр санагдсан. Үндэсний аудитын газрын зүгээс хийж байгаа аудит дээр ч гэсэндээ анхаарах асуудлууд байгаа учраас энийг оруулж өгөхөд анхаараач ээ гэж хүсмээр байна.

Мөн төсөв дээр орон нутгийн төсвийн ил тод байдал дээр нэлээн анхаарах хэрэгтэй байгаа. Нийслэл, дүүргийн төсвүүд бол ер нь маш хаалттай. Өргөө баригдлаа гэсэн мэдээлэл зөвхөн мэдээ гарчхаад төслүүд нь бол ил болохгүйгээр батлагдаад байгаа. Тэгэхээр орон нутгийн төсвийн асуудал дээр бас нэлээн амлалтуудыг оруулах хэрэгтэй байх.

Шилэн дансны тухай хууль шинэчлэгдэж өөрчлөлт орно гэчхээд энэ хууль тэр чигээрээ одоо чимээгүй болчихсон байгаа. Тэгэхээр энэ шилэн дансны хуулийн шинэчлэл мөн дагалдах журмын шинэчлэл дээр анхаарах хэрэгтэй байна гэж харж байна.

Монгол Улсын хувьд бол ерөнхийдөө төсвийн хөрөнгө оруулалт дээр нэлээн ил тод болгох асуудлууд байгаа. Бид бүхэн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуулийнхаа 2 дугаар хавсралтаар баталж байгаа. Гэхдээ энэ дээр тухайн төсөл хэддүгээрт үр ашгараа ач холбогдлоороо эрэмбэлэгдээд байгаа гэдэг мэдээлэл нь ил байхгүй байгаа. Дээрээс нь томоохон төслүүдийг ядаж төсвийнх нь үр ашгийн тооцоо, нийгэм эдийн засагт өгөх үр өгөөжийн талаар мэдээлэл хомс байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр бас нэлээн амлалтууд тусах ёстой болов уу гэж харж байна. За баярлалаа.

Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК-ын гүйцэтгэх захирал Э.Тунгалаг:

Нэг асуулт нь болохоор эдгээр 10 зорилтууд ер нь өөрчлөгдөх санал бид өгч

болох уу? Зорилт нэмэх санал өгч болох уу гэж асуумаар байна.

Миний санал болохоор эдгээр зорилтууд болон ер нь НЗТ-ийг бий болгоход төр эргээд иргэний нийгмийн хоорондын харилцааг сайжруулах тэр дунд солилцож байгаа мэдээллийг зөв болгох, бүрэн болгох гэдэг тал руу илүү явах байх гэж бодож байна. Тэгээд өмнөх зорилтуудаа харангуут нээлттэй өгөгдөл болон нээлттэй мэдээлэлтэй холбоотой хэд хэдэн зорилтууд байна л даа.

Монгол Улсад яг одоо нээлттэй өгөгдөл гэдэг ойлголт хууль эрх зүйн орчны хувьд дөнгөж саяхан яг нээлттэй өгөгдөл гэдэг үгээрээ орж ирж байгаа. Тийм учраас нээлттэй өгөгдлийг тусад нь нэг зорилт болгон оруулах тийм боломж байх уу.

Нөгөөтээгүүр нээлттэй өгөгдлийн энэ үйл явц нь харьцангуй удаан хийх ажил нэлээн их байгаа. За тэгээд нээлттэй өгөгдлийн чанар стандартыг сайжруулахаас эхлээд хэрэглээг нь нэмэгдүүлэх, яг бодит хэрэглээнд орж чадаж байгаа юм уу үгүй юм уу? Нээлттэй өгөгдлийн жагсаалтаа шинэчлэх гээд нэлээн их ажлууд хийгдэх шаардлагатай байгаа учраас энийг тусад нь зорилт болгоод оруулах юм болбол нэг талаасаа олон улсад энэ тал дээр бид юм хийж байгаа гэдгээ харуулах, нөгөө талаасаа эдгээр нээлттэй засгийн түншлэлийнхээ зорилтуудыг хэрэгжүүлэх үйл явцаараа дамжуулаад нээлттэй өгөгдлийн салбарыг илүү хөгжүүлэхэд бас түлхэц болж чадах юм болов уу гэж харж байна.

Эсвэл ингэж тусад нь зорилт болгохгүйгээр жишээ нь төсвийн өгөгдөл дээр нээлттэй өгөгдөл, эрдэс баялгийн нээлттэй өгөгдөл орж ирж болж байна. Төрийн худалдан авах үйл ажиллагаан дээр орсон зорилтуудыг нь илүү дэлгэрүүлээд яг нөгөө нээлттэй өгөгдлийн шаардлагыг нь хангасан юм уу бүрэн нарийвчилсан шалгуур үзүүлэлтийг бас оруулж болох юм аа гэдэг санал байна.

Түрүүний хүмүүсийн хэлж байгаа шиг яг шалгуур үзүүлэлтийг илүү нарийвчлах шаардлага бас байгаа гэдэг саналаа дахин хэлж байна. За ийм санал байгаа юм. Баярлалаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Сая ихэвчлэн саналууд хэллээ.

Амармэнд ямар ажлууд нь сайн болсон бэ гэдгийг асуусан. Бид IV тайланг өөрсдөө дүгнээд явуулчихсан албан ёсоор ирээгүй байгаа 12 сард ирнэ. 12 сард яг албан ёсоор дүгнэлт ирэхээр бид бүгд танилцана. Тэгэхээр яг тэрэн дээр бид нарын тайлагнасан тайлангийн юу нь сайн байгаа юм, юу нь муу байгаа юм, юу нь дунд зэрэг байгаа юм гэдгийгээ хэлэх юм. За тэгээд Болортуяа зөвлөх нэмж хариулбал та хариулаарай.

Оюунбадам Үндэсний аудитын газрыг Ажлын хэсэгт оруулъя аа гэсэн санал байна. Үндэсний аудитын газраас бол хүн байхгүй байгаа юм. За гэхдээ Ажлын хэсгийн гишүүн санал гаргасан учраас би ахлагчийн хувьд гишүүдийнхээ гаргасан саналын мөрөөр арга хэмжээг авах үүрэгтэй. Үндэсний Аудитын газар ЗГ-т харьяалагддаггүй, УИХ-ын дэргэдэх байгууллага учраас би холбогдох журмынхаа дагуу Ажлын хэсэгт оруулах арга хэмжээг авъя.

Ажлын хэсгийн гишүүнийхээ хэлсний дагуу орон нутгийн төсвийг нээлттэй болгоё, хөрөнгө оруулалтын арга хэмжээг нээлттэй болгоё гэсэн санал хэллээ гэж ойлголоо.

Тунгалаг санал өгч болно шүү дээ. Гол нь та хэдийн саналыг сонсох гээд л өнөөдөр бид нар суугаад байгаа шүү дээ. Тэгэхээр юуг өөрчлөх ямар санал байна? Алийг сайжруулах санал байна ерөөсөө чөлөөтэй. Эхний хурлын зорилт бол ерөөсөө л энэ байгаа шүү. Тэгээд нээлттэй өгөгдлийг тусад нь зорилт болгож оруулъя гэж байна. Энийг бол хэдүүлээ ажлын дэд хэсгүүд дээрээ аль алийг яг нээлттэй болгох юм ярилцая. Манай эрх зүйн орчин нь бүрдчихсэн тэгээд эх

өгөгдлөө хэдүүлээ эрхийг нь яаж бий болгох юм, тэндээсээ алийг нь нээлттэй болгох юм, тэндээсээ аль нь нээлттэй, аль нь нээлттэй бус болох вэ гэдэг үүднээс ажлын дэд хэсгүүд дээр ярья.

Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа:

Олон улсын хурлууд нь хэзээ болдог юм бэ гэж асуусан. Миний ойлгож байгаагаар Глобал саммит гээд олон улсын том хурал нь 2 жилд нэг болоод байх шиг байгаа юм. Тэгээд манай элч төлөөлөгч Төр-Од захирал бас сууж байгаа учраас нэмж тодруулга өгвөл илүү ойлголт өгөх байх. Давтамжаараа энэ жил олон улсын хурал нь Эстонид тааруад Монголын багаас Учрал сайд төлөөлж оролцсон хүндэт өргөмжлөл авсан байгаа. ЗГ-ын хэвлэл мэдээллээр мэдээлэгдсэн И-Монголиагийн шинэчлэлтэй холбогдуулаад манай улсын насанд хүрэгчдийн 72% нь И-Монголиа системийг тодорхой хэмжээнд ашиглаж байгаа үзүүлэлтээр бас И-Монголиа манай 2021-2023 оны зорилтод байсан. Өөрөөр хэлбэл энэ хэрэгжилт бол маш сайн хангагдсан.

Хоёрдугаарт Авлигын эсрэг 5Ш ажиллагааны хүрээнд ЦХХХЯ-ны shilen.gov.mn гээд төрийн маш олон мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй болгосон. Энэ үзүүлэлтээрээ хүндэт өргөмжлөл авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Болортуяа зөвлөхийн хэлсэн Учрал сайд ахлаад ирсэн Таллинн хотод манай энд байгаа иргэний нийгмийн байгууллагуудаас зарим төлөөллүүд явсан байсан шүү дээ. И-Монголиа маш богино хугацаанд нээлттэй засгийн хүрээнд маш амжилттайгаар хэрэгжүүлжээ гэдэг үүднээс 4 оронд тусгайлан өргөмжлөл өгсөн гэсэн үг. Тэрний нэг бол Монгол улс.

“Нээлттэй засаглалын түншлэл”-ийн олон улсын элч төлөөлөгч Л.Төр-Од:

Би маш богинохон 3 зүйлийг хэлчихье гэж бодож байна.

Зарим нь бүр анхнаас нь ажилласан, ялангуяа ННФ-ынхан болбол бүр I төлөвлөгөөнөөс одоог хүртэл хамт ажиллаж байна.

2011 онд ардчилсан засаглалтай 8 улс орнууд нэгдсэн. Тухайн үед Барак Обама АНУ-ын ерөнхийлөгч байсан, гол санаачилгыг дэвшүүлээд өнөөдрийн байдлаар 22 жилийн дараа бараг 80 улс орон гишүүн болоод ажиллаж байна.

Монгол Улсын хувьд 2013 онд НЗТ-д нэгдэх санал гаргасан. Би болбол 2012 оноос хойш бас хариуцаж ажиллаж байсан. Тэгээд 2013 онд тухайн үед ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд Сайханбилэг ахлаад, иргэний нийгмээс ННФ-ын гүйцэтгэх захирал Эрдэнэжаргал оролцоод анхны олон улсын хуралд нь оролцоод явсан. За энэ жилийн хувьд ННФ-аас 5-6 төрийн бус байгууллагуудыг дэмжээд саммитад оролцуулсан. Тэд маань бас оролцооныхоо талаар тусдаа хэлэлцүүлэг танилцуулах юм бол зүйтэй гэж бодож байна.

За ерөнхийдөө маш товчхон танилцуулбал үндсэндээ 2011 онд 8 улс орон, манай бүс нутгаас Индонез, Өмнөд Солонгос, Филиппин, Непал нэгдэж байсан.

Анх НЗТ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын хэрэгжилтийг мөн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг харсан. Тийм ч учраас ерөнхийдөө 4 чиглэлийг 22 жилийн өмнө тогтсон байдаг юм.

Нэгдүгээрт ард иргэд, олон нийт, нийгэм өөрөө ЗГ буюу төр засгийнхаа үйл ажиллагааны талаар нээлттэй мэдээлэлтэй болъё, тэгж байж хяналт тавьдаг болно.

Хоёрдугаарт иргэд болон иргэний нийгмийн бүлгийн оролцоог нэмэгдүүлье

гэж байгаа. Ялангуяа эргээд төр засгийн бодлого дахь хяналтыг УИХ, ЗГ, орон нутагт тавих.

Гуравдугаарт төрийн байгууллага болон төрийн албан хаагчдын үйл ажиллагааг хамгийн өндөр ёс зүйтэй, хариуцлагатай, хяналттай болгоё, эргээд хариуцлага тооцдог болъё.

Дөрөвдүгээрт чиглэлийг хэрэгжүүлэхийн тулд өндөр мэдээллийн технологи ашиглая. Өөрөөр хэлбэл эргээд энэ оролцоог хангах хяналттай болгох, ёс зүйтэй, хариуцлагатай болгох талаар юм.

Тийм учраас яах аргагүй бид 2 гол эрх зүйн баримт бичигтэйгээ уялдуулах ёстой. Нэг нь сая хаврын чуулганаар баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр байгаа. Нөгөө нь одоо боловсруулж байгаа Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. Тийм ч учраас миний ойлгож байгаагаар Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албанд энэ үүргийг даалгасан гэж ойлгож байгаа шүү. За баярлалаа.

“Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын тэргүүн Д.Жаргалсайхан:

Тэр энд тэнд очиж амлах яах вэ? Тэгээд энэ амлалтыг чинь хэрэгжүүлдэг арга хэрэгсэл маань нөгөө хууль дүрэм журам маань байгаа шүү дээ. Тэгээд тэр хууль дүрэм журмуудыгаа бид бодитоор амлалтыг хэрэгжүүлэх хүчтэй хэрэгсэл болж чадаж байна уу үгүй юу гэдгийгээ хянахгүй бол болохгүй нь. Би зүгээр нэг жишээ хэлье л дээ. Саяхан би нэг яамны веб сайт руу нь ороод тэн дээр байгаа мэдээллийг Авлигын тухай хуульд заачихсан заавал нээлттэй байлгах ёстой мэдээллүүдийн жагсаалттай тулгаж үзэхэд хуулиар шаардагдаж байгаа мэдээллийн дөнгөж 20% нь тэр яамны веб сайт дээр байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ болбол нийтлэг байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр бидний яагаад хууль дээр тийм заалт үүрэг өгчхөөд байхад хууль чинь хэрэгжихгүй байна вэ гэдгийг системийнх нь хувьд нь шинжлэхгүй болбол энд тэнд очоод хэдэн мянган амлалт өгөөд хоосон амлалт болоод л дуусна. Тийм учраас би энэ системийн шинжилгээ гэдэг юмыг заавал хийгээрэй гээд байгаа юм. Энэ маш чухал шүү. Энийг үнэхээр бодитой, иргэн болгонд хүртээмжтэй, чухал ажил болгоё. Эхлээд заавал шинэчлэх хэрэгтэй. За баярлалаа.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа:

Ажлын хэсгийн гишүүний хувьд санал хэлэх гэсэн юм. Худалдан авалтын нээлттэй байдал гэдэгтэй холбоотойгоор манай эрүүл мэндийн салбар, тэр тусмаа эм хангамжийн салбарт эмийн худалдан авалт, тендерийн асуудал, төрийн худалдан авалтыг эм эмнэлгийн хэрэгсэл дээр явдаг. Тэгэхээр энэ Ажлын хэсэг дээр тэр талын ТББ-ын хүмүүсээс нэмбэл яасан юм бэ. Тухайлах юм бол одоо эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын тендер бол эмнэлгүүд дээр болон төрийн худалдан авах ажиллагааны газар дээр тусчихдаг, зохион байгуулагдаад явдаг. Тэгэхээр тэр чиглэлийн ТББ-ын хүмүүсийн оролцоо байвал зүгээр юм уу?

Тэр чиглэлийн ТББ эсвэл зүгээр эм хангамжийн салбарт миний мэдэж байгаагаар бол 3 ТББ, холбоо байдаг. Тэгэхээр тэд нараас нь бас энэ ажлын хэсгийн төлөөлөл оролцуулбал яасан юм бэ гэсэн санал байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

За сая санал хэллээ. Ингээд өөр санал, асуулт байхгүй гэж ойлголоо. Гэхдээ Ажлын хэсгийн гишүүд, Ажлын хэсгийн нарийн бичигтэйгээ ярьж байгаад Болортуяа зөвлөхийн хэлсэн горимын саналын дагуу хүмүүсийнхээ чиглэл, илүү

мэргэшсэн байдлуудыг нь харж байгаад ийм байдлаар та багт орж ажиллахад болж байна уу гэдгийг нь хуваарилчхаад эргээд та бүхнээсээ нэг санал авъя.

Би Жаргалсайхан гуайн хийсэн системийн шинжилгээ дээр манай байгууллагаас яг энэ төлөвлөгөө гарсны дараа биелэлтээр нь процессын шинжилгээ хийнэ гэж хэлье. Ер нь ЗГ-аас сая процессын дахин инженерчлэлийг ЗГ-ын түвшинд цогц байдлаар 8 аргачлалыг нэг дор (чиг үүргийн эрсдэл, ажлын байрны сэтгэл ханамж, гэх мэт) анх удаа нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хийгээд засаг дээр танилцуулсан. Тэрэн дээр яг таны хэлж байгаа дүр зургууд, тэр олон ажлуудын нэг нь байгаа байхгүй юу. Энэ байгууллагын нийгмийн даатгалын хөдөлмөрийн халамж нээлттэй байж чадаж байна уу? Тэгэхээр манай байгуулагаас яг энэ тандалт судалгааны багийн ахлах орж байна гэдэг маань бид нарын төлөвлөгөө энэ ажлын хэсгээс гарлаа. Иргэний нийгмийн байгууллагатайгаа хамтраад бид нар яг явц дунд нь төрийн байгууллагууд дээр ажиллах болно. Манайхаас бол процессын дахин инженерчлэл гээд ярьж байгаа, тийм зүйлүүдийг үе шаттайгаар хийж байгаа. Өмнө нь бид процессын дахин инженерчлэл гээд уулзаж байсан шүү дээ. Тэгээд тусдаа бас хоёулаа системийн шинжилгээгээрээ уулзаж ажлын санал солилцъё гэдэг саналыг тавья.

За ингээд та бүхэнд өшөө санал байхгүй болбол манай нарийн бичигт юм уу эсвэл надад Ажлын хэсгийн ахлагчид өшөө асууж тодруулах зүйл, санал байсан бол хэлэхэд нээлттэй шүү. Утсаар, бичгээр, цахимаар аль ч хэлбэрээр болно.

Ажлын хэсгийн хуваарь ёсоор хэдүүлээ өнөөдөр Ажлын хэсгийн анхны хурал боллоо. 11 дүгээр сарын 9-ны өдөр анхдугаар хуралдаанаас гарсан шийдвэр өөрчлөлт сайжруулалтыг төлөвлөгөөний төсөлд тусган ажлын хэсгийн гишүүддээ илгээнэ. За ингээд ажлын хэсгийн II хуралдааныг зохион байгуулна, 16-ны өдөр товлож байгаа шүү. За 16-ны хуралд аль болох манай иргэний нийгмийн төлөөллүүдээ болж өгвөл танхимаар за болохгүй бол цахимаар оролцоход асуудал байхгүй шүү дээ. Төрийн байгууллагын албан тушаалтнуудыг Номинчимэг заавал оролц гээрэй. Энэ хүмүүс бол иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл. Ингээд орж ирж байхад төрийн байгууллагуудаас өнөөдөр бол 3-4 газрын дарга байхгүй байна. Энийг бүр амаар хатуу анхааруулаад дараагийн хурал дээр хэрвээ орохгүй болбол өөрөөр асуудал яригдана шүү гэдэг зүйлүүдийг хэлээрэй.

Иргэний нийгмийн төлөөллийн хүмүүстэй Ажлын хэсгийн гишүүдийг оруулаад бид нарын ирц 60 хэдэн хувьтай л байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ идэвхтэй оролцож байж л дараа нь аль аль талдаа хариуцлагаа ч ярьдаг, үүргээ ч ярьдаг, гавьяагаа ч ярьдаг тийм байвал нөгөө баланс нь тэнцвэртэй болох байх аа.

За тэгээд 11 дүгээр сарын 23-ны өдөр бид ажлын хэсгийн III хуралдааныг хийхээр төлөвлөж байгаа. За ингээд III хуралдаанаас ер нь гол зүйлүүд гарчихна гэсэн үг. III хуралдаанаас гарсан шийдвэр, өөрчлөлт, сайжруулалтыг бид нар төлөвлөгөөний төсөлд тусган эцэслэн боловсруулаад төлөвлөгөөний төслийг НЗТҮЗ-д танилцуулж батлуулах ёстой байгаа. Мөн хэлэлцүүлэг хийх ёстой, ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа шүү. Тэгэхээр Ажлын хэсэгт өнөөдөр ирсэн байгаа гишүүд маань идэвхтэй санаачилгатай оролцохыг би хүсье. Ер нь өнөөдрийн уур амьсгалыг харж байхад нэлээн идэвхтэй, үр дүнтэй, үр нөлөөтэй ажиллах байдал миний хувьд ажиглагдаж байна. Ингээд өнөөдөр цаг заваа гарган Ажлын хэсгийн анхны хуралдаанд ирсэнд баярлалаа. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдэе.

Хуралдаан 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 16.30 цагт өндөрлөв.

Хуралдааны тэмдэглэлийг хөтөлсөн:

МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 2024-2027 ОНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨ ВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.НОМИНЧИМЭГ

Areas of Opportunity for Mongolia

Буцах

Нээлттэй засгийн түншлэлийн Ажлын хэсгийн анхдугаар хуралдаан болов

08 Nov 2023 share

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөөний төсөл боловсруулж танилцуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлсан. Ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хуралдаж төлөвлөгөөний агуулгыг боловсруулж эхэллээ. Үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөөний төсөл боловсруулах явцад Нээлттэй засгийн түншлэлийн Хараат бус тайлагнах механизмаас иргэний нийгмийн орон зайг тэлэх, олборлох салбарын ил тод байдлыг сайжруулах, төрийн худалдан авах ажиллагааг ил тод болгох, зөвлөдөх ардчиллыг бэхжүүлэх мөн өмнөх төлөвлөгөөний хугацаанд хэрэгжиж дуусаагүй үүрэг амлалтуудыг үргэлжлүүлэн ажиллахыг зөвлөсөн.

- **Олон улсын дэмжлэг ба солилцоо:** Гадны оролцогчид үндэсний болон орон нутгийн өөрчлөлтийг удирддаггүй ч гэсэн дотоодын хүчин чармайлтыг дэмжиж нээлттэй засгийг илүү сэтгэл татам мөн магадлалтай болгодог өргөн цар хүрээтэй нөхцөл байдалд хувь нэмрээ оруулдаг. Олон улсын тавцан, стандарт, арга хэмжээний нэг хэсэг байх нь нээлттэй засгийн амлалтыг бий болгож, дэмжлэг үзүүлэхэд тусалдаг. Бусад орчны удирдагчид болон шинэтгэгч нартай холбогдох, одоогийн нөхцөлөөс суралцах, бусдаас урам зориг авах нь энэ ажилд үндэсний болон орон нутгийн удирдагчдыг дэмжин тусалж чадна.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1:

Нээлттэй засгийн шинэтгэгч, активист, тэмцэгч нарыг багтаасан өсөн нэмэгдэх, тууштай, харилцан уялдаатай олон нийтийг бий болгох

НЗТ-ийн хамгийн том хүч чадал бол нээлттэй засгийн шинэтгэгч, активист, тэмцэгч нарыг бүрдүүлдэг олон нийт юм. 2011 онд Засгийн газар, иргэний нийгмийн удирдагчдын жижиг бүлэг байгуулагдсанаас хойш НЗТ-ийн олон нийт илүү том, олон талын төлөөлөлтэй болсон.

Өнөөдөр хамгийн идэвхтэй гол гишүүн орнуудын Засгийн газар, иргэний нийгмийн шинэтгэгч нар орон нутгийн болон салбарын удирдагчид, парламентын гишүүд, залуучуудын байгууллага, жендэрийн тэгш эрхийн чиглэлээр ажилладаг бүлгүүд, эрдэмтэд, цөөн тооны тохиолдолд хувийн хэвшлийн төлөөлөгчид, шүүгчид, хэвлэл мэдээллийнхэн нэгдээд байна. НЗТ-ийн алсын хараат бодит болгоход үндэсний болон орон нутгийн орчинд энэ чичирхийлсэн хөдөлгөөнийг давтах, илүү том, хүчирхэг хөдөлгөөнийг нэмснээр нээлттэй засгийн удирдагчид, эвслүүд өөрийн орчинд өөрчлөлт авчирч харилцан суралцахад түлхэц болно.

Нээлттэй засгийн эдгээр удирдагчдыг дэмжих хэрэгтэй. Ингэснээр олон нийт улам бүр өргөжин тэлж, амбицтай шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх ур чадвар, сүлжээ, нөөц боломж, арга хэрэгсэл, сэтгэлгээтэй болох юм. Мөн тэдний ажлыг бэхжүүлэх, хурдан суралцах боломжийг олгодог үндэсний, сэдэвчилсэн, дэлхий дахины сүлжээний нэг хэсэг болж хоорондоо холбогдох хэрэгтэй.

Дэлхий даяар НЗТ нь олон улсын байгууллага, платформ, сүлжээтэй хүчтэй түншлэлийг бий болгосноор нээлттэй засгийн сэдвүүд хэрэгжих хөтөлбөрт багтдаг болсон. Одоо байгаа эдгээр түншлэлийг улам хүчтэй болгох, тус Стратегийн салбарыг урагшлуулахад туслахын тулд шинээр түншлэл мөн бий болгох хэрэгтэй.

НЗТ-ИЙН ОЛОН НИЙТ ЭНЭ ЗОРИЛГОДОО ХЭРХЭН ХҮРЧ ЧАДАХ ВЭ?

Түншлэлд хамаардаг Засгийн газар, иргэний нийгмийн удирдагчид нь нээлттэй засгийн олон нийтийг орчны хувьд мөн дэлхийн нөхцөлд илүү өргөн цар хүрээтэй болгож, бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үндэсний болон орон нутгийн түвшинд нээлттэй засгийн үндсэн удирдагчид болон олон талт оролцогч гишүүдийг багтаадаг бөгөөд эдгээр хүмүүс бусад боломжит холбоотнууд болох яамд, ахлах удирдагчид, яам болон агентлагийн мэргэжилтнүүд, засгийн газрын салбар бүрийн тэмцэгчид, илүү өргөн цар хүрээтэй иргэний нийгмийн байгууллагуудыг оруулдаг. Дэлхий даяар мөн НЗТ-ийн үндсэн хорооны гишүүд болох сайд болон иргэний нийгмийн байгууллагын гишүүд улс төрийн илүү их хөрөнгө мөнгө, цаг хугацаагаар хөрөнгө оруулах хэрэгтэй байна.

НЗТ-ийг Дэмжих нэгж нь өөрийн нөөц бололцоогоо зориулж дэлхийн болон бүс нутгийн арга хэмжээг зохиох, нээлттэй засгийн удирдагчдыг амжилтад хүрэхэд шаардлагатай арга хэрэгслээр хангах, нийгмийн өөр өөр хэсгүүдийн дунд холбоо тогтоох хэрэгтэй.

НЗТ-ийн олон нийтийн хүч чадал нь нийтлэг ашиг сонирхолтой өөр өөр салбаруудад оршдог. Жишээ нь, нээлттэй өгөгдөл, мэдээллийн хүртээмж, худалдан авалтын шинэчлэл дээр ажиллаж буй бүлгүүд байна. НЗТ-ийн орон зай болох арга хэмжээ, солилцоо нь цаашид ч илүү нэгдсэн бодлого боловсруулахад хүргэдэг харилцан ярианы боломжуудыг дээд зэргээр ашиглах зорилготой хэвээр байх болно.

2023-2028 ОНЫ СТРАТЕГИЙН ХУГАЦААНД ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

1. Нээлттэй засгийн газрын төлөө илүү хүчирхэг, илүү улс төрийн дэлхий дахины эвсэл байгуулах

Улс төрийн манлайлал нь нээлттэй засгийн шинэчлэлийг төлөвшүүлэн дэмжихэд нэн чухал юм. Үүнд төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, сайд нар, орон нутгийн удирдлагууд, ахлах зэрэгтэй төрийн албан хаагчид багтах бөгөөд тэд Засгийн газарт манлайллыг түгээж иргэний нийгмийн эвсэл зэрэг улс төрийн хүчний гадаад эх үүсвэртэй хамтран ажиллах болно.

Сайд болон Засгийн газрын тэргүүний түвшний оролцоо нь эхэн үеийн маш өндөр үзүүлэлтээс буурсан байна. Энэ хандлага нь дэлхий даяар ардчилал арван жилийн хугацаанд ухарч буйтай давхцаж, ардчилал болон нээлттэй засгийн төлөөх улс төрийн удирдлага олон оронд маш ихээр алга болж байгаатай холбоотой.

Ирэх таван жилд нээлттэй засаг болон НЗТ-д илүү өргөн цар хүрээтэй хүчин чармайлт оруулах шаардлагатай бөгөөд хотын дарга нар, парламентын гишүүд, сайд, төрийн болон засгийн газрын тэргүүнүүдийг дайчлах хэрэгтэй байна. Энэ нь ирээдүйн тэмцэгч нарт зориулсан дэд бүтцийг бий болгох бөгөөд удирдагч солигдсон ч нээлттэй засгийн шинэчлэлийг нэн тэргүүнд авч үзэхээ болих болон эмзэг бус байдлаас сэргийлэх болно.

Энэ бэрхшээлийг даван туулах хэд хэдэн өргөжүүлэх шаардлагатай арга барил байх бөгөөд зарим шинэ аргуудыг мөн туршиж үзэх хэрэгтэй.

Нэгдүгээрт, нээлттэй засгийн дэмжигчид улс төрийн ач холбогдолтой төлөвлөгөө болон тэргүүлэх асуудал дээр илүү сайн холбоог үүсгэж, улс төрийн үйл ажиллагааны өдөөлтийг бий болгох хэрэгтэй. Өөр өөр түүхтэй, өөр зүйлсийг эн тэргүүнд авч үздэг улс төрийн удирдагчдын сонирхлыг татахын тулд нотолгоо дээр суурилсан зоригжуулах түүхтэй, бусад улс оронтой харьцуулсан мэдээлэлтэй байж өөрийгөө бэлтгэн зэвсэглэсэн байна гэсэн үг юм. Түүнчлэн Сайд нарын түвшний Удирдах Зөвлөл болон НЗТ-ийг Дэмжих нэгж нь ирээдүйд сонгогдох болон төрийн албаны удирдагч нарыг оролцуулаад улс төрийн шинэ тэмцэгчдийн илүү өргөн цар хүрээтэй бие бүрэлдэхүүнийг сайн тодорхойлж, дэмжин, анхаарлын төвд авчрах хэрэгтэй.

Хоёрдугаарт, НЗТ-ийн бүс нутгийн болон дэлхийн дээд хэмжээний уулзалтуудыг тусгайлан олон улс төрийн оролцогчдын олон нийтийг бүрдүүлэх, улс төрийн хувьд ач холбогдолтой хэлэлцүүлгийг өрнүүлэх, удирдагчдаас тодорхой амлалтуудыг авахын тулд зохион байгуулдаг. Ингэснээр эдгээр арга хэмжээ нь өндөр түвшний оролцогчдод илүү сонирхолтой байх, одоогоор гишүүнчлэлгүй оролцогчдыг мөн татан оролцуулахыг хэлнэ.

Гуравдугаарт, НЗТ-ийн гишүүд өөрийн ГХЯ-тай хамтран бусад олон улсын үүрэг, амлалтуудтай уялдаа холбоог хангахын тулд ажиллах ёстой.

Дөрөвдүгээрт, Удирдах хорооны гишүүд НЗТ-ийн улс төрийн удирдлагын төлөөллийн хувьд орон нутгийн НЗТ-ийн үйл явцад үлгэрлэн манлайлж, олон улсад НЗТ болон Стратегийг ойлгон дэлгэрүүлэхэд удирдан чиглүүлэх хэрэгтэй.

Тавдугаарт, НЗТ-ийн элчин сайд болон элч төлөөлөгчдийн сүлжээ нь улс төрийн үүд хаалгыг нээх, улс төрийн холбоо үүсгэх боломжийг эрэлхийлэхэд илүү идэвхтэй оролцоно.

Зургаадугаарт, НЗТ нь гишүүн бус орнуудад нээлттэй засгийн хөгжил дэвшлийг дэмжих, санаачлахад илүү ихийг хийх болно. Нэн тэргүүнд НЗТ-ийн загварыг бие даан ашиглахыг дэмжих явдал юм. Үүнд ойрын ирээдүйд нэгдэх шаардлагыг хангасан орнуудад тодорхой дэмжлэг үзүүлнэ. Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй улс орнуудад оролцох тодорхой хувилбаруудыг Удирдах хороо шийдвэрлэнэ.

Орон нутгийн түвшинд гишүүн бус орнуудын эрх зүйн гишүүнчлэлийн хувилбаруудыг боловсруулна.

Эцэст нь хэлэхэд улс төрийн удирдагчид, төрийн албан хаагчдад шинэчлэлийг хэрэгжүүлэх, урагшлуулах хөшүүрэг бий болгодог нээлттэй засгийн төлөө олон нийтийн эрэлт хэрэгцээ их байх хэрэгтэй. НЗТ нь дэмжлэгтэй улс орнуудаас суралцах, сурсан зүйлээ хуваалцах орон зай байх болно. Ингэснээр Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллага илүү өргөн цар хүрээтэй олон нийтийг оролцуулах арга хэрэгслүүдтэй болно. Зарим нөхцөлд энэ нь нийгмийн хөдөлгөөн болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах орно.

2. Шинэтгэгч нарын манлайллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийх

Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагын бие даасан шинэчлэлийг, тэр ч байтугай хүнд нөхцөлд ч удирдан, дэмжиж чаддаг байх нь НЗТ-ийн олон нийтийн амин чухал хэсэг юм. НЗТ нь бусад оронтой туршлага солилцох, мэдлэг хуваалцах, техникийн тусламж авах платформ юм. Ирээдүйд ч мөн адил одоогийн болон ирээдүйн олон нийтийн удирдагчдын манлайлах ур чадварыг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулах болно. Ийм удирдагчид төрийн ахлах ажилчид, иргэний нийгмийн удирдагчид, дэд сайд нар, шинээр гарч ирж буй улс төрийн удирдагчид, парламентын гишүүд, үндэсний болон дэд салбарын бусад шүүмжлэлт шинэтгэгч нар багтах бөгөөд бүлэг бүр бусдад урам зориг өгөх эсвэл нээлттэй засгийн шинэчлэлийг урагшлуулах боломжтой.

Бүгд Найрамдах Доминикан Улсын Ёс зүй, Засгийн газрын үнэнч шударга байдлын сайд НЗТ-ээр дамжуулан дэвшүүлсэн шинэчлэлийг хуваалцаж байна. НЗТ-ийн гэрэл зураг

Шинэтгэгчийн удирдлага, дасан зохицох чадварыг дээшлүүлэх, нарийн төвөгтэй өөрчлөлтийг даван туулах, нээлттэй засгийн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэхэд туслах улс төрийн болон олон нийтийн дэмжлэгийг баталгаажуулах, нээлттэй засгийн ур чадварыг эзэмшихэд гол анхаарлаа хандуулна. Эдгээр ур чадварууд нь Засгийн газрын практик, бодлого, үйлчилгээнд олон нийтийг тэгш хамарсан оролцоог шигтгэх; утга учиртай болон идэвхтэй ил тод байдлыг дэмжих; иргэний орон зайг өргөтгөхөд оршино.

Тэргүүлэх ач холбогдолтой энэ зүйлийг хоёр тодорхой арга замаар ахиулна.

Нэгдүгээрт, НЗТ-ийн гишүүд болон Дэмжигч нэгж нь төр, төрийн бодлого, улс төрийн сургуулиуд болон бусад суралцах түншүүд, мэргэшсэн хүмүүс ба сонсогчидтой илүү нягт хамтран ажиллах болно. Эстон, Кени, Нигери, Испани зэрэг нэлээд хэдэн улсад төрийн албан хаагчдад нээлттэй засгийн сургалт явуулдаг бөгөөд тэдний сурч мэдсэн зүйлийг хуваалцаж болно. Мөн Баруун Балканы Олон нийтийн удирдлагын бүсийн сургууль, Латин Америкийн НҮБ-ын Эдийн засгийн комисс, Америк дахь Карибын орнууд (ECLAC-CEPAL) зэрэг сүлжээнүүд энэ ажлыг бүс нутгийн түвшинд анхдагч болгосон байна.

Үүний зорилго нь ач холбогдол бүхий оролцогчдод нээлттэй засгийн үзэл бодол, арга барилыг ил болгох, нээлттэй засгийн сургалтад оролцон төгссөн хүмүүсийн сүлжээг бий болгож, тэдгээр ур чадварыг ажлын хүрээндээ ашиглахад оршино. Эцсийн зорилго нь нээлттэй засгийн ур чадварыг Засгийн газар болон түүнээс цааш тараах явдал юм. НЗТ-г Дэмжих нэгж нь эдгээр байгууллагатай хамтран Нээлттэй засгийн анхан шатны ойлголт олгох сургалт болон олон нийт суралцах хөтөлбөрийг хамтран боловсруулна. Энэ нь НЗТ-г зоригжуулах, нотолгоонд суурилсан нээлттэй засгийн агуулга, суралцах хүчин чармайлтын нэг хэсэг байх болно.

Хоёрдугаарт, НЗТ Дэмжих нэгж нь өөрийн нөхцөлд өөрчлөлтийг жолоодож чадах, бие биеэ дэмждэг сүлжээг бий болгож чадах шинэтгэгч нарыг бүс нутгийн болон сэдэвчилсэн бүлгээс сонгон авч манлайллын хөтөлбөрийг өргөжүүлж, олон янзаар хөгжүүлэх болно. Ингэснээр Нээлттэй Засгийн Удирдлагын Хамтын Ажиллагаа нь туршилтын үеийг амжилттай давах юм. Цаг хугацаа өнгөрөх тусам НЗТ нь ийм хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагын институттэй хамтран ажиллах талаар судалж, чанарын хяналт, хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгох схемийг танилцуулна.

3. Нээлттэй засгийн зарчмыг бататгахын тулд стратегийн холбоо, түншлэлийг өргөжүүлэх

Шинэ оролцогчдод хүрч, олон нийтэд сурталчлах боломжийг бий болгохын тулд дэлхий дахины болон бүс нутгийн холбоо, түншүүдийн өргөн багц шаардлагатай. Тухайлбал, олон талын оролцоотой байгууллага, олон улсын сүлжээнүүд нь нэгдсэн зорилготой байх нь нээлттэй засгийн зарчмуудыг өөрсдийн стратеги, үйл ажиллагаагаар дамжуулан өргөжүүлэх, нутагшуулах боломжтой байдаг. Энэ нь Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (OECD)-ын Нээлттэй Засгийн асуудлаарх Зөвлөлийн зөвлөмж, Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг олон улсын хөтөлбөрт нөлөөлөх санаачилгуудаар дамжуулан нээлттэй засгийн талбарыг өргөжүүлэхэд тусалсан. НЗТ нь нэг талаас дэлхий нийтийн тавцан болон гэрээ хоорондын уялдаа холбоо бүхий эд эс, нөгөө талаас орон нутгийн хэрэгжүүлэгч, мөн ХБТМ-аар дамжуулан эгэх хариуцлага хүлээх түншлэл болж өөрийгөө бий болгосон.

Ирээдүйд Түншлэл нь илүү санаачилгатай, стратегийн арга барилаар дамжуулан нээлттэй засгийн хөдөлгөөнийг бэхжүүлэх, тэргүүний сэдэвчилсэн амлалтыг урагшлуулах, нээлттэй засгийн арга барилыг түгээн дэлгэрүүлэх холбоотон, платформ, түншлэлийг ашиглах болно.

Үндэсний болон орон нутгийн НЗТ-ийн үйл явцыг НЗТ-ийн олон нийт Ардчиллын төлөөх дээд хэмжээний уулзалт, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, Авлигын эсрэг олон улсын чуулган, бүс нутгийн байгууллагууд зэрэг дэлхийн хэмжээний амлалтуудыг нэгтгэхэд ашиглаж болно.

Мөн чухал мөчүүдэд хамтын хүч, дуу хоолойгоо ашиглан НЗТ-ийн Удирдах хороо, элчин сайд, элч төлөөлөгчид илүү ач холбогдол өгөх болно. Түүнчлэн НЗТ-ийн тэргүүлэх чиглэл дээр тулгуурлан шинээр гарч ирж буй олон нийтийн бодлогын сорилт бэрхшээлүүдэд илүү идэвхтэй цуглан хэлэлцэх, хөтөлбөр тогтоох үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь COVID-19 тахлын үеийн Ашиг тустай удирдлагын бүлэг, Нээлттэй хариулт + Нээлттэй нөхөн сэргээх кампанит ажил зэрэг өмнөх хүчин чармайлтууд дээр тулгуурлах болно.

Мөн НЗТ-ийн Удирдах хороо, Дэмжих нэгж нь өөрчлөлтийг жолоодож буй шинэтгэгч нарыг дэмжиж чадах шинэ болон хуучин хамтрагч байгууллагуудтай илүү хүчирхэг түншлэл бий болгоход хөрөнгө оруулалт хийх болно. Үүнд Европын Холбоо, ECLAC-CEPAL зэрэг олон улсын байгууллагууд, дэлхийн, бүс нутгийн, үндэсний түвшний техникийн хэрэгжүүлэлтийн түншүүд орно.

Нигерийн төрийн албан хаагчид болон иргэний нийгмийн байгууллагууд ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр компаниудын эзэмшигчдийн хууль бус санхүүгийн урсгалыг зогсоох асуудал дээр хамтран ажиллав. Нигер Улсын Төсөв, Үндэсний төлөвлөлтийн яамны гэрэл зураг

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2:

Төрийн бүх түвшинд, салбарууд тэргүүлэх ажлыг хэрхэн хэрэгжүүлэх дээр нээлттэй засгийг төвлөрүүлэх

НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ нь тодорхой үйлдэл, иргэний нийгмийн байгууллагатай хамтран бүтээх, эгэх хариуцлага дээр суурилдаг. Үүний тулд засгийн газрууд иргэний нийгмийн байгууллагатай хамтран Засгийн газрын тодорхой нээлттэй шинэчлэлийг хийж хэрэгжүүлэх, мөн ХБТМ, орон нутгийн оролцогчид болон бусад мониторингийн ажлуудаар дамжуулан эгэх хариуцлага шаардах боломжтой. Энэ хүрээ нь гоё хоосон үгнээс илүү нээлттэй засгийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нь чухал болохыг харуулдаг юм. Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага хоорондын хамтын бүтээлийн НЗТ-ийн гол загвар нь сайн хийгдсэн үед амбицтай амлалт, хүчтэй үр дүнг бий болгодгийг сүүлийн арван жил бидэнд харуулсан.

Цаг хугацаа өнгөрөх тусам хэрэгжиж, зохион байгуулалтад орсон, амбицтай шинэчлэл хийх боломжийг олгож, урам зориг өгөхийн тулд НЗТ-ийн одоогийн үйл ажиллагааны хүрээг бэхжүүлэх хэрэгтэй байна. Хамрах хүрээ нь хамтран бүтээх, хэрэгжүүлэх, хянах, эгэх хариуцлага хүлээх, хамтарсан олон талт хамтын ажиллагааны НЗТ-ийн гол загварын зарчмуудыг баримтлах талаар бүх гишүүдээс нийтлэг хүлээлтийг хадгалахын зэрэгцээ өөр өөр нөхцөл байдал, хэрэгцээнд зориулагдсан байх хэрэгтэй.

Өнөөдөр зарим НЗТ-ийн гишүүн орнууд болон оролцогч орон нутгийн эрх мэдэлтнүүдэд нээлттэй засгийн урт хугацааны стратеги боловсруулах, үндэсний хөгжлийн төлөвлөгөө буюу салбарын нэн тэргүүний хөтөлбөрүүдэд нээлттэй засгийн зарчмуудыг шигтгэх, нээлттэй засгийн хөтөлбөр, үйл ажиллагааг өргөжүүлэн орон нутгийн засаг захиргаа, парламент, шүүх, хяналтын байгууллагуудыг хамруулах зэрэг ажлууд хийгдэж байна. НЗТ-ийн алсын хараа нь ийм хүчин чармайлтыг гүнзгийрүүлж, зохион байгуулалтад оруулж, илүү олон газарт давтан хэрэгжүүлсэн тохиолдолд л хэрэгжих болно.

Засгийн газрууд хэрхэн ажилладагтай салшгүй нэг болгох хүчин чармайлттай зэрэгцэн дэлхий даяар, улс орны, орон нутгийн түвшинд нээлттэй засгийн замналыг өөрчилж болох томоохон үйл явдалд илүү сайн бэлтгэж, хариу үйлдэл үзүүлэх хэрэгтэй. Эдгээр үйл явдал нь томоохон авлигын жигшүүрт явдал, улс төрийн болон нийгмийн чухал явдлыг тодорхойлох болно. Жишээлбэл, улс төрийн томоохон шилжилт, эсэргүүцэл эсвэл дэлхий дахинаа төлөвлөгөө тогтоох түүхэн мөчүүд зэрэг хямралын үетэй холбоотой байж болно.

Засгийн газрууд, иргэний нийгмийн байгууллага, олон талын оролцогчдод боломж олгох "цонх"-нд хариу үйлдэл үзүүлж, дэлхий дахины түншүүд тэднийг хэрхэн дэмжиж болохыг тодорхойлоход нэгдмэл байдлыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. НЗТ-ийн гэрэл зураг

НЗТ-ИЙН ОЛОН НИЙТ ЭНЭ ЗОРИЛГОДОО ХЭРХЭН ХҮРЧ ЧАДАХ ВЭ?

Үндэсний болон орон нутгийн түвшинд Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд нь урт хугацааны стратегийн шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НЗТ-ийн платформ, үйл ажиллагааны хүрээг ашигладаг. НЗТ-ийн үндэсний болон орон нутгийн оролцогчид эсвэл олон талын оролцогчид нь нээлттэй засгийн нөхцөлд зохион байгуулах боломжийг үнэлэх, НЗТ-ийн хүрээнд нээлттэй засгийн ажлыг илүү сайн холбох, зөв тэмцэгчдийг оролцуулах, нээлттэй засгийн үндэсний болон салбарын гол стратеги, хөтөлбөрүүдэд оруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Түүнчлэн засгийн газрын нээлттэй хөтөлбөрт нам хоорондын дэмжлэгийг бий болгоход Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага, олон талын оролцогчид үүрэг гүйцэтгэдэг. Тэд боломж гарахад үр дүнтэй хариу үйлдэл үзүүлж, дэлхийн оролцогчид тэднийг хэрхэн дэмжиж болохыг тодорхойлоход туслахын тулд эвсэл байгуулах хэрэгтэй болно. Дэмжих нэгж нь гишүүдийн дунд туршлага солилцох, суралцах боломжийг олгож, ирээдүйд ижил хэрэгцээтэй тулгарах бусад хүмүүсийн хэрэгжүүлж болох хамтын нөөц боломж, арга хэрэгсэл, мэдлэгийг хадгалахын тулд ажиллана.

НЗТ-ийг Дэмжих нэгж нь Удирдах хорооны удирдлага дор үйл ажиллагааны хүрээнд дэмжих дэд бүтцийг бий болгоно: дүрэм, удирдамж, үйлчилгээ болон суралцах боломж. Мөн Дэмжих нэгж нь нөхцөл нь бүрдсэн, нэгдсэн арга барилыг харуулах нотолгоотой, нээлттэй засгийг бүх салбар, түвшинд нэвтрүүлэх олон улс орнуудад цаг хугацаа, нөөц бололцоогоор хөрөнгө оруулна.

2023-2028 ОНЫ СТРАТЕГИЙН ХУГАЦААНД ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

1. Олон төрлийн орчин, хэрэгцээнд тохирсон уян хатан үйл ажиллагааны хүрээгээр хангах

НЗТ-ийг Дэмжих нэгж нь Удирдах хорооны удирдлага дор олон нийтээс ирэх санал дээр суурилан уян хатан үйл ажиллагааны хүрээг боловсруулах бөгөөд үүнийг гишүүд өөрсдийн нөхцөлд тохируулж нээлттэй засгийг урагшлуулахын тулд ашиглах болно. Зарим хүмүүсийн хувьд энэ нь нээлттэй засгийн стратеги боловсруулна гэсэн үг байж болох юм, харин бусад хүмүүсийн хувьд хязгаарлагдмал улс төрийн дэмжлэг, захиргааны чадавхаас шалтгаалан тодорхой сэдэв, салбарт анхаарлаа хандуулах гэсэн үг байж болох юм. Олон хүний хувьд НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний одоогийн загварыг үргэлжлүүлсээр байна гэсэн үг байж болно.

Энэ хүрээнд гишүүд нээлттэй засгийн үйл ажиллагааг урагшлуулахын тулд тодорхой арга замыг сонгож байгаагаас үл хамааран хамтын бүтээл, үйл ажиллагаа, хэрэгжүүлэлт, хяналт, эгэх хариуцлага, суралцах гэсэн НЗТ-ийн зарчмуудыг баримтлахыг чухалчлах болно. Түүнчлэн орон нутгийн НЗТ, НЗТ-ийн гишүүд, НЗТ-ийн парламентын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хамаарах өөр өөр үйл ажиллагааны загваруудыг үндсэн хүрээнд нэгтгэхээс гадна Засгийн газрын өөр өөр салбаруудад тохирсон нэмэлт онцлогтойг анхаарах болно. Энэхүү шинэ хүрээнд шинэчлэгдсэн дүрэм, удирдамж, үйлчилгээ дагалдах болно.

2. Нээлттэй засгийн үйл ажиллагааг бүх түвшинд, төрийн ажлын салбаруудад голлон дэмжих

Үндэсний болон орон нутгийн хэд хэдэн нөхцөлд нээлттэй засгийн шинээр бий болсон хүчин чармайлтууд хийгдэж байна. Гэвч гишүүдийн дийлэнх нь нээлттэй засгийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, нээлттэй засгийн ажилд өөр өөр салбар, түвшнийг оролцуулахын тулд илүү суурь ажил хийх шаардлагатай байна.

Энэ ажлыг хэрэгжүүлэхийн тулд одоо байгаа хэд хэдэн арга барилыг өргөжүүлж, зарим шинэ аргуудыг турших болно. Эдгээр хүчин чармайлт нь НЗТ-ийн гишүүдэд нэмэлт шаардлага тавих эсвэл НЗТ-ийн брэнд дор үндэсний болон орон нутгийн нөхцөлд явагддаг нээлттэй засгийн бүх ажлыг авчрах гэсэн үг биш юм.

Нэгдүгээрт, нэн тэргүүнд засгийн газрын нээлттэй хөтөлбөрт өөр өөр салбар, түвшнийг хамруулах нэгдсэн арга барил хэрэгтэй болно. Энэ нь үндэсний болон орон нутгийн Засгийн газар, парламент, шүүх, хяналтын байгууллагууд нь ганцаарчилсан үйл явцтай төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн оронд бодлогын тодорхой салбарыг урагшлуулах эсвэл Засгийн газрын өргөн хүрээтэй нээлттэй стратеги боловсруулахад гүйцэтгэж болох үүрэгт анхаарлаа хандуулна гэсэн үг юм. Энэ нь НЗТ-д парламентын оролцооны тухай 2021 оны бодлогод заасан нээлттэй засгийг урагшлуулахад парламентын гүйцэтгэх үүрэг, 2020 оны НЗТ-ийн орон нутгийн стратегид үндэсний хэмжээнд интеграцид онцгой анхаарал хандуулахтай нийцэж байна.

НЗТ-ийг Дэмжих нэгж болон түншүүд нээлттэй засгийг дараагийн түвшинд хүргэхэд бэлэн байгаа цөөхөн улсад оруулах хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд тавина. Үүний хариуд эдгээр удирдагчид бусдыг дагахад нь нөлөөлж, дэмжих үүрэгтэй. Засгийн газрууд ийм нэгдсэн арга барилыг эхлүүлж чадахгүй бол иргэний нийгмийн байгууллага нь дэлхий дахины болон бүс нутгийн түншүүдийн дэмжлэгтэйгээр, НЗТ-ийн Удирдах хороо, Дэмжих нэгжийг сурталчилгаа хийх зэргээр хөтөлбөрийг холбоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Үндэсний салбарын түвшинд ажилладаг орон нутгийн болон бүс нутгийн холбоо эсвэл хараат бус байгууллага нь НЗТ-ийн манлайлагч болж НЗТ-тэй адил хамтын бүтээлийн үйл явц, үйл ажиллагааны төлөвлөгөөг өргөн хүрээнд орон нутгийн шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх боломжтой. Үүнээс гадна, НЗТ-ийн Орон нутгийн хэв маяг нь бусад газарт нээлттэй засгийн амбицтай шинэчлэлийг манлайлах, нөлөөлж буй тэмцэгчид, шинийг санаачлагчдын бүлэг болж тогтвортой өсөх болно.

Орон нутгийн түвшинд шинэчлэгчид өөрсдийн мэдэлд нээлттэй засгийг бэхжүүлэх санаачилгыг дэвшүүлсэн. НЗТ-ийн гэрэл зураг

Дээрх бүх зүйлд хүрэхийн тулд орон нутгийн түвшинд болон парламент, эрх зүйн салбарт шинэчлэгчдийг стратегийн зорилт 1-д заасны дагуу илүү хүчирхэг нээлттэй засгийн эвсэл байгуулах, удирдлагын ур чадвар, чадварыг бий болгох хүчин чармайлт гаргах шаардлагатай болно. Үүнтэй адилаар, тэд нээлттэй засгийн гол сэдвүүдээр хамтын хөгжил дэвшлийг эхлүүлж, стратегийн 4 ба 5-р зорилтуудад дурдсан өгөгдөл, нотолгоо, түүхүүдээр хамтын хөрөнгийг бий болгох хүчин чармайлтын нэг хэсэг байх хэрэгтэй болно.

Хоёрдугаарт, эн тэргүүнд улс төрийн шилжилтээр дамжуулан шинэчлэлийн төлөвлөгөөний тасралтгүй байдлыг хангахын тулд нээлттэй засгийн шинэчлэл, НЗТ-ийг зохион байгуулна гэсэн үг юм. Үүний тулд үндэсний болон орон нутгийн оролцогчид олон нийтийн дэмжлэгтэйгээр улс төрийн намуудын тэмцэгчидтэй хамтран ажиллаж нам хоорондын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх шаардлагатай болно. Мөн нээлттэй засаг, НЗТ-ийн амлалтуудыг улс төрийн мөчлөгөөр тасралтгүй байлгахын тулд удирдах, зохицуулах эсвэл хуулийн хэрэгслээр дамжуулан НЗТ-ийг зохион байгуулах гишүүдийн зөвлөмжийг боловсруулна гэсэн үг юм. Удирдах хороо нь Засгийн газрын өндөр түвшинд хамтран ажиллах, нээлттэй засаг, НЗТ-ийн үнэ цэнтэй саналыг хүргэх, шинээр байгуулагдсан Засгийн газрын амлалтыг баталгаажуулахад илүү улс төр, гадаад талын удирдлагын үүрэг гүйцэтгэнэ.

Гуравдугаарт, эн тэргүүнд үндэсний болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, салбарын бодлого, хөтөлбөр зэрэг нийгмийн гол сорилтуудыг даван туулах томоохон шинэчлэлүүдэд нээлттэй засгийн арга барилыг оруулна гэсэн үг юм. НЗТ-ийн хэд хэдэн гишүүд аль хэдийн хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Үүнд:

а) Ийм бодлого, практикийг боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр хийгдсэн үйл явцад хамтын бүтээл, олон талт хамтын ажиллагаа, хариуцлагыг бэхжүүлэх;

б) НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс гадуур болж буй Засгийн газрын нээлттэй хүчин чармайлтыг илүү сайн холбох; мөн

в) 1-р зорилтод тусгагдсан төрийн албан хаагчдын ур чадвар, чадавхад хөрөнгө оруулалт хийх, сайжруулах үйл явц нь нээлттэй засгийн соёл, практикт илүү шингээх боломжийг олгодог.

3. Улс төрийн боломжит “цонх” гарахад хариу үйлдэл сайн байх

НЗТ-ийн бүх хэсэг нь үндэсний болон орон нутгийн түвшинд нээлттэй засгийн замналыг эрс өөрчилж болох боломж эсвэл хямралын гол мөчүүдийг илүү хурдан олж тогтоон, бэлтгэхэд стратегич, ухаалаг байх хэрэгтэй. Үүнд ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо, хүртээмжийг сайжруулахыг дэмжихийг хүсдэг шинэ засгийн газруудад болон засгийн газрын нээлттэй санаачилгыг ноцтой нурааж, иргэний орон зайг дутуу үнэлж болох шинэ засгийн газруудад бэлтгэх явдал ордог.

НЗТ-ийн Дэмжих нэгж нь сэдэвчилсэн, хоёр талын, олон талт түншүүдтэй хамтран ажиллаж, улсын болон орон нутгийн түвшинд боломж гарч ирэх үед үндэсний болон орон нутгийн оролцогчидтой шуурхай хамтран ажиллана. Түншлэлийн өргөн хүрээтэй арга барилын бүрэлдэхүүн хэсгүүдэд түргэн хариу арга хэмжээ авах холимог арга, таних болон урамшуулах, НЗТ-ийн шуурхай хариу арга хэмжээний протокол болон хариу арга хэмжээний бодлогын хэрэгжилт, улс төрийн хүрээ, нийгмийн хөдөлгөөнүүдтэй хамтран ажиллах, Удирдах хороо, хандивлагч болон бусад хүмүүсээс дэмжлэг авах зэрэг болно.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3:

Иргэний нийгмийн орон зайг хамгаалах, тэлэх

НЗТ байгуулагдсанаас хойш олон улс нээлттэй засгийн өөр өөр хэмжээс дээр сайжирсан боловч иргэний орон зай ихээхэн буурсан байна. Энэ бууралт нь НЗТ-ийн загварыг зангуу болгож засгийн газар болон иргэний нийгмийн байгууллага хоорондын тэгш түншлэлд заналхийлж байна. Ардчилсан эрх нь хамгаалагдсан, иргэний нийгмийн чөлөөт, нээлттэй орон зай байгаа тохиолдолд л шинэчлэлийг тогтвортой хэрэгжүүлэх боломжтой.

Сүүлийн жилүүдэд иргэний орон зайг хамгаалах, өргөжүүлэх нь НЗТ-ийн эн тэргүүнд чухалчлах зүйл болж байна. Тухайлбал, үйл ажиллагааны төлөвлөгөөнд амлалт өгөх, Ардчилсан эрх чөлөөг судлах сүлжээ болон бусад суралцах орон зай, бүс нутгийн болон дэлхий дахины үйл явдлууд, Удирдах хорооны хамтарсан тэргүүлэгчдийн төлөвлөгөө, НЗТ-ийн Үнэлэмжийг шалгах, хариу үйлдлийн бодлого зэрэг бууралтыг дурдах НЗТ-ийн бодлого юм. Үүнийг үл харгалзан өнөөдрийг хүртэлх дэвшил дэндүү хязгаарлагдмал байсан ч Түншлэлийн хувьд иргэний орон зайн төлөө улс төрийн илүү их удирдлагыг дайчилж, ирэх таван жилд энэ хөтөлбөрт шинэчлэлийг урагшлуулах чухал боломж бий.

НЗТ-ИЙН ОЛОН НИЙТ ЭНЭ ЗОРИЛГОДОО ХЭРХЭН ХҮРЧ ЧАДАХ ВЭ?

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц болон Нээлттэй засгийн тунхаглалаар НЗТ-д элсэх тухай хүний эрх, сайн засаглалтай холбоотой олон улсын бусад холбогдох бичиг баримтуудад заасан зарчмуудыг бүх гишүүд дэмжиж байна. Энэ Стратегийн хүсэл эрмэлзэл нь эдгээр үнэт зүйлсийн талаарх үйл ажиллагааг урамшуулан дэмжих явдал юм. НЗТ-д оролцогч үндэсний болон орон нутгийн улс төрийн удирдагчид иргэний орон зайг нэн тэргүүнд тавьж, засгийн газрынхаа бусад хэсэгт иргэний нийгмийн байгууллагын төлөө тэмцэж чадна.

Ахмад албан тушаалтнууд иргэний нийгмийн байгууллагатай харилцан ярилцаж, хамтран ажиллах боломжийг бий болгон, бодлогын асуудалтай холбогдох иргэний орон зайн асуудлыг шийдвэрлэх боломжтой. Жишээ нь байгаль хамгаалагчидтай хамтран ажиллах. Эцэст нь иргэний нийгмийн байгууллагууд иргэний орон зайн шинэчлэлийн саналыг засгийн газруудтай хэлэлцэхдээ нэн тэргүүнд тавьж, ардчилал, хүний эрхийн төлөө төвлөрсөн бүлгүүдийг нээлттэй засагт оруулах боломжтой.

2023-2028 ОНЫ СТРАТЕГИЙН ХУГАЦААНД ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

1. Иргэний нийгмийн орон зайн үйл ажиллагааг дэмжиж, тэмцэгч нарыг хөгжүүлэх

Иргэний орон зай нь НЗТ-ийн бүх оролцогчдын хувьд чухал нийтлэг зүйл байх хэрэгтэй. Үнэндээ энэ нь одоо байгаа зарим аргыг өргөжүүлж, зарим шинэ аргыг туршиж үзсэн гэсэн үг юм.

Нэгдүгээрт, энэ нь иргэний орон зайн талаар арга хэмжээ авахад бүх гишүүдийг байнга ач холбогдол өгөхийг хэлж байна гэсэн үг юм. Энэ салбарт ахиц дэвшил гаргах боломжийг олгохын тулд Түншлэлийн удирдагчид, ялангуяа улс төрийн удирдагчид иргэний нийгэм, ардчилсан яриа хэлэлцээний орон зайг хамгаалах, өргөжүүлэх хэрэгцээг идэвхтэй ярих шаардлагатай болно. Үүнд улс төрийн өнгө аясыг өндөр хэмжээний арга хэмжээн дээр дурдах, хоёр талын хэлэлцүүлэгт иргэний орон зайг уриалах, ухарч байгаа улс орнуудын иргэний нийгмийг дэмжих зэрэг болно. Хамтрагчидтайгаа эх орондоо иргэний орон зайн талаар зоригтой арга хэмжээ авч, гадаадад байгаа асуудлыг идэвхтэй өмгөөлж буй улс төрийн удирдагчдын эвслийг бий болгохын төлөө Дэмжих нэгж ажиллана.

Хоёрдугаарт, иргэний орон зайн бодит шинэчлэлийг баталгаажуулахын тулд боломж гарч ирсэн бол эдгээр боломжийг алдахгүйн тулд НЗТ-ийн олон нийт дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. НЗТ-ийн олон түншүүдийн хийсэн судалгаа, түүний дотор Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв, CIVICUS, OECD-ийн хийсэн судалгаа нь шаардлагатай шинэчлэлийн талаар ХБТМ-аар дамжуулан зөвлөмжүүдийг хүргэдэг. НЗТ-ийг эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх платформ болгон ашиглаж болно.

Гуравдугаарт, Дэмжих нэгж нь бусад түншүүдтэй хамтран иргэний орон зайг шударга ёс, авлигатай тэмцэх, уур амьсгалын үйл ажиллагаа зэрэг бусад асуудал, эн тэргүүнд анхаарах зүйлсийн талаарх хэлэлцүүлэгтэй холбохын зэрэгцээ бодлогын гол сорилтуудыг шийдвэрлэх, хямралыг даван туулахад цэцэглэн хөгжиж буй иргэний нийгэм ямар чухал үүрэг гүйцэтгэдэг тухай ойлголтыг хүүрнэлүүдэд анхаарлаа хандуулна.

Дөрөвдүгээрт, Удирдах хороо болон Дэмжих нэгж нь салбар дундын тэмцэгч нарыг илүү сайн тодорхойлж, хамтран ажиллаж буй төр, иргэний нийгмийн шинэлэг аргуудыг онцлон тэмдэглэх болно. Төрийн нээлттэй удирдлагыг бий болгох, төрийн албан хаагчдыг сургах үйл ажиллагаануудад иргэний орон зай нэн тэргүүнд тавигдах болно. Иргэний орон зайн шинэтгэгч нар болон шинэчлэлийн үйл явдал, шагналын хөтөлбөр, кампанит ажлаар дамжуулан дэмжих болно.

НЗТ-ийн Ажлын албаны төлөөлөл нь иргэний нийгэмтэй хамтран шинэчлэлийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын хамт төр засгийнхаа хүрээнд иргэний нийгэмтэй харилцан ярилцаж, хамтран ажиллах боломжийг олгосон үнэ цэнтэй туршлагаа хуваалцахад дэмжлэг үзүүлнэ.

Тавдугаарт, НЗТ дахь иргэний орон зайн төлөө тэмцэгчдийн удирдамж, суралцах боломж, нөөц бололцоог сайн дэмжих хэрэгтэй. Үүнийг НЗТ-ийг Дэмжих нэгж нь Ардчилсан эрх чөлөөний суралцах сүлжээгээр дамжуулан хийх, брокерын зөвлөгөө, хөндлөнгийн мэргэжилтнүүдийн дэмжлэгийг авах, иргэний нийгмийн байгууллагыг зөвлөгөө, дэмжлэгийн эх үүсвэртэй холбож, иргэний орон зай доройтож байгаа газарт донорууд болон санхүүжилттэй холбох боломжийг олгох юм. Хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллах нь иргэний орон зайн шинэчлэлийг илүү өргөн дэмжих үнэ цэнтэй холбоотон мөн сэтгүүлчид рүү дайрах дайралт ихэссэний улмаас иргэний орон зайн хязгаарлалтыг хойш тавих түншүүдийн хувьд ч дээр байж болох юм.

2. Иргэний нийгмийн орон зайн талаарх Нээлттэй засгийн түншлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтмол хянах

НЗТ нь сайн дурын хэвээр байгаа хэдий ч бүтцэд нь Түнш доторх иргэний нийгмийн орон зайг хамгаалах чухал элементүүд байдаг. Удирдлагын хороо эдгээр одоогийн механизмыг илүү сайн хэрэгжүүлж, зорилгоо биелүүлж байгаа эсэхийг үе үе шалгана. Үүнд OGP Values Check орох бөгөөд энэ Түнштэй нэгдэхийн тулд улс орнууд тавих шаардлагыг хангах эсэхийг шалгадаг. Мөн улс орнууд НЗТ-д нэгдсэний дараа хэрэгждэг механизмууд, тухайлбал, Иргэний нийгмийн нээлттэй яриа хэлэлцээнд оролцох тогтвортой орон зайг хангахын тулд иргэний нийгмийн зарим үндсэн хамгаалалтыг хангадаг Хариу арга хэмжээний бодлого, шуурхай хариу арга хэмжээний протокол зэрэг орно.

Ирээдүйд НЗТ-ийг Дэмжих нэгж нь гишүүдийнхээ дунд иргэний орон зайд ахиц дэвшил эсвэл доройтол гарсан тохиолдлуудыг илүү идэвхтэй онцлон тэмдэглэх болно.

Эцэст нь хэлэхэд, орон нутгийн болон үндэсний түвшинд оролцоо, хамтын бүтээлийн стандартыг баримтлах нь иргэний нийгэм цаашид нээлттэй засгийн шинэчлэлийн яриа хэлэлцээнд чухал орон зайтай байх юм.

НЗТ-ийн олон нийт нь НЗТ-ийн үйл явдал, судалгааг ашиглах, нягтлан үзэх нь илүү үр дүнтэй бөгөөд хэрэгжүүлэх ажлыг урьдчилан хийх давуу талтай. НЗТ-ийн гэрэл зураг

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4:

Нээлттэй засгийн шинэчлэлийн хамтын үйл явцыг эрчимжүүлэх

2011 оноос хойш НЗТ-ийн гишүүд орон нутгийн болон үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дамжуулан нээлттэй засгийн сэдвүүдээр ахиц дэвшил гаргаж байна. Түншлэл нь бодлогын салбарын өсөн нэмэгдэж буй нээлттэй засгийн хандлагыг урагш ахиулдаг орон нутгийн болон үндэсний гишүүдтэй олон талын оролцоотой олон нийт болон өргөжсөн. Үүний зэрэгцээ ардчилал, нээлттэй засагт тулгарч буй сорилтууд өргөжиж, уур амьсгалын өөрчлөлт, тэгш бус байдал зэрэг нийгмийн өргөн цар хүрээтэй асуудлууд олон орны хувьд нэн тэргүүнд тавигдах боллоо.

Энэ Стратегийн талаарх зөвлөлдөөн нь ирэх таван жилд эдгээр сорилт бэрхшээлийг даван туулж чадах бодлогын талаар НЗТ-ийн олон нийт хамтын үр дүнг илүү хүчтэй харахыг хүсэж байгааг илэрхийлсэн юм. Санаачилга, удирдамж, нэгдэл, үйл явдал, харилцан суралцах боломж, харилцаа холбоо зэрэг нь НЗТ-ийн бүх гишүүд тодорхой нөхцөлд шинэчлэлийг оруулах орон зайг нээлттэй байлгахын зэрэгцээ хөгжил дэвшлийг урагшлуулах НЗТ-ийн өргөн цар хүрээтэй сорилтын цаана уялдуулна гэсэн үг юм.

НЗТ-ИЙН ОЛОН НИЙТ ЭНЭ ЗОРИЛГОДОО ХЭРХЭН ХҮРЧ ЧАДАХ ВЭ?

НЗТ-ийн шинэтгэгч нар өөр өөр сэдвээр хамтын хүсэл эрмэлзэл болон хэрэгжүүлэлтийг нэмэгдүүлэх гол үүрэг гүйцэтгэнэ. Хамтын ажиллагааны эхний арван жил нь ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо нь бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үнэ цэнтэй арга барил боловч тэгш бус хэрэгжсэн болохыг харуулсан.

Илүү их нөлөө үзүүлэхийн тулд нээлттэй засгийн удирдагчид эдгээр аргыг улс орны, орон нутгийн түвшинд илүү өргөн цар хүрээнд бодлогын сэдвээр тэнцүү өргөжүүлж, хүрэхийг хичээж байгаа зүйлдээ амбицтай хандах, найдвартай хэрэгжүүлэх хэрэгтэй болно. НЗТ-ийн шинэтгэгч нар болон түншүүд нь хүсэл эрмэлзэл, үйлдлээ загварчилж чадах сэдэвчилсэн нэгдэл буюу сүлжээг бий болгох, бусдыг ч мөн адил урамшуулан дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ. НЗТ-ийн бүх гишүүд энэ Стратегийн явцад наад зах нь хэд хэдэн нээлттэй засгийн гол бодлого дээр бодит ахиц дэвшлийг харуулах ёстой.

НЗТ-ийн Удирдах хороо нь тодорхой бодлого дээр Түншлэл даяар тулгамдаж буй асуудал дээр ахиц дэвшлийг гаргахад анхаарлаа хандуулна. Дэмжих нэгж нь улс орны, орон нутгийн түвшинд дэлхий нийтэд сурталчлах, нотолгоог баталгаажуулах, түүхийг ярихад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаануудыг удирдан явуулна.

2023-2028 ОНЫ СТРАТЕГИЙН ХУГАЦААНД ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

1. Ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо, хүртээмжийн шаардлагыг нэмэгдүүлэх

Бүх гишүүдийг НЗТ-ээр дамжуулан олон нийтийн бодлогын томоохон бэрхшээлүүдийг даван туулж, ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо, хүртээмжийн талаарх хүчин чармайлтаа гүнзгийрүүлэхийг дэмждэг. НЗТ-ийн эхний арван жилд ил тод байдал, нээлттэй мэдээллийн хүчин чармайлтад ихээхэн ахиц гарсан хэдий ч нэг гол сургамж бол ил тод байдлын төлөө илүүг хийх явдал юм.

Нэгдүгээрт, улс орны нөхцөлд хамаарах тэргүүлэх асуудлыг урагшлуулахын тулд НЗТ-ийн платформыг ашиглах нь нээлттэй, уян хатан хэвээр байгаа хэдий ч гишүүд бодит үр дүнд хүрэхийн тулд нээлттэй засгийн арга барилыг тодорхой сэдэв, салбарын бодлого, хөтөлбөрүүдэд хэрхэн нэгтгэх талаарх шаардлагыг дээшлүүлэх хэрэгтэй. Шинэчилсэн Нээлттэй засгийн удирдамж нь хөгжил дэвшлийг дэмжих удирдамж, шалгуур үзүүлэлтээр хангана.

Хоёрдугаарт, хүртээмжтэй оролцоонд онцгой анхаарал хандуулна. Олон нийтийн оролцооны шинэчлэл нь Түншлэлд дэндүү цөөхөн байсан. Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага нар олон нийтийн оролцоог байгууллагуудад шингээхэд хамтдаа түлхэц үзүүлэх хэрэгтэй. Дэмжих нэгж нь ур чадвар хуваалцах, бусдаас суралцах боломжийг олгох, олон нийтийн оролцооны шинэчлэлийг хэрэгжүүлэх, удирдамж, сайн дадал хэвшлийг хөхиүлэн дэмжих, үндэсний болон орон нутгийн удирдагчдын ажлыг дэмжиж, хүмүүсийн амьдралд нь нөлөөлөх шийдвэрүүдийг утга учиртай хэлбэрт оруулахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Гуравдугаарт, гишүүд хүйсийн бүлгүүд, маргиналагдсан олон нийт, өсвөр үеийнхэн болон бусад оролцогчидтой хамтран ажилласнаар тэдний санаачилгыг илүү өргөн хүрээтэй болгохын төлөө хүчин чармайлт гаргаж чадна. Дэмжих нэгж нь НЗТ-ийн оролцоо, хамтын бүтээлийн стандартууд дээр суурилан, хамтарсан оролцоонд чиглэсэн удирдамж, төлөвшсөн загварыг сурталчлах, хөгжүүлэх түншүүдтэй хамтран ажиллана.

2. Хамтын тэргүүлэх үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах уриалгыг эхлүүлэх

Хамтын хөгжил дэвшлийг илүү бий болгохын тулд арав орчим нээлттэй засгийн багц дээр НЗТ-ийн өргөн цар хүрээтэй сорилтыг тодорхойлж, 2023 онд Эстонид болох Дэлхийн дээд хэмжээний уулзалт дээр эхлүүлэх болно.

НЗТ-ийн бүх гишүүдийг эдгээр салбаруудаас тодорхой тооны асуудлыг урагшлуулахыг дэмжих болно. Энэ нь хүсэл эрмэлзэл, өсөх ирээдүйтэй салбар, үндэсний болон орон нутгийн нөхцөл байдалтай холбоотой холимог асуудлууд дээр үндэслэн НЗТ-ийн Удирдах хорооноос тодорхойлох юм. Тухайлбал, эдгээр асуудлууд нь мэдээлэл авах боломж, санхүүгийн нээлттэй байдал, төрийн үйлчилгээ авах зэрэг нээлттэй засгийн суурь асуудлыг хамарч болно.

Сорилтын хэсгүүдийг НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээнд ч мөн хүрээнээс гадуур ч мөрдөж болно, гэхдээ НЗТ-ийн хамтран бүтээх, үйл ажиллагаа явуулах, хэрэгжүүлэх, эгэх хариуцлага хүлээх үндсэн зарчмуудад уяж НЗТ-ийн хамтын нөөц боломж, сүлжээг ашиглаж болно.

Үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, хууль тогтоох, шүүх засаглалыг хамарсан Засгийн газрын шинэтгэгч нар эдгээр тулгамдсан асуудлаар ахиц дэвшил гаргаж улс төрийн дэмжлэгийг авахын тулд бие биетэйгээ болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах хэрэгтэй. Түншүүд болон холбоотон нар цаашид техникийн дэмжлэг үзүүлж, эдгээр салбарт суралцах, нөөц бололцоогоо хуваалцах боломжийг олгох болно. Шинэтгэгч нар болон хамтрагчид нэгдэл эсвэл сүлжээг удирдан, хүсэл эрмэлзэл, үйл ажиллагааг загварчлах хэрэгтэй. Мөн бусдыг үйлдэл хийхэд урамшуулан дэмжих хэрэгтэй болно.

Удирдах хороо болон Дэмжих нэгж нь Ардчиллын төлөөх дээд хэмжээний уулзалт, G7 болон G20, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болон бусад хүмүүсийн хамтын хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх дэлхийн платформуудтай холбоо тогтооно. Мөн Дэмжих нэгж нь Хамтын ажиллагааны өргөн цар хүрээтэй сорилтыг дэмжин удирдлагын хөгжлийн үйл ажиллагааг санаачлах, улс төрийн оролцооны чиглэлээр ажиллах, тохиромжтой тохиолдолд кампанит ажил эхлүүлэх болно.

Дэмжих нэгж цаг хугацаа, нөөц бололцоогоо зарцуулах эдгээр сорилтын эхний багцад авлигатай тэмцэх, дижитал технологийг хөгжүүлэн ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх үйл ажиллагааг урагшлуулах, хууль эрх зүйн мэдлэг олгох, шударга ёсыг тогтоох боломжийг ахиулах зэрэг стратегийн зөвлөгөөнүүдээс тодорсон эн тэргүүнд тавих зүйлүүд орно. Энэ нь оролцоо болон хүртээмжийн асуудалтай давхцаж байгаад анхаарлаа хандуулна.

- **Авлигатай тэмцэхэд их хэмжээний авлига, клептократ** (авлигад идэгдсэн улс төрчид хуулиас гадуур нууцаар баяжиж албан тушаалгүй болох үед хэрэглэх мөнгийг гадны улс орнууд руу экспортлохыг хэлнэ), хууль бус мөнгөний урсгал болон мөнгө угаахтай тэмцэх бодлого, олон нийтийн шударга зарчимд голлон анхаарна. Үүнд эзэмшигч тал, нээлттэй гэрээ байгуулах, лоббидох, улс төрийн санхүү, хөрөнгийн ил тод байдал зэрэг тодорхой асуудлууд орно.

- **Дижитал технологийг хөгжүүлэх, ашиглах** талаар ардчилал болон засаглалын дижитал арга хэрэгсэл, ардчиллыг дэмжих арга хэмжээ болон арга хэрэгсэл, төрийн бусад салбаруудын өгөгдөл болон тоон хувиргалтыг чиглүүлэх бодлогод анхаарна.

- **Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх үйл ажиллагааг ахиулах**ад уур амьсгалын санхүүг зохицуулах орон нутгийн тогтолцооны ил тод байдал, эгэх хариуцлагыг бэхжүүлэх, уур амьсгалтай холбоотой тоо, мэдээллийг нээлттэй болгох, мөн хамгийн чухал нь цаг ууртай холбоотой бодлогын оролцоог гүнзгийрүүлэхэд инновацыг нэвтрүүлэхийг дэмжихэд чиглэнэ.

- **Хууль эрх зүйн эрх мэдэл олгох, шударга ёсыг тогтоох** явдлыг дэмжихэд олон нийтийн шударга ёсыг тогтоох механизмыг өргөжүүлэх, шударга ёсны институтийг нээлттэй болгохын зэрэгцээ хууль эрх зүйн салбарыг хөшүүрэг болгож Засгийн газрын бусад арга хэмжээг бэхжүүлэхэд чиглэнэ.

Дэмжих нэгж нь сэдэвчилсэн нэгдэл, сүлжээнээс гарч буй удирдлагыг дэмжин, удирдлагын ялгаа бүхий бүс нутгуудад эдгээр эвслүүдийг хөгжүүлж, үйл ажиллагааг загварчлах, бусдад урам зориг өгөхийг дэмжих болно. Энэ нь салбар хоорондын хурал, кампанит ажил зохион байгуулах, хүлээн зөвшөөрөгдөх, бусадтай туршлага солилцох, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, сэдэвчилсэн тэтгэлэг, шагнал олгох, орон нутгийн үйл ажиллагааг урамшуулах зэрэгт дэлхийн тавцанг ашиглах болно.

Африкийн шинэтгэгч нар бүс нутагт өрийн ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. НЗТ-ийн гэрэл зураг

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5:

Нээлттэй засгийн шинэчлэл, нотолгоо, түүхийг өгүүлэн зоригжуулах нутаг орон болох

НЗТ нь эхэн үеэс эхлэн олон нийтийн жишээнүүдийг олж авах, хуваалцахын зэрэгцээ шинэтгэгч нар болон шинэчлэлийг хүлээн зөвшөөрөхөд хөрөнгө оруулалт хийсэн. НЗТ-ийн олон нийт нь амжилт, бүтэлгүйтлийг хуваалцахад идэвхтэй оролцоноор олон нийтэд урам зориг өгөх, өсөж хөгжих, сэдэвчилсэн тэргүүлэх асуудлыг тавьж НЗТ-ийн өөрчлөлтийн онолын чухал хэсэг байсаар ирсэн.

НЗТ-ийн гол давуу талуудын нэг нь арван нэгэн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, амлалт, ХБТМ тайлан, судалгааны үр дүнд цугларсан тоо баримт, нотолгоо, түүх, мэргэжилтнүүдийн сүлжээ юм. Олон нийт бий болгосон энэхүү мэдээллийг шинэтгэгч нарыг илүү хүчирхэгжүүлэх, бусад стратегийн зорилтуудыг урагшлуулахад ашиглах асар том боломж юм.

Энэ нь агуулгыг олох, олон нийтээс хүлээн авах, тэднээр болон тэдэнтэй хамт хуваалцсан тохиолдолд л амжилттай байх болно. Ингэхийн тулд түүх ярих, чанарын судалгаа хийх, тоо баримтыг нэгтгэх шаардлагатай болно. Мөн хүлээн зөвшөөрөх, зоригжуулах, нотолгоонд тулгуурласан үр дүнг тэнцвэржүүлэх хэрэгтэй болно. Энэ нь мөн агуулгыг олон нийттэй холбох тухай юм.

НЗТ-ИЙН ОЛОН НИЙТ ЭНЭ ЗОРИЛГОДОО ХЭРХЭН ХҮРЧ ЧАДАХ ВЭ?

НЗТ-ийн олон нийт нь зоригжуулах үндсэн эх сурвалж бөгөөд хэрэв илүү сайн хадгалан үргэлжлүүлж чадвал Стратеги дахь бүх зорилгыг биелүүлэхэд туслах болно. Урам өгөх түүх, чанарын судалгаа, мэдээллийг олох, нотолгоонд суурилсан үр дүнгээр хамтдаа бусдыг зоригжуулах нь НЗТ-д эн тэргүүнд хэвээр байх болно.

Ирээдүйд НЗТ-ийг Дэмжих нэгж нь эдгээр хамтын нөөц бололцоог системтэйгээр, бүтээлчээр нээж илүү их хөрөнгө оруулалт хийх, өөр өөр оролцогчдын хэрэгцээнд нийцсэн, өөрчлөлтөд нь туслах олон янзын хэлбэр, бүтээгдэхүүнд нэвтрэхэд хялбар болгох болно. Мөн Түншийн гол цөм болсон хүн ам, орон зай, сүлжээг бэхжүүлэх, холбоход хөрөнгө оруулалт оруулсаар байх болно.

2023-2028 ОНЫ СТРАТЕГИЙН ХУГАЦААНД ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

НЗТ-ийг Дэмжих нэгж нь бусадтай хамтран ажиллаж динамик нөөцийг үзүүлэх жишээ, арга барил, дэмжих тайлбар, төлөвшлийн загвар, одоо байгаа гуравдагч стандарт буюу үнэлгээний эшлэл, үнэ цэнтэй саналуудын хамт гаргаж ажиллана. Үүнд олон нийт агуулгыг нь гаргаж мэргэжлийн байгууллагатай хамтран бүтээн шинэчилсэн Нээлттэй засгийн зааварчилгааг оруулах бөгөөд энэ нь гишүүд өөрийн эхлэх цэгт тулгуурлан нээлттэй засгийн ахиц дэвшил гаргахын тулд юу хийж болох талаар тогтмол шинэчлэгдэн гарах “нэг цэгийн үйлчилгээ” юм.



НЗТ-ийн дэлхий дахины арга хэмжээнд оролцогчид. НЗТ-ийн гэрэл зураг

Түүнчлэн шинэтгэгч нар болон түншүүд бие биеэ эрэлхийлж, дэмжихэд илүү хялбар болгох зорилготой юм.

НЗТ-ийг Дэмжих нэгж нь өндөр чанартай, бодит, зоригжуулах агуулга бүхий нотолгоонд суурилсан мэдээллийн сан боловсруулах бөгөөд үүгээр дамжуулан олон төрлийн хэрэгцээг хангасан, нэвтрэхэд хялбар, олон хэлбэртэй бүтээгдэхүүнийг олон нийтэд хүргэх болно. Эдгээр эх сурвалжуудад нээлттэй түүх, чадамж, удирдлагын хөгжлийн сургалтын хөтөлбөр, мэдлэгийн эх сурвалж зэрэг харилцаа холбооны материалууд орно.

Удирдагчдыг хүлээн зөвшөөрч, урамшуулахын тулд НЗТ-ийг Дэмжих нэгж нь Стратегид өгүүлсэн бусад хэлбэрийн дэмжлэгээр шагнах, танигдах хөтөлбөрүүдийг боловсруулна.

Эрдэм шинжилгээний байгууллага, судлаач-практикч нарын сүлжээ нь эх судалгаа гаргах, цаашид нээлттэй засгийн нотолгооны бааз суурийг тавихад гол үүрэг гүйцэтгэнэ. Шинэлэг санааг инкубаторт оруулах, хуваалцах, ийм төрлийн хүчин чармайлтаас сургамж авах зэрэгт төр, иргэний нийгмийн байгууллага чухал үүрэг гүйцэтгэнэ. Мөн суралцах, удирдан чиглүүлэх, сурталчлах эх сурвалжуудыг хуваалцахыг дэмждэг. ХБТМ нь нотолгоонд суурилсан судалгаа гаргах, түгээхэд чухал үүрэг гүйцэтгэсээр байх болно. НЗТ-ийг Дэмжих нэгж нь эдгээр оролцогчдын ажлыг хадгалах, түгээх, НЗТ-ийн өөрийн өгөгдөл, суралцах санаачилгуудаас бий болсон нотолгоо, үйл ажиллагааны ойлголттой хослуулахад төвлөрнө.

ЗАСАГЛАЛ БА МАНЛАЙЛАЛ

НЗТ-ийн удирдлагын байгууллагууд Стратегийн хэрэгжилтийг хянах, улс төрийн удирдлагаар хангах үүрэг хүлээнэ.

НЗТ-ийн Удирдах хороо нь санаачилгыг гүйцэтгэх болон стратегийн шийдвэр гаргах байгууллага юм. НЗТ-ийн засгийн газар–иргэний нийгмийн бүрдлийг эргэцүүлэн харж Удирдах хороонд Засгийн газар, иргэний нийгмийн төлөөлөл тэнцүү тоогоор бүрдэнэ. Удирдах хороо нь байгууллагад хоёрдмол үүрэг гүйцэтгэдэг. Аливаа удирдах зөвлөлийн нэгэн адил бодлого, хөтөлбөр, журмыг баталдаг бөгөөд энэ нь мөн НЗТ-ийн нөлөөллийг урагшлуулах бодит арга замуудад маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Удирдах хорооны гишүүд бусад орнуудад үлгэрлэж, дипломат нөлөөгөө ашиглан бусад оролцогчдыг НЗТ-д нэгдэхэд илүү дэмжлэг үзүүлэх ёстой. Удирдах хороо болон түүний бүрэлдэхүүний талаар илүү ихийг мэдэж аваарай.

Удирдах хорооны стратегийн хяналтын үүргийг нөхөхийн тулд Захирлуудын зөвлөл нь НЗТ-ийн итгэл хүлээсэн, хууль зүйн хяналтыг хариуцдаг. Үүнд НЗТ-ийн төсвийг хянах, батлах зэрэг орно. Зөвлөл гишүүдээ Удирдах хорооноос авдаг бөгөөд удирдлагын аль аль нь үйл ажиллагааныхаа талаар бие биедээ мэдээлэл өгдөг. Захирлуудын зөвлөлийн талаар илүү ихийг мэдэж аваарай.

Олон улсын экспертүүдийн бүлэг (IEP) нь бүс нутгийн болон сэдэвчилсэн таван мэргэжилтнээс бүрдсэн зөвлөх байгууллага юм. IEP нь ХБТМ-ыг хараат бус байдлаа хамгаалахад хяналт тавьж, ХБТМ -ын арга барил, хяналт шалгалтын явц, ашиг сонирхлын зөрчил, бүтээгдэхүүний талаар чанарын баталгаа өгдөг. IEP нь ХБТМ-ын алсын хараг тогтоох, түүний ололтыг сурталчлахад чухал зөвлөх үүрэг гүйцэтгэдэг. IEP-ийн гишүүдийг нээлттэй үйл явцаар нэр дэвшүүлж, НЗТ-ийн Удирдах хорооноос томилдог. Олон улсын экспертүүдийн бүлгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.

НЗТ-ийн Удирдах хорооны гишүүд 2022 онд хуралдаж, ирэх таван жилд хамтын ажиллагааны чиглэлийг хэлэлцсэн байна. НЗТ-ийн гэрэл зураг

Аргентин улсын Буэнос-Айрес хот иргэдийн шударга ёс, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. НЗТ-ийн гэрэл зураг

ЗАСАГЛАЛЫН ХЯНАЛТ

Стратегийг эхлүүлэхэд Удирдлагын хорооны чиг үүрэгт анхаарал хандуулж, 2023 онд удирдлагын шалгалт дуусгавар болно. Гол зорилго нь Удирдах хорооны чиг үүрэг, ажиллах арга зам, НЗТ-ийн удирдлагын ерөнхий загвар нь тухайн үеийн хэрэгцээ, шинэ Стратегийн хэрэгцээг хангах зорилгод нийцсэн хэвээр байх явдал юм. Үүнээс гадна энэхүү хяналт нь Удирдах хорооны бусад үндсэн НЗТ-ийн байгууллага, түүн дотроо Дэмжих нэгж, Захирлуудын зөвлөл, IEP-тэй хэрхэн хамтран ажиллаж байгааг үнэлэх болно.

Хяналт шалгалтад дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- **Улс төрийн удирдлагыг сайжруулах:** Улс төрийн илүү хүчирхэг удирдлага, хамгаалал, хамтын ажиллагааны нөөц бололцоог дайчлах, гишүүдийн хувь хүний болон хамтын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх боломж олгохын тулд Удирдах хорооны хүлээлт, үүргийг эргэн харах явдал орно. Үүнд ирээдүйн Удирдах хорооны удирдлагын холбогдох дэд бүтцийг барих арга замуудыг судлах зэрэг болно.
- **Шинэ дуу хоолойн орон зайг бий болгох:** Удирдах хороо нь Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагын аль алиных нь хувьд дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн олон төлөөллөөс үргэлж бүрддэг. Гэвч НЗТ-ийн Орон нутгийн гишүүд, залуучуудын хамгаалагчид, салбарын эсвэл сэдэвчилсэн сүлжээний дуу хоолой, үзэл бодол дутуу сонсогдсон хэвээр байна. Удирдлагын хяналт нь эдгээр болон бусад чухал сонгогчдыг тусгахын тулд үйл явц, бүтцийг хэрхэн бэхжүүлж болохыг авч үзнэ.
- **Ажиллах арга замыг дээшлүүлэх:** Удирдлагын хороо болон түүний дэд хороодод ажиллах арга замыг сайжруулах, түүнчлэн Удирдах хороо, Дэмжих нэгж болон НЗТ-ийн бусад удирдлагын байгууллагуудын хооронд ажиллах арга замыг сайжруулахад чиглэнэ. Ингэснээр Удирдлагын хороо гадаад, дотоодод стратегийн анхаарал хандуулахын зэрэгцээ илүү үр дүнтэй байх боломжийг олгоно.

НЗТ-ийн Засаглалын тухай өгүүллүүд нь энэхүү шалгалтын дараа шинэчлэгдэн НЗТ-ийн удирдлагын бүтцэд гарсан аливаа өөрчлөлт, Удирдах хорооны үүрэг, Стратеги болон удирдлагын хяналтаас үүдэлтэй бусад үр дагаврыг тусгах болно.

БАЯЛГИЙГ АШИГЛАХ АРГА БАРИЛ

Нээлттэй засгийн шинэчлэл, шинэтгэгч нарын эх үүсвэр нь Түншлэлийг амжилттай хэрэгжүүлж, энэхүү шинэ стратегийг хэрэгжүүлэх нэн чухал урьдчилсан нөхцөл юм. Үүнд иргэний нийгмийн байгууллага, Засгийн газрын аль алинд нь өөрчлөлтийг жолоодож, шинэчлэлийг хэрэгжүүлэх, НЗТ-ийг Дэмжих нэгж болон ХБТМ-д үндсэн үүргээ гүйцэтгэх эх үүсвэр орно.

Сүүлийн жилүүдэд гадаад геополитикийн хүчин зүйл, эдийн засгийн тодорхойгүй байдал, орон нутгийн улс төрийн дарамт шахалтаас шалтгаалан Засгийн газрын тусламжийн төсвийн нэг хэсэг болох хоёр талын донорын ажлын санхүүжилтийн түвшин буурч байна. Мөн олон суурь санхүүжүүлэгчдийн Засгийн газрын нээлттэй талбар руу чиглэсэн санхүүжилтийн ерөнхий түвшинд нөлөөлсөн стратегид өөрчлөлт орсон байна.

Энэ хэцүү нөхцөл байдлын дунд НЗТ нь одоогийн болон шинэ санхүүжилтийн эх үүсвэрүүдийг оролцуулах, шинэ арга барилыг хэрэгжүүлэх, НЗТ дэд зөвлөл болох Дэмжих нэгж, ХБТМ болон нээлттэй засгийн талбарын тогтвортой санхүүжилтийг баталгаажуулах хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ. Үүнд:

- **Хамтын хандив цуглуулах:** НЗТ стратегийн зорилт 4-ийн дурдсан тэргүүлэх сэдвээр дэлхий дахины болон орон нутгийн адил бодолтой түншүүд, хандивлагсдыг эрэлхийлэх болно. Нээлттэй засгийн үнэ цэнтэй шинэчлэгдсэн санал дэвшүүлж, үүнийг эн тэргүүнд тавих бодлогын зорилгуудтай нь нийцүүлэхийн тулд одоогийн хандивлагсадтай дахин нэгдэх, НЗТ-ээр удирдуулсан эсвэл нэгдэн орсон эдгээр сэдэвчилсэн бодлогын салбарт одоогийн болон шинэ хандивлагсадтай хамтран ажиллах, өрсөлдөөнтэй эсвэл өрсөлдөөнгүй гэсэн хамтын саналууд орно. Мөн НЗТ-ийн ажлын шинэ нээлтүүд, түүний дотор орон нутгийн зохион байгуулалтад чиглэсэн чиг хандлагад нийцсэн хоёр талын, олон талт, суурь санхүүжүүлэгчидтэй шинэ түншүүдийг эрэлхийлэх болно.

Нээлттэй засгийн экосистемд орон нутгийн оролцогчдыг дэмжих хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд орон нутгийн иргэд, байгууллагуудад хөрөнгө оруулах орчныг илүү сонирхох болсон. Энэ нь нээлттэй засгийн арга барилаар ажилладаг орон нутгийн нэгдэл, түншүүдийг дэмжих боломжийг олгосон. Орон нутгийн шинэтгэгч нарыг дэмжих нь НЗТ-ийн ДНХ-ийн гол хэсэг бөгөөд хоёр талын болон суурь санхүүжүүлэгчид НЗТ-ийн өвөрмөц байрлал, сүлжээг ашиглан орон нутгийн оролцогчдод илүү их санхүүжилт хийх боломжийг бий болгож чадна.

Үүнд хүрэх стратегиудад зорилтот улс орнуудыг тодорхойлохын тулд санхүүжүүлэгчидтэй холбоо тогтоохыг эрэлхийлж буй НЗТ-ийг Дэмжих нэгж орно. Энэ нь улс төрийн боломжтой, санхүүгийн хэрэгцээ өндөртэй, донор орнууд эсвэл бүс нутгуудтай уялдаж болох юм. Энэ нь хоёр талын донoруудын дунд орон нутгийн болон бүс нутгийн санхүүгийн боломж байж болох улс орон эсвэл бүс нутгийн зорилгуудтай НЗТ нягт хамтран ажиллах явдал байж болно. Мөн тодорхой бүс нутаг, улс орон эсвэл салбарын эрх мэдэлтнүүдэд иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан сан байгуулах боломжийг эрэлхийлэх болно.

Эцэст нь, энэ нь бүс нутгийн төвлөрсөн хөтөлбөрүүдийг судлах явдал юм. Жишээлбэл, Европын комиссын санхүүжүүлсэн Европын холбооны зарчимч байдлын хөтөлбөр буюу

БНСУ-ын “Анхны чөлөөт санаачилга” нь бүх насны иргэдийг цуглуулж, эвлэлдэн нэгдэж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн санал дэвшүүлэх боломжийг олгох замаар бодлогыг дэмжих зорилготой юм. НЗТ-ийн гэрэл зураг

Франкофоны Африкийн орнуудад зориулан Agence française de Développement-ийн санхүүжүүлсэн PAGOF II хөтөлбөр зэрэг нь орон нутгийн иргэний нийгмийн байгууллага, Засгийн газар, НЗТ-ийг Дэмжих нэгж болон ХБТМ-д аль алинд нь нөөц бололцоог бий болгодог.

- **Улс орны хандив**: НЗТ нь 2015 оноос хойш бүх гишүүн орнуудаас сайн дурын үндсэн дээр хандив хүссэн нь НЗТ-ийн гишүүд өөрсдөө эзэд нь гэдгийг харуулж байна. Эдгээр гишүүдийн хандив нь НЗТ-ийн Ажлын албаны бүх гишүүн Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагад зайлшгүй шаардлагатай үйлчилгээ үзүүлэхэд тусалдаг санхүүжилтийн амин чухал эх үүсвэр юм.

  2024 оноос эхлэн хоёр жилийн хугацаанд улс орны хандивыг нэмэгдүүлэх болно. Энэ өсөлт нь дэлхий даяар инфляцын өсөлт болон НЗТ-ийн 2023-2028 оны стратегийг хэрэгжүүлэхэд тогтвортой санхүүжилт олгох шаардлагатай байгааг харуулж байна. Мөн НЗТ-ийг Дэмжих нэгж болон Удирдлагын хороо нь одоогийн цалин хөлсгүй гишүүдэд хандив өгч эхлэх ажлыг эн тэргүүнд тавьж, дэмжлэг үзүүлнэ.

Эдгээр улсын хандив нь НЗТ-ийн дэд зөвлөлийн бүх гишүүн болох Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага нэн чухал үйлчилгээ үзүүлэх боломжийг олгодог. Тухайлбал, орон нутгийн шинэчлэлийг хамтран бүтээх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бүс нутгийн болон бусдаас суралцах боломжийг бүрдүүлэх, бодлогын сэдвээр арга зүйн мэдлэг олгох, удирдлага, эвслийг байгуулах талаар сургалт явуулах, нээлттэй засгийн бүс нутгийн болон дэлхий дахины арга хэмжээг зохион байгуулах зэрэг юм. Түүнээс гадна, ХБТМ нь НЗТ-ийн гишүүдэд эгэх хариуцлага тооцож, засгийн газрын нээлттэй хүчин чармайлтыг нь дэмжихийн тулд бие даасан, нотолгоонд тулгуурласан, зорилготой тайлан гаргах замаар оролцогч орнуудын хөгжил дэвшлийг хянадаг.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА БАРИЛ

НЗТ-ийн 2023-2028 оны стратегид тусгасан стратегийн зорилтуудад хүрэхэд Хамтын ажиллагааны бүх хэсгийг хамарсан арга барил, ажиллах арга зүй, суралцахад өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Стратегийн цар хүрээ, хүсэл эрмэлзлийг харгалзан эдгээр бүх өөрчлөлтүүд нэгэн зэрэг бодитойгоор эхэлж чадахгүй. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа дэс дараалалтай явагдана. НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээг дахин бодож үзэх, сэдвийн сорилтын бүсийг тодорхойлох зэрэг суурь үйл ажиллагаануудыг эхний жилүүдэд нэн тэргүүнд тавьж, дараа дараагийн жилүүдэд Засгийн газрын нээлттэй хөтөлбөрт олон нийтийн дэмжлэгийг илүү ихээр бий болгох зэрэг илүү дэвшилтэт зорилтуудыг хэрэгжүүлэх боломжийг олгоно.

Түншлэлийг хамарсан стратегийг хэрэгжүүлэхийн тулд Түншлэлийг бүрдүүлдэг олон оролцогчдын дунд зохицуулалт хийх шаардлагатай болно.

НЗТ-ийн Удирдах хороо стратегийг хэрэгжүүлэх чиглэл өгч, стратегийн зорилтуудыг урагшлуулах НЗТ-ийг Дэмжих нэгж, ХБТМ-ын ажлын төлөвлөгөөг батална. НЗТ-ийг Дэмжих нэгж, ХБТМ нь ажлын төлөвлөгөөг жил бүр тайлагнана. Жил бүрийн тайланг нийтэлнэ.

Олон нийтэд санал бодлоо илэрхийлэх хугацаа нь тайлангууд өргөн түншлэлийн хөгжил дэвшлийг харуулж чадах эсэхийг баталгаажуулна.

Стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсвийг Нээлттэй засгийн түншлэлийн Захирлуудын зөвлөл батална.

НЗТ-ийн дэлхийн чуулган, бүс нутгийн арга хэмжээ, оролцогчдын хоёр жил тутмын судалгааг илүү өргөн цар хүрээтэйгээр НЗТ-ийн олон нийт, түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх, хөгжил дэвшлийг тогтмол судалж, Дэмжих нэгж болон Удирдах хорооны хоёр жилийн ажлын төлөвлөгөөнд хувь нэмрээ оруулан ашиглах болно.

Үүнээс гадна НЗТ-ийг Дэмжих нэгж нь ХБТМ-ын өгөгдөл, дүн шинжилгээ болон стратегийн эхний жилд боловсруулах сургалтын хүрээг ашиглан стратегийг урагшлуулахад гарсан ахиц дэвшлийг мөрдөж, мэдэрч байгааг үе үе мэдээлнэ.

Өмнөд Африкийн иргэний нийгмийн байгууллагууд Засгийн газартай хамтран үндэсний төсвийг нээлттэй болгов. НЗТ-ийн гэрэл зураг

СУРАЛЦАХ АРГА БАРИЛ

Стратегийг хэрэгжүүлэх эхний жилд НЗТ-ийг Дэмжих нэгж нь Стратегитай уялдуулах сурах арга барилаа сэргээнэ. Стратеги нь хувь хүний болон системийн өөрчлөлтийг биет болон биет бус хэмжүүрээр хэмждэг. Биет хэмжүүрт амархан харуулах эсвэл хэмжих боломжтой хэмжүүр багтдаг бол биет бус хэмжүүрт нөлөөлж чадах эсвэл хувь нэмрээ оруулж чадах боловч шууд харуулах хэцүү хэмжүүр багтдаг. Хувь удирдагч, шинэтгэгч нарын хувьд биет бус хэмжүүр нь тэдний чадвар, улс төрийн боломж, нөлөөтэй холбоотой байж болох бол биет хэмжүүр нь өөрчлөлтийг жолоодох нөөц бололцоо багтаж болно. Системийн өөрчлөлт нь Засгийн газар болон засгийн газрын бус оролцогчдын итгэлцэл, харилцаа, хамтын үйл ажиллагаа, дэлхий нийтийн хэм хэмжээг тогтоох, бодлого, хууль эсвэл шинэ эвсэл байгуулах бодит болон албан ёсны өөрчлөлт зэрэг биет бус талуудыг бид харах болно.

Суралцах арга барил нь системийн болон хувь хүний аль алиныг нь дагах хэмжүүрийн арга барилаар бүтээгдэх бөгөөд өөрчлөлт, үйл ажиллагааны онолоор хийгдсэн таамаглалуудыг туршихад туслах, стратеги хэрэгжүүлэх явцад ахиц дэвшлийг үнэлэх, шаардлагатай бол залруулгыг мэдээлэх биет болон биет бус өөрчлөлтөөр зохион байгуулна.

Өнгөрсөн арван жилийн бариимтаас харахад иргэд амьдралд нь нөлөөлөх шинэчлэлийг зохион бүтээх, хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэдэг байна. НЗТ-ийн гэрэл зураг

Сургалтын шинэчилсэн хүрээг үндэслэсэн шинэ асуултуудын жишээ:

- Хувь хүн шинэчлэл хийж бэхжүүлэхэд санал болгодог нээлттэй төрийн удирдлага, ур чадварыг хөгжүүлэх чадвар, уялдаа холбоо хаана, хэрхэн байна вэ?
- Энэ нь тэдний эхлүүлсэн шинэчлэлийн хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Шинэ үйл ажиллагааны хүрээнд өгөгдсөн урамшууллын аль багц нь нээлттэй засгийн шинэчлэлд илүү их хүсэл эрмэлзлийг өдөөхөөр ажиллаж байна вэ?
- НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс гадна нээлттэй засгийн гол зорилго юу вэ?
- Засгийн газрын шинэ оролцогчид иргэний орон зай гэх мэт эмзэг сэдвээр илүү нээлттэй ярилцаж, оролцож байна уу? Иргэний нийгмийн удирдагчид үүнийг хэлэлцэж байна уу?
- Ямар шалгуур үзүүлэлт, бэрхшээл, бусад арга хэрэгсэл нь чухал сэдвийг авч үзэх хүсэл эрмэлзлийг өдөөж байна вэ?
- Хамтын хөгжил дэвшилд хүрэхийн тулд Түншлэлийг сорьж, дэмжих ямар ур дүнтэй арга замууд байдаг вэ?
- НЗТ-ийн боловсруулсан, хадгалсан эх үүсвэрүүдийг хэрхэн ашиглаж, ур шимийг нь хүртэж байна вэ?

Эдгээр асуултуудад хариулахын тулд бодит мэдрэмжийг бий болгох, хамт олонтой ажиллах, стратегийн хяналт шалгалт хийх, чанарын болон тоо хэмжээний арга барилыг ашиглан өөр өөрчлөлтийг дагах, тэднийг холбох, ур дүнг харуулах, хандивт дүн шинжилгээ хийх зэрэг аргуудтай уялдуулан ХБТМ-ын өгөгдөл, анализыг хослуулан ашиглах шаардлагатай болно.

Дэмжих нэгж нь бодит цагт суралцах, дасан зохицох сэтгэлгээгээр олон нийттэй хамт стратегийн хэлэлцүүлгийг удирдана. НЗТ-ийн Удирдах хорооны стратегийн албан ёсны үнэлгээг Стратегийн төгсгөлд хийнэ.

2022 онд болсон НЗТ-ийн бүсийн арга хэмжээний үеэр шинэтгэгч нар өөрсдийн нөхцөлд нээлттэй засгийн шинэчлэлийг урагшлуулахад нь туслах үйл ажиллагааны хүрээний талаар ярилцжээ. НЗТ-ийн гэрэл зураг



Энэхүү бүтээл нь Creative Commons Attribution 4.0 Олон улсын лицензийн дагуу лицензтэй болно.
Энэхүү зөвшөөрлийн хуулбарыг үзэхийн тулд http://creativecommons.org/licenses/by/ 4.0/ дарна уу.

Дизайн & Зураглал

Алекс Планкетт
Neue Bandbreite | Коммуникацисдесигн,
Берлин neuebandbreite.com

Бидэнтэй хамтран ажиллах:
Хэрэв танд энэ бүтээгдэхүүний талаар ямар нэгэн асуулт байвал info@opengovpartnership.org холбогдоно уу.

Бидний арга хэмжээнд оролцоорой.

Сар бүрийн НЗТ-ийн сониноор дамжуулан НЗТ-ийн мэдээг цаг алдалгүй авч байгаарай. (Испани, Англи хэл дээр үзэх боломжтой)

Бидэнтэй хамтарч НЗТ-ийн эвсэлд нэгдээрэй.

www.opengovpartnership.org

@opengovpart

@OpenGovernmentPartnership

Open Government Partnership

@opengovpartnership

Англи хэлний хувилбар 1.0/05.2023

Timestamp	Таны нэр?	Таны төлөөлж буй байгууллагын нэр?
11-10-2023 16:27:07	Наранцэцэг	Монголын Байгаль Эхийн Аврал Сан-ТББ
11-10-2023 19:24:45	Отгонбаатар	Хил хязгааргүй хуульчид ТББ
11-10-2023 21:49:08	Э.Тунгалаг	Тунгаахуй өгөгдлийн урлан ХХК
11-13-2023 11:23:58	Дававаням	ЗГХЭГ
11-13-2023 12:04:39	Ганбатын Халиунгоо	Азийн сан
11-13-2023 12:23:37	О.Энхзул	Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны Ажлын алба
11-13-2023 13:42:04	Б.Онон	Глоб Интернэшнл төв
11-13-2023 16:12:44	Г.Гүнжидмаа	Хэвлэл мэдээллийн зөвлөл
11-13-2023 16:57:21	Д.Оюунбадам	Нээлттэй нийгэм форум
11-14-2023 17:06:03	Э.Баасансүрэн	Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн
11-15-2023 8:43:45	Ш.Энхтуяа	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
11-15-2023 10:16:54	Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэн
11-15-2023 11:54:09	О.Хатанболд	ШУА-ийн Философийн хүрээлэн
11-15-2023 16:42:32	Наранцэцэг	Монголын Байгаль Эхийн Аврал Сан-ТББ
11-16-2023 8:51:33	Батзул	Төрийн худалдан авах ажиллагааны газар
11-16-2023 19:58:20	Д.Ган-Эрдэнэ	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
11-17-2023 17:23:30	Х.Эрдэм-Ундрах	ХЗҮХ
11-19-2023 23:32:15	Билгүүн	Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн үүр төв

НЗТ-ИЙН V ТӨЛӨВЛӨГӨӨНД АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДЭЭС САНАЛ АВАХ ТУХАЙ

Таны нэр?
.....
Таны төлөөлж буй байгууллагын нэр?
.....

Та доорх жагсаалтаас өөрийн мэргэшсэн салбарыг сонгоно уу? (1-2 сонгох боломжтой) *

- ◯ Эрдэс баялаг, эрчим хүч
- ◯ Хэвлэл мэдээллийн эрх чөлөө
- ◯ Худалдан авах ажиллагаа
- ◯ Иргэний нийгмийн орон зай
- ◯ Байгаль орчин, хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлт
- ◯ Улсын төсөв
- ◯ Эм, эмнэлгийн хэрэгсэл
- ◯ Бизнес ба Хүний эрх
- ◯ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл
- ◯ Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлэх
- ◯ Нээлттэй өгөгдөл
- ◯ Шүүх засаглал
- ◯ Other: _____

Салбар №1. Эрдэс баялаг, эрчим хүчний салбар

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьж, хэлэлцүүлэх

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн холбогдох байгууллага, төрийн өмчит компаниудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх;

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Монголын Олборлох Ил Тод Санаачилгын тайлангаар дамжуулан нийтэд ил тод болгодог мэдээллүүдийг төрийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар дамжуулан шууд мэдээлдэг болох

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөвт суулган шийдвэрлэх

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгыг Уул уурхай хүнд үйлдвэрийн Яамны нэг нэгж болгосон 17-н жил идэвхтэй явж ирсэн үйл ажиллагаа доголдож, нэр төдий болж хувирч байгаа нь тун харамсалтай;
2. Байхгүй;
3. Эрдэс баялгийн салбарын нээлттэй өгөгдлийг стандартжуулах, нээлттэй өгөгдлийн жагсаалтад нэмэх ("Нээлттэй өгөгдлийн жагсаалт", Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолын хавсралт);
4. УУХҮЯ-наас оруулах саналыг заавал харгалзан үзэх;
5. Нэмэлт саналгүй;
6. Энэ салбарын эксперт биш тул саналаа өгөөгүй;
7. Үгүй;
8. Байхгүй;
9. Хариулт: Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. салбар ажлын хэсгүүдээр хэлэлцүүлэн үлдээх болон өөрчлөх амлалтыг шийдвэрлэсэн нь зөв гэж бодож байна;

11. "мэдээллүүд ил тод байх боломжийг бүрдүүлэх";
12. "Үндсэн хуулийн 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэдгийг үндэслэн баялгийн салбарын ил тод байдлыг хуульчлах ёстой. Ингэснээр дараах ач холбогдолтой байж болох юм. Үүнд: -Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хянах, хариуцлага тооцох хууль зүйн үндэслэлийг сайжруулах. -Ил тод байдлын асуудал дээр Эрдэнэт үйлдвэрийг жишээ авч болно. Энэ нь иргэд үйлдвэрийн үйл ажиллагааны талаар мэддэг болсноор үргүй зардлаас зайлсхийж Эрдэнэт үйлдвэрийн ашгийн хэмжээ нэмэгдэж эхэлсэн. -Нээлттэй засгийн түншлэлийн хүрээнд манай улс олон улсын өмнө эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сайжруулна гэж амалсан. -Эрдэс баялгийн салбар Монгол Улсын хувьд эдийн засгийн асар их ач холбогдолтой учраас энэ салбар дахь авлигын эсрэг хууль зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна. Үүний үр дүн нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, эдийн засгийн болон байгаль орчин, иргэдийн мэдэх эрхийн тухайд чухал ач холбогдолтой, хугацааны хувьд 2023-2027 оны хооронд хэрэгжих боломжтой байна";
13. not applicable;
14. "Ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг УУХҮЯ-ны харьяанаас гаргаж Ерөнхий сайдын Багцанд оруулж ажиллуулах";
15. Мэдээллийг нээлттэй өгөгдөл хэлбэрээр хэлбэрээр байршуулдаг байх эрх зүйн орчин хэрэгтэй байна;
16. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх;
17. "Үндсэн хуулийн 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэдгийг үндэслэн баялгийн салбарын ил тод байдлыг хуульчлах ёстой. Ингэснээр дараах ач холбогдолтой байж болох юм. Үүнд: -Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хянах, хариуцлага тооцох хууль зүйн үндэслэлийг

сайжруулах. -Ил тод байдлын асуудал дээр Эрдэнэт үйлдвэрийг жишээ авч болно. Энэ нь иргэд үйлдвэрийн үйл ажиллагааны талаар мэддэг болсноор үргүй зардлаас зайлсхийж Эрдэнэт үйлдвэрийн ашгийн хэмжээ нэмэгдэж эхэлсэн. -Нээлттэй засгийн түншлэлийн хүрээнд манай улс олон улсын өмнө эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сайжруулна гэж амласан. -Эрдэс баялгийн салбар Монгол Улсын хувьд эдийн засгийн асар их ач холбогдолтой учраас энэ салбар дахь авлигын эсрэг хууль зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна. Үүний үр дүн нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, эдийн засгийн болон байгаль орчин, иргэдийн мэдэх эрхийн тухайд чухал ач холбогдолтой, хугацааны хувьд 2023-2027 оны хооронд хэрэгжих боломжтой байна";

18. В.

Салбар №2 Хэвлэл мэдээллийн эрх чөлөө

Төрийн болон албаны нууцын жагсаалтыг мэдээллийн ил тод байдлын зорилгод нийцүүлэн өөрчлөх

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Төрийн болон албаны нууцын тухай хуулийг өөрчилж Засгийн газрын тогтоол, төрийн байгууллагын шийдвэрээр бус зөвхөн хуулиар төрийн нууцын жагсаалтыг батлах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг эцэслэн боловсруулж өргөн барих. Лобби үйл ажиллагаа зохион байгуулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Сэтгүүлч эх сурвалжаа нууцлах баталгааг "Шүгэл үлээгчийг хамгаалах тухай" болон "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуулийн төсөлд тусгах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Алга;
2. "байхгүй";
3. Төрийн болон албаны нууцын жагсаалтаас гарсан мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох;

4. Шүгэл үлээгч өөрийн эх сурвалжаа нууцлах баталгааг хуулиар хамгаалсан ч эх сурвалж нь үнэн байх баталгааг өөрөө хариуцах тухай заалтыг нарийвчлан оруулж өгөх хэрэгтэй гэж үзэж байна. Мэдээллийн эх сурвалжийг шалгах, нотлох үйл явцад гарсан зардлыг тухайн мэдээлэл өгсөн иргэн хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх гэх мэт;
5. Нэмэлт саналгүй;
6. Энэ салбарын эксперт биш тул саналаа өгөөгүй;
7. Үгүй;
8. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртэй уялдуулж ажиллах, уг баримт бичигт оролцогч талуудыг мэдээллээр хангах нөлөөллийн ажил хийсний дараа буюу 2026 онд УИХ-д өргөн барихаар төлөвлөсөн байгаа;
9. Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. байхгүй байна;
11. Сэтгүүлч нарын ёс зүйг сайжруулах;
12. "Хүн бүр өөрийн үзэл бодол, мэдээлэл, баримтыг өөрийн болон нууц, зохиомол нэрээр нийтлэн гаргах, илэрхийлэх, түгээх, хуваалцах үндсэн эрхтэй. Цаашлаад эх сурвалжаа нууцлах, ил болгох зэрэг нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх арга, хэлбэрт хамаардаг. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээллийн ажилтан мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзах эрх нь үг хэлэх эрхийн нэг хэсэг юм. Энэ талаар Хууль зүйн үндэсний хүрээлэн 2023 онд “Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”, “Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүн нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах тодорхой зорилготой, хэд хэдэн шалгуур үзүүлэлт гарган үр дүнг хэмжин, хүрч болохуйц, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаснаар иргэдийн мэдэх эрх, үзэл бодлын эрх чөлөө хангагдах ач холбогдолтой, хугацааны хувьд 2023-2027 оны хооронд хэрэгжих боломжтой байна";
13. not applicable
14. Тодорхой санал алга, мэргэжлийн бус учир;
15. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай асуудлыг тусад нь эрх зүйн орчныг боловсронгуй болох замаар шийдвэрлэх;
16. Саналгүй;
17. "Хүн бүр өөрийн үзэл бодол, мэдээлэл, баримтыг өөрийн болон нууц, зохиомол нэрээр нийтлэн гаргах, илэрхийлэх, түгээх, хуваалцах үндсэн эрхтэй. Цаашлаад эх сурвалжаа нууцлах, ил болгох зэрэг нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх арга, хэлбэрт хамаардаг. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээллийн ажилтан мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзах эрх нь үг хэлэх эрхийн нэг хэсэг юм. Энэ талаар Хууль зүйн үндэсний хүрээлэн 2023 онд “Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”, “Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүн нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах тодорхой зорилготой, хэд хэдэн шалгуур үзүүлэлт гарган үр дүнг хэмжин, хүрч болохуйц, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаснаар иргэдийн мэдэх эрх, үзэл бодлын эрх чөлөө хангагдах ач

холбогдолтой, хугацааны хувьд 2023-2027 оны хооронд хэрэгжих боломжтой байна";
18. N/A.

Салбар №3 Худалдан авах ажиллагаа

Цахим каталогийн системийн өгөгдлийг цуглуулж ашиглалтад оруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Худалдан авах ажиллагааны хариуцлагын тогтолцоог төгөлдөржүүлж, RED FLAG INDICATOR бий болгох, олон нийтэд ил тод түгээх

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Алга;
2. Байхгүй;
3. Худалдан авах ажиллагааны нээлттэй өгөгдөл бий болгох, нээлттэй өгөгдлийн жагсаалтад орсон "Төрийн худалдан авах ажиллагааны мэдээлэл" гэдгийг нарийвчлан задлах ("Нээлттэй өгөгдлийн жагсаалт", Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолын хавсралт);
4. Цахим мэдээллийн сантай болох, хэрэглэх, зөв ашиглах талаар цаашид энэ сангийн мэдээллийг хэрхэн хадгалах, архив бүрдүүлэх талаар нэгдсэн дүрэм, журам гаргах шаардлагатай гэж үзэж байна;
5. Нэмэлт саналгүй;
6. Энэ салбарын эксперт биш тул саналаа өгөөгүй;
7. Үгүй;
8. Үгүй;
9. Нийслэл, дүүргүүдийн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд нийт худалдан авалтад шууд худалдан авалтын эзлэх хувь хэмжээг бууруулах, Худалдан авах ажиллагааны тухай болон Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох;
10. байхгүй байна;
11. "дэмжиж байна";
12. "RED FLAG INDICATOR гэдэг нь санхүүгийн үйл ажиллагаа дахь сэжигтэй зүйлсийг илрүүлэх, мэдээлэхэд ашигладаг механизм юм. Энэ нь мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. RED FLAG INDICATOR нь үйлчлүүлэгчийн нууц эсвэл сэжигтэй үйлдэл, хууль ёсны арилжааны зорилгогүйгээр оффшор бүсэд shell компани байгуулах, ямар нэгэн тодорхой шаардлагагүйгээр

компаний нэр дээр гүйлгээ хийх, хэт төвөгтэй корпорацийн бүтэцтэй байх зэрэг нийтлэг байдлаар илэрч болно. Мөнгө угаах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан шинж чанартай байдаг тул энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд олон улсын байгууллагууд бий болсон ба тэдгээрийн нэг нь FATF ба Монгол Улс үүнтэй 2007 оноос хамтран ажиллаж байгаа. Тус байгууллагаас мөнгө угаахтай тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааны загвар, зөвлөмжүүдийг гаргадаг тул тэдгээрийг төрийн худалдан авах ажиллагаандаа хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна";

13. No;
14. Өөр санал алга;
15. Худалдан авах гэрээний үр дүн, санхүүжилтийг ил тод болгож, тогтмол хөтлүүлдэг байх;
16. төр хувийн хэвшлийн түншлэл;
17. "RED FLAG INDICATOR нь мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. RED FLAG INDICATOR нь үйлчлүүлэгчийн нууц эсвэл сэжигтэй үйлдэл, хууль ёсны арилжааны зорилгогүйгээр оффшор бүсэд shell компани байгуулах, ямар нэгэн тодорхой шаардлагагүйгээр компанийн нэр дээр гүйлгээ хийх, хэт төвөгтэй корпорацын бүтэцтэй байх зэрэг нийтлэг байдлаар илэрч болно. Мөнгө угаах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан шинж чанартай байдаг тул энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд олон улсын байгууллагууд бий болсон ба тэдгээрийн нэг нь ФАТФ (FATF) ба Монгол Улс үүнтэй 2007 оноос хамтран ажиллаж байгаа. Тус байгууллагаас мөнгө угаахтай тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааны загвар, зөвлөмжүүдийг гаргадаг тул тэдгээрийг төрийн худалдан авах ажиллагаандаа хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна";
18. N/A

Салбар №4 Иргэний нийгмийн орон зай

Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийн төрөөс хараат бус ажиллах орон зайг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Иргэний нийгмийн суурь зарчим, үнэт зүйлсийг багтаасан Төр, иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод, иргэн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоотой явуулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Иргэний Нийгмийн байгууллагуудыг чадавхтай болгоход төрийн бодит дэмжлэгийг бий болгох. Энэ нь төсвийн тодорхой хэсэгт ИНБ-ын санхүүжилтийг тусгах;

2. Байхгүй;
3. Санал байхгүй;
4. Иргэний нийгмийн байгууллагууд болох сан, тбб, холбооны хуулийг шинэчлэн батлуулах, гол нь иргэний нийгмийн байгуулагуудыг эргээд хариуцлагажуулах шаардлага байна гэж үзэж байгаа тул хуульчлах талаарх зорилтыг тусгах;
5. Нэмэлт саналгүй;
6. Байхгүй;
7. Үгүй;
8. Байхгүй;
9. Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. байхгүй байна;
11. Иргэний нийгмийн байгууллагын гишүүдийг тухайн салбарын чиглэлээр чадавхжуулах, хараат бус байх тогтолцоог бүрдүүлэх;
12. "ИНБ гэдэг нь холбоо, судалгааны байгууллага, олон нийтийн бүлэг, нийтлэг ашиг сонирхлын бүлэг, улс төрийн хөдөлгөөн, сонирхлын клуб гэх мэт байгууллагуудыг хэлнэ. 1997 оны ТББ-ын тухай хуулийн хүрээнд ИНБ-ууд нь хуулийн этгээдээр бүртгүүлснээр албан ёсоор санхүүжилт авах болон тайлагнах боломж бүрдэж, орон тооны ажилтан ажиллуулах, үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээнд явуулах боломжтой болсон ба тус хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт төрийн бус байгууллага нь төрөөс хараат бус байхаар хуульчилсан. Манай улсын хувьд иргэний нийгмийн байгууллагуудыг татварын бодлого, санхүүжилтийн 2 хувийг бус илүү их хувийг төрөөс гаргах боломжоор хангах шаардлагатай байна. , Иргэний нийгмийн байгууллагуудын гол зорилго нь нийгмийн эрх ашигийг хамгаалж, төр засаг, улс төрөөс хараат бус үйл ажиллагаа явуулах, төрийн шийдвэрүүдэд иргэдийн зүгээс оролцох боломжийг нэмэх явдал юм";
13. хуулийн өөрчлөлт;
14. ИНБ-уудаар гүцэтгэх ажлыг санрүүжилттэй нь шийдэж өгч байх;
15. Хуулиар тодорхой зохицуулалтыг оруулсан боловч харилцааг боловсронгуй болгох шаардлагатай. Нэр төдий иргэдийн оролцоог хангасан хэлбэрийн төдий тогтолцоо үйлчилж байна;
16. хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөлд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх;
17. "ИНБ гэдэг нь холбоо, судалгааны байгууллага, олон нийтийн бүлэг, нийтлэг ашиг сонирхлын бүлэг, улс төрийн хөдөлгөөн, сонирхлын клуб гэх мэт байгууллагуудыг хэлнэ. 1997 оны ТББ-ын тухай хуулийн хүрээнд ИНБ-ууд нь хуулийн этгээдээр бүртгүүлснээр албан ёсоор санхүүжилт авах болон тайлагнах боломж бүрдэж, орон тооны ажилтан ажиллуулах, үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээнд явуулах боломжтой болсон ба тус хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт төрийн бус байгууллага нь төрөөс хараат бус байхаар хуульчилсан. Манай улсын хувьд иргэний нийгмийн байгууллагуудыг татварын бодлого, санхүүжилтийн 2 хувийг бус илүү их хувийг төрөөс гаргах боломжоор хангах шаардлагатай байна. , Иргэний нийгмийн байгууллагуудын гол зорилго нь нийгмийн эрх ашгийг хамгаалж, төр засаг, улс

төрөөс хараат бус үйл ажиллагаа явуулах, төрийн шийдвэрүүдэд иргэдийн зүгээс оролцох боломжийг нэмэх явдал юм";
18. N/A.

Салбар №5 Байгаль орчин, хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлт

"Хог хаягдлын тухай" хуулийн хяналт үнэлгээний дүнг олон нийтэд болон шийдвэр гаргагч нарт танилцуулж, сайжруулах арга хэмжээний төсөл боловсруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх тодорхой асуудлыг сайжруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Уур амьсгалын өөрчлөлтөд Монгол улсын оруулах хувь нэмэр болохоор зорьж буй "Тэрбум Мод" үндэсний хөтөлбөр хэрхэн үр дүнтэй явагдаж байгаа талаарх мэдээлэлийг олон нийтэд ил тод нээлттэй байлгах;
2. дэвшүүлэх саналаа улам тодорхой болгох;
3. Санал байхгүй;
4. Хог хаягдлын талаар олон нийтэд нээлтэй, тогтмол мэдээллэх, хогны мөнгө хэмээн иргэдээс авч буй хураамжийн зарцуулалтын тайланг иргэд, олон нийтэд тавих, хэлэлцүүлэх, нөгөө талаар сайн туршлагыг сурталчлах зэрэг үйл ажиллагааг дэмжих чиглэлийн зорилтод тусгах;
5. ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТОДОРХОЙЛСОН ХУВЬ НЭМРИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ;
6. Энэ салбарын эксперт биш тул саналаа өгөөгүй;
7. Үгүй;
8. Үгүй;
9. Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. байхгүй байна;
11. Хог хаягдлыг ангилан хаях боломжийг бүрдүүлэн, иргэдийн ухамсар, хог хаягдлаа ангилан, хаядаг дадалд сургахад нөлөөллийг ажлыг зохион байгуулах, Сургууль, цэцэрлэгийн орчинд хог хаягдлыг ангилан хаях орчныг бүрдүүлэн, хүүхдүүдэд хог хаягдлаа ангилан хаягдаг дадлыг төлөвшүүлж, сургаж, дадалтай болгох;
12. Байхгүй;
13. Үгүй;

14. НҮБ-аас уур амьсгалын өөрчлөлтийг багасгахад иргэдийн оруулах хувь нэмрийн талаарх мэдээлэлийг ил тод хүргэхээр зорьж ажиллах;
15. Зорилт нь тодорхой бус учир илүү ойлгомжтой болгох;
16. Саналгүй;
17. Хог хаягдлаас метан хий ялгардаг, мөн хөрс, усны бохирдол үүсгэн манай улсын байгаль орчин, уур амьсгалд сөрөг нөлөө үзүүлдэг. Энэ талаар хог хаягдлаас ялгарах хорт хий, орчны бохирдлын талаар Байгаль орчны мэдээллийн газар, Байгаль орчин уур амьсгалын сан, Цаг уур, орчны шинжилгээний газар тус тус өөрт холбогдох асуудлаар шинжлэх ухааны тооцоолол хийдэг тул байгаль орчин, хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлтийн талаар холбогдох асуудлуудыг шийдвэрлэх баримт бичгүүдийн холбогдох салбарын яам түүний харьяа байгуулагуудаар хэрэгжилтийг хангуулах нь зөв;
18. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө Монголд ямар байгаа талаар судалгаа, мэдээллийг тогтмол, нээлттэй танилцуулах.

Салбар №6 Улсын төсөв

Монгол Улсын төсөв, хөрөнгө оруулалт, тусгай сангууд, зээл тусламж, төсөл хөтөлбөрийн төлөвлөлтөөс эхлээд хэрэгжүүлж дуусах бүхий л үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтыг төсвийн хууль тогтоомжид оруулах, үүний тулд одоо байгаа зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тэдгээрийг хэрхэн боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий зөвлөлдөх механизмыг талуудын оролцоотойгоор ажиллуулж үр дүнд хүрэх

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журамд батлагдсан төсвийн тоон мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар ил болгох зохицуулалт оруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Shilendans.gov.mn сайтыг шинэчлэхдээ төсвийн хэрэгжилт, ил тод байдлыг хангахад ашиглагдаж буй систем хоорондын уялдааг хангах, талуудын оролцоог тэгш хангаж санал солилцох, судалгаан дээр тулгуурлан хөгжүүлэх

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд жилийн турш саналаа өгч болох цахим талбар бий болгох

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn сайт дахь хайлтын системд төслийг “эхлэх огноо”-оор нь хайлт хийх сонголт оруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Дээрх саналуудтай санал нэг байна. Дан ялангуяа дараа жилийн улсын төсөвийн төлөвлөлтбнд иргэд,олон нийт саналаа өгдөг нээлттэй системийг нэвтрүүлж,тогтмолжуулах;
2. Байхгүй;
3. Шилэн дансны мэдээллийг нээлттэй өгөгдөл болгож, shilendans.gov.mn цахим хуудсанд нээлттэй өгөгдлийн цэс үүсгэн оруулах;
4. Саналгүй;
5. нэмэлт саналгүй;
6. Байхгүй;
7. Энгийн, ойлгомжтой болгох;
8. Үгүй;
9. "1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтийг боловсронгуй болгох. Үүнд: -УИХ-аар төсөв хэлэлцэх явцад хөрөнгө оруулалтын төсөл нэмэх тохиолдолд уг төсөл нь төсвийн төлөвлөлтийн шаардлагыг хангаж буй эсэх талаар Үндэсний аудитын газраас дүгнэлт гаргуулдаг болох зохицуулалтыг Төсвийн тухай хуульд оруулах (Үндэслэл: Төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт удаашрахад нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу батлагдсан зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг Засгийн газраас төсөвт тусгаж, түүнийг нь УИХ баталж буй явдал юм. Энэ байдлыг Үндэсний аудитын газраас төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл болон дуусаагүй орхигдсон барилга, байгууламжуудад хийсэн удаа дараагийн аудитаар хөндөж, зөвлөмж өгсөн боловч нөхцөл байдал өнөөг хүртэл давтагдсаар байна. Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасны дагуу шинээр эхлэх барилга байгууламжийг төсөвт суулгах үед зохих үнэлгээ болон зураг, төсөв нь хийгдсэн байх ёстой юм) -Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт дахь “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” маягтад “Төсвийн тухай хуулийн 29.4 дэх “ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх” шаардлагыг хангаж буй эсэх мэдээллийг төсөл тус бүрээр тусгах байдлаар өөрчлөлт оруулах; -Засгийн газраас төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн мэдээллийн агуулгыг сайжруулж, жил бүрийн төсвийн төслийн танилцуулгад шинээр эхлэх томоохон төсөвт өртөгтэй төслүүдийн үр ашгийн тооцоог ил болгох, түүнчлэн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн төрлийг дурдалгүй “төсөл” гэсэн ерөнхий нэрээр төлөвлөгдсөн томоохон дүнтэй

зардлуудын дэлгэрэнгүй танилцуулгыг багтаах; -Улс, орон нутгийн төсвийн тодотгол хийгдэх тохиолдолд төсөлд туссан хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд худалдан авах ажиллагаа хийгдсэн эсэх, тодотголоор нэмэгдсэн болон хасагдсан төслүүдийн жагсаалт, тухайн онд санхүүжих дүн өөрчлөгдсөн эсэх мэдээллийг маягтад мөн тусгадаг байхаар тусгайлсан маягт боловсруулах. 2. Улсын төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх. Үүнд: -Улсын жилийн төсвийн төслийн баримт бичиг, тооцооллын хавсралтууд дахь тоон мэдээллийг нээлттэй өгөгдлийн хэлбэрээр ил болгох; -Улсын төсвийн төслийн баримт бичигт төсвийн жилийн байдлаарх Засгийн газарт буй санхүүгийн хөрөнгийн мэдээлэл (хөрөнгийн жагсаалт, үнийн дүн) тусгах; -Улсын төсвийн төслийн баримт бичигт төсвийн жилийн байдлаарх Засгийн газарт буй санхүүгийн бус хөрөнгийг төрлөөр нь ангилсан мэдээлэл тусгах; -УИХ-аас баталсан улсын төсвийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулах хүрээнд зарлагыг эдийн засгийн ангиллаар эсхүл зориулалтаар, хөтөлбөрөөр ангилсан байдлаар баталдаг болох; -Төрийн аудитын байгууллагаас улсын төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг УИХ, Засгийн газар үйл ажиллагаандаа хэрхэн тусгасан талаарх тайланг гаргаж, нийтэд ил болгох; -Төсөв захирагчид аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг ил болгох шаардлагын хэрэгжилтийг дээшлүүлэх; -Шилэн дансны тухай хууль, журмыг боловсронгуй болгох. Үүнд, Засгийн газрын тусгай сангуудын төсвийг зарцуулах сонгон шалгаруулалт, санхүүжилтийн үйл жиллагаа, гадаад, дотоодын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтын үйл ажиллагаа, төрийн өмчит компаниуд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, гүйлгээ, холбогдох шийдвэрийн хуулбарын ил тод байдлыг дээшлүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийг актлах, устгах тухай шийдвэрийг ил болгох талаарх зохицуулалтыг хууль, журамд тусгах, боловсронгуй болгох; -Нийслэл, дүүргүүдийн зүгээс Шилэн дансны хуулийн дагуу 5 сая төгрөгөөс дээш худалдан авалт, гүйлгээнд холбогдох шийдвэр, төсвийн төслийн ил тод байдлыг хангах заалтуудын хэрэгжилтийн аудитыг тогтмолжуулж, хэрэгжилтийг хангуулах";

10. байхгүй байна;
11. Төрийн үйлчилгээний цахим систем бий болгох, хөгжүүлэх ажилд төсвөөс хангалттай хэмжээгээр санхүүжүүлж, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх;
12. Байхгүй;
13. Үгүй;
14. Өөр санал одоогоор алга;
15. Хэрэгжих боломжтой саналууд оруулмаар байна. Жишээ төсөв батлахад бүрдүүлэх материалуудыг олон нийтэд ил тавих. Ямар институтын санаачлагаар тухайн төсөл, араг хэмжээ хэрэгжих болсон, түүний үндэслэл, судалгаа;
16. төсвийн үр дүн, үр нөлөөг сайжруулах;
17. "Улсын төсөв нь нийгэм, эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд улсын мөнгөн хуримтлал юм. Үүнийг УИХ-аас баталж, Засгийн газар бүрдүүлэн, зарцуулдаг ба урсгал орлого, тусламжийн орлого гэж ангилдаг. Энэ талаар сангийн яамнаас “ИРГЭДИЙН ТӨСӨВ” нэртэй улсын төсвийг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад ойлгомжтой, энгийн байдлаар тайлбарласан номыг 2018 оноос

гаргаж байгаа ба 2023 оны 10 сард “Иргэдийн төсөв 2024” төсвийн төслийг өөрийн цахим хаягтаа байршуулсан байна. Ингэснээр улсын төсвийн талаар мэдлэгээ иргэд, иргэний нийгмийн байгууллагууд нэмэгдүүлснээр төсөвт тавих хяналт, оролцоогоо нэмэгдүүлж чадах юм. Үүний үр дүн нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, ач холбогдолтой, хугацааны хувьд 2023-2027 оны хооронд хэрэгжих боломжтой байна. Иймд дээрх зорилтыг төлөвлөгөөнд үлдээх саналтай байна";

18. N/A.

Салбар №7 Эм, эмнэлгийн хэрэгсэл

Эмийн үнийн эрх зүйн орчны үнэлгээг хийж, хууль эрх зүйн баримт бичигт үнийн зохицуулалтын талаар өөрчлөлт оруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Эмийн сурталчилгааны төгсгөлд эмийн зохистой хэрэглээний тухай дурдах журмыг батлах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Системийн нарийн мэдээлэлийг мэдэхгүй учир тодорхой өгөх санал байхгүй;
2. Байхгүй;
3. Санал байхгүй;
4. Эмийн сурталчилгааг зөвхөн хэрэглэх заалтын дагуу буюу ямар өвчинд хэрхэн хэрэглэх талаар нь сурталчлах, мөн эмч эмнэлгийн ажилтан эм, нэмэлт бүтээгдэхүүн, витаминыг сурталчлахгүй байх зэрэг зрхицуултыг журамлах саналтай байна;
5. Нэмэлт саналгүй;
6. Энэ салбарын эксперт биш тул саналаа өгөөгүй;
7. Үгүй;
8. үгүй, эдгээр асуудлыг сайн мэдэхгүй байгаа тул үлдээх гэснээр явлаа;
9. Хариулт: Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. байхгүй байна;
11. Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, хяналтын нэгдсэн цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангах;
12. Байхгүй;
13. Үгүй;
14. Өөр санал алга;
15. НЗТ-ийн үндсэн агуулгад шууд хамааралгүй;
16. Эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой стандартыг сайжруулах, шинэчлэх;

17. "Энэ талаарх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар эмчилгээ, оношилгооны өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой ажилладаг. Гэтэл ЦХХХЯ-ны сайд Н.Учрал, ХЗДХЯ-ийн сайд Б.Энхбаяр нар монголд эмийн мафи байгаа талаар нэг бус удаа олон нийтэд мэдээлж байсан. Манай улс эмийнхээ 80, биологийн идэвхт бүтээлдэхүүний 95, оношлуурын 99 хувийг импортолдог. Улсын хэмжээнд 2100 орчим эмийн сан, эм ханган нийлүүлэх 440 гаруй байгууллага байдаг. Гэвч энэ талаар сүүлийн 3 жилийн хугацаанд бүрэн хэмжээний судалгаа хийгээгүй, чанар болоод үнийн өсөлтийн талаар яг ямар арга хэмжээ авдаг нь тодорхойгүй байна. Иймд эмийн үнийн эрх зүйн орчны үнэлгээг хийж, хууль эрх зүйн баримт бичигт үнийн зохицуулалтын талаар өөрчлөлт оруулахдаа эмийн чанар, үнийн өсөлтийн талаар болон гадаад улсуудад хямд чанартай зарагддаг эм, эмнэлгийн хэрэгсэл манай улсад зарагдах боломжийн талаар хуульдаа тусгах саналтай байна";
18. Эм, эмнэлгийн хэрэгсэлийг зөвшөөрлийн нээлттэй мэдээллийн санг боловсронгуй болгох, үүнд тухайн импортын болон дотоодын эм, эмнэлгийн хэрэгсэлд ямар судалгаа, баталгааг үндэслэн зөвшөөрөл олгосон мэдээллийг ил тод болгох.

Салбар №8 Бизнес ба Хүний эрх

"Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)"-д туссан үйл ажиллагаа *(Тус төлөвлөгөө Ажлын хэсгийн гишүүдэд илгээсэн файлын санд бий)*

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Бизнесийн үйл ажиллагааны тодорхой асуудлыг сайжруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Хүний эрхийн тодорхой асуудлыг сайжруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. "Тодорхой асуудал гэдгийг тодорхой заах. Үндсэн хуулиар баталгаажсан эдлэх ёстой эрх ноцтой зөрчигдөөд байгаа учир зөрчигдсөн эрхийг хамгаалах бодит аргх хэмжээ тусгах";
2. Байхгүй;
3. Санал байхгүй;

4. ХЭТТ-д заасан нэг эрх болох өргөдөл, гомдол гаргах эрхийг хэрэгжүүлэх, өргөдөл гомдлын хуулийн шинэчлэн боловсруулж батлуулах гэсэн зорилтыг оруулах саналтай байна;
5. Нэмэлт саналгүй;
6. Энэ салбарын эксперт биш тул саналаа өгөөгүй;
7. Төлөвлөгөөг оролцогч бүх талуудад, ялангуяа бизнес эрхлэгчдэд таниулах ажлууд зохион байгуулах;
8. Үгүй;
9. Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. байхгүй байна;
11. Бизнесийн үйл ажилллагааны цахим пратформтой болж, холбогдох мэдээллүүд нь ил тод, нээлттэй болох;
12. "Тус ажиллагааны төлөвлөгөө нь Монгол Улсад хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах, бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдөх, хүрээлэн буй орчинд үүсэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотойгоор хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, төлөвлөх, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, хэрэгжүүлэхэд зорилготой байна. НҮБ-ын “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын I тулгуур баганад хүний эрхийг хамгаалах талаар төрийн хүлээх үүрэг, хариуцлагатай холбогдуулан 10 зарчмыг тодорхойлсон. Төр нь хүний эрхийг хүндэтгэх орчин бүрдүүлэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчилд хариуцлага тооцох, арилгах талаар зохих арга хэмжээ авах замаар төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, хувь хүн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зүгээс хувь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчихөөс хамгаалах үүрэгтэй. Иймд тус үйл ажиллагаа нь бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх тул үлдээх саналтай байна";
13. Үгүй;
14. Одоогоор өөр санал байхгүй;
15. Хэт ерөнхий байгаа тул оновчтой томъёлох;
16. төр, төрийн албан хаагчид эрх олгосон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг эргэн харах;
17. "Тус ажиллагааны төлөвлөгөө нь Монгол Улсад хүний эрхийг хүндэтгэсэн бизнесийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах, бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдөх, хүрээлэн буй орчинд үүсэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотойгоор хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, төлөвлөх, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, хэрэгжүүлэхэд зорилготой байна. НҮБ-ын “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын I тулгуур баганад хүний эрхийг хамгаалах талаар төрийн хүлээх үүрэг, хариуцлагатай холбогдуулан 10 зарчмыг тодорхойлсон. Төр нь хүний эрхийг хүндэтгэх орчин бүрдүүлэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчилд хариуцлага тооцох, арилгах талаар зохих арга хэмжээ авах замаар төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, хувь хүн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зүгээс хувь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчихөөс

хамгаалах үүрэгтэй. Иймд тус үйл ажиллагаа нь бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх тул үлдээх саналтай байна";
18. N/A.

Салбар №9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл

Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг УИХ-д өргөн барьж, батлуулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Нилээн бодитой шийдлүүдийг бий болгох;
2. стандартын хэрэгжилтийг хангах;
3. Санал байхгүй;
4. Саналгүй;
5. Нэмэлт саналгүй;
6. Энэ салбарын эксперт биш тул саналаа өгөөгүй;
7. Үгүй;
8. Үгүй;
9. Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. өөр санал алга байна;
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих эрх, сурах боломжийг бүрдүүлэхэд анхаарах;
12. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг , Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар зохицуулж байна. Гэвч тус хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүнд аливаа саад учрахаас урьдчилан сэргийлэх, учирч буй саадыг арилгах мөн тэдэнд барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо зэрэг үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зохицуулалт хангалтгүй байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл, хүртээмжийг сайжруулах чиглэлээр Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг УИХ-д өргөн барьж, батлуулах нь зүйтэй";
13. Үгүй;
14. Нарийн мэдээлэл алга;
15. Салбарын одоо байгаа хуулийг мөрдүүлөх, шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт эсхүл шинэчлэн батлуулах;
16. нийгэмшүүлэх, төрийн албанд ажиллах боломжийг нэмэгдүүлэх;

17. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг , Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар зохицуулж байна. Гэвч тус хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүнд аливаа саад учрахаас урьдчилан сэргийлэх, учирч буй саадыг арилгах мөн тэдэнд барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо зэрэг үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зохицуулалт хангалтгүй байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл, хүртээмжийг сайжруулах чиглэлээр Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг УИХ-д өргөн барьж, батлуулах нь зүйтэй";
18. N/A.

Салбар №10 Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлэх

Цаазаар авах ялын хор хөнөөлийг таниулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Гэмт хэрэг зөрчил нь энэхүү ялыг авч хэрэгжүүлмээр тийм аймшигтай байдал нийгэмд амь бөхтэй байгаад байгаагийн зэрэгцээ,илүү хэрцгий шинжийг агуулж байгаа нь энэхүү ялыг байлгаж гүйцэтгэх үүргийг сэргээх нь чухалаар тавигдаж байна;
2. Байхгүй;
3. Санал байхгүй;
4. Саналгүй;
5. Нэмэлт саналгүй;
6. Энэ салбарын эксперт биш тул саналаа өгөөгүй;
7. Үгүй;
8. Үгүй;
9. Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. сайн мэдэхгүй гэсэн хариулт нэмсэн бол зүгээр санагдлаа. Дээрх санал дээр бол тодорхой мэдээлэл байхгүй учир хасах талаар санал өглөө;
11. Дэмжиж байна;
12. "Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн ""амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно"" гэж заасан. Улсын Их Хурал Иргэний болон улс төрийн эрхийн тухайн олон улсын пактынм цаазаар авах

ялыг халахад чиглэсэн Нэмэлт II протоколд нэгдэн тухай хуулийн 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталж цаазаар авах ялыг халах үүргийг олон улсын өмнө хүлээсэн ба энэхүү II Нэмэлт Протоколоос буцаж гарах хууль зүйн боломж байхгүй. Саяхан болсон хүүхэд хүчирхийлж улмаар амь насыг хөнөөсөн гэмт хэргийн холбогдогчийн хувийн мэдээлэл задарч, цахим орчинд иргэд цаазаар авах ялыг сэргээх хэрэгтэй гэж үзэл бодлоо илэрхийлсэн билээ. Гэтэл цаазаар авах ял нь хүн ёсонд нийцэхгүй бөгөөд, хүний жам ёсны эрхэд халдсан зүйл мөн. Энэ талаар иргэдэд эрх зүйн боловсрол олгох замаар цаазаар авах ялын хор хөнөөлийн талаар мэдээдэл хүргэх нь зүйтэй";

13. Үгүй;
14. Цаазын ялгүй улс гэж зарлачихсан учир дахин авч хэрэгжүүлэх талаар эрх зүйн тодорхой мэдээлэл алга;
15. НЗТ-ийн зорилтод шууд хамааралтай эсэхийг тодруулах;
16. Саналгүй;
17. "Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн ""амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно"" гэж заасан. Улсын Их Хурал Иргэний болон улс төрийн эрхийн тухайн олон улсын пактынм цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II протоколд нэгдэн тухай хуулийн 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталж цаазаар авах ялыг халах үүргийг олон улсын өмнө хүлээсэн ба энэхүү II Нэмэлт Протоколоос буцаж гарах хууль зүйн боломж байхгүй. Саяхан болсон хүүхэд хүчирхийлж улмаар амь насыг хөнөөсөн гэмт хэргийн холбогдогчийн хувийн мэдээлэл задарч, цахим орчинд иргэд цаазаар авах ялыг сэргээх хэрэгтэй гэж үзэл бодлоо илэрхийлсэн билээ. Гэтэл цаазаар авах ял нь хүн ёсонд нийцэхгүй бөгөөд, хүний жам ёсны эрхэд халдсан зүйл мөн. Энэ талаар иргэдэд эрх зүйн боловсрол олгох замаар цаазаар авах ялын хор хөнөөлийн талаар мэдэгдэл хүргэх нь зүйтэй";
18. N/A.

Салбар №11 Нээлттэй өгөгдөл

Нээлттэй өгөгдлийн чанар, стандартыг сайжруулах

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нээлттэй өгөгдлийн жагсаалтыг шинэчлэх

Тийм, үлдээх саналтай
Үгүй, хасах саналтай

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Зайлшгүй олон нийтэд нээлттэй байх мэдээлэлийн өгөгдөлүүдийг багтааж оруулах;
2. Байхгүй;
3. Нээлттэй өгөгдлийн стандартыг батлах, Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэхэд төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн нээлттэй хамтын ажиллагааг хангах;
4. ЦХХХЯ-наас гаргах саналд үндэслэх;
5. Нэмэлт саналгүй;
6. Энэ ажил дээр ЦХХХЯ, ҮСХ хамтран ажиллаж байгаа;
7. Үгүй;
8. Үгүй;
9. Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
10. өөр санал алга байна;
11. дэмжиж байна;
12. Байхгүй;
13. Үгүй;
14. Нээлттэы мэдээлэлийн өгөгдлийг иргэд чөлөөтэй ашиглахад хялбар болгох;
15. Жагсаалтыг шинэчлэхээс илүү дэд бүтцийг бий болгоход бодлогын дэмжлэг, програм хангамж, мэдээллийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах хэрэгтэй;
16. нээлттэй өгөгдлийн жагсаалтыг өргөжүүлэх, нарийвчлах;
17. "Нээлттэй өгөгдөл гэдэг нэр томьёог 1995 онд Америкийн шинжлэх ухааны агентлагийн баримт бичигт геофизикийн болон байгаль орчны мэдээллийг нээлттэй болгох тухай тусгасан байдаг. Харин 1993 оноос интернэт, World Wide Web (www) буюу цахим хуудас хөгжиж эхэлснээр нээлттэй өгөгдлийн өнөөгийн ойлголт бий болох суурь бүрдэж, улмаар 2009 онд АНУ-ын Ерөнхийлөгч асан Барак Обама төрийн ил тод, нээлттэй өгөгдлийн тухай бодлогын баримт бичгийг баталж, дэлхийн ихэнх хөгжилтэй улс орнууд төрийн нээлттэй өгөгдлийг хэрэглээнд нэвтрүүлээд байна. Монгол Улсад машинд уншигддаг, ямар нэгэн бүртгэл, бичиг баримт шаардагдахгүйгээр авч, чөлөөтэй ашиглаж хэрэглэж, дахин түгээж болдог, нээлттэй лицензтэй цахим өгөгдөл гэж тодорхойлж байна. 2022 оны 5 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-д нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох тухай анх удаа зааж өгсөн. Ингэхдээ Засгийн газраас нээлттэй өгөгдлийн жагсаалтыг (Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоол) баталж, түүний дагуу мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдлөө өөрийн цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд (https://opendata.gov.mn) байршуулах, тогтмол шинэчлэх тухай зохицуулж өгсөн";
18. Төрийн байгууллагууд хуулиар хүлээсэн нээлттэй өгөгдөл, шилэн дансны мэдээллийг цаг тухайд нь, бүрэн гүйцэд оруулах нөхцлийг бүрдүүлэх, хяналтыг сайжруулах.

Салбар №12 Шүүх засаглал

Нэмэлт санал, тайлбарыг энд бичнэ үү.

Ирсэн санал:

1. Шүүх Засаглалын мэдээлэлүүдийг ил тод болгох. Нууцын зэрэглэлтэй зарим нэг зайлшгүй ил байх шаардлагатай өгөгдөл мэдээлэлүүдийг бий болгох;
2. Шүүх эрх мэдлийн төсвийн тогтвортой байдлыг баталгаажуулах, хөрөнгө оруулалтын төсвийг нэмэгдүүлэх, шүүхийн захиргааны ажилтнуудын цалин, ажиллах орчныг сайжруулах;
3. Иргэний хэргийг шүүхэр шийдвэрлэхдээ эцэслэн шийддэггүй, хохирлыг төлүүлэх, иргэнийг хохиролгүй болгох талаарх шийдвэр нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр очоод гацах, удаан хугацаанд шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх тохиолдол иргэний гомдолд их байдаг;
4. Нэмэлт саналгүй;
5. Байхгүй;
6. Үгүй;
7. Үгүй;
8. Нэмэлт саналаа XI/16-ны дотор өгөх хүсэлтэй байна;
9. санал алга байна;
10. Шүүх засаглалын ил тод байдлыг сайжруулах, шударга байх;
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td>ХБХХЕГ, ХХҮЕГ</td><td>Түгээмэл хөгжил</td><td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум ба Эрхийн хороо</td></tr>
<tr><td rowspan="2">Тэгш хамруулах боловсрол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах:
1. Тохирох хэрэглэгдэхүүн, Туслах багшийн хангамж, ойлголтын талаар үнэлгээ хийх
2. Тохирох хэрэглэгдэхүүн, туслах багшийн талаар БШУЯ-аас журам шинэчлэн гаргах</td><td rowspan="2">Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагдах боломж нэмэгдэж хамрагдалт нэмэгдэнэ.</td><td rowspan="2">2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: БШУЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td>БЕГ, ХБХХЕГ</td><td>Түгээмэл хөгжил төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум</td><td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо</td></tr>
<tr><td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх:</td><td></td><td>2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ХНХЯ</td></tr>
</table>

<table>
<tr><td>Ямар шийдлүүдийг санал болгож байна вэ?</td><td colspan="4">Стандартыг бүх түвшинд боловсруулан гаргаж, хэрэгжилтийг бүх шатны төрийн байгууллагуудад хангуулах.</td></tr>
<tr><td>Энэ үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="4">Богино хугацаанд:
• Стандарт хангасан, чанартай нээлттэй өгөгдөл бий болох
Урт хугацаанд нээлттэй өгөгдөл нь:
1. Шинэ санаа, инновацыг дэмжинэ.
2. Шинэ мэдлэгийг бүтээнэ.
3. Асуудлыг нээж, асуудлыг шийдвэрлэхэд тусална.
4. Баялаг бүтээнэ.
5. Үр дүн, үр нөлөө сайжирна.</td></tr>
<tr><td>Хүрэх үе шатууд</td><td>Хүлээгдэж буй үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td colspan="3">Оролцогчид</td></tr>
<tr><td rowspan="4">Нээлттэй өгөгдлийн шаардлага, стандартыг батлах</td><td rowspan="4">Мэдээлэл хариуцагч төрийн байгууллагууд нээлттэй өгөгдөл бий болгохдоо мөрдөх нэгдсэн стандарт бий болно.</td><td rowspan="4">2024</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЦХХХЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>ХЗДХЯам</td><td>-</td><td>Иргэн, аж ахуй нэгжүүд</td></tr>
<tr><td rowspan="4">Нээлттэй өгөгдлийн талаарх төрийн албан хаагчдын мэдлэгийг сайжруулах сургалт зохион байгуулах</td><td rowspan="4">(Нөхөж бичих)</td><td rowspan="4">(Нөхөж бичих)</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЦХХХЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td></td><td>-</td><td></td></tr>
<tr><td>Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д өгөгдлөө нийтэлж буй мэдээлэл</td><td>(Нөхөж бичих)</td><td>(Нөхөж бичих)</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЦХХЯам</td></tr>
</table>

<table>
<tr><td rowspan="2">1. Хөдөлмөрийн нөхөн сэргээлтийн дүрэм журмыг шинэчлэн боловсруулах
2. Хөдөлмөрийн нөхөн сэргээх үйлчилгээг явуулж эхлэх</td><td rowspan="2">Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.</td><td rowspan="2"></td><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td></td><td></td><td>ХХҮЕГ, ХБХХЕГ</td><td>Бизнес инкубатор төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум</td><td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо</td></tr>
<tr><td colspan="6">Зорилт – 8 Нээлттэй өгөгдөл</td></tr>
<tr><td colspan="6">Үүрэг амлалтын тодорхойлолт: Нээлттэй өгөгдлийн шаардлага, стандартыг боловсруулж, хэрэгжилтийг хангуулах замаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12-р зүйлийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх</td></tr>
<tr><td>Манлайлж хэрэгжүүлэх байгууллага</td><td colspan="5">ЦХХХЯ, Үндэсний статистикийн хороо</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжин ажиллагчид</td><td>Төрийн байгууллага</td><td colspan="2">Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>Хууль зүй, дотоод хэргийн яам</td><td colspan="2">МҮХАҮТанхим</td><td>Иргэн, аж ахуй нэгжүүд</td></tr>
<tr><td colspan="6">Асуудлын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Үүрэг амлалт ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна вэ?</td><td colspan="5">Хууль эрх зүйн орчинд дүрэм, журмуудыг баталж тодорхой түвшинд мөрдөгдөж байгаа боловч Нээлттэй өгөгдлийн стандарт байхгүйгээс нэгдсэн ойлголтгүй, хэрэглээнд тогтмолжоогүй байна.</td></tr>
<tr><td>Асуудлын шалтгаан юу вэ?</td><td colspan="5">1. Нээлттэй өгөгдлийн хэрэглээ бизнесийн салбарт огт байхгүй байгаа нь ЭЗ-ийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.
2. Төрийн үйл ажиллагаанд тавих хяналт, иргэд, ТББ, хувийн хэвшлийн оролцоо хангалттай үндэслэлтэй бус байна.
Төрийн аливаа шийдвэр гаргалтад ашиглахуйц мэдээлэл цогц биш, уялдаа холбоо байхгүй байгаа нь шийдвэр оновчтой биш байдлыг бий болгож байна.</td></tr>
<tr><td>Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?</td><td colspan="5">Стандарт боловсруулах зөвлөх багийг сонгон шалгаруулж, ажлыг эхэлсэн байгаа.</td></tr>
</table>

<table>
<tr><td colspan="2">Ямар шийдлүүдийг санал болгож байна вэ?</td><td colspan="4">Стандартыг бүх түвшинд боловсруулан гаргаж, хэрэгжилтийг бүх шатны төрийн байгууллагуудад хангуулах.</td></tr>
<tr><td colspan="2">Энэ үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="4">Богино хугацаанд:
• Стандарт хангасан, чанартай нээлттэй өгөгдөл бий болох
Урт хугацаанд нээлттэй өгөгдөл нь:
1. Шинэ санаа, инновацыг дэмжинэ.
2. Шинэ мэдлэгийг бүтээнэ.
3. Асуудлыг нээж, асуудлыг шийдвэрлэхэд тусална.
4. Баялаг бүтээнэ.
5. Үр дүн, үр нөлөө сайжирна.</td></tr>
<tr><td colspan="2">Хүрэх үе шатууд</td><td>Хүлээгдэж буй үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td colspan="2">Оролцогчид</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="4">Нээлттэй өгөгдлийн шаардлага, стандартыг батлах</td><td rowspan="4">Мэдээлэл хариуцагч төрийн байгууллагууд нээлттэй өгөгдөл бий болгохдоо мөрдөх нэгдсэн стандарт бий болно.</td><td rowspan="4">2024</td><td colspan="2">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЦХХХЯ</td></tr>
<tr><td colspan="2">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>ХЗДХЯам</td><td>-</td><td>Иргэн, аж ахуй нэгжүүд</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="4">Нээлттэй өгөгдлийн талаарх төрийн албан хаагчдын мэдлэгийг сайжруулах сургалт зохион байгуулах</td><td rowspan="4">(Нөхөж бичих)</td><td rowspan="4">(Нөхөж бичих)</td><td colspan="2">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЦХХХЯ</td></tr>
<tr><td colspan="2">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td></td><td>-</td><td></td></tr>
<tr><td colspan="2">Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д өгөгдлөө нийтэлж буй мэдээлэл</td><td>(Нөхөж бичих)</td><td>(Нөхөж бичих)</td><td colspan="2">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЦХХЯам</td></tr>
</table>

хариуцагч төрийн байгууллагуудын нээлттэй өгөгдлийн бүрдэл, чанар, стандартыг тогтмол үнэлэх			Дэмжин ажиллагчид:		
			Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад оролцогчид
			-	-	-
Зорилт – 9 Шүүх засаглал					
Үүрэг амлалтын тодорхойлолт:					
Манлайлж хэрэгжүүлэх байгууллага	*(Нөхөж бичих)*				
Дэмжин ажиллагчид	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад оролцогчид		
	Улсын дээд шүүх, бусад шүүх	*(Нөхөж бичих)*	*(Нөхөж бичих)*		
Асуудлын тодорхойлолт					
Үүрэг амлалт ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна вэ?	Иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, иргэний эрхээ мэдэх, түүнийг нэхэн шаардах эрх зүйн орчныг танин мэдүүлэх				
Асуудлын шалтгаан юу вэ?	Шүүхийн хараат бус байдалд иргэд эргэлзэж байна.				
Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?	*(Нөхөж бичих)*				
Ямар шийдлүүдийг санал болгож байна вэ?	- Шүүхийн шийдвэрийг иргэдэд ойлгомжтой тайлбартайгаар нийтлэх - Шүүхийн процессыг ил тод болгох (хуулиар хаалттай шийдвэрлэх хэргээс бусдыг)				
Энэ үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?	Шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн шүүх, шударга ёсонд итгэлийг нэмэгдүүлнэ.				

<table>
<tr><td>Хүрэх үе шатууд</td><td>Хүлээгдэж буй үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td colspan="3">Оролцогчид</td></tr>
<tr><td rowspan="4">Шүүхийн төсвийг олон улсын түвшинд хүргэх</td><td rowspan="4">(Нөхөж бичих)</td><td rowspan="4">(Нөхөж бичих)</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЦХХХЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>.....</td><td>.....</td><td>.....</td></tr>
<tr><td rowspan="4">Шүүхийн ажилчдад шүүхийн ■ийдвэрийн үндэслэлийг иргэдэд ойлгомжтой байдлаар тайлбарлах чиглэл өгөх.</td><td rowspan="4">Шүүхийн шийдвэрийн үндэслэл нь иргэдэд ойлгомжтой тайлбартай болсон байна.</td><td rowspan="4">2024-2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЦХХХЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>Улсын дээд шүүх, бусад шүүх</td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="6">Зорилт – 10 Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх</td></tr>
<tr><td colspan="6">Үүрэг амлалтын тодорхойлолт:</td></tr>
<tr><td>Манлайлж хэрэгжүүлэх байгууллага</td><td colspan="5">Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжин ажиллагчид</td><td>Төрийн байгууллага</td><td colspan="2">Төрийн бус байгууллага</td><td colspan="2">Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>яамд, нутгийн захиргааны байгууллага</td><td colspan="2">Иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод</td><td colspan="2">Иргэд</td></tr>
</table>

Асуудлын тодорхойлолт	
Үүрэг амлалт ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна вэ?	-Яамд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг хийхэд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангах -Бодлогын үнэлгээг хийхэд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоог хангах -Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод нээлттэй байдлын талаарх хэрэглэгчийн буюу иргэн, хуулийн этгээдийн сэтгэл ханамжийн тандан судалдаг байх, үүнд үндэслэн төрийн үйлчилгээний хүргэх ажлыг сайжруулах
Асуудлын шалтгаан юу вэ?	-Яамд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг зөвхөн KPI үзүүлэлтээр үнэлж, дүгнэдэг бөгөөд төрийн байгууллагын чадавх, төрийн байгууллагын үйл ажиллагаа үр дүнтэй (үр дагавар, үр нөлөө) байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч чаддаггүй. Байгууллагын гүйцэтгэлийг ЗГ-ын 2021 оны 206 дугаар журмаар зохицуулдаг бөгөөд уг журмын дагуу төрийн байгууллагын үнэлгээнд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод оролцох боломж хязгаарлагдмал бөгөөд үр дүн багатай байдлаар зохицуулагдсан. -Төрийн бодлогын үр дүнд үнэлгээ хийгдэхгүй байна. Ингэснээр бодлого үр дүнтэй байсан эсэх, цааш үргэлжлүүлэх, өөр бодлого хэрэгжүүлэх гэх мэт шийдвэрийг хангалттай үндэслэл, судалгаатай гаргахгүй байна. Холбогдох журамд мониторинг болон үнэлгээг ижил хэлбэр, агуулгааг хийхээр тусгасан бөгөөд төрийн байгууллагууд ийм байдлаар хийж хэвшсэн. -Төрийн байгууллага, үйлчилгээний талаар иргэд, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авах ажил хангалттай болон зохих ёсоор, тогтмол, бодитой хийгддэггүй
Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?	Өмнө яам, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тухайн байгууллага өөрсдөө судалгааны байгууллагаар захиалга өгч цөөхөн хэдэн чиг үүргийг сонгон авч хийлгүүлдэг байсан. Одоогийн байдлаар яам, агентлагийн үйл ажиллагаа дахь хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг ЗГХЭГ нэгтгэн зохион байгуулан авч байгаа бөгөөд агуулгын хувьд дорвитой өөрчлөлт байхгүй байна.
Ямар шийдлүүдийг санал болгож байна вэ?	-Яамд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг дүгнэх үзүүлэлтэд мэргэжлийн холбоод болон иргэний нийгмийн байгууллагууд тухайн төрийн байгууллагын тодорхой гүйцэтгэлийн үзүүлэлтэд өгдөг тогтолцоог бүрдүүлэх /ил тод, нээлттэй байдлын үнэлгээ гэх мэт/ -Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийхэд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагыг оролцоог хангах -Иргэдийн сэтгэл ханамжийг төрийн үйлчилгээ авснаас хой■ жилийн дараа бус тухай бүр авдаг, тандалт судалгаа хийдэг, үр дүнг нь төрийн үйлчилгээ сайжруулахад ашигладаг болох тогтолцоог бүрдүүлэх. Иргэний буюу үйлчилгээ авагчийн санал хүсэлтийг оролцоонд түшиглэсэн төрийн үйлчилгээг хүргэх.

<table>
<tr><td colspan="2">Энэ үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="4">-Төрийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ илүү бодитой болох, үнэлгээнд иргэний нийгмийн оролцоог хангах
-Төрийн бодлогын хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийдэг болох, иргэний нийгмийн оролцоог хангах
-Иргэний буюу үйлчилгээ авагчийн санал хүсэлтийг оролцоонд түшиглэсэн төрийн үйлчилгээг хүргэх, төрийн үйлчилгээг сайжруулах</td></tr>
<tr><td>Хүрэх үе шатууд</td><td>Хүлээгдэж буй үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td colspan="3">Оролцогчид</td></tr>
<tr><td rowspan="4">ИНБ, ТББ болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог төрийн байгууллагын шийдвэрлэлтэд оролцуулах</td><td rowspan="4">Бодлого батлагдахаас өмнө батлагдсаны дараа хүртэл үнэлгээ хийх процесс дээр ИНБ-аар үнэлгээ хийж төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрдөг тогтолцоог бий болгох</td><td rowspan="4">(Нөхөж бичих)</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>.....</td><td>.....</td><td>.....</td></tr>
<tr><td rowspan="5">Иргэдийн сэтгэл ханамжийг тогтмол дүгнэдэг болох</td><td rowspan="5">-Сар, улирал, хагас жил тутамд дүгнэж тус дүгнэлт дээр суурилаад төрийн байгууллага өөрөө өөрсдийгөө сайжруулдаг тогтолцоо бий болгох
-Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд төрийн захиргааны буюу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын ажлын үзүүлэлтүүдийг дүгнэхдээ ИНБ, ТББ нарын оролцоотойгоор дүгнэдэг болох</td><td rowspan="2">(Нөхөж бичих)</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td rowspan="3"></td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>.....</td><td>.....</td><td>.....</td></tr>
</table>

__oOo__

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 01 өдөр Дугаар 99 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөөний төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Баасандорж (Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга)
Ажлын хэсгийн дэд ахлагч:	Б.Болорсайхан (Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга)
Гишүүд:	Ч.Болортуяа (Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх)
	Ч.Ундрахбаяр (Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх)
	Ч.Ариунхур (Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх)
	Д.Ган-Эрдэнэ (Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч)
	Б.Анар (Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач)
	Л.Балчинлувсан (Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга)

0023200381

М.Санжаадорж (Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга)

Э.Энхтуяа (Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга)

Б.Золбоо (Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын Хүний эрхийн хэлтсийн дарга)

П.Оюунаа (Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга)

Ц.Болорчулуун (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга)

М.Мэндбаяр (Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга)

Б.Буяннэмэх (Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга)

Б.Билэгдэмбэрэл (Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга)

О.Номинчимэг (Нийслэлийн Засаг даргын Нийгмийн бодлого, байгаль орчин, агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч)

Ц.Батзул (Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга)

Л.Баярмандал (Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ш.Энхтуяа (Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Х.Эрдэм-Ундрах (Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн захирал)

Н.Дабааням (Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн дарга)

Д.Цэнд-Аюуш (Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар)

О.Энхзул (Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга)

Х.Энхбат (Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга)

Б.Дөлгөөн ("Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв" УТҮГ-ын захирал)

С.Баясгалан (Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга) (тохиролцсоноор)

Л.Төр-Од ("Нээлттэй засаглалын түншлэл"-ийн олон улсын элч төлөөлөгч) (тохиролцсоноор)

О.Хатанболд (Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, доктор) (тохиролцсоноор)

Д.Бумдарь (Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор, доктор, "Стратеги академи" ТББ-ын захирал) (тохиролцсоноор)

Э.Мөнхжаргал ("Транспэрэнси Интернешнл Монгол" ТББ-ын гүйцэтгэх захирал) (тохиролцсоноор)

Б.Төрболд ("Оюуны-Инноваци" ТББ-ын гүйцэтгэх захирал) (тохиролцсоноор)

Г.Халиунгоо (Азийн сангийн Хотын засаглалтыг сайжруулах төслийн менежер) (тохиролцсоноор)

Э.Баасансүрэн (Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Хөтөлбөрийн ажилтан) (тохиролцсоноор)

Н.Наранцэцэг ("Байгаль эхийн аврал сан" ТББ-ын тэргүүн) (тохиролцсоноор)

Б.Амарзаяа (“Бодлогод залуусын хяналт” ТББ-ын гүйцэтгэх захирал) (тохиролцсоноор)

Ч.Энхбаяр (“Глоб Интернэшнл төв” ТББ-ын гүйцэтгэх захирал) (тохиролцсоноор)

Д.Жаргалсайхан (“Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын тэргүүн) (тохиролцсоноор)

Г.Нямпүрэв (“Залуус эрүүл мэнд төв” ТББ-ын хөтөлбөрийн менежер) (тохиролцсоноор)

О.Нурболат (“Монголын Казахуудын хэл, соёлыг дэмжих холбоо” ТББ-ын захирал) (тохиролцсоноор)

Х.Оюунцэцэг (“Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо” ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн) (тохиролцсоноор)

Ш.Ариунаа (“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн) (тохиролцсоноор)

Д.Оюунбадам (“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер) (тохиролцсоноор)

С.Оюунтуяа (“Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын гүйцэтгэх захирал) (тохиролцсоноор)

Б.Дуламхорлоо (“Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төв” НҮТББ-ын гүйцэтгэх захирал) (тохиролцсоноор)

Э.Тунгалаг (“Тунгаахуй өгөгдлийн урлан” ТББ-ын гүйцэтгэх захирал (тохиролцсоноор)

Ч.Отгонбаатар (“Хил хязгааргүй хуульчид” ТББ-ын захирал) (тохиролцсоноор)

С.Амармэнд (“Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ-ын Судалгааны хорооны дарга) (тохиролцсоноор)

Г.Уранцоож (“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн) (тохиролцсоноор)

Ц.Тамир (“Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” ТББ-ын гүйцэтгэх захирал) (тохиролцсоноор)

Г.Гүнжидмаа (“Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ-ын Гүйцэтгэх захирал) (тохиролцсоноор)

Нарийн бичгийн дарга: Д.Номинчимэг (Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн)

2.Төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг (Б.Баасандорж)-т зөвшөөрсүгэй.

4.Төлөвлөгөөний төслийг боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Баасандорж)-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
2024-2027 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛААГАНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ, ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН ТББ-Н ТӨЛӨӨЛӨЛТЭЙ ХИЙХ УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хэзээ: 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Даваа гараг
Хаана: Төрийн ордон Орон нутгийн удирдлагын танхим
Зохион байгуулагч: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба бөгөөд Нээлттэй засгийн түншлэлийн Дэмжих нэгж
Оролцогчид: Ажлын хэсгийн бүрэлдэхүүн - 23 гишүүн

Хугацаа	Танилцуулах асуудал	Хариуцах албан тушаалтан
14.50-15.00	Бүртгэл	
15.00-15.10	Нээлт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн дэд дарга Б.Баасандорж
15.10-15.20	Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны Үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөө боловсруулсан явц, төлөвлөгөөний төсөл танилцуулах	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба бөгөөд Нээлттэй засгийн түншлэлийн Дэмжих нэгжийн мэргэжилтэн Д.Номинчимэг
15.20-16.50	Төлөвлөгөөний төсөл дээр санал солилцох	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Болорсайхан Ажлын хэсгийн гишүүд
16.50-17.00	Хаалт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн дэд дарга Б.Баасандорж

---oOo---

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
2024-2027 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛААГАНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ, ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН ТББ-Н ТӨЛӨӨЛӨЛТЭЙ ХИЙХ УУЛЗАЛТЫН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

№	Албан тушаал	Овог, нэр	Гарын үсэг
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга	Б.Баасандорж	Оролцсон
2	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга	Б.Болорсайхан	
3	Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх	Ч.Болортуяа	
4	Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх	Ч.Ундрахбаяр	Оролцсон
5	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх	Ч.Ариунхур	Оролцсон
6	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч	Д.Ган-Эрдэнэ	Оролцсон
7	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач	Б.Анар	Оролцсон
8	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	М.Санжаадорж	
9	Хууль зүй, дотоод хэргийн яам		
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга	М.Мэндбаяр	
11	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Б.Билэгдэмбэрэл	
12	“Нээлттэй засгийн түншлэл”-ийн олон улсын элч төлөөлөгч	Л.Төр-Од	
13	“Транспэрэнси Интернешнл Монгол” ТББ-ын гүйцэтгэх захирал	Э.Мөнхжаргал	
14	Азийн сангийн Хотын засаглалтыг сайжруулах төслийн менежер	Г.Халиунгоо	Оролцсон
15	Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Хөтөлбөрийн ажилтан	Э.Баасансүрэн	Оролцсон

16	“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер	Д.Эрдэнэчимэг	
17	“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер	Д.Оюунбадам	Оролцсон
18	“Бодлогод залуусын хяналт” ТББ-ын зөвлөх	Ц.Мандхайхатан	Оролцсон
19	“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн	Ш.Ариунаа	Оролцсон
20	“Тунгаахуй өгөгдлийн урлан” ТББ-ын гүйцэтгэх захирал	Э.Тунгалаг	Оролцсон
21	“Хил хязгааргүй хуульчид” ТББ-ын захирал	Ч.Отгонбаатар	
22	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн	Д.Номинчимэг	Оролцсон
23	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн	Э.Бадамханд	Оролцсон

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХОРОО

Open Government Partnership

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ V ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ЯВЦ, ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023.12.18

ХЭХҮХ-ны Ажлын алба, НЗТ Дэмжих нэгж

10/25	11/08	11/13-11/17	11/21	11/30	12/01	12/11-12/15	12/18	12/19	12/22
НЗТ-ийн тухай танилцуулах вебинар зохион байгуулах	Ажлын хэсгийн анхдугаар хуралдаан Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсэг цахимаар санал өгсөн Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсгийн II хуралдаан Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Хэлэлцүүлэг зохион байгуулах Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсгийн III хуралдаан Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Яамд, агентлагаас бичгээр санал авах Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсгийн төлөөлөлтэй уулзах Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсгийн IV хуралдаан Төслийг эцэслэн хүргүүлэх	Төслийг НЗТ-ийн Үндэсний зөвлөл батлах 12/25-12/28 Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөө илгээх, ЗГХЭГ-ын даргын тушаал албажих

ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ V ТӨЛӨВЛӨГӨӨ (2024-2027)

Хэрэгжих хугацаа (4 жил): 2024.01.01 – 2027.12.31

Зорилт 1 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх үе шатыг оруулах
2. Хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагын хүрч ажиллаж чадахгүй асуудал дээр ТББ нар оролцох зохицуулалт оруулах
3. НЗТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэл, хүндрэлийг урьдчилан тооцох
4. СаЯ татан оролцуулах

Зорилт 2 Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах

1. Иргэд мэдээллийг нээлттэй авах төрийн механизм бий болгох
2. Төрийн байгууллагад мэдээллийг нээлттэй хуваалцах соёл түгээхийн тулд холбогдох төрийн албан хаагчдад сургалт явуулах
3. Олон улсын ямар зөвлөмжийг хэрэгжүүлэхийг тодорхой оруулах

Зорилт 3 Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бус бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйг орчныг боловсронгуй болгох

1. Төр, иргэний нийгмийн түншлэлийг идэвхжүүлэхэд шинэлэг санаачилга оруулах
2. Хараат бус ажиллах орон зайг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх үе шатыг илүү тодорхой заах
3. Томоохон санхүүжилт хүлээн авсан ТББ-ын мэдээллийг ил болгохоос гадна тус байгууллагын санхүүгийн тайланд туссан мэдээллийг иргэдэд ил тод болгох

Зорилт 4 Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн оролцоог хангах, хяналтыг сайжруулах

1. Иргэдийн оролцоог дэмжих, мониторинг хийх шинэ механизм санал болгох

Зорилт 5 Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх

1. Нэгдсэн платформоос төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнах, аудитын мэдээллийг иргэд хүлээн авдаг байх
2. Иргэдээс санал ирүүлсэн ажил төсөвт ороогүй шалтгааныг төрийн байгууллагаас тайлбарладаг процесс байх

Төрийн худалдан авах ажиллагааны
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
....дугаар албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 2024-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮНДЭСНИЙ 5 ДУГААР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ТӨРИЙН ХУДАЛДАН АЖИЛЛАГААНЫ ГАЗРААС ӨГӨХ САНАЛ

<table>
<tr><th>Хүрэх үе шатууд</th><th>Хүлээгдэж буй үр дүн</th><th>Хэрэгжүүлж дуусах хугацаа</th><th colspan="3">Оролцогчид</th></tr>
<tr><td colspan="6">Зорилт 5.1: Төсвийн ил тод байдлыг сайжруулна</td></tr>
<tr><td rowspan="3">5.1.8.Шилэн дансны тухай хуулийн дагуу захиалагч төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулахад дэмжлэг үзүүлж, хүний оролцоогүй мэдээлэл солилцох холболтыг хийх.</td><td rowspan="3">Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, гэрээний мэдээллийг төсвийн бүх шатны захиалгчдын мэдээллийг бүрэн цахим системд оруулж олон нийтэд нээлттэй болсон байна.</td><td rowspan="3">2024-2025 он</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: Төрийн худалдан авах ажиллагааны газар</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиглагчид: Сангийн яам</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>Бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчид</td><td>Хамтран ажилладаг төрийн бус байгууллагууд</td><td>Иргэд, олон нийт</td></tr>
<tr><td colspan="6">Зорилт 5.2: Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг илүүтэй боловсронгуй болгох</td></tr>
<tr><td rowspan="3">5.2.5.Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, худалдан авах ажиллагааны цахим системд холбогдсон мэдээллийн системийн тоог нэмэгдүүлэх, цахим системд бүртгэгдэж буй машин унших боломжтой өгөгдлийн тоог нэмэгдүүлж, нээлттэй өгөгдлийг түгээх, тендер шалгаруулалтын үнэлгээнд хүний оролцоог бууруулах техникийн боломжийг бүрдүүлж систем хоорондын холболт хийх.</td><td rowspan="3">Худалдан авах ажиллагааны нэгдсэн мэдээллийн системийн хөгжүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг хангах, системийн хэрэглэгчдийг чадавхжуулах, мэдээллийн технологид суурилсан худалдан авах ажиллагааны хяналтын тогтолцоог бий болгох.</td><td rowspan="3">2024-2025 он</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: Төрийн худалдан авах ажиллагааны газар</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиглагчид:Төрийн байгууллагууд</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Бусад</td><td>Хамтран ажилладаг төрийн бус байгууллагууд</td><td>Бүх тендерт оролцогчид</td></tr>
</table>

Зорилт 6 Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах

1. НЗТ-ийн үнэт зүйлстэй холбон эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, чанар, аюулгүй байдал, нийлүүлэлт дээр нээлттэй засгийн “линз”-ээр харж олон нийтийг түлхүү оролцуулах

Зорилт 7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах

1. Дэд бүтэц, ажлын байр олгох зэрэг асуудлыг шийдвэрлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулах
2. Засгийн газрын аливаа шийдвэрт бүх төлөөллийн дуу хоолойг сонсож санаачилгыг оруулах

<table>
<tr>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх:
1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний Үндэсний хороо, дэд хороо, салбар зөвлөлийн жүрмыг шинэчлэх
2. Төр, засгийн байгууллага дээр ажиллах аливаа комисс, багт орж ажиллах чадвартай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бэлдэх
3. Төр, засгийн байгууллага дээр хийгдэх ажлын комисс, багт хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл оролцох</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо хангагдахад нэг том ахиц хийгдэнэ</td>
<td>2025</td>
<td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ХНХЯ</td>
</tr>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td colspan="3">Дэмжин ажиллагчид: ~~Улаанбаатар хотын Захиргаа~~
Нутгийн захиргааны байгууллага</td>
</tr>
<tr>
<td>Төрийн байгууллага</td>
<td>Төрийн бус байгууллага</td>
<td>Бусад оролцогчид</td>
</tr>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td>ХБХХЕГ, бүх яамд</td>
<td>Түгээмэл хөгжил</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум ба Эрхийн хороо</td>
</tr>
<tr>
<td>~~Улаанбаатар хотын~~ явган хүний замыг шинэчлэх:
1. нийтийн тээврийн хүртээмжтэй зогсоолын стандарт боловсруулагдан батлагдах
2. Загвар зогсоол баригдах
~~3. Хотын нийтийн тээврийн зогсоол шинэчлэгдэж эхэлсэн байна~~</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил нийтийн тээврээр зорчих нөхцөл бүрдэхэд нэг алхам хийгдэнэ</td>
<td>2025</td>
<td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
~~Улаанбаатар хотын Захиргаа~~
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба</td>
</tr>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td>
</tr>
<tr>
<td>Төрийн байгууллага</td>
<td>Төрийн байгууллага</td>
<td>Төрийн байгууллага</td>
</tr>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td>ХБХХЕГ</td>
<td>Түгээмэл хөгжил</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум ба Эрхийн хороо</td>
</tr>
<tr>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах тогтолцооны суурийг тавих:
1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах
2. Түүнийг дагалдан гарах журам, аргачлалыг шинэчлэх
3. Үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг чадваржуулах сургалт, дадлага явуулах
4. Үйлчилгээг явуулж эхлэх</td>
<td>Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах, нийгмийн оролцоо нэмэгдэх, бусдын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн идэвх санаачилга нэмэгдэх</td>
<td>2025</td>
<td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ХНХЯ</td>
</tr>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td>
</tr>
<tr>
<td>Төрийн байгууллага</td>
<td>Төрийн бус байгууллага</td>
<td>Бусад оролцогчид</td>
</tr>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td>ХБХХЕГ, ХХҮЕГ</td>
<td>Түгээмэл хөгжил</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум ба Эрхийн хороо</td>
</tr>
</table>

Зорилт 8 Нээлттэй өгөгдөл

1. Одоогийн нөхцөл байдалтай харьцуулан төлөвлөгөө хэрэгжүүлж дуусахад ямар түвшинд хүрсэн байх тухай тодорхой заах
2. Монгол Улсын иргэн бүр мэдээлэл хүлээн авах агуулгыг оруулах
3. Засгийн газрын нээлттэй өгөгдлийн шаардлага болон мониторинг ТББ-ын оролцоотой хянах

Зорилт 9 Шүүх засаглал

1. Зөвлөмж ирээгүй

Зорилт 10 Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх

1. ТББ-аас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхийг шаарддаг төрийн байгууллага байх эсэх
2. Иргэний нийгмий орон зайн 3-р зорилттой агуулга давхцаж байгаа эсэхийг нягтлах

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

УЛС

МОНГОЛ УЛС

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
2024-2027 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛААГАНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ, ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ХӨТӨЛБӨР

Хэзээ: 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг
Хаана: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хурлын танхим болон Зуум талбар
Зохион байгуулагч: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба бөгөөд Нээлттэй засгийн түншлэлийн Дэмжих нэгж
Оролцогчид: Ажлын хэсгийн бүрэлдэхүүн - 52 гишүүн

Хугацаа	Танилцуулах асуудал	Хариуцах албан тушаалтан
09.50-10.00	Бүртгэл	
10.00-10.10	Нээлт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн дэд дарга Б.Баасандорж
10.10-10.20	Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны Үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөө боловсруулсан явц, төлөвлөгөөний төсөл танилцуулах	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын алба бөгөөд Нээлттэй засгийн түншлэлийн Дэмжих нэгжийн мэргэжилтэн Д.Номинчимэг
10.20-10.45	Асуулт, хариулт, хэлэлцүүлэг	Ажлын хэсгийн гишүүд
10.45-11.00	Төлөвлөгөөг батлах	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Болорсайхан
11.00-11.10	Хаалт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн дэд дарга Б.Баасандорж

---oOo---

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
2024-2027 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Ажлын хэсгийн хоёрдугаар хуралдааныг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр 10.00 цагт Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хурлын танхим болон зуум платформ дээр зохион байгуулав.

Ирц: 56 хувь

Оролцсон:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж
2. Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа
3. Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Ундрахбаяр
4. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур
5. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ
6. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач Б.Анар
7. Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлувсан (төлөөлөлч оролцсон)
8. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж
9. Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Нямгэрэл
10. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр
11. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга Г.Энхмөнх
12. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа
13. Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах
14. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн дарга Н.Дабааням
15. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Д.Цэнд-Аюуш
16. “Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв” УТҮГ-ын захирал Б.Дөлгөөн (төлөөлөгч оролцсон)
17. “Оюуны-Инноваци” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Төрболд
18. Азийн сангийн Хотын засаглалтыг сайжруулах төслийн менежер Г.Халиунгоо
19. Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Хөтөлбөрийн ажилтан Э.Баасансүрэн
20. “Байгаль эхийн аврал сан” ТББ-ын тэргүүн Н.Наранцэцэг
21. “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Амарзаяа (төлөөлөгч оролцсон)
22. Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Х.Оюунцэцэг
23. “Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн

Ш.Ариунаа

24. “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам
25. “Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын гүйцэтгэх захирал С.Оюунтуяа
26. “Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төв” НҮТББ-ын гүйцэтгэх захирал Б.Дуламхорлоо (төлөөлөгч оролцсон)
27. “Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК-ын гүйцэтгэх захирал Э.Тунгалаг
28. “Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож
29. Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг

Оролцоогүй:

1. Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Б.Болорсайхан
2. Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын Хүний эрхийн хэлтсийн дарга Б.Золбоо
3. Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа
4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун
5. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл
6. Нийслэлийн Засаг даргын Нийгмийн бодлого, байгаль орчин, агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч О.Номинчимэг
7. Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул
8. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал
9. Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга О.Энхзул
10. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Х.Энхбат
11. Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баясгалан
12. “Нээлттэй засаглалын түншлэл”-ийн олон улсын элч төлөөлөгч Л.Төр-Од
13. Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, доктор О.Хатанболд
14. Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор, доктор, “Стратеги академи” ТББ-ын захирал Д.Бумдарь
15. “Транспэрэнси Интернешнл Монгол” ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Мөнхжаргал
16. “Глоб Интернэшнл төв” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Онон
17. “Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын тэргүүн Д.Жаргалсайхан
18. “Залуус эрүүл мэнд төв” ТББ-ын хөтөлбөрийн менежер Г.Нямпүрэв
19. Монголын Казахуудын хэл, соёлыг дэмжих холбооны захирал О.Нурболат
20. “Хил хязгааргүй хуульчид” ТББ-ын захирал Ч.Отгонбаатар
21. “Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ-ын Судалгааны хорооны дарга С.Амармэнд
22. “Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” ТББ-ын гүйцэтгэх захирал Ц.Тамир
23. “Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ажлын хэсгийн 4-р хуралдаанд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Ажлын хэсэг 52 гишүүнтэй. Өнөөдөр олонхи нь хүрэлцэн ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцож эхэлж байна. Хуралдааныг цахимаар болон танхимаар зохион байгуулж байна.

Бид НЗТ-ийн Үндэсний үйл ажиллагааны 5-р төлөвлөгөөг зохих журмын дагуу боловсруулж, НЗТ-ийн зүгээс хүргүүлсэн зөвлөмжийг хүлээн авч, яамд, агентлагаас санал авсан. Мөн олон улсын болон дотоодын ТББ-аас санал хүлээн авсан. Төслийн бичиг баримт боловсруулах хугацаанд ажлын дэд хэсгүүд хуралдсан. Өчигдөр Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон зарим төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж өнөөдрийн хурлын бэлтгэл ажлыг хангасан байгаа. Бидний төлөвлөгөө бол энэ 5 дахь өдөр Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулж батлуулахаар ажиллаж байна.

Одоо та бүхэнд төлөвлөгөөний төсөл боловсруулсан явцыг Ажлын хэсгийн НБД Д.Номинчимэг хийнэ. Үүний дараа та бүхэн өөрсдийн санал, шүүмж, зөвлөмжөө чөлөөтэй илэрхийлээрэй.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Бид төслийн бичиг баримт дээр ажиллаад нилээд хугацаа өнгөрлөө. 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр НЗТ-тэй танилцах вебинарыг зохион байгуулсан. 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр Ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг зохион байгуулж Үндэсний үйл ажиллагааны 4-р төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж дуусаагүй үүрэг, амлалтыг багтаасан эхний төслийг танилцуулсан. Үүний дараа 11 дүгээр сарын 13-17 өдөр ажлын хэсгийн гишүүд цахимаар санал өгч төлөвлөгөөний төслийн 2-р хувилбар бэлэн болсон. Ажлын хэсэг 11 дүгээр сарын 21-ны өдөр дэд ажлын хэсэгт хуваагдан ажиллаж төслийн 3-р хувилбарыг гаргасан. 11 дүгээр сарын 30-ны өдрийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан ба хэлэлцүүлгийн мөрөөр хоёр санал ирсэн. Ажлын хэсгээс ирүүлсэн саналыг нэгтгэн төрийн байгууллагууд руу албан бичиг хүргүүлж саналыг авсан.

Та бүхэнд НЗТ-ийн Хараат бус тайлагнах механизмаас ирүүлсэн зөвлөмжийг танилцуулая:

Зорилт 1 - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх үе шатыг оруулах
2. Хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагын хүрч ажиллаж чадахгүй асуудал дээр ТББ нар оролцох зохицуулалт оруулах
3. НЗТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэл, хүндрэлийг урьдчилан тооцох
4. СаЯ татан оролцуулах

Зорилт 2 - Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах

1. Иргэд мэдээллийг нээлттэй авах төрийн механизм бий болгох
2. Төрийн байгууллагад мэдээллийг нээлттэй хуваалцах соёл түгээхийн тулд холбогдох төрийн албан хаагчдад сургалт явуулах
3. Олон улсын ямар зөвлөмжийг хэрэгжүүлэхийг тодорхой оруулах

Зорилт 3 - Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бус бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйг орчныг боловсронгуй болгох

1. Төр, иргэний нийгмийн түншлэлийг идэвхжүүлэхэд шинэлэг санаачилга оруулах
2. Хараат бус ажиллах орон зайг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх үе шатыг илүү тодорхой заах
3. Томоохон санхүүжилт хүлээн авсан ТББ-ын мэдээллийг ил болгохоос гадна тус байгууллагын санхүүгийн тайланд туссан мэдээллийг иргэдэд ил тод болгох

Зорилт 4 - Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн оролцоог хангах, хяналтыг сайжруулах

1. Иргэдийн оролцоог дэмжих, мониторинг хийх шинэ механизм санал болгох

Зорилт 5 - Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх

1. Нэгдсэн платформоос төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнах, аудитын мэдээллийг иргэд хүлээн авдаг байх
2. Иргэдээс санал ирүүлсэн ажил төсөвт ороогүй шалтгааныг төрийн байгууллагаас тайлбарладаг процесс байх

Зорилт 6 - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах

1. НЗТ-ийн үнэт зүйлстэй холбон эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, чанар, аюулгүй байдал, нийлүүлэлт дээр нээлттэй засгийн “линз”-ээр харж олон нийтийг түлхүү оролцуулах

Зорилт 7 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах

1. Дэд бүтэц, ажлын байр олгох зэрэг асуудлыг шийдвэрлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулах
2. Засгийн газрын аливаа шийдвэрт бүх төлөөллийн дуу хоолойг сонсож санаачилгыг оруулах

Зорилт 8 - Нээлттэй өгөгдөл

1. Одоогийн нөхцөл байдалтай харьцуулан төлөвлөгөө хэрэгжүүлж дуусахад ямар түвшинд хүрсэн байх тухай тодорхой заах
2. Монгол Улсын иргэн бүр мэдээлэл хүлээн авах агуулгыг оруулах
3. Засгийн газрын нээлттэй өгөгдлийн шаардлага болон мониторинг ТББ-ын оролцоотой хянах

Зорилт 9 - Шүүх засаглал

1. Зөвлөмж ирээгүй

Зорилт 10 - Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх

1. ТББ-аас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхийг шаарддаг төрийн байгууллага байх эсэх
2. Иргэний нийгмий орон зайн 3-р зорилттой агуулга давхцаж байгаа эсэхийг нягтлах

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

За баярлалаа. Зорилтын хүрээнд санал, зөвлөмжийг танилцууллаа. Та бүхэнд горимын санал дэвшүүлмээр байна. Зорилт тус бүр дээр яриад явья. Ажлын хэсгийн гишүүд саналаа нэг бүрчлэн яриад явья. Цахимаар оролцож байгаа хүмүүс мөн саналаа хэлээрэй. Амлалтыг оруулахдаа хэмжигдэхүйц, үр дүнг тооцох боломжтой, цаг хугацаандаа хэрэгжүүлж дуусахаар, онц чухал амлалтуудыг оруулмаар байна.

Зорилт 1 – Хуулийн төслийг баталсан байна, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах. Хүрэх үе шат, хүлээгдэж буй үр дүнг сайн хараад ярилцаад явья.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр:

Бид жил болгон асуумж гаргаад жил болгон тайлангаа өгөөд явдаг. МХГ-тай хамтраад нэгтгэсэн нэг тайлан явуулдаг. Хариуцлагын механизмын хүрээнд цаг хугацаандаа тайлан ирүүлээгүй ААН-ийг Зөрчлийн тухай хуулиар торгоод явж байсан. Тийм болохоор тайлан ирүүлэлт өндөр хувьтай байдаг.

Хууль маань анх УУХҮЯ-ны санаачилга явж байгаад, БОАЖЯ руу шилжин одоо бол ХЗДХЯ дээр явж байна. Хууль батлагдсаны дараа бид хэрэгжилт дээр оролцоод явна. Ганбаатар сайдаас бичгээр ирсэн санал бол дэмжсэн санал байгаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Нямгэрэл:

Энэ хуулийг батлах явцын хувьд Ажлын хэсэг байгуулагдаад хуулийн төслийг боловсруулж дуусаад эхний хэлэлцүүлэг хийгдсэн. 2027 онд төлөвлөгөө дуусахаас өмнө тус хуулийг хэлэлцэн батлах бүрэн боломжтой гэж харж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Олборлох үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх гэдэг нь тусдаа яриад байна уу эсвэл энэ хуулийг батлуулахтай хамт яриад байна уу?

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр:

Мэдээллийн сан салбар өөр дээрээ хөтлөгдөөд явж байгаа сан бол байгаа. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын асуудал болохоор байгалийн баялагтай холбоотой мэдээлэл, бүртгэл явагдах юм байна. Түүнийг БОАЖЯ хариуцна гэж харж байна. Тэр 2-ыг холбоод нэгдсэн мэдээлийн сангийн асуудал бол тусдаа явах юм байна гэж ойлгож байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны Инновацын бодлогын газрын дарга н.Золзаяа:

Төслийн баримт бичиг их хоцорж ирсэн. Бидний зүгээс дараах зарчмын

саналуудыг гаргаж байна:

1. Өгүүлбэр зүйн найруулгыг хянах, үг үсгийн алдааг хянах
2. Зорилтуудыг бодит хэрэгжихүйц байлгах
3. Санхүүжилтийн хэмжээг тодорхой оруулах
4. Хүрэх үр дүнг нарийн тодорхойлох.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Бид ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэсэн хувилбар тус бүрийг хүргүүлж байсан. Манай ажлын хэсгийн гишүүд дийлэнх нь хангалтгүй ажиллаж байна. Бид ямар байдалтай ажилласныг ҮЗ хуралдаан дээр бодитоор танилцуулна.

“Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК-ын гүйцэтгэх захирал Э.Тунгалаг:

Нээлттэй өгөгдлийг тусад нь оруулах саналтай байна. Бидэнд мэдээлэл байна гэхдээ нээлттэй өгөгдөл буюу шууд боловсруулалт хийх боломжтой өгөгдөл байхгүй болохоор шинжилгээ хийх боломжгүй, хайлтын системтэй л байгаад байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ:

Зорилт 2 буюу Мэдээллийн ил тод байдал дээр эм эмнэлгийн хэрэгсэл, нээлттэй өгөгдөл, олборлох үйлдвэрлэлтэй холбоотой асуудылг нэгтгэх саналтай байна. 3 зорилтыг харахаар мэдээллийн ил тод байдлыг л яриад байна. Мэдээллийн ил тод байдал тусдаа, нээлттэй өгөгдөл тусдаа зорилт болж орж ирж байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын асуудлыг Мэдээллийн ил тод байдал руу оруулах саналтай байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Цахимаар оролцож байгаа гишүүд саналаа хэлээрэй.

“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож:

Олборлох үйлдвэрлэл гэхээр бусад бүх баялгийн нөөцийн асуудал орж ирсэн. “Эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн сан”-г томьёоллыг “байгалийн нөөцийн мэдээллийн нэгдсэн сан” гэж өөрчлөх зөв болов уу гэж бодож байна. Мэдээллийн нээлттэй болгох асуудлыг шилжүүлж болох ч хуультай болох асуудал зорилт дээрээ хэвээрээ байх нь зөв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр:

Бид олон улсын тайланг тогтсон маягтын дагуу хугацаандаа өгдөг. Нэмэлт мэдээлэл оруулаад хэрхэн тайлагнах нь тодорхойгүй байна. Маягт, мэдээлэл боловсруулалт бүгд өөр байдаг. Тус тусдаа тайлагнах уу, яах уу? Мэдээллийн ил тод байдлын зорилт руу шилжүүлж болно гол нь нэгтгэл нь яаж явах вэ?

“Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын гүйцэтгэх захирал С.Оюунтуяа:

Өмнөх 2,3-р төлөвлөгөө дээр ажиллаж байхад хүрэх үр дүнг хэрхэн хэмжих нь тодорхой байх хэрэгтэй. Хүлээгдэж буй үр дүн, үйл ажиллагааг үе шаттай тодорхой төлөвлөх. Тэгэхгүй бол дараа нь үнэлгээ хийхэд төвөгтэй байдал үүсч байсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Хүрэх үе шат, хүлээгдэж буй үр дүн холилдоод байна. Ажлын хэсгийн гишүүдийн саналыг дагуу мэдээллийн нэгдсэн сан байгуулах гэдгийг Хүлээгдэж буй үр дүн руу шилжүүлээд, давхар Зорилт 2 руу Хүрэх үе шат руу оруулмаар байна. Учир нь мэдээллийн ил тод байдалтай холбоотой юм. Улсын төсөвд суух гэдэг асуудал харин хаана нь орох ёстой юм ярилцах хэрэгтэй.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Нямгэрэл:

Үндэсний баялгийн сангийн тухай хууль давхар ЗГХЭГ дээр явж байгаа. Хоёр хуулиар зохицуулагдах асуудлыг нэгтгээд оруулсан байгаа тул хуулиудаа тусад нь ялгаатай болгож өгмөөр юм байна. Хуулиудыг тодорхой болгож нэр зааж өгөх саналтай байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

За тэгэхээр Зорилт 1-ыг сая ярилцсаны дагуу өөрчлөөд “дэмжих” саналыг хурааяа. Цахимаар оролцож байгаа гишүүд мөн гараа өргөөрэй.

Ажлын хэсгийн гишүүд санал нэгтэйгээр дэмжлээ. Одоо Зорилт 2 руу орьё.

Зорилт 2 - Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах.

Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа:

Тодруулж асуух нэг зүйл байна. Хүрэх үе шат дээр дэвшүүлсэн санал хэний санал вэ? Хэвлэл мэдээллийн бусад холбоо бас санал нийлэхгүй байх боломжтой. Бусад оролцогч талууд руу хэн руу санал авахаар явуулсан бэ?

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн Д.Номинчимэг:

Дэд ажлын хэсэгт ХМЗ, Глоб Интернэшнл, Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төвийн төлөөлөл ажилласан. Бид мөн цахим болон албан бичгээр Хэвлэлийн нэгдсэн хүрээлэн, Сэтгүүлчдийн нэгдсэн холбоонд санал авахаар хүргүүлсэн ч огт хариу өгөөгүй.

Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа:

Төрийн нууцын жагсаалтыг батлах тухай асуудал дээр ХЗДХЯ-ны байр суурийг сонсоё.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хүрээнд яригдаж байсан. Төрийн нууц гэсэн хүрээнд маш олон асуудлыг нуудаг, нээлттэй болгодоггүй. Түүнийг хуулиар зохицуулдаг болох тухай санал юм.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ:

Өчигдөр дэд ажлын хэсэг хуралдаж дараах саналыг дэвшүүлсэн:

1. Нээлттэй өгөгдлийн шаардлагын стандартыг батлах
2. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг тогтох, үнэлгээ хийх
3. Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, аюулгүйн тогтолцоог бий болгох. ЭМЯ-ны лицензтэй холбоотой бүртгэл мэдээлэл байдаг.

Эдийн засаг, хөгжлийн яамны Инновацын бодлогын газрын дарга н.Золзаяа:

Зөвшөөрлийн тухай хуулиар зөвшөөрлийн бүртгэл мэдээллийг бүртгэх байгууллага нь ЭЗХЯ байдаг. ЭЗХЯ license.mn дээр бүх тусгай болон энгийн зөвшөөрлийг бүртгэдэг.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа:

License болон LiceMed 2 өөр юмаа. License тусгай зөвшөөрлийг бүртгэдэг харин LiceMed дээр 1994 оноос хойш эмийг бүртгэж байгаа. Эмийн холбоотой мэдээллийг бүртгүүлсэн байгууллагын мэдээлэл мөн ордог. Бид одоо энэ программыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа. Одоогийн байдлаар 7000 гаруй эмийн сантай, 4000 гаруй эмийн бүртгэлтэй байгаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Нэг юмыг 2.1 болон 2.2 дээр хийсэн харагдаж байна. Ажлын хэсгийн гишүүд саналаа хэлээрэй. Нээлттэй өгөгдлийн шаардлагын стандартыг батлах нь маш чухал зүйл юм. Төрийн байгууллагатай хэвлэл мэдээллийн байгууллага хийсэн бүх гэрээг ил тод болгох. Энэ дээр СаЯ саналаа хэлнэ үү.

Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга н.Бат-Эрдэнэ:

Гэрээтэй холбоотой бүх мэдээлэл Шилэн дансан дээр ороод явж байгаа. Хэрэгжээд явж байгаа заалтыг нэмэж оруулах хэрэгтэй юу? Төсвийн тухай зорилт дээр бид бас саналаа өгсөн.

“Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төв” НҮТББ н.Билгүүн:

Олон улсын байгууллагаас ирүүлсэн яг ямар зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай

гэвэл хэд хэдэн зөвлөмж гарсан. Яг нэрийг нь одоо цохож хэлж чадахгүй байна. Үндсэн агуулга бол үзэл бодлоо илэрхийлэх асуудлыг гэмт хэрэгт тооцож байгаа асуудал юм. Зөвлөмжийн нэр болон гаргасан байгууллагын мэдээллийг хүргүүлж болно.

“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож:

Үзэл бодлоо илэрхийлэх асуудал бол хаана хэн хэлж байгаагаас шалтгаалан өөр өөр байдаг. Судалгааны үр дүнд орон нутгийн түвшинд иргэд үзэл бодлоо илэрхийлж чадахгүй байна. Илэрхийлсэн хүнийг хавчих, ялгаварлан гадуурхаж байна. Үүнийг халах талруу зорилт, үйл ажиллагаа оруулмаар байна.

Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Х.Оюунцэцэг:

Бид нар төрийн хэмжээнд хийж байгаа зүйлийг төлөвлөгөөнд тусгаад баймааргүй байна. Хамтын ажиллагааны арга хэмжээ, байгууллагууд хэрхэн хамтрах тухай илүү чухалчилмаар байна. ТББ, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа юу байх вэ? Ямар асуудал дээр хэрхэн хамтрах тухай яримаар байна. Хэрэгжихгүй бол хэн араас нь явж хэрэгжүүлэх вэ? Хэн дээр очиж асуудлыг тавих вэ?

“Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын гүйцэтгэх захирал С.Оюунтуяа:

Манай зорилтууд хэтэрхий нүсэр байна. Шалгуур үзүүлэлтийг яаж хэмжих вэ, үүрэг амлалтыг илүү ИНБ төртэй түншилж байгаад хамтдаа хийж чадах, олон улсад сайн туршлага болох орон зай руу орох нь зөв гэж бодож байна.

“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн Ш.Ариунаа:

НЗТ-ийн гол зорилго бол ард иргэд хүсээд байгаа тэр засаглалыг хамтдаа цогцлоох явдал юм. ЗГХЭГ дээр байх нь оновчтой байсан. НЗТ-ийн шалгуурыг харахад гарын авлага нь байгаа. Дутуу зүйл бол ҮЗ-д хэн хэн байдаг вэ? ҮЗ ажиллахгүй байна. Аймгийн засаг дарга нараас санал авсан уу? Олон улсын байгууллага санхүүгээр дэмжиж дайчлан ажиллах хэрэгтэй. Төлөвлөгөө баталсны дараа ҮЗ-ийг ажиллах процессыг хийж өгмөөр байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

ҮЗ-ийг шахах үгүй нь биднээс шалтгаалаад байна. ҮЗ-н гишүүдийг танилцуулая:

№	Албан тушаал	Овог, нэр
1	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	Д.Амарбаясгалан
2	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	Н.Учрал
3	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга	Б.Баасандорж

4	Улсын Их Хурлын даргын зөвлөх	-
5	Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх	Ч.Болортуяа
6	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх	Ү.Амарбат
7	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	И.Батхүү
8	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга	Н.Анхбаяр
9	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	Ж.Ганбат
10	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Л.Нямгэрэл
11	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	С.Магнайсүрэн
12	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга	Б.Батцэцэг
13	Төрийн бүтээмжийн үндэсний хорооны Ажлын албаны дарга	Н.Энхзул
14	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч	Д.Энхтүвшин
15	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн ерөнхий захирал	Б.Лакшми
16	Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал	П.Эрдэнэжаргал
17	Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн	Г.Уранцоож
18	“Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ-ын гүйцэтгэх захирал	Э.Мөнхжаргал
19	“Нээлттэй засаглалын түншлэл”-ийн Олон улсын элч төлөөлөгч	Л.Төр-Од
20	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга	Б.Болорсайхан

“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож:

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний орон нутаг дахь хэрэгжилт дээр хяналт, үнэлгээ хийдэг болох. Энэ саналыг би дахин дахин онцлоод байгаа учир нь орон нутагт түгээмэл болоод байна, хариуцлагатай нээлттэй засаглал орон

нутагт байхгүй болох гээд байна.

“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам:

Орон нутагт ТББ үйл ажиллагаа явуулахад төрийн байгууллагаас маш их шахалт, дарамт ирдэг. Орон нутгийн түвшинд энэ асуудлыг хөндөн оруулах саналтай байна. Хяналт, үнэлгээ хийдэг болох нь маш чухал юм.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Та бүхний саналыг хүлээн авлаа. Ажлын хэсгийн гишүүд Зорилт 2 дээр саналаа хэлсэн тул санал хурааяа. Бас нэг дурдах ёстой зүйл бол эм, эмнэлгийн хэрэгсэл болон хог хаягдлын 2 асуудлыг амлалт биш тул Зорилт 2 руу оруулж өгсөн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа:

Эмийн асуудлаас гадна бусад асуудлыг Зорилт 2 руу оруулж болохоор харагдаж байна. Иргэдийн эмийн зохистой хэрэглээ гэхээс илүү иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшлэнэ гэж оруулж өгсөн дээр болов уу.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Эм, эмнэлгийн хэрэгсэл болон хог хаягдлын асуудлыг зарчмын хувьд Зорилт 2 руу оруулахыг дэмжиж байна. Сүүлд хэлсэн саналыг нэмж оруулах эсэх дээр ярилцая. Бусад хүрэх үе шатыг дэмжиж байна гэж ойлгоод “дэмжиж байна” гэж санал хурааяа. Бүгд санал нэгтэйгээр дэмжлээ.

Зорилт 3 - Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бус бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож:

Төр, иргэний нийгмийн түншлэлийг дэмжих зорилгоор бидний бэлдсэн баримт бичиг байгаа. Тэрнийг УИХ-аар батлуулах гэдэг санал байна.

ИНБ-ын эвсэл, сүлжээ болж хамтарч ажилладаг болохыг төрөөс дэмждэг болох гэдэг санал юм.

“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн Ш.Ариунаа:

Бусад ТББ нартай ярилцсан юм. Судалгаа, бодлогын баримт бичиг, хууль эрх зүй, татварын дэмжлэг, бусад дэмжлэг гэсэн дараалалтай болгосон.

Төсвийн ерөнхийлөн захирагч ТББ-тай хийсэн гэрээг ил тод болгох, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг ил тод болгох үүрэг амлалт авахаар санал оруулсан.

Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга н.Бат-Эрдэнэ:

Төсвийн ерөнхийлөн захирагч нар хуулийн дагуу батлагдсан төсвийг ямар үйл ажиллагаа явуулж зарцуулсан тухай өөрсдөө тайлагнадаг. Зорилт 5 дээр төсвийн тухай хангалттай оруулсан тул давхардах вий гэж болгоомжилж байна.

“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн Ш.Ариунаа:

30,000 гаруй ТББ нар байна. Нэг хэсэг нь хамтарч ажиллаад явдаг, нээлттэй бусаар санхүүжилт олгосон байдаг. Төр нь хэнийг хэрхэн дэмжиж байгааг харахыг хүсч байна. Төрийн зарим чиг үүргийг ТББ-аар хэрэгжүүлж байгааг ил тод болгох. Тийм учраас эхний ээлжинд ТББ-тэй хийсэн гэрээг ил тод болгох нь зөв байна.

УБЕГ бүртгэлийг ил тод болгож гаргах, ТЕГ-аас хэн хэн тайлан өгч байгаа тухай мэдээллийг гаргаж ирэх боломжтой. Бид тайлан өгдөг ч эргээд хариу өгдөггүй.

“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам:

НЗТ-ээс ирүлсэн зөвлөмж болох Засгийн газраас санхүүжилт авсан ТББ мэдээллийг ил тод болгох асуудал дээр Шилэн дансны тухай хуулийн дагуу 10 сая төгрөгөөс дээш гэрээ хийсэн шийдвэр, мэдээллийн хэрэгжилтийг сайжруулах гэж оруулах саналтай байна. Хуулийн хэрэгжилтэд аудитыг хийхэд хэрэгжилтийг тодорхой хувиар нэмэгдүүлэх дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож:

Төрөөс ИНБ-ын эвсэл, сүлжээ байгуулахыг дэмжих, төсвөөс олгосон үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ гэж оруулахыг дахин онцолж хэлмээр байна.

Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Х.Оюунцэцэг:

Зорилт 10 дээр хамтын ажиллагааг оруулая гэж бид ярьсан. Яам болон Засаг даргын үйл ажиллагааг үнэлэх дээр туршилтын маягаар хийж хэрэглэгчдийн үнэлгээг хийх саналтай байна. Хамтын ажиллагааны загвар үйл ажиллагааг хийх аргачлалыг гаргах саналтай байна.

Үнэлгээ хийх тухай мэдээлэл, зарыг олон нийтэд нээлттэй тавьдаг баймаар байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Таны саналыг Зорилт 10 дээр ярилцая. Зорилт 3 дээр томьёоллыг дахин хийе. Бодлогын баримт бичгийг үлдээеэ. Нэмж ирсэн саналыг аваад “дэмжих” санал хураалт явуулая. За бүгд дэмжлээ.

Зорилт 4 - Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн оролцоог хангах, хяналтыг сайжруулах. Энэ тусдаа амлалт болохоор асуудал мөн үү үгүй юу гэдэг дээр та бүхний саналыг хүлээн авья.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга Г.Энхмөнх:

Бид саналаа өгөхдөө Хог хаягдлын холбоо буюу Батжаргалын саналыг нэгтгэж оруулсан. Хог хаягдлыг тээвэрлэлт,менежментийн асуудал хийгдээд явж байна. Томьёоллыг зарчмын хувьд дэмжиж байна.

Зарим чиг үүргийг ТББ, мэргэжлийн холбоод руу шилжүүлэн ажиллавал боломжтой гэж харж байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач Б.Анар:

Бодит ажлыг жагсаах, суурийг схемээр тавьж өгөх гэж томьёолох, олон улсын байгууллагыг татан оруулах саналтай байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

ИНБ, мэргэжлийн холбоодод суурилсан схемийг бий болгох гэж Энхмөнх дарга шинээр томьёолоод саналыг авья. Өөр саналтай гишүүн байхгүй бол “дэмжих” саналыг хурааяа. Санал нэгтэйгээр дэмжлээ.

Зорилт 5 - Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх.

“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам:

Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтийг жагсаасан байна. Улсын төсвийн ерөнхий захирагч нар энэ цагалбарыг дагадаг, гэхдээ орон нутаг, нийслэл, дүүрэг дээр учир дутагдалтай байдаг.

Төсвийн тоо мэдээллийг шаардлага хангасан формат, өгөгдлийн шаардлагыг компьютерээр боловсруулалт хийхэд амар байдлаар нийтлэх хэрэгтэй.

Нийслэлийн төсвийг ил тод болгох, 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ, шийдвэр хангалтгүй байна. Хэлэлцээл баталдаг, ил тод байдлыг хангах нь хангалтгүй байна.

Тусгай сангийн худалдан авалт, төрийн өмчийг актлах, устгах шийдвэрийг ил тод болгох хэрэгтэй.

Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн үр ашгийн мэдээллийг ил болгох, жагсаалт батлах бус цогц мэдээлэлтэй байж УИХ батлах нь зөв юм.

Тухайн төслийг ач холбогдлоор эрэмбэлэх мэдээлэл дутмаг байдаг.

Төсвийн тодотгол хийхэд ямар төслүүд нэмэгдэж, хасагдаж байна, тухайн жилд төсвийн өөрчлөлт байгаа эсэх дээр мэдээлэл дутмаг байдаг.

“Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК-ын гүйцэтгэх захирал Э.Тунгалаг:

Нээллтэй өгөгдлийн стандарт байхгүй тул бид Зорилт дотор оруулсан. Машин унших формат, бөөнөөр татаж авах зэрэг ерөнхий байдлаар оруулж өгснийг бид нарийвчлан зааж стандартад оруулж өгөхөөр зорьж байгаа.

“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн Ш.Ариунаа:

Эрэмбэлж байгаа төслийн мэдээллийг ил тод болгох нь жижиг мөртлөө том зүйлийн эхлэх болох болов уу.

Төрийн мөнгөөр ТББ-ыг дэмжисний үр дүн юу байгааг харах чухал байна.

Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга н.Бат-Эрдэнэ:

Ил тод болгох асуудал дээр манлайлж хэрэгжих байгууллагыг СаЯ гэж санал өгсөн байгаа. Төсвийн бусад ерөнхий захирагч нарыг оруулах нь зөв гэж бодож байна.

“Хүний эрх, хөгжил төв” ТББ-ын тэргүүн Г.Уранцоож:

Гадаадын зээл тусламжтай холбоотой мэдээллийг харахад үйл ажиллагааны үр дүн дээр үнэлгээ ордог байх ёстой.

Өрийн асуудлыг оруулмаар байна. Бид хичнээн өртэй байна, хэрхэн төлөгдөх вэ, юунаас үүссэн өр зэрэг холбогдох мэдээллийг оруулж өгнө үү.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач Б.Анар:

Үр дүнгийн шинжилгээ болон үнэлгээ хийх гэж томьёолж оруулах саналтай байна. Мөн СаЯ дээр мэдээлэл ил тод байгаа гэдэг ч тэр мэдээллийг хэрэглэж болохоор байна уу гэдэг дээр дахиж хармаар байна. Зээл, буцалтгүй тусламжийн мэдээллийг бид хайгаад хомс байсан. Ялангуяа хаагдсан тусламжийн мэдээлэл бүр олдохгүй байсан. Өгөгдлийн стандарттай болох дээр тусгаад өгвөл хэн ч энэ мэдээллийг авч анализ хийж болох хэмжээнд хүрвэл үр дүнтэй болно. Хүүхдийн эрхтэй холбоотой бүх төсөл дээр үнэлгээ хийж үзсэн. Түүн дотор энэ талаарх мэдээллийг олох нь хэцүү байна гэдэг дүгнэлт гарч байсан.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ:

СаЯ дээр мэдээлэл нээлттэй байгаа ч хайлт хийх, олж авахад ойлгомжтой байдаггүй. Сангуудтай холбоотой мэдээллийг ил тод болгох саналтай байна.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж:

Зорилт 5 дээр санал өгсөн асуудлууд ирэх жилээс бүгд шинээр хэрэгжих ёстой юм. Үүнийг эхний ээлжинд маш сайн хийгээд сурчихая.

Орон нутаг, нийслэл, дүүргийн хэмжээнд төсвийг ил болгохгүйгээр хэлэлцээд батлаж байгаа асуудлыг шинэ хуулийн зүйл заалтыг хэрэгжүүлэх дээр чухалчилж ажиллах хэрэгтэй байна. Орон нутгийг шахаж ажиллаж болно. Нийслэл хүнд байдаг, гэхдээ бид дахин ярилцая.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ:

Сая ярилцсан шинэ саналыг СаЯ-тай дахин сууж томьёолоод өнөөдрийн

дотор НБД-д хүргүүлье.

Зорилт 6 - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах. Мэдээллийн ил тод байдлын тухай асуудал руу шилжүүлэхээр бид ярилцсан. Энхтуяа даргын саналыг мөн хүлээн авсан. Тэгэхээр тусдаа зорилтоос хасах саналтай байгаа. Гишүүд “дэмжих” санал хурааяа. Бүгд дэмжлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Зорилт 7 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах.

Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Ундрахбаяр:

Өчигдөр ярилцсаны дагуу ХНХЯ, ИНБ-ын санал, ЕС-д өгсөн шаардлага, НҮБ-ээс ирүүлсэн зөвлөмжийг нэгтгэн харахад “институтийг тараах төлөвлөгөө” гэдэг зүйлийг ярьж байгаа. Энэ бол ерөнхий агуулга мөртлөө ХБ-тэй иргэдийн хувьд хэрэгцээ, шаардлага болсон зүйл юм. Үүнийг буруу ойлгодог, хуучин тогтолцоог шинэчлэхийг хэлдэг.

Шинэ тогтолцоог бий болгохын тулд аажмаар дэмжих үйлчилгээг бий болгох, тухайлсан асрамжийн төвийг дэмждэг санхүү, үйл ажиллагааг аажмаар бууруулах, нийгмийн оролцоог дэмжсэн шинэ тогтолцоо руу шилжих, төр иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийн асуудал зэрэг бүгд хамаарч ордог.

Явган хүний замыг бий болгох зэрэг төрөөс хийгдэж байгаа зарим ажлууд орсон харагдсан. Энэ удаа бол арай өөрөөр буюу зөвлөмж, хэрэгцээ шаардлагыг нэмж нэгтгэсэн.

ХБ-тэй хүнийг гэр бүлд даалгах эсвэл асрамжийн төвд даалгадаг загвартай. Энэ нь олон асуудлыг үүсгэдэг. НҮБ-ын зөвлөмж бол институтад биш амьдарч байгаа орон нутагт нь амьдрах төлөвлөгөө, стратегитай байхыг хэлдэг. Асуудлыг бид ярих түвшинд маш их ярьсан, гэхдээ хэрэгжүүлэх асуудлыг одоо эхлүүлэх хэрэгтэй байна.

“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн Ш.Ариунаа:

НЗТ-ийн шалгууруас хараад нэг санал байна. Зорилтот бүлгийн төрийн хамтын ажиллагаа гэдэг маягаар томьёолвол зүгээр болов уу.

Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Ч.Ундрахбаяр:

Бид томьёоллыг дахин харья. Гэхдээ энэ зүйл бол шинэ биш, төр эхлүүлэх гээд байдаг гэхдээ зориглож орж ирэхгүй байна. Институтийг тараах төлөвлөгөө гэдэг нь зөвхөн ХБИ дээр биш ахмад настан, хүүхэд зэрэг бүх бүлгийг хамруулдаг. Inclusive буюу бусад нийгмийн бүлгүүдийг хамаатуулсан байдлаар томьёолно гэж ойлголоо.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Ундрахбаяр зөвлөх дахин томьёолоод илгээхээр боллоо. Түүний дараа бид дахин санал авья.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ:

Институтийг тараах төлөвлөгөө гэж орж ирэхээр нийгэмд буруу ойлголт өгөх магадлалтай тул нэршлээ бодож зөв өгөх хэрэгтэй.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээг ТББ, доод шат руу тараахыг зорьж байна гэж ойлгож байна. Тийм төрлийн нэр буюу хариу үйлдлийн агуулгыг оруулж нэрийг нь өгвөл зүгээр болов уу.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

ХБИ-ний асуудал зөвхөн ХНХЯ-ны асуудал биш, бүх яам, бүх салбарт анхаарах ёстой асуудал юм. Тэгэхээр шинээр томьёолоод НБД-д хүргүүлээрэй. Зарчмын хувьд Зорилт 7-г “дэмжих” санал хураалт явуулая. Бүгд санал нэгтэйгээр дэмжлээ.

Зорилт 8 - Нээлттэй өгөгдөл.

“Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК-ын гүйцэтгэх захирал Э.Тунгалаг:

Стандарт хэрэгтэй гэдэг үүднээс төсөв, тендерийн мэдээлэл байгаа ч шаардлага хангахгүй болохоор хэрэглэхэд төвөгтэй, мэдээлэл авдаг хайлтын систем биш нээлттэй өгөгдөл болгох хэрэгтэй байна. Нарийвчилсан стандарттай болж хэрэгжилтийг хангах саналтай байна.

“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн Ш.Ариунаа:

Нээлттэй өгөгдөл тусдаа зорилт байснаар 2 давуу талтай гэж харж байна. 1-т Зорилт 2 дээр олон асуудлыг оруулсан. Үнэлгээ хийхэд дийлэнх нь хэрэгжээгүй бол муу үзүүлэлт авах магадлалтай. 2-т хурдан хугацаанд хэрэгжих боломжтой харагдаж байна. Бие даасан зорилтоор үлдээх саналтай байна.

“Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК-ын гүйцэтгэх захирал Э.Тунгалаг:

Тусад нь үлдээх нь илүү юм байна. Мэдээлэл, өгөгдөл 2-ыг ялгаж өгөх нь зүгээр байна. Тусдаа ярих нь илүү үр дүнтэй байх. Тусдаа байснаар төр илүү анхаарч үзнэ. Төр нээлттэй мэдээлэл тавьсан мөртлөө нээлттэй өгөгдөл болгохгүй байна. Тусдаа байвал дээр гэж саналтай байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ:

Мэдээллийн ил тод байдал дээр хамт байх нь зөв гэж бодож байна. Хамт байж илүү үр дүнтэй, нээлттэй мэдээлэл, ил тод байдал гэдэг зүйл илүү чанаржина гэж харж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Ажлын хэсгийн гишүүдийн саналыг “дэмжих” санал хурааяа. Нээлттэй өгөгдөл тусдаа байна. Мэдээллийн ил тод байдал дээр хүлээгдэж буй үр дүн руу оруулахаар боллоо. За санал хурааяа. Бүгд дэмжлээ.

Зорилт 9 - Шүүх засаглал санал байхгүй. Энэ бол ЗГ-ын бие дааж гаргаж байгаа амлалт тул ЗГ шууд утгаараа шүүх засаглал, хууль тогтоох байгууллагыг төлөөлөхгүй. Тийм учраас шүүх засаглалыг хасах саналтай байна, санал хурааяа. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөөрэй. Санал нэгтэйгээр дэмжлээ.

Зорилт 10 - Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх. Оюунцэцэг гишүүний хэлсэн саналыг яримаар байна.

“Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” ТББ-ын тэргүүн Ш.Ариунаа:

Хүний эрхийн хөтөлбөр батлагдана гэж харж байгаа. Хүний эрхийн төлөв байдлын тайланг хагас жилд нэг удаа орон нутгаас авч байгааг тэрэнтэй уялдуулж болох уу?

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач Б.Анар:

Энэ Зорилт дээр 3 агуулга явж байгаа:

1. Төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийг дүгнэхэд ИНБ-ыг оролцуулах, ИНБ дүгнэх.
2. Бодлогын үнэлгээнд ИНБ-ын оролцоо, үнэлгээ, санал, зөвлөмж, дүгнэлтийг оруулах.
3. Нийт иргэд болон төрийн албан хаагчдын чанар, хүртээмж, ил тод байдлыг дүгнэдэг иргэдийн сэтгэл ханамжийн индексыг бий болгох.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа:

Зорилт 2 дээр орсон эм, эмнэлгийн хэрэгслийн асуудлыг Зорилт 10 руу оруулвал тохиромжтой юу?

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Дотоод хяналтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ:

Энэ 3 агуулга зорилт руу тус тусдаа салж орвол ямар вэ? Үнэлэхэд асуудал үүсэх магадлалтай. 3 агуулгыг 3 зорилт болгоод тус тусад нь үнэлэхгүй бол нэгнийгээ татаж унагаах эрсдэлтэй.

Мөн төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийг нэмэх саналтай байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж:

Зорилт 10-ыг хоёр салгах саналтай байна. Шинээр томьёолоод НБД-д өгье. 5 дахад ҮЗ-н хуралдаан дээр шаардлагатай гэж үзвэл зарим төрийн болон ТББ-ын төлөөллийг оролцох асуудлыг ярилцаад хариу өгнө. Ажлын хэсгийн гишүүд 22-ны өдөр хүртэл идэвхтэй саналаа өгөөд оролцоорой. Тэрнээс хойш би та бүхэнд саад

болохгүй.

Өнөөдөр цаг заваа гарган хуралдаанд оролцсон та бүхэнд баярлалаа. Саналыг нэгтгээд цахимаар илгээнэ. Баярлалаа.

Хуралдаан 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 13.30 цагт өндөрлөв.

Хуралдааны тэмдэглэлийг хөтөлсөн:

МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
2024-2027 ОНЫ ҮНДЭСНИЙ V ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, ТАНИЛЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.НОМИНЧИМЭГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХОРОО

Open Government Partnership

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ V ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ЯВЦ, ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023.12.19

ХЭХҮХ-ны Ажлын алба, НЗТ Дэмжих нэгж

10/25	11/08	11/13-11/17	11/21	11/30	12/01	12/11-12/15	12/18	12/19	12/22
НЗТ-ийн тухай танилцуулах вебинар зохион байгуулах	Ажлын хэсгийн анхдугаар хуралдаан Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсэг цахимаар санал өгсөн Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсгийн II хуралдаан Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Хэлэлцүүлэг зохион байгуулах Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсгийн III хуралдаан Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Яамд, агентлагаас бичгээр санал авах Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсгийн төлөөлөлтэй уулзах Төсөлд нэмэлт мэдээллийг оруулах	Ажлын хэсгийн IV хуралдаан Төслийг эцэслэн хүргүүлэх	Төслийг НЗТ-ийн Үндэсний зөвлөл батлах 12/25-12/28 Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөө илгээх, ЗГХЭГ-ын даргын тушаал албажих

ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ V ТӨЛӨВЛӨГӨӨ (2024-2027)

Хэрэгжих хугацаа (4 жил): 2024.01.01 – 2027.12.31

Зорилт 1 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх үе шатыг оруулах
2. Хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагын хүрч ажиллаж чадахгүй асуудал дээр ТББ нар оролцох зохицуулалт оруулах
3. НЗТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэл, хүндрэлийг урьдчилан тооцох
4. СаЯ татан оролцуулах

Зорилт 2 Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах

1. Иргэд мэдээллийг нээлттэй авах төрийн механизм бий болгох
2. Төрийн байгууллагад мэдээллийг нээлттэй хуваалцах соёл түгээхийн тулд холбогдох төрийн албан хаагчдад сургалт явуулах
3. Олон улсын ямар зөвлөмжийг хэрэгжүүлэхийг тодорхой оруулах

Зорилт 3 Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бус бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйг орчныг боловсронгуй болгох

1. Төр, иргэний нийгмийн түншлэлийг идэвхжүүлэхэд шинэлэг санаачилга оруулах
2. Хараат бус ажиллах орон зайг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх үе шатыг илүү тодорхой заах
3. Томоохон санхүүжилт хүлээн авсан ТББ-ын мэдээллийг ил болгохоос гадна тус байгууллагын санхүүгийн тайланд туссан мэдээллийг иргэдэд ил тод болгох

Зорилт 4 Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн оролцоог хангах, хяналтыг сайжруулах

1. Иргэдийн оролцоог дэмжих, мониторинг хийх шинэ механизм санал болгох

Зорилт 5 Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх

1. Нэгдсэн платформоос төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнах, аудитын мэдээллийг иргэд хүлээн авдаг байх
2. Иргэдээс санал ирүүлсэн ажил төсөвт ороогүй шалтгааныг төрийн байгууллагаас тайлбарладаг процесс байх

Төрийн худалдан авах ажиллагааны
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
....дугаар албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН 2024-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮНДЭСНИЙ 5 ДУГААР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ТӨРИЙН ХУДАЛДАН АЖИЛЛАГААНЫ ГАЗРААС ӨГӨХ САНАЛ

<table>
<tr><th>Хүрэх үе шатууд</th><th>Хүлээгдэж буй үр дүн</th><th>Хэрэгжүүлж дуусах хугацаа</th><th colspan="3">Оролцогчид</th></tr>
<tr><td colspan="6">Зорилт 5.1: Төсвийн ил тод байдлыг сайжруулна</td></tr>
<tr><td rowspan="4">5.1.8.Шилэн дансны тухай хуулийн дагуу захиалагч төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулахад дэмжлэг үзүүлж, хүний оролцоогүй мэдээлэл солилцох холболтыг хийх.</td><td rowspan="4">Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, гэрээний мэдээллийг төсвийн бүх шатны захиалгчдын мэдээллийг бүрэн цахим системд оруулж олон нийтэд нээлттэй болсон байна.</td><td rowspan="4">2024-2025 он</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: Төрийн худалдан авах ажиллагааны газар</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиглагчид: Сангийн яам</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>Бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчид</td><td>Хамтран ажилладаг төрийн бус байгууллагууд</td><td>Иргэд, олон нийт</td></tr>
<tr><td colspan="6">Зорилт 5.2: Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг илүүтэй боловсронгуй болгох</td></tr>
<tr><td rowspan="4">5.2.5.Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, худалдан авах ажиллагааны цахим системд холбогдсон мэдээллийн системийн тоог нэмэгдүүлэх, цахим системд бүртгэгдэж буй машин унших боломжтой өгөгдлийн тоог нэмэгдүүлж, нээлттэй өгөгдлийг түгээх, тендер шалгаруулалтын үнэлгээнд хүний оролцоог бууруулах техникийн боломжийг бүрдүүлж систем хоорондын холболт хийх.</td><td rowspan="4">Худалдан авах ажиллагааны нэгдсэн мэдээллийн системийн хөгжүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг хангах, системийн хэрэглэгчдийг чадавхжуулах, мэдээллийн технологид суурилсан худалдан авах ажиллагааны хяналтын тогтолцоог бий болгох.</td><td rowspan="4">2024-2025 он</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: Төрийн худалдан авах ажиллагааны газар</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиглагчид:Төрийн байгууллагууд</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Бусад</td><td>Хамтран ажилладаг төрийн бус байгууллагууд</td><td>Бүх тендерт оролцогчид</td></tr>
</table>

Зорилт 6 Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах

1. НЗТ-ийн үнэт зүйлстэй холбон эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, чанар, аюулгүй байдал, нийлүүлэлт дээр нээлттэй засгийн “линз”-ээр харж олон нийтийг түлхүү оролцуулах

Зорилт 7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах

1. Дэд бүтэц, ажлын байр олгох зэрэг асуудлыг шийдвэрлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулах
2. Засгийн газрын аливаа шийдвэрт бүх төлөөллийн дуу хоолойг сонсож санаачилгыг оруулах

<table>
<tr>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх:
1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний Үндэсний хороо, дэд хороо, салбар зөвлөлийн жүрмыг шинэчлэх
2. Төр, засгийн байгууллага дээр ажиллах аливаа комисс, багт орж ажиллах чадвартай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бэлдэх
3. Төр, засгийн байгууллага дээр хийгдэх ажлын комисс, багт хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл оролцох</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо хангагдахад нэг том ахиц хийгдэнэ</td>
<td>2025</td>
<td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ХНХЯ</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td colspan="3">Дэмжин ажиллагчид: ~~Улаанбаатар хотын Захиргаа~~
Нутгийн захиргааны байгууллага</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>Төрийн байгууллага</td>
<td>Төрийн бус байгууллага</td>
<td>Бусад оролцогчид</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>ХБХХЕГ, бүх яамд</td>
<td>Түгээмэл хөгжил</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум ба Эрхийн хороо</td>
</tr>
<tr>
<td>~~Улаанбаатар хотын~~ явган хүний замыг шинэчлэх:
1. нийтийн тээврийн хүртээмжтэй зогсоолын стандарт боловсруулагдан батлагдах
2. Загвар зогсоол баригдах
~~3. Хотын нийтийн тээврийн зогсоол шинэчлэгдэж эхэлсэн байна~~</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил нийтийн тээврээр зорчих нөхцөл бүрдэхэд нэг алхам хийгдэнэ</td>
<td>2025</td>
<td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
~~Улаанбаатар хотын Захиргаа~~
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>Төрийн байгууллага</td>
<td>Төрийн байгууллага</td>
<td>Төрийн байгууллага</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>ХБХХЕГ</td>
<td>Түгээмэл хөгжил</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум ба Эрхийн хороо</td>
</tr>
<tr>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах тогтолцооны суурийг тавих:
1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах
2. Түүнийг дагалдан гарах журам, аргачлалыг шинэчлэх
3. Үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг чадваржуулах сургалт, дадлага явүүлах
4. Үйлчилгээг явуулж эхлэх</td>
<td>Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах, нийгмийн оролцоо нэмэгдэх, бусдын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн идэвх санаачилга нэмэгдэх</td>
<td>2025</td>
<td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ХНХЯ</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>Төрийн байгууллага</td>
<td>Төрийн бус байгууллага</td>
<td>Бусад оролцогчид</td>
</tr>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>ХБХХЕГ, ХХҮЕГ</td>
<td>Түгээмэл хөгжил</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Форум ба Эрхийн хороо</td>
</tr>
</table>

Зорилт 8 Нээлттэй өгөгдөл

1. Одоогийн нөхцөл байдалтай харьцуулан төлөвлөгөө хэрэгжүүлж дуусахад ямар түвшинд хүрсэн байх тухай тодорхой заах
2. Монгол Улсын иргэн бүр мэдээлэл хүлээн авах агуулгыг оруулах
3. Засгийн газрын нээлттэй өгөгдлийн шаардлага болон мониторинг ТББ-ын оролцоотой хянах

Зорилт 9 Шүүх засаглал

1. Зөвлөмж ирээгүй

Зорилт 10 Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх

1. ТББ-аас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхийг шаарддаг төрийн байгууллага байх эсэх
2. Иргэний нийгмий орон зайн 3-р зорилттой агуулга давхцаж байгаа эсэхийг нягтлах

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2023.12.20

ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ – V
2024-2027 МОНГОЛ УЛС
НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН АМЛАЛТ, ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

<table>
<tr><th colspan="4">Зорилт – 1 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах</th></tr>
<tr><th colspan="4">Үүрэг амлалтын тодорхойлолт</th></tr>
<tr><td>Манлайлж хэрэгжүүлэх байгууллага</td><td colspan="3">Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжин ажиллагчид</td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Цахим хөгжил, харилцаа холбооны яам</td><td>Төлсөн авсанаа нийтэл (ТАН) эвсэл</td><td>ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл</td></tr>
<tr><td>Хэрэгжих хугацаа</td><td colspan="3">2024-2027</td></tr>
<tr><th colspan="4">Асуудлын тодорхойлолт</th></tr>
<tr><td>Үүрэг амлалт ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна вэ?</td><td colspan="3">Ил тод байдлаар дамжуулан байгалийн баялаг ашиглах үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулж, хариуцлагыг нэмэгдүүлж, авлига, ашиг сонирхлыг зөрчлийн эрсдэлийг бууруулах</td></tr>
<tr><td>Асуудлын шалтгаан юу вэ?</td><td colspan="3">Эрдэс баялгийн салбар, ялангуяа энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны авлига, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл өндөр.
Уул уурхайн хариуцлагагүй үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, хүний эрхийн зөрчил нь уул уурхайг үл дэмжих хандлагыг нэмэгдүүлж, орон нутагт үйл ойлголцол, зөрчил маргаан үүсгэдэг.
Монгол Улс 2006 оноос эхлэн амжилттай хэрэгжиж ирсэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хэрэгжилт сүүлийн жилүүдэд илт суларсан нь ил тод байдлыг хангахтай холбоотой төр, хувийн хэвшлийг үүрэг, хариуцлага хуулиар баталгаажаагүйтэй холбоотой.
Ил тод байдал, засаглалын сул байдал нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлдөг.</td></tr>
</table>

<table>
<tr><td>Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?</td><td colspan="4">Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2020 онд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг тухай хуулийн төслийг боловсруулсан боловч УИХ-д өргөн барихаас болгоомжилсон.
2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яам дээрх хуулийн төслийг татан авч, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл болгон өөрчилж, эрдэс баялгаас гадна газар, ой, ус зэрэг байгалийн бусад баялгийн ашиглалтад ил тод байдлыг хангах асуудлыг нэмж тусган олон нийтээс санал авах ажиллагаа хийгдэж байна.</td></tr>
<tr><td>Ямар шийдлүүдийг санал болгож байна вэ?</td><td colspan="4">● Ил тод байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах үйл ажиллагааг Засгийн газар хариуцан хэрэгжүүлэхээр тусгана.
● Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэл, үйл ажиллагааг хуульчилж, төрийн нээлттэй өгөгдлийн сантай холбоно.
● Мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбоотой төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлно.
● Олборлох үйлдвэрийн салбарт эцсийн өмчлөгчийн ил тод тод байдлыг хангахаар тогтооно.
● Гэрээний ил тод байдлыг хангана.
● Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаа, орлого, зарлагын ил тод байдлыг хуульчилна.
● Олборлох үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдэд ил тод байдлыг хангахаар тогтооно.
● Ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол тогтоох, тусгай зөвшөөрөл олгох, байгалийн баялаг ашиглахтай холбоотой гэрээ байгуулах, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник эдийн засгийн үнэлгээ батлах, газар, ус ашиглах зөвшөөрөл олгох зэрэг шийдвэр гаргах үйл явцад ил тод байдлыг хангахаар хуульчилна.
● Ил тод байдлыг хангах, салбарын бодлогыг тодорхойлох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа дахь иргэний нийгмийн оролцоог хангах механизмыг бий болгоно.
● Ил тод байдлыг хангах үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгоно. Улс, орон нутгийн төсөв, олборлох үйлдвэрийн салбарын бодлого, зохицуулалтыг тодорхойлоход салбарын мэдээлэл, тооцоо судалгааг харгалзах нөхцөлийг бүрдүүлнэ.
● Ил тод байдлыг хангах үүргийн зөрчилд хүлээлгэх хариуцлага тодорхойлно.</td></tr>
<tr><td>Энэ үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="4">(Нөхөж бичих)</td></tr>
<tr><td>Хүрэх үе шатууд</td><td>Хүлээгдэж буй үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td colspan="3">Оролцогчид</td></tr>
<tr><td rowspan="4">Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьж, хэлэлцүүлэх</td><td rowspan="4">1. Хуулийн төслийг баталсан байна
2. Олборлох үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх

Уранцоож гишүүн:</td><td rowspan="4">2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: УУХҮЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>УУХҮЯ, БОАЖЯ, СаЯ</td><td>ТАН эвсэл</td><td>ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td>Байгалийн нөөцийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх</td><td></td><td colspan="3"></td></tr>
<tr><td rowspan="4">Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн холбогдох байгууллага, төрийн өмчит компаниудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх; Монголын Олборлох Ил Тод Санаачилгын тайлангаар дамжуулан нийтэд ил тод болгодог мэдээллүүдийг төрийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар дамжуулан шууд мэдээлдэг болох</td><td rowspan="4">Хуулийн төслийг баталсан байна.</td><td rowspan="4">2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: БОАЖЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>ЦХХХЯ
ТӨБЗГ
Усны газар
Ойн газар
АМТГТГ</td><td>ТАН эвсэл</td><td>ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл</td></tr>
<tr><td rowspan="4">Ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөвт суулган шийдвэрлэх</td><td rowspan="4">Хуулийн төслийг баталсан байна.</td><td rowspan="4">2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>СЯ</td><td>ТАН эвсэл</td><td>ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл</td></tr>
<tr><td rowspan="4">Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв:
Төрийн өмчит компаниудын ТУЗ-д байгаа гишүүдийн мэдээллийг ил тод болгох, жендерийн тогтвортой байдлыг хангах үүднээс квот тогтоож өгөх.</td><td rowspan="4"></td><td rowspan="4"></td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ЗГХЭГ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td></td><td></td><td></td></tr>
</table>

<table>
<tr><td colspan="4">Зорилт – 2 Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах</td></tr>
<tr><td colspan="4">Үүрэг амлалтын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Манлайлж хэрэгжүүлэх байгууллага</td><td colspan="3">Засгийн гарын Хэрэг эрхлэх газар</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжин ажиллагчид</td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>ХЗДХЯ, ЦХХХЯ, ЭМЯ, СХЗГ, ТЦҮЗГ, ЭЭХХЗГ</td><td>ХМЗ, ХХ, Глоб Интернэшнл төв, Сэтгүүл зүйн инновац хөгжлийн гүүр төв, МСНЭ, МСТК, ХХЗХ, МҮОНКТ, МОНЦАМЭ</td><td>Харилцаа холбооны зохицуулах хороо</td></tr>
<tr><td>Хэрэгжих хугацаа</td><td colspan="3">2024-2027</td></tr>
<tr><td colspan="4">Асуудлын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Үүрэг амлалт ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна вэ?</td><td colspan="3">1. Нээлттэй өгөгдлийн стандартыг бий болгох
2. Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх
3. Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтын тогтолцоог сайжруулах</td></tr>
<tr><td>Асуудлын шалтгаан юу вэ?</td><td colspan="3">1. Нээлттэй өгөгдлийн хэрэглээ бизнесийн салбарт нэвтрээгүй байна. Төрийн үйл ажиллагаанд тавих хяналт, иргэд, ТББ, хувийн хэвшлийн оролцоо хангалттай үндэслэлтэй бус байна. Төрийн аливаа шийдвэр гаргалтад ашиглахуйц мэдээлэл цогц биш, уялдаа холбоо байхгүй байгаа нь шийдвэр оновчтой биш байдлыг бий болгож байна.</td></tr>
<tr><td>Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?</td><td colspan="3">1. Засгийн газрын 2022 оны “Жагсаалт батлах тухай” 232 дугаар тогтоолын хавсралтаар 58 мэдээлэл хариуцагч байгууллагын 606 нээлттэй өгөгдлийн жагсаалтыг баталсан.Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал https://opendata.gov.mn/ -ыг ашиглалтад оруулж, 2023 оны 12 дугаар сарын байдлаар 60 байгууллагын 943 нээлттэй өгөгдлийг байршуулсан.
2. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/268, А/48 дугаар хамтарсан тушаалаар нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийг байгуулсан.
3. Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/509, А/60 дугаар хамтарсан тушаалын дагуу эмийн чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлтэй холбоотой эмийн мэдээллийг цахимаар авах, хянах боломжийг бүрдүүлэх “Licemed” программын үндсэн өгөгдлийн санг Үндэсний дата төвд байршуулсан. E-Mongolia системээр дамжуулан аж ахуйн нэгж, байгууллагууд биологийн идэвхт бүтээгдэхүүн, импортын эм, үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эм, эмийн түүхий эдийг бүртгэх, сунгах, өөрчлөх, зохицуулах үйл ажиллагааг тус системд оруулж байна. Ингэснээр эм ханган нийлүүлэх 100 гаруй байгууллага эдгээр үйлчилгээг</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td colspan="3">цахимаар авах боломж бүрдсэн. 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар аж ахуйн нэгж, байгууллагууд биологийн идэвхт бүтээгдэхүүн, импортын эм, үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эм, эмийн түүхий эдийг бүртгэх, сунгах, өөрчлөх, зохицуулах зэрэг 14 үйл ажиллагаанд 4,512 хүсэлтийг төрийн мэдээллийн E-Mongolia платформд, 20 үйл ажиллагаанд 4,711 хүсэлтийг E-Business платформоор дамжуулан тус тус хүсэлт гаргасан байна.</td></tr>
<tr><td>Ямар шийдлүүдийг санал болгож байна вэ?</td><td colspan="3">1. Нээлттэй өгөгдлийн стандартыг боловсруулан баталж, холбогдох сургалтыг зохион байгуулан, бүх шатны мэдээлэл хариуцагч байгууллагуудаар хэрэгжилтийг хангуулах
2. Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх
Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтын тогтолцоог сайжруулах</td></tr>
<tr><td>Энэ үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="3">Богино хугацаанд: Стандарт хангасан, чанартай нээлттэй өгөгдөл бий болох, Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх, LICEMED программ хангамжийн үйл ажиллагааг сайжруулах
Урт хугацаанд: Нээлттэй өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдах, Эмийн аюулгүй байдлын цахим тогтолцоог бүрдүүлэх.</td></tr>
<tr><td>Хүрэх үе шатууд</td><td>Хүлээгдэж буй үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td>Оролцогчид</td></tr>
<tr><td colspan="4">Зорилт 2.1: Мэдээллийн ил тод байдал</td></tr>
<tr><td rowspan="4">Нээлттэй өгөгдлийн шаардлага, стандартыг батлах</td><td rowspan="4">Мэдээлэл хариуцагч байгууллагууд нээлттэй өгөгдөл бий болгохдоо мөрдөх нэгдсэн стандарт бий болсон байна.</td><td rowspan="4">2024-2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: Харилцаа, холбооны зохицуулах хороо</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>ЦХХХЯ</td><td>.....</td><td>Иргэн, ААН</td></tr>
<tr><td rowspan="4">Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтын тогтолцоог сайжруулах</td><td rowspan="4">Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтын тогтолцоо LICEMED программ хангамжид түшиглэн сайжруулсан байна.</td><td rowspan="4">2024-2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>ЭМЯ, ЦХХХЯ</td><td>ТББ, холбоод</td><td>Иргэн, ААН</td></tr>
<tr><td rowspan="2">Ханнс-Зайделийн сан:</td><td rowspan="2"></td><td rowspan="2"></td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
</table>

<table>
<tr><td>Шүүх эрх мэдлийн мэдээлэл ил тод нээлттэй, шүүхэд гарсан гомдол, шүүх хуралдааны мэдээлэл, шийдвэр гаргах процедур, гарсан шийдвэрүүд нь нийтэд нээлттэй, хүртээмжтэй, ойлгомжтой байх</td><td></td><td></td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td rowspan="3">Олборлох үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх

Уранцоож гишүүн:
Байгалийн нөөцийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх</td><td rowspan="3"></td><td rowspan="3"></td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн байгууллага</td></tr>
<tr><td>Иргэний нийгмийн орон зай зорилтоос оруулсан:
Төсвийн ерөнхийлөн захирагч нарын ТББ-уудтай хийсэн гэрээ, санхүүжилт, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг ил тод болгох</td><td>Төсвийн гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд иргэдийн хяналт сайжирна</td><td>2024-2027</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Дэмжин ажиллагчид:
Төрийн байгууллага | Төрийн байгууллага | Төрийн байгууллага</td></tr>
<tr><td colspan="6">Зорилт 2.2: Хэвлэл мэдээллийн эрх чөлөө</td></tr>
<tr><td rowspan="3">Төрийн болон албаны нууцын тухай хуулийг өөрчилж Засгийн газрын тогтоол, төрийн байгууллагын шийдвэрээр бус зөвхөн хуулиар төрийн нууцын жагсаалтыг батлах

НЭГТГЭХ

Төрийн болон албаны нууцын жагсаалтыг мэдээллийн ил тод байдлын зорилгод нийцүүлэн өөрчлөх</td><td rowspan="3">-Судалгаа, мониторинг хийж хуулийн хэлэлцүүлэгт оруулах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах
-ХЗҮХ-ийн судалгааны дүнг ажил болгон хэрэгжүүлэх

-Нууцлалын талаарх хэм хэмжээ, түүний үндэслэлийг тодорхой болгох
-Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлын тухай дүрэм, журам сайжруулах.</td><td rowspan="3">.....</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
ХЗДХЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага

ТЕГ
ЦХХХЯ
ХЗДХЯ</td><td>Төрийн байгууллага

ННФ
Бусад ТББ</td><td>Төрийн байгууллага

Нууцтай харилцах эрх бүхий этгээд, бусад албан тушаалтан</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td>Түүний хэрэгжилт, хуулийн хэрэглээг сайжруулах.
-Төрийн мэдээлэлтэй шууд харьцдаг төрийн албан хаагчдын мэдлэг ойлголт, хандлагыг өөрчлөх
-Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг тусгай зохицуулах дүрмээр үүрэгжүүлэх</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td rowspan="4">Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг эцэслэн боловсруулж өргөн барих.</td><td rowspan="4">-Хэвлэл мэдээллийн салбарын нөхцөл байдлыг цогцоор судлах
-Эзэмшлийн ил тод байдлыг хангах
-Иргэдийн мэдээллийн боловсролыг сайжруулах</td><td rowspan="4">.....</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: ХЗДХЯ</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн байгууллага</td></tr>
<tr><td>ЦХХХЯ
МУХХЗХ
ЦЕГ
УБЕГ
ХЗҮХ
“МОНЦАМЭ”
Монголын Үндэсний Мэдээллийн агентлаг</td><td>Монголын Сэтгүүчдийн нэгдсэн Холбоо
-Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн Холбоо</td><td>МУИС ХЗС</td></tr>
Үүрэг амлалт ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна вэ?	-Яамд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг хийхэд иргэний нийгмийн байгууллага, холбоодын оролцоог хангах -Бодлогын үнэлгээг хийхэд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоог хангах -Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод нээлттэй байдлын талаарх хэрэглэгчийн буюу иргэн, хуулийн этгээдийн сэтгэл ханамжийг тандан судалдаг байх, үүнд үндэслэн төрийн үйлчилгээний хүргэх ажлыг сайжруулах		
Асуудлын шалтгаан юу вэ?	-Яамд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг зөвхөн KPI үзүүлэлтээр үнэлж, дүгнэдэг бөгөөд төрийн байгууллагын чадавх, төрийн байгууллагын үйл ажиллагаа үр дүнтэй (үр дагавар, үр нөлөө) байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч чаддаггүй. Байгууллагын гүйцэтгэлийг ЗГ-ын 2021 оны 206 дугаар журмаар зохицуулдаг бөгөөд уг журмын дагуу төрийн байгууллагын үнэлгээнд иргэний нийгмийн байгууллага, холбоод оролцох боломж хязгаарлагдмал бөгөөд үр дүн багатай байдлаар зохицуулагдсан. -Төрийн бодлогын үр дүнд үнэлгээ хийгдэхгүй байна. Ингэснээр бодлого үр дүнтэй байсан эсэх, цааш үргэлжлүүлэх, өөр бодлого хэрэгжүүлэх гэх мэт шийдвэрийг хангалттай үндэслэл, судалгаатай гаргахгүй байна. Холбогдох журамд мониторинг болон үнэлгээг ижил хэлбэр, агуулгаар хийхээр тусгасан бөгөөд төрийн байгууллагууд ийм байдлаар хийж хэвшсэн. -Төрийн байгууллага, үйлчилгээний талаар иргэд, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авах ажил хангалттай болон зохих ёсоор, тогтмол, бодитой хийгддэггүй		
Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?	Өмнө яам, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тухайн байгууллага өөрсдөө судалгааны байгууллагаар захиалга өгч цөөхөн хэдэн чиг үүргийг сонгон авч хийлгүүлдэг байсан. Одоогийн байдлаар яам, агентлагийн үйл ажиллагаа дахь хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг ЗГХЭГ нэгтгэн зохион байгуулан авч байгаа бөгөөд агуулгын хувьд дорвитой өөрчлөлт байхгүй байна.		

<table>
<tr><td>Ямар шийдлүүдийг санал болгож байна вэ?</td><td colspan="4">-Яамд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг дүгнэх үзүүлэлтэд мэргэжлийн холбоод болон иргэний нийгмийн байгууллагууд тухайн төрийн байгууллагын тодорхой гүйцэтгэлийн үзүүлэлтэд өгдөг тогтолцоог бүрдүүлэх /ил тод, нээлттэй байдлын үнэлгээ гэх мэт/
-Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийхэд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагыг оролцоог хангах
-Иргэдийн сэтгэл ханамжийг төрийн үйлчилгээ авснаас хойш жилийн дараа бус тухай бүр авдаг, тандалт судалгаа хийдэг, үр дүнг нь төрийн үйлчилгээ сайжруулахад ашигладаг болох тогтолцоог бүрдүүлэх. Иргэний буюу үйлчилгээ авагчийн санал хүсэлтийг оролцоонд түшиглэсэн төрийн үйлчилгээг хүргэх.</td></tr>
<tr><td>Энэ үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="4">-Төрийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ илүү бодитой болох, үнэлгээнд иргэний нийгмийн оролцоог хангах
-Төрийн бодлогын хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийдэг болох, иргэний нийгмийн оролцоог хангах
-Иргэний буюу үйлчилгээ авагчийн санал хүсэлтийг оролцоонд түшиглэсэн төрийн үйлчилгээг хүргэх, төрийн үйлчилгээг сайжруулах</td></tr>
<tr><td>Хүрэх үе шатууд</td><td>Хүлээгдэж буй үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td colspan="3">Оролцогчид</td></tr>
<tr><td rowspan="4">ИНБ, ТББ болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлага, үнэлгээ, мониторинг болон бодлогын үнэлгээ, мониторингид бий болгох</td><td rowspan="4">Бодлого батлагдахаас өмнө батлагдсаны дараа хүртэл үнэлгээ хийх процесс дээр ИНБ-аар үнэлгээ хийж төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрдөг тогтолцоог бий болгох
Төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлагын үнэлгээ, мониторингийн үйл явцад иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо бий болж, үнэлгээний дүнд оролцох</td><td rowspan="4">2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид: Иргэний нийгмийн байгууллагууд, Засгийн газар болон гүйцэтгэх засаглалын төрийн байгууллагууд, холбоод</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогчид</td></tr>
<tr><td>Гүйцэтгэх засаглалын төрийн байгууллагууд</td><td>нээлттэй</td><td>нээлттэй</td></tr>
<tr><td rowspan="4">Иргэдийн сэтгэл ханамжийг тогтмол дүгнэдэг болох</td><td rowspan="4">-Сар, улирал, хагас жил тутамд дүгнэж тус дүгнэлт дээр суурилаад төрийн байгууллага өөрсдийгөө сайжруулдаг тогтолцоо бий болгох
-Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд төрийн захиргааны буюу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын ажлын үзүүлэлтүүдийг дүгнэхдээ ИНБ, ТББ нарын оролцоотойгоор,</td><td rowspan="4">2026</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагчид: Иргэний нийгмийн байгууллагууд, Засгийн газар болон гүйцэтгэх засаглалын төрийн байгууллагууд, холбоод</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн байгууллага</td></tr>
<tr><td>Гүйцэтгэх засаглалын төрийн байгууллагууд</td><td>Гүйцэтгэх засаглалын төрийн байгууллагууд</td><td>Гүйцэтгэх засаглалын төрийн байгууллагууд</td></tr>
</table>

	иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээгээр дүгнэдэг болох				

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДЭД ХҮРГҮҮЛСЭН ЗАХИА
(ЗОРИЛТ ТУС БҮР ДЭЭР ДУТУУ ЗҮЙЛСИЙН ЖАГСААЛТ)

Зорилт 1 – Олборлох үйлдвэрлэл
Санал ирүүлсэн: ХЗДХЯ, УУХҮЯ, ННФ Д.Эрдэнэчимэг, “Байгаль эхийн аврал са Н.Наранцэцэг, “Хүний эрх, хөгжил төв” Г.Уранцоож, “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв” Б.Лакшми

Дэд ажлын хэсэг:
1. ХЗДХЯ-аас ирүүлсэн саналыг цэнхэрээр тэмдэглэв
2. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс ирүүлсэн саналыг улбар шараар тэмдэглэв
3. “Энэ үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?” асуултад хариулж нөхөж бичих
4. Ирсэн саналтай танилцаж төслийг эцэслэн хүргүүлэх

Зорилт 2 – Мэдээллийн ил тод байдал
Санал ирүүлсэн: Ч.Болортуяа зөвлөх, ЗГХХГ Д.Ган-Эрдэнэ, ЦХХХЯ Б.Билэгдэмбэрэл, ЭЭХХЗГ Ш.Энхтуяа, “Хүний эрх, хөгжил төв” Г.Уранцоож, “Сонгогчдын боловсрол төв” С.Оюунтуяа, “Глоб интернэшнл төв” Б.Онон, “Сэтгүүл зүйн инновац хөгжлийн гүүр төв” н.Билгүүн, “Тунгаахуй өгөгдлийн урлан” Э.Тунгалаг, “Хэвлэл мэдээллийн зөвлөл” Г.Гүнжидмаа, Б.Болормаа, “Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих сан” Ш.Ариунаа

Дэд ажлын хэсэг:
1. ХЗДХЯ-аас ирүүлсэн саналыг цэнхэрээр тэмдэглэв
2. Ханнс-Зайделийн сан, Г.Уранцоож гишүүнээс ирүүлсэн саналыг улбар шараар тэмдэглэв
3. Хар өнгөөр үлдсэн хуучин саналыг эцэслэх, үлдээхээр бол холбогдох мэдээллийг нөхөж бичих
4. Ирсэн саналтай танилцаж төслийг эцэслэн хүргүүлэх

Зорилт 3 – Иргэний нийгмийн орон зай
Санал ирүүлсэн: ХЗДХЯ, СаЯ М.Санжаадорж, НЗТ-ийн олон улсын элч Л.Төр-Од, “Транспэрэнси Интернэшнл Монголиа” Э.Мөнхжаргал, “Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн” Э.Баасансүрэн, “Бодлогод залуусын хяналт” н.Мандхайхатан, “Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих сан” Ш.Ариунаа, “Хүний эрх, хөгжил төв” Г.Уранцоож, ННФ Д.Оюунбадам

Дэд ажлын хэсэг:
1. ХЗДХЯ, Г.Уранцоож нараас ирүүлсэн саналыг улбар шараар тэмдэглэв
2. ИНБ-ын төлөөллөөс ирүүлсэн саналыг цэнхэрээр тэмдэглэв
3. “Манлайлж хэрэгжүүлэх байгууллага”, “Дэмжин ажиллах төрийн, төрийн бус, бусад байгууллага” хэсгийг нөхөж бичих
4. “Дахин томьёолох” хэсгийг бичих
5. Ирсэн саналтай танилцаж төслийг эцэслэн хүргүүлэх

Зорилт 4 – Хог хаягдал
Санал ирүүлсэн: ЗГХХГ Б.Анар, БОАЖЯ Г.Энхмөнх, НЗДТГ О.Номинчимэг, ОББҮХ Х.Энхбат, “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв” Б.Лакшми, Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо

Дэд ажлын хэсэг:
1. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс ирүүлсэн саналыг улбар шараар тэмдэглэв
2. Манлайлж оролцох байгууллагыг нөхөж бичих
3. БОАЖЯ дахин томьёолох
4. Холбогдох мэдээллийг нөхөж бичих
5. Ирсэн саналтай танилцаж төслийг эцэслэн хүргүүлэх

Зорилт 5 – Улсын төсөв
Санал ирүүлсэн: СаЯ М.Санжаадорж, ТХАА Ц.Батзул, АТГ Д.Цэнд-Аюуш, Азийн сан Г.Халиунгоо, ННФ Д.Оюунбадам

Дэд ажлын хэсэг:
1. СаЯ, Оюунбадам гишүүнээс хамтран ирүүлсэн саналыг цэнхэрээр тэмдэглэв
2. Хар өнгөөр үлдсэн саналыг нэгтгэх, үлдээхээр бол холбогдох мэдээллийг нөхөж бичих
3. “Манлайлж хэрэгжүүлэх байгууллага”, “Дэмжин ажиллах төрийн, төрийн бус, бусад байгууллага”, “Асуудлын тодорхойлолт” хэсгийг тус тус нөхөж бичих
4. Ирсэн саналтай танилцаж төслийг эцэслэн хүргүүлэх

Зорилт 6 – Эм, эмнэлгийн хэрэгсэл
Санал ирүүлсэн: ЭЭХХЗГ Ш.Энхтуяа
Ажлын хэсгийн гишүүдийн саналаар зорилтыг хасаж 2-р зорилт руу нэгтгэв.

Зорилт 7 – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрх
Санал ирүүлсэн: Ч.Ундрахбаяр зөвлөх, ХНХЯ, “Түгээмэл хөгжил” Я.Авирмэд, П.Гэсэр, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо” Ө.Баясгалан, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн форум ба эрхийн хороо, Бизнес инкубатор төв
Дэд ажлын хэсэг:
1. Зорилтын нэрийг дахин томьёолох
2. Бусад нийгмийн бүлгийг хамруулах
3. Төслийг эцэслэн хүргүүлэх

Зорилт 8 – Нээлттэй өгөгдөл
Санал ирүүлсэн: ЗГХХГ Д.Ган-Эрдэнэ, ЦХХХЯ Б.Билэгдэмбэрэл, “Тунгаахуй өгөгдлийн урлан” Э.Тунгалаг, “Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо” Ш.Ариунаа
Дэд ажлын хэсэг:
1. Зорилт 2 дээр давхар оруулсан мөн тусдаа зорилт хэвээр үлдсэн
2. Хар өнгөөр үлдсэн хуучин “хүрэх үе шат”-ыг үлдээх эсэх дээр шийдэх, үлдээсэн тохиолдолд “нөхөж бичих” хэсгийг бөглөх
3. Төслийг эцэслэн хүргүүлэх

Зорилт 9 – Шүүх засаглал
Санал ирүүлсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэн Х.Эрдэм-Ундрах, “Хил хязгааргүй хуульчид” Ч.Отгонбаатар, ННФ П.Бадамрагчаа
Дэд ажлын хэсэг:
1. Шинээр ирсэн саналыг улбар шараар тэмдэглэв
2. Ажлын хэсгийн гишүүдийн саналаар хасав

Зорилт 10 – Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх
Санал ирүүлсэн: ЗГХХГ Ч.Ариунхур, Д.Ган-Эрдэнэ, Б.Анар, “Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо” Х.Оюунцэцэг
Дэд ажлын хэсэг:
1. Ажлын хэсгийн хуралдаан дээр зорилтыг 2 хуваахаар шийдсэн, түүний дагуу шинээр томьёолох
2. Төслийг эцэслэн хүргүүлэх

Ажлын хэсгийн 4-р хуралдааны бичлэгийг энэ линкээс хүлээн авна уу. Та бүхэн эцэслэсэн саналаа 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 14.00 цагаас өмнө NCHR@cabinet.gov.mn хаягаар хүргүүлэхийг хүсье. Баярлалаа.

НЗТ-ийн YAYT-V төлөвлөгөөний төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн 4-р хуралдаан



НЗТ-ийн YAYT-V төлөвлөгөөний төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн 4-р хуралдаан

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 04 өдөр Дугаар 120 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөөг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, үр дүнг тооцож, хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Хүний эрхийг хангах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Болорсайхан)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН

0023200449

Монгол Улсын сайд, Засгийн газрын
Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны
12 дугаар сарын 27 -ны өдрийн
120 дугаар тушаалын хавсралт

ҮНДЭСНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ – V
2024-2027 МОНГОЛ УЛС

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН АМЛАЛТ, ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

<table>
<tr><td colspan="4">Зорилт 1.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах</td></tr>
<tr><td colspan="4">Үүрэг амлалтын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Манлайлж хэрэгжүүлэх байгууллага</td><td colspan="3">Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжин ажиллагч</td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ХЗДХЯ, БОАЖЯ, ЦХХХЯ</td><td>“Төлсөн авснаа нийтэл” Иргэний нийгмийн эвсэл (ТАН эвсэл)</td><td>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын үндэсний зөвлөл (ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл)</td></tr>
<tr><td>Хэрэгжих хугацаа</td><td colspan="3">2024-2027 он</td></tr>
<tr><td colspan="4">Асуудлын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Үүрэг амлалтаар ямар асуудлыг шийдэхийг зорьж байна вэ?</td><td colspan="3">Ил тод байдлаар дамжуулан байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаа, түүний орлогын менежмент, засаглалыг олон нийтийн хяналтад оруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхлыг зөрчлийн эрсдэлийг бууруулах.</td></tr>
<tr><td>Асуудлын шалтгаан юу вэ?</td><td colspan="3">Эрдэс баялгийн салбар, ялангуяа энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны авлига, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл өндөр.
Уул уурхайн хариуцлагагүй үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, хүний эрхийн зөрчил нь уул уурхайг үл дэмжих хандлагыг нэмэгдүүлж, орон нутаг болон нийгэмд үл ойлголцол, зөрчил маргаан үүсгэдэг.
Монгол Улс 2006 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж ирсэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хэрэгжилт сүүлийн жилүүдэд илт суларсан нь ил тод байдлыг хангахтай холбоотой төр, хувийн хэвшлийн үүрэг, хариуцлага хуулиар баталгаажаагүйтэй холбоотой.
Ил тод байдал, засаглалын сул байдал нь өрсөлдөх чадварыг бууруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлдөг.</td></tr>
</table>

Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2020 онд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан боловч УИХ-д өргөн мэдүүлээгүй. Энэ нь гуравдахь удаагийн төсөл юм. Хууль зүй, дотоод хэргийн яам 2022 онд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд эрдэс баялгаас гадна газар, ой, ус зэрэг байгалийн бусад баялгийн ашиглалтад ил тод байдлыг хангах асуудлыг нэмж тусган Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл болгон өөрчилж, уг хуулийн төслийн талаар олон нийтээс санал авч байгаа болно.		
Ямар шийдлийг санал болгож байна вэ?	1.Ил тод байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах үйл ажиллагааг Засгийн газар хариуцан хэрэгжүүлэхээр тусгана. 2.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэл, үйл ажиллагааг хуульчилж, төрийн нээлттэй өгөгдлийн сантай холбоно. 3.Мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбоотой төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлно. 4.Олборлох үйлдвэрлэлийн салбарт эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангахаар тогтооно. 5.Гэрээний ил тод байдлыг хангана. 6.Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаа, орлого, зарлагын ил тод байдлыг хуульчилна. 7.Олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдэд ил тод байдлыг хангахаар тогтооно. 8.Ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол тогтоох, тусгай зөвшөөрөл олгох, байгалийн баялаг ашиглахтай холбоотой гэрээ байгуулах, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник, эдийн засгийн үнэлгээ батлах, газар, ус ашиглах зөвшөөрөл олгох зэрэг шийдвэр гаргах үйл явцад ил тод байдлыг хангахаар хуульчилна. 9.Ил тод байдлыг хангах, салбарын бодлогыг тодорхойлох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаан дахь иргэний нийгмийн оролцоог хангах механизмыг бий болгоно. 10.Ил тод байдлыг хангах үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгоно. Улс, орон нутгийн төсөв, олборлох үйлдвэрлэлийн салбарын бодлого, зохицуулалтыг тодорхойлоход салбарын мэдээлэл, тооцоо, судалгааг харгалзах нөхцөлийг бүрдүүлнэ. 11.Ил тод байдлыг хангах үүргийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлно.		
Үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?	Байгалийн баялгийн олборлолт, ашиглалттай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг төрийн, орон нутгийн, хувийн болон холимог өмчит компаниуд, тэдний туслан гүйцэтгэх, ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааны гэрээ, санхүүгийн мэдээллийг тогтмол нээлттэй байлгаж, олон нийтийн хяналтад оруулна. Ингэснээр байгалийн баялгийн салбарын төслүүдийн ашигт чанар, үр өгөөж нэмэгдэнэ.		
Хүрэх үе шат	**Хүлээж байгаа үр дүн**	**Хэрэгжүүлж дуусах хугацаа**	**Оролцогч**
1.1.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн	-Хуулийн төслийг баталсан байна.	2025 он	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам **Дэмжин ажиллагч:**

төслийг УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх.	-Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлсэн байна.		**Төрийн байгууллага**	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			БОАЖЯ, ХЗДХЯ, СаЯ	ТАН эвсэл МБОИЗ	ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл
1.2.Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн холбогдох байгууллага, төрийн, орон нутгийн, хувийн, холимог өмчит компаниудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх; Монголын олборлох ил тод санаачилгын тайлангаар дамжуулан нийтэд ил тод болгодог мэдээллүүдийг төрийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар дамжуулан шууд мэдээлдэг болох.	Төрийн байгууллага, төрийн, орон нутгийн, хувийн, холимог өмчит хуулийн этгээд холбогдох мэдээллийг ил тод мэдээлдэг болсон байна.	2024-2025 он	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам		
			Дэмжин ажиллагч:		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			ЦХХХЯ, ТӨБЗГ, Усны газар, Ойн газар, АМГТГ	ТАН эвсэл, МБОИЗ	ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл
1.3.Ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөвт тусгаж шийдвэрлэх.	Ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг тусгасан улсын төсвийг баталсан байна.	2025	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Сангийн яам		
			Дэмжин ажиллагч:		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			ЭЗХЯ	ТАН эвсэл, МБОИЗ	ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл

<table>
<tr><td colspan="4">Зорилт 2.Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил тод байдлыг сайжруулах</td></tr>
<tr><td colspan="4">Үүрэг амлалтын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Манлайлж хэрэгжүүлэх байгууллага</td><td colspan="3">Засгийн газрын Хэрэг эрхлэх газар</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжин ажиллагч</td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ХЗДХЯ, ЦХХХЯ, ЭМЯ, СХЗГ, ТЦҮЗГ, ЭЭХХЗГ</td><td>ХМЗ, ХХ, Глоб Интернэшнл төв, Сэтгүүл зүйн инновац хөгжлийн гүүр төв, МСНЭ, МСТК, ХХЗХ, МҮОНРТ, МОНЦАМЭ</td><td>Харилцаа холбооны зохицуулах хороо</td></tr>
<tr><td>Хэрэгжих хугацаа</td><td colspan="3">2024-2027</td></tr>
<tr><td colspan="4">Асуудлын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Үүрэг амлалтаар ямар асуудлыг шийдэхийг зорьж байна вэ?</td><td colspan="3">1.Нээлттэй мэдээллийн цахим системд (www.shilen.gov.mn) нээлттэй мэдээллийг нийтэлнэ.
2.Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоож, үнэлгээ хийнэ.
3.Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулна.</td></tr>
<tr><td>Асуудлын шалтгаан юу вэ?</td><td colspan="3">Төрийн үйл ажиллагаанд тавих хяналт, иргэд, ТББ, хувийн хэвшлийн оролцоо хангалттай үндэслэлтэй бус байна. Төрийн аливаа шийдвэр гаргалтад ашиглахуйц мэдээлэл цогц биш, уялдаа холбоо байхгүй байгаа нь шийдвэрийн оновчтой бус байдлыг бий болгож байна.</td></tr>
<tr><td>Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?</td><td colspan="3">1.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/268, А/48 дугаар хамтарсан тушаалаар нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийг байгуулсан.
2.Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/509, А/60 дугаар хамтарсан тушаалын дагуу эмийн чанар, аюулгүй байдал, үйлдвэрлэлтэй холбоотой эмийн мэдээллийг цахимаар авах, хянах боломжийг бүрдүүлэх “Licemed” программын үндсэн өгөгдлийн санг Үндэсний дата төвд байршуулсан. E-Mongolia системээр дамжуулан аж ахуйн нэгж, байгууллагууд биологийн идэвхт бүтээгдэхүүн, импортын эм, үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эм, эмийн түүхий эдийг бүртгэх, сунгах, өөрчлөх, зохицуулах үйл ажиллагааг тус системд оруулж байна. Ингэснээр эм ханган нийлүүлэх 100 гаруй байгууллага эдгээр үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн. 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар аж ахуйн нэгж,</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td colspan="4">байгууллагууд биологийн идэвхт бүтээгдэхүүн, импортын эм, үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эм, эмийн түүхий эдийг бүртгэх, сунгах, өөрчлөх, зохицуулах зэрэг 14 үйл ажиллагаанд 4,512 хүсэлтийг төрийн мэдээллийн E-Mongolia платформд, 20 үйл ажиллагаанд 4,711 хүсэлтийг E-Business платформоор дамжуулан тус тус хүсэлт гаргасан байна.</td></tr>
<tr><td>Ямар шийдлийг санал болгож байна вэ?</td><td colspan="4">1.Мэдээлэл хариуцагч өөрийн хариуцсан нээлттэй мэдээллийг www.shilen.gov.mn цахим системд байршуулах;
2.Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх;
3.Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтын тогтолцоог сайжруулах.</td></tr>
<tr><td>Үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="4">Богино хугацаанд:
-Бүрэн бүтэн, үнэн зөв нээлттэй мэдээллийг нийтэлж хэвших;
-Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх;
-LICEMED программ хангамжийн үйл ажиллагааг сайжруулах;
-Эмийн мэдээллийг төрийн үйлчилгээний цахим систем eMongolia-тай холбох.

Урт хугацаанд:
-Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах;
-Эмийн аюулгүй байдлын цахим тогтолцоог бүрдүүлэх.</td></tr>
<tr><td>Хүрэх үе шат</td><td>Хүлээж байгаа үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td colspan="3">Оролцогч</td></tr>
<tr><td rowspan="4">2.1.Нээлттэй мэдээллийг “www.shilen.gov.mn” системд нийтлэх.</td><td rowspan="4">Мэдээлэл хариуцагч байгууллагууд нээлттэй мэдээллийг тогтмол шинэчлэн нийтэлдэг болсон байна.</td><td rowspan="4">2024-2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Цахим хөгжил, харилцаа холбооны яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ХЗДХЯ</td><td>ТББ, холбоод</td><td>Иргэн, ААН</td></tr>
<tr><td rowspan="4">2.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, хяналтын цахим тогтолцоог сайжруулах.</td><td rowspan="4">-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын ил тод байдал хангагдаж, үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирсан байна.
-Монгол Улсад зарж байгаа эм, бэлдмэлийн орц, хүчинтэй хугацаа, импорт, гарал үүсэл зэрэг иргэдэд шаардлагатай</td><td rowspan="4">2024-2028</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ЭМЯ, ЦХХХЯ, СаЯ, ЭЗХЯ, ЭМДЕГ, ГЕГ, ТЕГ, ТХААГ,</td><td>ТББ, холбоод</td><td>ОУБ, Эм хангамжийн</td></tr>
</table>

	мэдээллийг ил тод, нээлттэй түгээдэг болсон байна.		ЭМБ		байгууллага, ААН
2.3.Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг хүртээмжтэй түгээх.	Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан нээлттэй өгөгдөл бүрдүүлсэн, түгээсэн байна.	2024-2027	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам		
			Дэмжин ажиллагч:		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			БОАЖЯ, ХЗДХЯ, СаЯ	ННФ	-
2.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын ТББ-уудтай хийсэн гэрээ, санхүүжилт, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг ил тод болгох.	Төсвийн гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд иргэдийн хяналт сайжирсан байна.	2024-2027	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам		
			Дэмжин ажиллагч:		
			Төрийн байгууллага	**Төрийн байгууллага**	**Төрийн байгууллага**
			БОАЖЯ, ХЗДХЯ, СаЯ	ННФ	-

Зорилт 3.Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бусаар, бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох			
Үүрэг амлалтын тодорхойлолт			
Манлайлж хэрэгжүүлэх байгууллага	Хууль зүй, дотоод хэргийн яам		
Дэмжин ажиллагч	**Төрийн байгууллага**	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
	ЗГХЭГ, СаЯ, ТЕГ, УБЕГ	ОУБ	Хүний эрх, хөгжил төв, Хүний Эрхийн ТББ-ын Форум, ТББ-ын корсерциум
Хэрэгжих хугацаа	2024-2027		
Асуудлын тодорхойлолт			
Үүрэг амлалтаар ямар асуудлыг шийдэхийг зорьж байна вэ?	Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийг төрөөс хараат бус ажиллах орон зай, ил тод, нээлттэй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх.		

Асуудлын шалтгаан юу вэ?	1.Төрийн бус байгууллагын тухай хууль нь өнөөгийн ашгийн төлөө бус байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа салбар, олон улсын стандарт, хэрэгцээ, шаардлагад нийцэхгүй, бүрэн үйлчилж чадахгүй болсон. 2.Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байх олон улсын нийтлэг шаардлага, стандарт, зарчимд нийцүүлэх шаардлага бий болсон.
Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?	1.Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Холбооны эрх зүйн байдлын тухай болон Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн. 2.НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг тус тус баталсан.
Ямар шийдлийг санал болгож байна вэ?	1.Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, дүрэм, журамд иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийн төрөөс хараат бус ажиллах орон зайг хангах, иргэний нийгмийн байгууллагын ил тод нээлттэй ажиллах нөхцөлийг дордуулсан зүйл, заалтуудыг эргэн харж, сайжруулах. 2.Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын санхүү, үйл ажиллагааны тайланг бүртгэж авах, үр дүн, үр нөлөөг үнэлэх, үйл ажиллагааг нь ил болгохтой холбогдсон дүрэм, журмыг боловсронгуй болгох. 3.Нийтэд тустай үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, эвслийн үйл ажиллагааг төрөөс дэмжих.
Үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?	Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэний нийгмийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлсэн эрх зүйн орчин бүрдэнэ.

Хүрэх үе шат	**Хүлээж байгаа үр дүн**	**Хэрэгжүүлж дуусах хугацаа**	**Оролцогч**		
3.1.Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах болон иргэний нийгмийн төрөөс хараат бус, санхүүгийн тогтвортой ажиллах хууль зүйн баталгааг бүрдүүлэх, иргэний орон зайд хийдэл, бэрхшээл учруулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох.	Хүний эрхийг хангах, иргэний нийгмийн хараат бус, санхүүгийн тогтвортой ажиллах эрх зүйн орчин сайжирч, орон зайг хэмжих үндэсний шалгуур үзүүлэлт бий болно.	2024-2025	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Хууль зүй, дотоод хэргийн яам		
			Дэмжин ажиллагч:		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			ЭЗХЯ, СаЯ	ТББ-ын консерциум, Хүний Эрхийн ТББ-ын Форум, ННФ	ОУБ
3.2.Иргэний нийгмийн олон улсын суурь зарчим, үнэт зүйл, хариуцлага,	-Иргэний нийгмийн суурь зарчим, үнэт зүйлсийг	2024-2025	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Эдийн засаг, хөгжлийн яам		

<table>
<tr><td rowspan="3">нийтэд тустай үйл ажиллагааг төрөөс хэрхэн дэмжих зэрэг асуудлыг Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдэд тусгах.</td><td rowspan="3">багтаасан, хүний эрхийг баталгаатай хангах, төр-иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх бодлого боловсронгуй болно.
-Иргэний нийгмийн эвсэл, сүлжээ болж хамтран ажиллахад чиглэсэн дэмжлэг, туслалцаа, хууль зүйн баталгаа бүрдсэн байна.</td><td rowspan="3"></td><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ЗГХЭГ, ХЗДХЯ</td><td>Хүний Эрх, Хөгжил Төв ТББ</td><td>ТББ-ын консорциум, Хүний Эрхийн ТББ-ын Форум</td></tr>
<tr><td rowspan="4">3.3.Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын санхүү, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, тайлагнах, дүгнэх журмыг батлах.</td><td rowspan="4">Төрийн бус байгууллагаас үйл ажиллагаагаа тайлагнах, үйл ажиллагаагаа үнэлүүлэх журам тодорхой болсон байна.</td><td rowspan="4">2024-2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Хууль зүй, дотоод хэргийн яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>СаЯ, ТЕГ, УБЕГ</td><td>Нээлттэй Нийгэм Форум, Хүний Эрх Хөгжил Төв, МЭХДХ ТББ</td><td>Төрийн бус байгууллагын консорциум, Хүний Эрхийн ТББ-ын Форум</td></tr>
<tr><td rowspan="4">3.4.Төсвөөс санхүүжилт авсан төрийн бус байгууллагын гэрээ, санхүүжилт, ажлын үр дүнгийн мэдээллийг ил тод болгох.</td><td rowspan="4">Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжсэн төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нийтэд ил болсон байна.</td><td rowspan="4">2024-2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Сангийн яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ХЗДХЯ, ТЕГ, УБЕГ</td><td>Нээлттэй Нийгэм Форум, Хүний Эрх Хөгжил Төв, МЭХДХ ТББ</td><td>Үндэсний болон орон нутгийн ИНБ-ын эвсэл, сүлжээ</td></tr>
</table>

<table>
<tr><td colspan="4">Зорилт 4.Ардчилсан ёсыг бэхжүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах</td></tr>
<tr><td colspan="4">Үүрэг амлалтын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Манлайлж хэрэгжүүлэх байгууллага</td><td colspan="3">Хууль зүй, дотоод хэргийн яам</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжин ажиллагч</td><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>МОНЦАМЭ</td><td>Азийн сан,
ХМЗ,
ХХ,
МСНЭ</td><td>Нээлттэй нийгэм форум,
Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв,
Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төв</td></tr>
<tr><td>Хэрэгжих хугацаа</td><td colspan="3">2024-2027</td></tr>
<tr><td colspan="4">Асуудлын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Үүрэг амлалтаар ямар асуудлыг шийдэхийг зорьж байна вэ?</td><td colspan="3">Нээлттэй засгийн түншлэлийн үнэт зүйлс болох нээлттэй засгийг хөхиүлэн дэмжих, иргэдийг чадавхжуулах, авлигатай тэмцэх зэргийг бодитоор биелүүлж, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлж, хэвлэл мэдээлэл зэрэг иргэний орон зайг тэлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна.</td></tr>
<tr><td>Асуудлын шалтгаан юу вэ?</td><td colspan="3">Мэдээлэл өгөхөөс татгалзах, бичсэн нийтлэл, нэвтрүүлгээс ямар нэгэн дарамт, заналхийлэлд өртсөн, ажлын багаж хэрэгсэлд халдсан, нийтлэл, нэвтрүүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглосон, хориглохыг завдсан, нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан зэрэг зөрчлүүд тохиолдож байна. Төрийн байгууллага нь нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг дотоод зохион байгуулалтын хүрээнд гаргадаг ба хэт ерөнхий тодорхойлсон байдаг. Энэ нь тухайн байгууллага өөрийн цензурээр мэдээллийг нууц гэж томьёолж, мэдээлэл олж авах, түгээхэд саад хийх нөхцөлийг бүрдүүлж байна. Нийтлэл, нэвтрүүлгийг нийтлэгдэх, нэвтрүүлэхээс өмнө хориглож буй зөрчил нь хэвлэл мэдээллийн байгууллагын эзэн, эрх мэдэл бүхий албан тушаалтан, мэргэжил нэгт сэтгүүлчдийн нөлөөлөл, хаалтын гэрээ зэргээр илэрч байна.</td></tr>
<tr><td>Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?</td><td colspan="3">Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, төрийн нууцтай хамаарах хууль тогтоомж, жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хуулийн төслийг ХЗДХЯ-аас өнгөрсөн жилүүдэд боловсруулаад байна.</td></tr>
<tr><td>Ямар шийдлийг санал болгож байна вэ?</td><td colspan="3">Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс төрийн нууц гэсэн үндэслэлээр мэдээллийг ил тод болгохгүй хязгаарладаг байдлыг халах, нарийвчлан журамлах, хэвлэл мэдээллийн салбарын нөхцөл байдлыг судлах, оролцогч талуудыг тодорхойлох, иргэний нийгэм, хувийн хэвшилд эзлэх орон зайг үнэлэх, цаашид хамтран түншлэх замын зураг боловсруулах, хэвлэл мэдээллийн ёс зүйн хариуцлага тооцох явцыг сайжруулах, эрэн</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td colspan="4">сурвалжлах сэтгүүл зүйг орон нутагт хөхиүлэн дэмжих, эх сурвалжаа хамгаалах, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, жагсах, цуглах эрхийг дэмжих.</td></tr>
<tr><td>Үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="4">Дээрх үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр манай улсын иргэдэд шууд хамаарах үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, хадгалах, түгээх, жагсах, цуглах зэрэг эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхэд ахиц дэвшил гарсан байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын чадавх бэхжсэн байна.</td></tr>
<tr><td>Хүрэх үе шат</td><td>Хүлээж байгаа үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td colspan="3">Оролцогч</td></tr>
<tr><td rowspan="4">4.1.Төрийн нууцын жагсаалтыг хуулиар батлах зохицуулалтыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд оруулж, төрийн болон албаны нууцын жагсаалтыг мэдээллийн ил тод байдлын зорилгод нийцүүлэх.</td><td rowspan="4">Нууцлалын талаарх хэм хэмжээ, түүний үндэслэл тодорхой болсон байна.</td><td rowspan="4">2024-2027</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Хууль зүй, дотоод хэргийн яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>Тагнуулын ерөнхий газар,
ЦХХХЯ.
ХЗДХЯ,
БХЯ,
Зэвсэгт хүчний жанжин штаб</td><td>Азийн сан,
Нээлттэй нийгэм форум,
холбогдох ТББ</td><td>Нууцтай харилцах эрх бүхий этгээд,
бусад албан тушаалтан</td></tr>
<tr><td rowspan="4">4.2.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг эцэслэн боловсруулж, өргөн мэдүүлэх.</td><td rowspan="4">-Хэвлэл мэдээллийн салбарын нөхцөл байдлыг цогцоор судалсан байна.
-Эзэмшлийн ил тод байдлыг хангасан байна.
-Иргэдийн мэдээллийн боловсролыг сайжруулсан байна.
-Хууль сахиулах байгууллагын зүгээс хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халдаж, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг хязгаарлахын эсрэг</td><td rowspan="4">2024-2027</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Хууль зүй, дотоод хэргийн яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:
Хэвлэл мэдээллийн зөвлөл</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ЦХХХЯ,
ХХЗХ,
ЦЕГ, УБЕГ,
ХЗҮХ,
“МОНЦАМЭ”</td><td>Азийн сан,
Монголын сэтгүүлчдийн нэгдсэн холбоо</td><td>МУИС-ХЗС</td></tr>
</table>

	хууль зүйн баталгаа бүрдсэн байна.		Монголын Үндэсний Мэдээллийн агентлаг		
4.3.Сэтгүүлч эх сурвалжаа нууцлах баталгаатай холбогдсон зохицуулалтыг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд тусгах.	-Сэтгүүлчийн мэдээлэл олж авах арга хэрэгсэл баталгаатай болсон байна. -Сэтгүүлчийн аюулгүй байдлын хамгаалалт сайжирсан байна.	2024-2027	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Хууль зүй, дотоод хэргийн яам		
			Дэмжин ажиллагч: Хэвлэл мэдээллийн зөвлөл		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			ЦХХХЯ, ХХЗХ, ЦЕГ, УБЕГ, ХЗҮХ, “МОНЦАМЭ” Монголын Үндэсний Мэдээллийн агентлаг	Азийн сан, Монголын Сэтгүүчдийн нэгдсэн Холбоо	МУИС-ХЗС
4.4.Хэвлэл мэдээллийн салбарын ёс зүйн асуудлыг боловсронгуй болгох.	Хэвлэл мэдээллийн ажилтны ёс зүйн зохицуулалт боловсронгуй болсон байна.	2024-2027	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага**: Хууль зүй, дотоод хэргийн яам		
			Дэмжин ажиллагч: Хэвлэл мэдээллийн зөвлөл		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			ЦХХХЯ, ХХЗХ, ЦЕГ, УБЕГ, ХЗҮХ, “МОНЦАМЭ” Монголын Үндэсний	Азийн сан, Монголын Сэтгүүчдийн нэгдсэн Холбоо	МУИС-ХЗС

			Мэдээллийн агентлаг		
4.5.Иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсах цуглах зэрэг хүний эрхийн олон улсын механизмаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.	Олон улсын хамтын нийгэмлэгийн болон бүс нутгийн хүний эрхийн механизм, энэ чиглэлээр мэргэшин ажилладаг гишүүнчлэлтэй иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.	2024-2027	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Хууль зүй, дотоод хэргийн яам		
			Дэмжин ажиллагч: Гадаад харилцааны яам		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс	Азийн сан, Глоб Интернэшнл төв ТББ	ЦЕГ, Аймаг, нийслэлийн засаг дарга нар
4.6.Орон нутагт иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	-Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийдэг болсон байна. -Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүний хэрэгжилтийг Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын тайлангийн илтгэлд тусгадаг болсон байна.	2024 оноос эхлэх	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Хууль зүй, дотоод хэргийн яам		
			Дэмжин ажиллагч:		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			Аймаг, нийслэлийн ЗДТГ	Хүний эрхийн ТББ-ын форум, Орон нутгийн ТББ-ууд	ХЭҮК, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбоо
4.7.Харилцаа холбооны сүлжээнд иргэдийн үг хэлэх, үзэл	-Хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцаа	2024 оноос эхлэх	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Цахим хөгжил, харилцаа холбооны яам		

<table>
<tr><td rowspan="3">бодлоо илэрхийлэх нөхцлийг хязгаарлахыг хориглосон зохицуулалтыг харилцаа холбооны тухай хуулийн төсөлд тусгах.</td><td rowspan="3">холбооны сүлжээнд хүний үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, олон нийтийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн хязгаарлалт тогтоохыг хориглосон зохицуулалттай болсон байна.</td><td rowspan="3"></td><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>Хууль зүй, дотоод хэргийн яам</td><td>Монголын сэтгүүчдийн нэгдсэн холбоо</td><td>ХЭҮК</td></tr>
<tr><td colspan="6">Зорилт 5.Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх</td></tr>
<tr><td colspan="6">Үүрэг амлалтын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Манлайлж хэрэгжүүлэх байгууллага</td><td colspan="5">Сангийн яам</td></tr>
<tr><td rowspan="2">Дэмжин ажиллагч</td><td>Төрийн байгууллага</td><td colspan="2">Төрийн бус байгууллага</td><td colspan="2">Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ЭЗХЯ</td><td colspan="2">“Нээлттэй нийгэм форум” ТББ, “Үнэн хатамж” ТББ</td><td colspan="2">-</td></tr>
<tr><td>Хэрэгжих хугацаа</td><td colspan="5">2024-2027</td></tr>
<tr><td colspan="6">Асуудлын тодорхойлолт</td></tr>
<tr><td>Үүрэг амлалтаар ямар асуудлыг шийдэхийг зорьж байна вэ?</td><td colspan="5">Монгол Улсын хүн амын ядуурал, ажилгүйдлийн түвшнийг бууруулахад төсвийн бодлого чухал нөлөөтэй. Төсвийн тухай хуульд “Төсвийг төлөвлөн, баталж, хэрэгжүүлэхдээ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах; санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; ил тод байдлыг ханган, хариуцлагатай байх” гэсэн зарчмуудыг тусгасан байдаг. Гэсэн хэдий ч төсвийн ил тод байдал бүрэн хангагдахгүй байгаагийн зэрэгцээ төсвийн зарцуулалттай холбоотой зөрчлүүд төрийн аудитаар ихээхэн илэрч байна. Нийслэлийн төсвийн төсөл, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалт, гүйлгээнд холбогдох шийдвэрийн ил тод байдал сул байгаа нь ажиглагдаж байна. Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд тухайн жилийн төсвийн төсөлд багтсан шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтийг УИХ-аас хэлэлцэхдээ төслүүдийн үр ашиг, ач холбогдолыг нухацтай хэлэлцэх шаардлагатай байна.

Төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд төсвийн ил тод байдал чухал юм. Иймд орон нутгийн төсвийн төлөвлөлтийн ил тод байдлыг дээшлүүлэх, улсын төсвийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн шаардлагад нийцсэн байдлаар ил</td></tr>
</table>

	тод болгох, тухайн жилийн төсвийн төсөлд багтсан шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн ач холбогдлын эрэмбийн мэдээллийг ил болгох шаардлагатай байна. Түүнчлэн тусгай сангуудын төсвийг зарцуулах сонгон шалгаруулалт, санхүүжилт, төрийн өмчит компаниудын 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын холбогдох шийдвэр болон төрийн өмчийг актлах устгах шийдвэрийг ил тод болгох зохицуултыг бий болгох хэрэгтэй байна.
Асуудлын шалтгаан юу вэ?	Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төслүүдийн үр ашиг, ач холбогдолын мэдээлэл ил бус, энэ асуудлыг УИХ-аас төсөв хэлэлцэхдээ анхаарахгүй байна. Улсын төсвийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн шаардлагад нийцсэн байдлаар ил тод болгох, тухайн жилийн төсвийн төсөлд багтсан шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн ач холбогдлын эрэмбийн мэдээллийг ил болгох, түүнчлэн тусгай сангуудын төсвийн зарцуулах сонгон шалгаруулалт, санхүүжилт, төрийн өмчит компаниудын 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын холбогдох шийдвэр болон төрийн өмчийг актлах, устгах шийдвэрийг ил тод болгох зохицуулалт холбогдох хуульд хангалтгүй байна.
Асуудлыг шийдэхийн тулд өнөөг хүртэл юу хийсэн бэ?	Улсын төсвийн хууль, эрхзүйн орчинд нааштай өөрчлөлтүүд гарч байгаа боловч орон нутгийн төсвийн төлөвлөлтийн ил тод байдал хуулийн дагуу хэрэгжихгүй байгаа байдал ажиглагдаж байна. Улсын төсвийн төслийн болон танилцуулгын хавсралтуудыг нээлттэй өгөгдлийн шаардлагад нийцсэн байдлаар ил тод болгох, Шилэн дансанд тусгай сангуудын төсвийг зарцуулах сонгон шалгаруулалт, санхүүжилт, төрийн өмчит компаниудын 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын холбогдох шийдвэр, төрийн өмчийг актлах, устгах шийдвэр, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн үр ашиг, ач холбогдлын эрэмбийн мэдээллийг ил болгох шаардлагатай байгаа талаар иргэний нийгмийн зүгээс асуудлыг хөнддөг боловч энэ чиглэлээр ахиц гараагүй байна.
Ямар шийдлийг санал болгож байна вэ?	1.Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн ил тод байдлыг хангах (Төсвийн хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах); 2.Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д улс, орон нутгийн тухайн оны төсвийн тухай төслийн болон танилцуулгын хавсралтуудыг нээлттэй өгөгдлийн шаардлагад нийцсэн байдлаар ил тод болгох; 3.Шилэн дансны хууль, журамд тусгай сангуудын төсвийг зарцуулах сонгон шалгаруулалт, санхүүжилт, төрийн өмчит компаниудын 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын холбогдох шийдвэрийг ил болгох талаар заалт тусгах. Төрийн өмчийг актлах, устгах шийдвэрийг ил тод болгох зохицуулалтыг тусгах; 4.Тухайн жилийн төсвийн төсөлд тусгасан шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэнтэй холбоотой мэдээллийг ил болгох; 5.Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын хасагдсан, нэмэгдсэн болон төсвийн дүнд оруулсан өөрчлөлттэй холбоотой мэдээллийг хавсралтаар гаргадаг болох; 6.Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах үед иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

<table>
<tr><td>Үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхийг зорьж байна вэ?</td><td colspan="3">Улс, орон нутгийн төсвийн ил тод байдал нэмэгдэж, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын оновчтой байдал нэмэгдэнэ. Энэ нь улсын төсвийг улс орны хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлэхэд хувь нэмэр оруулах юм.</td></tr>
<tr><td>Хүрэх үе шат</td><td>Хүлээж байгаа үр дүн</td><td>Хэрэгжүүлж дуусах хугацаа</td><td>Оролцогч</td></tr>
<tr><td colspan="4">Зорилт 5.1.Төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх</td></tr>
<tr><td rowspan="4">5.1.1.Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн ил тод байдлыг хангахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</td><td rowspan="4">Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч тухайн шатны төсвийг төлөвлөх, батлахад Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж төсвийн ил тод байдлыг хангасан байна.</td><td rowspan="4">2024-2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Сангийн яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ЭЗХЯ, Аймаг нийслэлийн ТЕЗ</td><td>Нээлттэй нийгэм форум ТББ, Үнэн хатамж ТББ</td><td>-</td></tr>
<tr><td rowspan="4">5.1.2.Улсын болон орон нутгийн тухайн оны төсвийн төслийн танилцуулга болон түүнтэй холбоотой хавсралтуудыг нээлттэй өгөгдлийн стандартад нийцүүлэн ил тод, нээлтэй болгохтой холбогдсон зохицуулалтыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д тусгах.</td><td rowspan="4">“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д холбогдох зохицуулалтыг тусгаснаар улс, орон нутгийн тухайн оны төсвийн төсөлтэй холбогдсон мэдээлэл ил тод, нээлттэй болно.</td><td rowspan="4">2024</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Сангийн яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ЭЗХЯ, Аймаг нийслэлийн ТЕЗ</td><td>Нээлттэй нийгэм форум ТББ, Үнэн хатамж ТББ</td><td>-</td></tr>
<tr><td rowspan="2">5.1.3.Тусгай сангийн төсвийг зарцуулах сонгон шалгаруулалт, санхүүжилт, төрийн өмчит компанийн 5 сая төгрөгөөс дээш худалдан авалттай холбогдох</td><td rowspan="2">“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д холбогдох зохицуулалтыг тусгаснаар</td><td rowspan="2">2024</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Сангийн яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
</table>

шийдвэр болон төрийн өмчийг актлах, устгах шийдвэрийг ил тод болгох зохицуулалтыг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д тусгах.	тусгай сангийн зарцуулалт болон төрийн өмчит компанийн худалдан авалттай холбоотой үйл ажиллагаа ил тод, нээлттэй болно.		**Төрийн байгууллага**	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			ЭЗХЯ	Нээлттэй нийгэм форум ТББ, Үнэн хатамж ТББ	-
5.1.4.Тухайн жилийн төсвийн төсөлд тусгасан шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэнтэй холбоотой мэдээллийг ил болгох.	Төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын төслүүдийн талаарх мэдээлэл иргэд, сонгогчдод нээлттэй болно.	2024-2025	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Сангийн яам		
			Дэмжин ажиллагч:		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			ЭЗХЯ	Нээлттэй нийгэм форум ТББ, Үнэн хатамж ТББ	-
5.1.5.Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын хасагдсан, нэмэгдсэн болон төсвийн дүнд оруулсан өөрчлөлттэй холбоотой мэдээллийг хавсралтаар гаргадаг болох.	Төсвийн тодотгол хийгдэх тохиолдолд тодотголын хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын хасагдсан, нэмэгдсэн, төсвийн дүнд оруулсан өөрчлөлтийн мэдээлэл ил тод, тодорхой байна.	2024-2025	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Сангийн яам		
			Дэмжин ажиллагч:		
			Төрийн байгууллага	**Төрийн бус байгууллага**	**Бусад оролцогч**
			ЭЗХЯ	Нээлттэй нийгэм форум ТББ, Үнэн хатамж ТББ	-
5.1.6.Төсвийн хэрэгжилт, ил тод байдлын систем хоорондын	www.shilendans.gov.mn сайт төсвийн хэрэгжилт, ил тод	2024-2025	**Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:** Сангийн яам		

<table>
<tr><td rowspan="3">уялдаа, талуудын оролцоог тэгш хангаж санал солилцох, судалгаан дээр тулгуурлан хөгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn сайтыг шинэчлэх.</td><td rowspan="3">байдлыг хангахад ашиглагдаж буй систем хоорондын уялдаа сайжирсан байна.
www.shilendans.gov.mn сайтын хөгжүүлэлт сайжирсан байна.</td><td rowspan="3"></td><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ЭЗХЯ</td><td>Нээлттэй нийгэм форум ТББ, Үнэн хатамж ТББ</td><td>-</td></tr>
<tr><td rowspan="4">5.1.7.Гадаадын зээл тусламжтай холбоотой мэдээллийг www.ODAMIS.mof.gov.mn системд бүртгэх, дэлгэрэнгүйгээр байршуулах, чиглэлийн уялдаа холбоог хангах, санхүүжилт болон үйл ажиллагааны үр дүнгийн уялдааг хангах, төслүүдийн худалдан авах үйл ажиллагааны журмыг олон нийтэд ил тод болгож сайжруулах.</td><td rowspan="4">Гадаадын зээл тусламжтай холбоотой мэдээлэл ил тод, нээлттэй мэдээлэгдэнэ.</td><td rowspan="4">2025</td><td colspan="3">Манлайлж хэрэгжүүлэх байгууллага:
Сангийн яам</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжин ажиллагч:</td></tr>
<tr><td>Төрийн байгууллага</td><td>Төрийн бус байгууллага</td><td>Бусад оролцогч</td></tr>
<tr><td>ЭЗХЯ</td><td>Нээлттэй нийгэм форум ТББ, Үнэн хатамж ТББ</td><td>-</td></tr>
<tr><td colspan="6">Зорилт 5.2.Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх</td></tr>
